Хөрсний тухайд бүс нутгаас шалтгаалан олон төрөл, зүйлийн шинж чанар агуулсан хөрсний бүтэцтэй. Гол, мөрний ай сав газарт үржил шим ихтэй хунгарласан хөрс хуримтлагдсан байдаг (Зураг 2.1.7), нутгийн зүүнээс өмнөд хэсэгт буудайн тариалалтанд тохиромжтой хар шороо¹ (чернозём) чанарын хөрс элбэг (Зураг 2.1.8)



Эх сурвалж: УГЗБЕТ, ГХГЗЗГ

Зураг 2.1.7 Хөрс



Эх сурвалж: УГЗБЕТ, ГХГЗЗГ

Зураг 2.1.8 Хар шорооны тархалт


¹ Биологи, химийн шинж чанараар тэнцвэр сайтай, үржил шимтэй хөрс

2.2 Хүн амын шилжилт хөдөлгөөн

Энэхүү хэсэгт хөгжлийн урьдчилсан нөхцөл болох хүн амын шилжилт хөдөлгөөний талаар Монгол улсын голлох асуудлын нэг болсон “Улаанбаатар хотын хэт төвлөрөл”-д анхаарал хандуулан, хүн амын шилжилт хөдөлгөөний бодит байдал, тулгарч буй асуудлыг тоймлов.

(1) Монгол улсын засаг захиргааны хуваарь

Монгол улс нь хойд хэсгээрээ ЗХУ, зүүн болон өмнөд хэсгээрээ БНХАУ, Өвөр Монголын өөртөө засах улстай хиллэдэг эх газрын улс билээ. Орон нутгийн засаг захиргааны хувьд аймаг, сум, баг гэсэн нэгжтэй, 21 аймаг, 347 сум, эдгээрт 1681 баг харъяалагдаж байна. Эдгээр аймгуудыг Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Улаанбаатарын бүс хэмээн 5 бүс нутагт хуваан төлөвлөгөө гаргах тохиолдол байдаг ч энэ нь засаг захиргааны нэгжид хамаарахгүй.² (Зураг. 2.1.1)



Эх сурвалж: ESRI, ГЗЗГ-ын мэдээлэлд үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.2.1 Монгол улсын засаг захиргааны хувиарилалт

²УИХ-ын 2001 оны 57 дугаар тушаал “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тулгуурлав. (4.1 2 хэсгийг харна уу)

(2) Хүн амын хөдөлгөөн

1) Монгол улсын нийт хүн амын хөдөлгөөн




Монгол улсын хүн ам нь тасралтгүй өссөөр буй бөгөөд 2014 оны үзүүлэлтийг 1989 онтой харьцуулахад бараг 1.5 дахин өсчээ. Жилийн дундаж өсөлт нь 1989 оноос 2000 онд 1.5% байсан бол, 2000-2010 онд 1.4% байсан бол 2010-2014 онд 2.1% болж нэмэгджээ (Зураг 2.2.1).

Хүн амын бүтцийн өөрчлөлтийг харвал, 1990-ээд он хүртэл пирамид хэлбэрийн суварга байсан бол 2000 оны үеийн социалист систем нуран унасаны дараах хямралыг даван гарч 2010 оны үед 20-24 насны хүн ам хамгийн олонтой дунд хэсгээрээ өргөссөн ³хэлбэртэй болжээ. (Зураг2.2.2)

Хүснэгт 2.2.1 Монгол улсын нийт хүн амын өсөлтийн үзүүлэлт

	1989	2000	2010	2014	1989-2000 оны жилийн дундаж өсөлт	2000-2010 оны жилийн дундаж өсөлт	2010-2014 оны жилийн дундаж өсөлт
Нийт	2,043,954	2,403,105	2,760,968	2,995,949	1.5%	1.4%	2.1%
Эр	1,020,669	1,190,244	1,342,081	1,466,455	1.4%	1.2%	2.2%
Эм	1,023,285	1,212,861	1,418,887	1,529,494	1.6%	1.6%	1.9%

Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав




Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг
үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны
баг боловсруулав

Зураг 2.2.2 Монгол улсын хүн амын суваргын өөрчлөлт

³УИХ-ын 2001 оны 57 дугаар тушаал «Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал» д тулгуурлав. (4.1 2 хэсгийг харна уу)

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хөдөө орон нутгийн хүн ам нэмэгдэж хот суурин газрын хүн ам багасах хандлага ажиглагдсан ч, 1999 оноос хойш хот суурин газрыг чиглэсэн урсгал эрс нэмэгдэн, хот суурин газарт хүн ам хэт төвлөрч байна (Зураг 2.2.3). Эдийн засаг өндөр өсөлттэй үед хот суурин газарт хүн ам төвлөрч, эдийн засгийн өсөлт саарахад хот руу чиглэсэн урсгал буурах хандлагатай байдаг. Бусад хотуудад ажиглагдаж байгаачлан илүү орлого олох, дээд боловсрол эзэмшихээр хот суурин газарт шилжин суурьших үндсэн шалтгаан байгаа хэдий ч, Улаанбаатар хотод хүн ам олноор шилжин суурьших болсон хамгийн гол шалтгаанаар дараах хоёр шалтгааныг дурьдах нь зүйтэй болов уу. Нэгдүгээрт 2001 онд “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийг баталсанаар хот суурин газарт шилжин суурьшихад хялбар болсон, хоёрдугаарт үе үе тохиох зудын гамшигийг дурдаж болох юм. Өвөлжилтийн бэлтгэл бүрэн хангагдаагүй үед хүйтний эрч эрс чангарсанаар, малын тоо толгой хорогдон аргагүй нөхцлөөс шалтгаалан хот суурин газарт шилжин суурьших малчид цөөнгүй байгаа бөгөөд үүнийг статистик үзүүлэлтээс тодорхой харж болох юм.

Хот суурин газарт төвлөрч байгаа хүн амын дийлэнхийг амьжиргаанаас доогуур түвшний орлоготой иргэд эзэлж байгаа бөгөөд амьдран суух газраа олж хүрээлэн, босгосноор хотод оршин сууж эхэлдэг ч ажлын олдоц муу зэргээс ядуурал, оршин суугаа орчны бохирдол зэрэг асуудлууд давхар үүсч байна.



Эх сурвалж: ҮСХ


Анхаарах : ҮСХ-ийн 2014 оны жилийн тайлангаас харахад хот суурин газрын хүн амыг Улаанбаатар хот, аймгийн төвийн хүн ам, хөдөө орон нутгийн хүн амыг сумын төв болон хөдөө оршин сууж буй хүн ам хэмээн тодорхойлсон байна.

Зураг 2.2.3 Хот суурин газар хөдөө орон нутгаар ангилсан хүн амын өөрчлөлт

Сүүлийн жилүүдэд хот суурин газар шилжин суурьших үзэгдэл дэлхийн хэмжээнд өсөх хандлагатай байгаа бөгөөд Монгол улсын хувьд мөн адил, 2014 оны байдлаар хот суурин газар оршин суугчид хүн амын 66 хувийг эзэлж байна. (Зураг 2.2.4,

Хүснэгт 2.2.2) Монгол улсын нийт хүн амын 45 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотноо төвлөрсөн байгаа бөгөөд 2014 оны байдлаар Улаанбаатар хотын нийт хүн ам 1,320 мянга⁴ байна. Улаанбаатар хотын дараа орох Эрдэнэт хотын хүн ам 110 мянга байна. Хот суурин газрын хүн амын бөөгнөрөл⁵ Улаанбаатар хотод хамгийн их байгаагаас харахад цаашдаа ч нийслэл хотод хүн амын төвлөрөл нэмэгдэх магадлалтай байгаа бөгөөд хүн амын хэт төвлөрөлийг шийдэхийн тулд хөдөө орон нутагт хот суурин газрыг хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөлийг сааруулах арга хэмжээ авах нь засгийн газрын түвшинд шийдвэрлэх асуудал болж байна.

Дэлхийн хэмжээнд хот суурин газар оршин сууж буй хүн амын тоон харьцааны өөрчлөлт



Эх сурвалж: UN 2006, World Urbanization Prospects: The 2005 Revision

Зураг 2.2.4 Дэлхийн хэмжээнд хот суурин газар оршин сууж буй хүн амын тоон харьцааны өөрчлөлт (Хотжилтын хувь) (1950 – 2030он)

Хүснэгт 2.2.2 Монгол улсын хотжилтын хувь

Он	1956	1963	1970	1980	1990	2000	2010	2014
Хот суурин газрын хүн амын эзлэх хувь	22%	40%	44%	51%	57%	57%	69%	66%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2) Аймаг тус бүрийн хүн ам, өрхийн тооны шилжилт

Хүн амын тоог аймаг тус бүр дээр авч үзэхэд дээр дурдсанчлан Улаанбаатар хотод нийт хүн амын 45%, ойролцоогоор 1 сая 131 мянган хүн (2014 он) оршин сууж байгаа бөгөөд хотжилт хэт эрчимтэй явагдсан байдалтай байна. (Хавсралт 2.2.1-г харах)

⁴ Үндэсний статистикийн хорооны 2014 оны тайлан “Residents in Mongolia” үзүүлэлт

⁵ Нэгдсэн үр дүн, гэдэг нь нэгдсэн суурь хөрөнгөөс бүрдэх гадаад эдийн засаг болон муу эдийн засгийг хэлнэ. Гадаад эдийн засаг гэдэг нь олон төрлийн аж үйлдвэр, жа ахуй нэгж, ард иргэд нь нэг бүс нутагт бөөгнөрөхөөс үүдэн гарах харилцааны боломж ихэссэн эдийн засгийн үр дүнг хэлнэ. Муу эдийн засаг гэдэг нь замын түгжрэл, агаарын бохирдол, газрын төлбөр өсөх зэрэг дарамт нэмэгдэхийг хэлнэ.

Аймаг тус бүрийн хүн амыг 2010 он болон 2014 онтой харьцуулж үзэхэд Өмнөговь аймгаас бусад аймагт хүн ам өссөн байна. Ялангуяа Говьсүмбэр аймагт жилийн 3.8%-ын дундаж өсөлттэй байна. (Улсын жилийн дундаж өсөлт:2.1%). Говьсүмбэр болон Баян-Өлгий аймагт хүн амын хэвийн өсөлт хамгийн өндөр байгаа бөгөөд 1000 хүн тутамд 26 хүн байна (Улсын дундаж: 1000 хүн тутамд 22 хүн). Төрөлт хувьд ч дээрх хоёр аймагт 1000 хүн тутамд 31-32 хүний үзүүлэлттэй, (Улсын дундаж: 1000 хүнд 28хүн) , дундаж наслалтаар (73нас) (Улсын дундаж: 70) тэргүүлж байна

Баян-Өлгий аймагт 1000 хүн тутамд 18 гэрлэх насны хүн, (Улсын дундаж: 1000 хүн тутамд 6 хүн), нэг өрхөд 4.2 хүн (Улсын дундаж: Нэг өрхөд 3.6 хүн) ноогдож байгаа нь өндөр үзүүлэлт юм.

2014 оны байдлаар нийт 823 мянга өрх байгаа бөгөөд нэг өрхөд ноогдох хүний тоо 3.6 байна. 2010 оноос хойш бүх аймагт өрхийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд ялангуяа Өмнөговь аймаг, Улаанбаатар хотод эрс нэмэгдэж, жилд дунджаар 3.8% болон 3.7%-аар нэмэгдсэн байна. (Улсын дундаж: 2.1%) (Хавсралт 2.2.2-с харах)




Өрхийн нийт дүнгээр авч үзэхэд хотжилтын хувь 65%-д хүрч байгаа бөгөөд газар нутгийн талбай багатай суурин газрын гол төв болсон Улаанбаатар хотод нийт өрхийн 100%, Орхон аймагт 95%, Дархан-Уул аймагт 83% нь хот суурин газар оршин сууж байна. Мөн Говьсүмбэр болон Дорноговь аймагт нийт өрхийн 60% нь хот суурин газарт оршин сууж байна. Бусад аймгуудад нийт өрхийн 60%-с дээш хувь нь хөдөө орон нутагт оршин сууж байна. 2010 болон 2014 оныг харьцуулахад хот суурин газар оршин суух өрхийн тоогоор Өвөрхангай аймаг, Өмнөговь аймаг 5%-ийн нэмэгдсэн үзүүлэлттэй (улсын дундаж 3%) байгаа бөгөөд хөдөө орон нутагт оршин суух өрхийн нийт дүнгийн өсөлтөөр Өмнөговь аймаг 3%-р (Улсын дундаж: 0.5%) тэргүүлж байна.

3) Сум тус бүрийн хүн амын тархалт болон хүн амын тоон шилжилт

1990, 2000, 2010 оны байдлаарх сумын хүн амын тархалтыг зураг 2.2.5-т үзүүлэв. 1990 онд хамгийн олон хүн амтай нь Сайншанд байсан бөгөөд 1990 оноос 2000 оны хооронд хүн ам Улаанбаатар хотод төвлөрч эхлэхийн зэрэгцээ 2000 оноос 5,000-гаас дээш хүн амтай сумын тоо өссөн. Ялангуяа Хангайн нурууны орчимд төвлөрч байгааг харж болно. Гэвч 2010 онд 2,500-гаас доош хүн амтай сумын тоо дахин ихэсч Улаанбаатар болон аймгийн төвүүд рүү чиглэсэн хүн амын урсгал эрчимжжээ.

2010 оны байдлаар 10000-с дээш хүн амтай хотуудын ихэнх нь аймгийн төв байсан ба ялангуяа улсын хойд хэсэгт орших Улаанбаатар хот (1159,899), Дархан (77,547), Эрдэнэт (85,783)-ийн хүн ам бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад олон, хүн ам ихээр төвлөрсөн байна. Аймгийн төвүүдээс гадна 10000-с дээш хүн амтай сум нь Төв аймаг, Дархан-Уул аймгийн дунд орших Сэлэнгэ аймгийн Мандал (25,009), БНХАУ-


тай хиллэдэг Замын-Үүд (Дорноговь аймаг, 13,799 хүн), Хархорин (Өвөрхангай аймаг, 12,933), Говьсүмбэр аймгийн төв Чойрын зэргэлдээ орших Дархан (Хэнтий аймаг, 11,196), эдгээр 4 сум байна.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА судалгааны баг боловсруулав.

Зураг 2.2.5 Сумдын хүн амын өсөлтийн хувь (1990, 2000, 2010 он)

1990-2000 оны хоорондох хүн амын өсөлт бууралтыг харахад 78 сумын хүн ам буурсан ба энэ нь нийт сумдын 23% байсан бол 2000-2010 оны хооронд 252 сум буюу нийт сумдын 74%-д хүн ам буурчээ. 2000-2010 оны хооронд хүн ам буураагүй сумын ихэнх нь аймгийн төв бөгөөд ялангуяа Улаанбаатар хотод хүн ам төвлөрсөн байна. Мөн Сэлэнгэ аймгийн ОХУ-тай хиллэдэг хэсэг, Говьсүмбэр аймгийн Чойр орчим, Өмнөговь аймгийн Оюутолгой, Тавантолгой зэрэг уурхай орчимд хүн ам өсчээ. Ялангуяа БНХАУ-тай хиллэдэг хилийн боомт хот болох Дорноговь аймгийн Замын-Үүдийн хүн ам 5 жилд 125% өссөн байна. Харин Завхан аймаг зэрэг баруун бүсийн Хангай нуруу, Алтай нуруу хооронд орших бүс нутагт хүн ам буурсан сумын тоо олон байгаа нь ажиглагдаж байна. Зураг 2.2.6-д 1990-2010 оны хоорондох сумуудын хүн амын өсөлтийн тоо, Зураг 2.2.7-д хүн амын өсөлтийн хувийг харуулав.




1990 он—2000 он



2000 он—2010 он

Эх сурвалж : ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн ЖАЙКА судалгааны баг боловсруулав

Зураг 2.2.6 Сумдын хүн амын тоо (1990—2000 он)



Эх сурвалж : ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн ЖАЙКА судалгааны баг боловсруулав

Зураг 2.2.7 Сумдын хүн амын өсөлтийн хувь (2000—2010 он)


(3) Хотуудын хүн амын хэмжээний онцлог

Монгол улсын хотуудыг 2010 оны хүн амын тооллогын дүнг ашиглан хүн амын хэмжээгээр эрэмбэлэн зураг 2.2.8 т харууллаа. 2 дахь хот болох Эрдэнэт хотын хүн ам 100 мянга хүрэхгүй, Улаанбаатар хотод хэт их төвлөрсөн байдалтай байна. Дэлхийн хэмжээнд нэг улс буюу бүс нутагт хотын ранк болон хүн амын хэмжээнд Zipf ийн дүрэм буюу хүн амын хэмжээ болон давхарга хоорондоо холбоотой гэж үздэг. 2 дахь хотоос эхлээд онолын хувьд байх ёстой хүн амын хэмжээг зураастай графикаар харуулсан байгаа. Бодит үзүүлэлт болон онолын хувьд байх ёстой хүн амын хэмжээнд зурагт харуулснаар томоохон зөрүү гарч байгаа бөгөөд бодит байдалд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их хэмжээтэй байна

Хотыг нэг талаас зах зээл гэж үзэж болох ба хөдөө орон нутагт суурин газар бүрэн гүйцэд хөгжиж чадаагүй нь зах зээлийн эдийн засаг бүрэн гүйцэд нэвтэрч чадаагүй Монгол улсын түүхтэй уялдаа холбоотой юм. Социалист нийгмийн үед Чойбалсан, Ховд, Мөрөн, Сайншанд зэрэг голлох бүс нутгийг сонгон авч, гурилын үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр зэргийг бодлоготойгоор барьж байгуулахаар оролдсон хэдий ч, төлөвлөгөөт эдийн засаг нуран унасанаар ЗХУ-аас үзүүлэх дэмжлэг зогсох, зах зээл хаагдах, гадаад худалдааны нөхцөл нарийсах,эд бараа үйлчилгээ хоорондын үнийн зөрүү зэрэг эдийн засгийн давхар цохилтууд бүрэн гүйцэд хөгжиж амжаагүй байсан аж үйлдвэрлэлийн салбарыг уналтанд оруулсанаар 1990 онд эдийн засгийн хямрал нүүрлэсэн билээ. Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараах 2000-д оны үед газрын

баялаг дэлхий нийтийн анхаарлын төвд орсоноор, хөдөө аж ахуй, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарыг дахин сэргээн босгох ажил эхэлсэн нь Монгол улсын бүс нутгийн эдийн засгийн товч түүхэн явц билээ. Орон нутгийн зах зээлийн гол хөдөлгөгч хүч мал аж ахуй байсан тэр цаг үед дийлэнх малчин айл өрхүүд хэрэглээний бараа, үйлчилгээний дийлэнх хувийг өөрсдөө хангах болон хөрш зэргэлдээ айлуудтай солилцох гэх мэт харилцан бие биеэ дэмжих байдлаар хангаж ирсэн нь зах зээлийн систем нэвтрэх явцыг удаашруулсан юм. Мал аж ахуйд дангаар түшиглэсэн аж үйлдвэрлэлийн бүтэц нь газар зүйн талаасаа төв суурин болон түүний эргэн тойрон хэмээх газар зүйн тогтолцоог бий болгосон гэж хэлж болох юм.

Цаашдаа иргэдэд үзүүлэх үйлчилгээ, зах зээлийн эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр хөдөө орон нутаг дахь суурин газрын эдийн засаг хөгжин тэлвэл хот суурин аяндаа өргөжин томрох боломжтой юм.




Эх сурвалж : ҮСХ-ны мэдээлэл (2010 оны хүн амын тооллого)д үндэслэн

Зураг 2.2.8 Монгол улсын хотын хүн амын бодит тоо, логик тоо

(4) Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийн шалтгаан

Хүн ам хот (Ялангуяа Улаанбаатар) руу төвлөрч байгаа шалтгааныг дараах зурагт нэгтгэн үзүүлэв. Хөх өнгөөр татах хүчин зүйл, улбар шараар түлхэх хүчин зүйлийг тэмдэглэсэн байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн сөрөг нөлөөлөлд ихээр өртсөн малчид ажил хайж хот руу шилжиж байна. Нөгөө талаар хот хөдөөгийн эдийн засгийн ялгаа улам ихэсч байгаа үед эдийн засаг эрчимтэй хөгжиж буй нийслэл хотод шинэ боломжийг эрэлхийлэн ирэх, хотын гэр хороололд газар өмчлөх боломжтой болсон зэрэг нь татах хүчин зүйл болж байна. Хот хөдөөгийн төрөл

садангуудын хооронд, хот руу шилжин суурьшсан айлд малчдын сургуулийн насны хүүхдүүд байж, хөдөө байдаг нь малаа нийлүүлэн хариулдаг, бие биеэ нөхсөн харилцаа ч үүссэн байдаг.



Эх сурвалж ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.2.9 Хүн ам хотод төвлөрөх болсон шалтгаан

2.3 Нийгмийн хөгжил болон иргэдэд үзүүлэх үйлчилгээ

Энэхүү бүлэгт хөгжлийн нэг гол асуудал болох Улаанбаатар хот болон орон нутгийн хөгжил, иргэдэд үзүүлэх үйлчилгээний ялгааны талаарх одоогийн нөхцөл байдлыг нэгтгэнэ.

(1) Нийгмийн хөгжлийн одоогийн байдал болон тулгамдаж буй асуудлууд

1) Хүний хөгжил

Монгол улс 2014 оны байдлаар хүний хөгжлийн индексээр (HDI) БНХАУ-тай зэрэгцэн нийт 188 орноос 90-дүгээр байрт жагссан бөгөөд Зүүн Ази, Ази номхон далайн бүс нутгийн дунджаас дээгүүр, хүний хөгжлийн төвшин өндөр орны тоонд багтсан байна. (Хүснэгт 2.3.1). 2000-2010 оны хоорондох 10 жилийн хугацаанд хүний хөгжлийн индекс 1.68% өссөн байгаа нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших тун өндөр үзүүлэлт бөгөөд, 2010 оноос хойш 1-с дээш хувиар тогтмол өсч байна. Хүний хөгжлийн индекс бүх аймагт жил бүр өсч байгаа бөгөөд ялангуяа Улаанбаатар хот 0,8% гэсэн өндөр үзүүлэлттэй (Улсын дундаж 0.7), (Хавсралт 2.3.1 харах).

Тухайн улс доторх тэгш бус байдлыг хэмжих хүний тэгш бус байдлын коэффициент 12.9%-тайб байгаа нь Япон улстай (12.4%) ойр байна.

Хүснэгт 2.3.1 Хүний хөгжлийн индекс

Country	Human Development Index (HDI)				Average annual HDI growth			Inequality-adjusted HDI (IHDI)	
	Value				(%)			Value	Overall loss (%)
	1990	2000	2010	2014	1990–2000	2000–2010	2010–2014	2014	2014
Mongolia	0.578	0.589	0.695	0.727	0.18	1.68	1.11	0.633	12.9
High human development	0.592	0.642	0.723	0.744	0.81	1.20	0.71	0.600	19.4
Developing countries	0.513	0.568	0.642	0.660	1.02	1.23	0.70	0.490	25.7
East Asia and the Pacific	0.516	0.593	0.686	0.710	1.39	1.48	0.87	0.572	19.4

Эх сурвалж: Хүний хөгжлийн тайлан 2015 он

2) Боловсрол

Монгол улсын боловсролын түвшин тун өндөр үзүүлэлттэй бөгөөд бага дунд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн ялгаа бараг байхгүй байна. Нийт хүн амын

⁶ Тэгш бус байдал коэффициент ХХИ, тэгш бус байдал тооцсон ХХИ (ТБНТХХИ) зөрүүг тооцно.

98% нь бичиг үсэгт тайлагдсан ба дундаас дээш шатны боловсрол эзэмшсэн хүн ам нийт хүн амын 85%-ийг эзэлж байна. (Хүснэгт 2.3.2)

Аймаг тус бүрээр бага дунд боловсролын түвшинг авч үзвэл, бага шатны боловсролд хамрагсадын эзлэх хувь Булган, Төв аймагт 95%-с бага, дунд шатны боловсролд хамрагсадын тоо Төв, Дундговь, Архангай, Сэлэнгэ аймагт 95%-с бага үзүүлэлттэй байна. Орхон, Дархан-Уул аймагт бага болон дунд шатны боловсролд хамрагсадын тоо 110%⁷-с илүү үзүүлэлттэй байна. (Хавсралт 2.3.1)

Хүснэгт 2.3.2 Боловсрол

Country	Expected years of schooling	Mean years of schooling	Literacy rate	Population with at least some secondary education	Gross enrolment ratio			
	(years)	(years)	(% ages 15 and older)	(% ages 25 and older)	Pre-primary (% of preschool-age children)	Primary (% of primary school-age population)	Secondary (% of secondary school-age population)	Tertiary (% of tertiary school-age population)
	2014	2014	2005–2013	2005–2013	2008–2014	2008–2014	2008–2014	2008–2014
Mongolia	14.6	9.3	98.3	84.8	86	109	92	62
High human development	13.6	8.2	94.5	64.9	72	118	91	35
Developing countries	11.7	6.8	79.9	51.2	50	110	70	25
East Asia and the Pacific	12.7	7.5	94.5	60.5	64	118	85	28

Эх сурвалж: Хүний хөгжлийн 2015 оны тайлан

3) Эрүүл мэндийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэнд

Дэлхийн хөгжиж буй олон орнуудад асуудал болж буй сүрьеэ, ДОХ-оор өвчлөгсөдийн тоо Монгол улсад харьцангуй бага байна. Гэвч эмэгтэйчүүдийн дундаж наслалт 74, эрэгтэйчүүдийнх 65 байгаа нь хүний хөгжлийн түвшин дээгүүр орнууд (эмэгтэй 77, эрэгтэй 76) болон Зүүн Ази Номхон далайн бүс (эмэгтэй 73, эрэгтэй 72) тэй харьцуулахад доогуур байгаа бөгөөд насанд хүрэгсэдийн нас баралтын хувь⁸ тэр дундаа эрчүүдийн нас баралтын хувь хөгжиж буй орнуудаас даруй 1.5 дахин өндөр байгаа юм.

⁷ Сургуульд элсэн орох хувь сургуульд эрт элсэн орох, өнжин суралцах, хөдөө орон нутгаас шилжин суралцах зэрэг шалтгаанаас хамааран 100% давах тохиолдол бий:

⁸ нас барах магадлал 15-60 нас

Мянганы хөгжлийн хөтөлбөрт 2015 онд жирэмсэн эхийн эндэгдэлийг 100 мянган хүн тутамд 50 байхаар тусгасан ч 2013 оны байдлаар 100 мянган хүн тутамд 68 эх эндсэн байна. Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас (72) эхдоогуур байгаа хэдий ч хүний хөгжлийн түвшин дээгүүр орнуудын дундажтай (42 эх) харьцуулахад өндөр байна.(Хүснэгт2.3.3)

Нярай болон бага насны хүүхдийн эндэгдлийг Мянганы хөгжлийн хөтөлбөрт 2015 онд 1000 хүүхэд тутамд 15 болон 21 хүүхэд хэмээн тусгасан ч 2013 оны байдлаар 1000 хүүхэд тутамд 26 болон 32 хүүхэд эндсэн байна. Хөгжиж буй орнуудын дунджаас (37 болон 49) доогуур байгаа ч хүний хөгжлийн түвшин дээгүүр орнуудын дундаж(12 болон 14)болон Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас(16 болон 20)их байна. Мянганы хөгжлийн хөтөлбөрт 2015 онд 1000 хүүхэд тутамд 15 болон 21 хүүхэд хэмээн тусгасан ч энэхүү зорилт нь хэрэгжихэд хүндрэлтэй юм.

Хүснэгт 2.3.3 Эрүүл мэндийн үйлчилгээ

Country	Adult mortality ratio (per 1,000 people)		Maternal mortality ratio	Mortality rates (per 1,000 live births)	
	Female	Male	(deaths per100,000 live births)	Infant	Under- five
	2013	2013	2013	2013	2013
Mongolia	148	309	68	26.4	31.8
High human development	85	143	41	12.0	13.9
Developing countries	134	192	225	37	49.3
East Asia and the Pacific	89	130	72	16.1	19.5

Эх сурвалж: Хүний хөгжлийн 2015 оны тайлан

Нярай болон бага насны хүүхдийн эндэгдлийг аймаг тус бүр дээр харахад баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай аймагт 1000 хүүхэд тутамд 22 хүүхэд эндсэн өндөр үзүүлэлттэй байгаа бол төвийн бүсийн Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул аймгуудад 1000 хүүхэд тутамд 7-оос доош хүүхэд эндсэн (Дархан-Уул аймгийн нярайн эндэгдэл 8 хүүхэд) байдалтай, аймаг тус бүрт томоохон ялгаа ажиглагдаж байна. (Улсын дундаж: Нярайн эндэгдэл 1000 хүүхэдэд 15, бага насны хүүхдийн эндэгдэл 1000 хүүхэд тутамд 18 байна.)2010 оныг 2014 онтой харьцуулахад, Нярай болон бага насны хүүхдийн эндэгдэл Говьсүмбэр болон Говь-Алтай аймгаас бусад аймгуудад буурсан байх бөгөөд нааштай байдал ажиглагдаж байна. Ялангуяа Хангайн бүсийн Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Архангай аймгуудад эндэгдэл ихээр буурсан байна (Хавсралт 2.3.1).

Нярайн эндэгдэлтэй холбож үзэх болох, дундаж наслалт уртассан үзүүлэлт байгаа бөгөөд баруун бүсийн аймаг болон Улаанбаатар хотод уртассан үзүүлэлттэй байна.

4) Ажил эрхлэлт

Монгол улсад тэтгэвэр, жирэмсэн болон амаржсаны дараах цалинтай амралт зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо бүрэлдэн тогтсон. Мал аж ахуй эрхлэгч олон байгаагаас улбаалан ажил эрхлэлт тогтворгүй, насанд хүрээгүй хүүхдийн ажил эрхлэлтийн хувь өндөр байгаагаас харахад улсын аж үйлдвэрийн салбарын хөгжилтэй хамтад нь шийдвэрлэх шаардлагатай болов уу.

Ажил эрхлэлтийн тогтворгүй байдал 51%, хөгжиж буй орнуудын дундаж 54%-д дөхсөн байгаа бөгөөд, хүний хөгжлийн түвшин өндөр орнуудын дундажтай (29%) харьцуулахад хэт өндөр байна (Хүснэгт2.3.4). Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт 10%-аас давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд хүний хөгжлийн түвшин өндөр орнуудын дундажаас(8%) өндөр байна.

Ажилгүйдлийн түвшин 8%, хүний хөгжлийн түвшин өндөр орнуудын дундаж (5%) болон Зүүн Ази, хөгжиж буй орнуудын дундаж (6%), Зүүн Ази, Ази Номхон далайн бүсийн дундажаас (3%) өндөр байна (Хүснэгт2.3.4). Залуучуудын ажилгүйдлийн түвшин үүн дотроо хамгийн өндөр 16.5% байна.

Аймаг тус бүрээр ажилгүйдлийн түвшинг авч үзвэл баруун бүс болон зүүн бүсийн аймгуудад 13%-с дээш байгаа нь улсын дундажаас хэт өндөр байна. Ялангуяа Баян-Өлгий аймаг 22%、Хэнтий аймаг 18%-аар тэргүүлж байна. Эсрэгээр Өвөрхангай, Архангай,Завхан аймаг 4%-аас доош үзүүлэлттэй байгаа нь аймаг тус бүрт томоохон ялгаа байгааг харуулж байна (Хавсралт 2.3.1 харах).

Нэг ажилтаны бүтээмжийг тодорхойлдог хөдөлмөрийн бүтээмж 10921 доллар байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөр орнуудын тал хувьд хүрэхгүй байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авч буй даатгуулагч 10%, хүний хөгжлийн түвшин өндөр орнуудтай (8%) харьцуулахад өндөр байгаа ч, дэлхий нийтийн үзүүлэлттэй (12%) харьцуулахад бага. Өндөр насны тэтгэвэр авагч 100% байна. Хуулинд заасан жирэмсэний болон амаржсаны цалинтай амралт 120 хоног байх бөгөөд хүний хөгжлийн түвшин өндөр орнууд (125 өдөр) ,хүний хөгжлийн түвшин маш өндөр орнуудтай (123 өдөр) ижил түвшинд байна.

Хүснэгт 2.3.4 Ажил эрхлэлт


Country	Vulnerable employment	Unemployment		Labour productivity	Work that is a risk to human development	Security from employment		
	(% of total employment)	Total (% of labour force)	Youth (% of youth labour force)	Output per worker (2011 PPP \$)	Child labour (% ages 5–14)	Unemployment benefits recipients (% of unemployed ages 15–64)	Mandatory paid maternity leave (days)	Old age pension recipients (% of statutory pension age population)
	2008-2013	2008-2013	2008-2014	2005-2012	2005–2013	2008–2013	2014	2004–2012
Mongolia	51.4	7.9	16.5	10,921	10.4	10.0	120	100.0
High human development	28.7	4.7	16.7	23,766	8.3	6.0	125	73.9
Developing countries	54.0	5.6	14.6	..	14.5	2.5	99	51.0
East Asia and the Pacific	..	3.3	18.6	1.6	..	65.3

Эх сурвалж: Хүний хөгжлийн 2015 оны тайлан

5) Орлого

Хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт орлого доогуур. 2014 оны хот суурин газрын дундаж орлого 1,174,005 төгрөг, орон нутгийн дундаж орлого 915,606 төгрөг байгаа нь ойролцоогоор 260 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Орлогийг эх үүсвэрээр нь харахад тэтгэвэр болон бусад халамж хүртэгсэд хот суурин газар 13%, орон нутагт 14%-г эзэлж байгаа нь ижил түвшинд байгаа бөгөөд хот суурин газар цалин, сарын орлогоор 57% нь орлогожиж, 14% нь гэр бүлийн бизнесээс орлого олж байна. Хөдөө орон нутагт 23%, 35% байгаа нь цалин, сарын тогтмол орлогоос илүү гэр бүлийн бизнес орлогийн эх үүсвэр болж байна.

2011 он болон 2014 оны орлогийн түвшинг өрхийн тоотой харьцуулахад хот суурин газар, хөдөө орон нутагт аль алинд нь амьжиргаанаас доогуур орлоготой айл өрхийн тоо багассаныг харж болно (Хүснэгт 2.3.1). Гэхдээ 2014 онд хот суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт амьжиргаанаас доогуур орлоготой айл өрхийн тоо ихэссэн байгаа бөгөөд 500 мянган төгрөгөөс доош орлоготой айл өрхийн тоо 45%-ыг эзэлж байна.



Эх сурвалж: ҮСХ 2014 оны тайла

Зураг 2.3.1 Орлого

б) Ядуурал


2002 оноос 2010 он хүртэлх ядуурлын түвшинг улс, хот суурин газар, хөдөө орон нутаг, Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төв, бусад орон нутгаар авч үзэхэд хөдөө орон нутагт ядуурал ихэссэнийг харж болно. (Хүснэгт 2.3.5) Социалист нийгмийн төлөвлөгөөт эдийн засгийн үед зах зээлийн тогтворгүй байдал, амьжиргааны баталгаа зэргээс шалтгаалан мал аж ахуй газар тариаланг илүү тогтвортойгоор хөгжүүлж ирсэн ч зах зээлийн эдийн засаг руу шилжих явцад нэгдэл тарж, мал хувьчлагдаж, ЭЗХТЗ хэмээх байнгын тогтвортой зах зээл алдагдсан нь ихээр нөлөөлсөн.

Хүснэгт 2.3.5 Ядуурлын түвшний өөрчлөлт

Ангилал	2002-2003	2007-2008	2009	2010
Улс	36.1%	35.2%	38.7%	39.2%
Хот суурин газар	30.3%	26.9%	30.6%	32.2%
Хөдөө орон нутаг	43.4%	45.6%	49.6%	47.8%
Улаанбаатар	27.3%	21.9%	26.7%	29.3%
Аймгийн төв	33.9%	34.9%	37.0%	36.2%
Сумын төв	44.5%	42.0%	42.6%	38.5%
Бусад	42.7%	49.7%	53.2%	54.2%

Эх сурвалж: Vulnerability to Sustainability: Environment and Human Development

2.3.2 зурагт 2010 оны хүн ам, орон сууцны тооллого болон 2011 оны айл өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны дүнд тулгуурлан гаргасан бүс нутаг, аймаг тус бүр дээр санхүүгийн талаас нь ядуу амьдралтай хүн амын эзлэх хувийг харуулав. Ногооноос шар өнгөөр болон ядуурлын хувь хэт нэмэгдсэн хэсгийг улаанаар тэмдэглэсэн болно. Хүн амын 40-с дээш хувь нь амьжиргаанаас доод түвшинд Хангайн бүс болон баруун бүсийн аймгууд байгаа бөгөөд улсын баруун тал хэсэгт төвлөрсөн байдалтай байна.



Эх сурвалж: Harold Coulombe and Gereltuya Altankhuyag, MDGs and Poverty map – 2011: Region, aimag, soum and district level results, Ulaanbaatar, 2012

Зураг 2.3.2 Амьжиргаанаас доогуур түвшний хүн ам

7) Гэмт хэрэг

Шоронд ял эдэлж байгаа иргэн 100 мянган хүн тутамд 287 хүн (2002-2013 он), хүн амины гэмт хэргийн хувь 100 мянган хүн тутамд 10 хүн (20082-2012 он) байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөр орнуудтай харьцуулахад (тус бүр 188 хүн, 7 хүн) өндөр байна.⁹

2014 оны гэмт хэргийн гаралыг аймаг тус бүрээр авч үзэхэд Говьсүмбэр аймагт (1000 хүн тутамд 208 хэрэг) болон Улаанбаатар хотод (1000 хүн тутамд 194 хэрэг) байгаа нь маш өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас (1000 хүн тутамд 140 хэрэг) 1.5 дахин их байна. Дээрх хоёр газарт 2010 оноос гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бөгөөд ялангуяа Говьсүмбэр аймагт 1.6 дахин нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд мөн адил гэмт хэргийн гаралт нэмэгдэж, Сүхбаатар, Төв, Булган аймагт 5 жилийн хугацаанд гэмт хэргийн гаралт 1.5 дахин нэмэгдсэн байна (Хавсралт 2.3.1).

8) Жендер

Хүний хөгжлийн 3 үндсэн үзүүлэлт болох эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн нөөцөөр тооцсон хүйсийн ялгааг харуулсан Хүйсийн тэгш эрхийн хөгжлийн индекс (GDI) 1.028, эмэгтэйчүүдийн хүний хөгжлийн индекс эрэгтэйчүүдээс давуу (2014 он) байгаа нь дэлхийн олон улсаас ялгарч байна. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрх мэдэл, эдийн засгийн үйл ажиллагаа шалгуур үзүүлэлтээр хэмжих Жендерийн эрх тэгш бус байдлын индекс (GI¹⁰) нь 2014 оын байдлаар 0.325 байгаа нь 188 орноос 63-т бичигдэж байна.

⁹ Хүний хөгжлийн тайлан 2015 он

¹⁰ 「Эрүүл мэнд」 (Жирэмсэн эхийн эндэгдэл болон жирэмсэн эхчүүдийн хувь), 「Эрх мэдэл (Их хуралд сонгогдсон гишүүдийн хүйсийн харьцаа, боловсролын түвшин)」「Ажил эрхлэлт (Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн харьцаанд оролцох хувь) ээрэг 3 үзүүлэлтээр хэмжих үзүүлэлт

Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн харьцаанд эзлэх хувь өндөр хэдий ч эмэгтэйчүүдийн цалин хөлс эрэгтэйчүүдээс бага, цалин хөлсний зөрүүтэй байна. Мал аж ахуйд туслуулах зорилгоор эрэгтэйчүүдийг дундаас дээд шатны боловсрол эзэмшүүлэхгүй байх, эмэгтэйчүүдтэй харьцуулахад дундаж наслалт богино, шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн тоо бага зэрэг нөхцөл байдлууд ажиглагдаж байна. Жишээ нь сургуулийн насны хүүхдийн суралцах хугацаа, 25 –с дээш насны насанд хүрэгсэдийн суралцсан дундаж хугацааг хүйсээр нь авч үзэхэд эмэгтэйчүүд олон жил суралцсан байх бөгөөд бусад орнуудаас ялгаатай байна. Энэ үзүүлэлттэй хамааралгүй ч эрэгтэйчүүдийн амиа хорлолт эмэгтэйчүүдийнхээс 4 дахин их байна (Хүснэгт 2.3.6).

Их хурлын гишүүдийн 14.9% нь эмэгтэй гишүүд байгаа нь Япон улсаас (11.6%) өндөр байгаа хэдий ч хүний хөгжлийн түвшин өндөр орнууд, хөгжиж буй орнууд, Зүүн Ази, Ази Номхон далайн бүсийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна¹¹. Шийдвэр гаргах түвшний төрийн албан хаагч (leading officers) эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2012 онд 12.2% байгаа нь доогуур үзүүлэлт юм¹². Үүнийг сайжруулахаар 2013 онд “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-д төрийн албан хаагчдын талаарх нэмэлт заалт багтаж төрийн байгууллага болон төрийн албан хаагчийн албан тушаалд дүйцүүлэх квотыг (Төрийн албан байгууллагын удирдах албан тушаалд аль нэг хүйсийн төлөөлөл 40%-с дээш байна) тогтоохыг хуульчилсан¹³.

Жендерийн эрх тэгш бус байдлын индекс нь улсын хэмжээнд 0.3 буюу өндөр биш үзүүлэлттэй байгаа ч аймаг тус бүрээр харахад Улаанбаатар хот, Завхан, Говьсүмбэр аймгаас бусад аймагт 0.7 болон түүнээс дээш болон муу үзүүлэлттэй аймгууд олон байна (Хавсралт 2.3.1).

¹² Ministry of Economic Development, Fifth National Progress Report 2013

¹³ ЖАЙКА, Жендерийн мэдээлэл бэлтгэх судалгаа Монгол улсын тайлан 2013 он 12 сар

Хүснэгт 2.3.6 Жендэр

Country	Gender Development Index	Human Development Index (HDI)		Life expectancy at birth		Expected years of schooling		Mean years of schooling		Estimated gross national income per capita (2011 PPP \$)		Gender Inequality Index	Maternal mortality ratio	Share of seats in parliament	Labour force participation rate (% ages 15 and older)		Suicide rate (per 100,000 people)	
	Value	Female (F)	Male (M)	F	M	F	M	F	M	F	M	Value	(deaths per 100,000 live births)	(% held by women)	F	M	F	M
	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2014	2013	2014	2013	2013	2012	2012
Mongolia	1.028	0.737	0.716	73.9	65.3	15.3	13.9	9.5	9.0	9,029	12,462	0.325	68	14.9	56.6	69.3	3.7	16.3
High human development	0.954	0.724	0.758	77.4	72.8	13.8	13.4	7.7	8.5	10,407	17,443	0.310	41	20.6	57.0	77.2	6.4	10.3
Developing countries	0.899	0.617	0.686	71.7	68.0	11.6	11.9	5.4	7.3	5,926	12,178	0.478	225	20.2	49.5	78.7	8.3	13.4
East Asia and the Pacific	0.948	0.692	0.730	76.0	72.2	13.0	12.8	6.9	8.0	9,017	13,780	0.328	72	18.7	62.6	79.4	7.3	7.3

Эх сурвалж: Хүний хөгжлийн талаарх 2015 оны тайлан

(2) Нийтийн үйлчилгээ үйлчилгээний одоогийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд

Нийтийн үйлчилгээ үйлчилгээний тухайд эрүүл мэнд, боловсролын салбараас гадна холбооны дэд бүтцийн талаар тоймлов (Хүснэгт 2.3.7).

10 мянган хүн тутамд 28 эмч оногдож байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөр улсуудаас (18 эмчээр илүү) үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн салбарын зардал дотоодын нийт бүтээгдхүүний 6%-г эзэлж байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөр улсуудтай ижил түвшинд байгаа ч дэлхийн дундаж 10%-тай харьцуулахад доогуур түвшинд байна.

Бага дунд боловсролын мэргэшсэн багшийн эзлэх хувь 100%, нэг багшид 28 сурагч ноогдож байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөр орнууд болон Зүүн Ази, Номхон далайн орнуудтай (19 хүүхэд) харьцуулахад олон. Боловсролын салбарын зардал ДНБ-ийн 6%-ийг эзэлж байгаа нь дээрх орнуудын дундаж 5%-аас илүү байна.

Интернет хэрэглэгчдийн тоо 27%, хүний хөгжлийн түвшин өндөр орнууд болон Зүүн Ази, Номхон далайн орнуудтай(40%) харьцуулахад доогуур түвшинд байна. Гар утас эзэмшигч 100 хүн тутамд 105 буюу нэг хүнд нэгээс илүү ноогдож байна.

Хүснэгт 2.3.7 Нийтийн үйлчилгээ

Country	Health		Education			Communication	
	Physicians	Public health expenditure	Primary school teachers trained to teach	Pupil-teacher ratio, primary school	Public expenditure on education	Internet users	Mobile phone subscriptions
	(per 10,000 people)	(% of GDP)	(%)	(number of pupils per teacher)	(% of GDP)	(% of population)	(per 100 people)
	2001–2013	2013	2008–2014	2008–2014	2005–2014	2014	2014
Mongolia	27.6	6.0	100	28	5.5	27.0	105.1
High human development	17.6	6.2	95	19	4.9	49.8	104.6
Developing countries	10.3	5.6	84	27	4.7	31.9	91.2
East Asia and the Pacific	12.2	5.3	..	19	4.9	42.1	100.5
World	13.8	9.9	..	25	5.0	40.5	96.2

Эх сурвалж: Хүний хөгжлийн тайлан 2015он

Улаанбаатар хотоос гадна томоохон хот байхгүй шалтгаанаас хөдөө орон нутаг дахь боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээний тал дээр асар зөрүү үүсч байгаа бөгөөд үүнээс шалтгаалан Улаанбаатар хотод хүн ам төвлөрч байна. Социалист нийгмийн үед нийтэд үзүүлэх үйлчилгээ, нийтийн үйлчилгээний байгууламжийг нэгэн тэгш байдлаар хөгжүүлж ирсэн. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш тухайн бүс нутгийн хүн амын давхаргад тохируулах байдлаар байгуулж буй хэдий ч засвар үйлчилгээний зардал өндөр зэргээс шалтгаалан барилга байгууламж хуучирч муудах зэргээр нийтэд үзүүлэх үйлчилгээний түвшин маш муу нөхцөлтэй байна.

Хөдөө орон нутагт иргэдийг тогтвор суурьшилтай амьдрахад нэн тэргүүнд иргэдэд үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, чанарыг сайжруулах нь чухал хэдий ч өргөн уудам газар нутагт хүн ам хамгийн цөөнөөр тархан суурьшсан одоогийн нөхцөлд бүх орон нутагт иргэдэд үзүүлэх үйлчилгээг тэгш байдлаар хүргэх нь хүндрэлтэй . Иймд хүн амын тоогоор 2,3т орох Эрдэнэт, Дархан болон аймгийн төвүүдэд үе шаттайгаар иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүргэх, сайжруулах нь цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын нэг юм.


2.4 Тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих стратеги бүхий аж үйлдвэрийн салбын өнөөгийн байдал болон тулгарч буй асуудал

(1) Аж үйлдвэрийн бүтцийн онцлог

1) ДНБ-ний бүтэц

Монгол улсын аж үйлдвэрийн салбар нь ДНБ-ний 17% байдаг ба уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай. ХАА салбар 13.5%-гаар удаалж, уул уурхай, ХАА салбар нийлээд ДНБ-ний 30% эзэлдэг. Аж үйлдвэрийн салбарын суурь тогтоц харьцангуй сул, 2014 оны ДНБ-д эзлэх хувь дөнгөж 8% байна.(Зураг 2.4.1)

Аж үйлдвэрийн салбарын суурь тогтоцыг хөрш зэргэлдээ хуучин социалист улс онуудтай харьцуулахад Киргизстан 13,1%, Казахстан 10,3% -аас доогуур сул үзүүлэлттэй байна.(Хүснэгт 2.4.1)



Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хороо

Зураг 2.4.1 Үйлдвэрлэлийн салбар тус бүрээр ДНБ-ний бүтэц (2014он)

Хүснэгт 2.4.1 Үйлдвэрлэлийн салбар тус бүрээр ДНБ-ний бүтэц (2014он)¹⁴


	Мьянмар	Ветнам	Камбож	Киргизстан	Казахстан	Монгол	Тайланд	Индонез	Япон	Хятад	Австрали
ХАА	27.9%	18.1%	28.7%	14.8%	4.2%	14.2%	10.5%	13.4%	1.2%	9.5%	2.4%
Уул уурхай	7.3%	11.3%	1.1%	0.6%	15.6%	16.8%	3.7%	9.8%	0.1%	4.4%	8.3%
Үйлдвэрлэл	19.9%	17.5%	15.3%	13.1%	10.3%	8.9%	27.7%	21.0%	18.4%	29.9%	6.4%
Барилгаа	5.8%	5.3%	8.5%	7.4%	6.1%	5.2%	2.6%	9.9%	5.8%	7.0%	7.9%
Худалдаа	18.7%	13.6%	14.4%	17.4%	16.2%	10.8%	13.9%	0.0%	14.4%	9.8%	8.4%

Эх үүсвэр : "Statistics Data Base", ADB

¹⁴Японы 2013 оны үзүүлэлт, БНХАУ-ын уул уурхай, үйлдвэрлэлийн үзүүлэлт нь 2009 оны үзүүлэлтээр 2014 оны дүнг үнэлэн орлуулж тооцсон.

2) Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн хүн ам


2014 оны байдлаар 15 наснаас дээшхи хөдөлмөрийн насны хүн ам 1.11 сая байна. Үүнийг аж үйлдвэрийн салбар (ХАА, үйлдвэрлэл, үйлчилгээ) тус бүрээр авч үзэхэд, 2014 онд ХАА салбарт 28%, түүний дараа худалдааны салбарт 15.3%, үйлдвэрлэлийн салбарт 7.7%, ДНБ-ний эзлэх хувь хамгийн өндөр (17.1%) уул уурхайн салбарт 3.7% гэсэн бүтэцтэй, ДНБ-ний бүтэцтэй харьцуулахад ажил олголт урвуу харьцаатай буюу доогуур үзүүлэлттэй байх магадлалтай байна (зураг 2.4.2).



Эх сурвалж: Монголын үндэсний статисткийн хороо

Зураг 2.4.2 ДНБ бүтэц үйлдвэрлэл тус бүрээр(2014 он)

2000 оноос 2014 он хүртэлх 15 наснаас дээшхи хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийг харахад, 400 мянга байсан ХАА салбарт хөдөлмөр эрхлэгчийн тоо 300 мянга болон буурч, худалдааны салбар 80 мянга байснаас 170 мянга болон нэмэгдсэн байна. Уул уурхайн салбар 2000 оны дундуур 40 мянга болсноос хойш, бараг ижил түвшинд байна. 2012 оны өсөлтийн нөлөөгөөр 2013 онд хэсэг хугацаанд 50 мянган хүн болсон хэдий ч 2014 онд 40 мянга руу буурсан байна (зураг 2.4.3).




Эх сурвалж: Монголын үндэсний статисткийн хороо

Зураг 2.4.3 15-аас дээш насны хөдөлмөр эрхлэгчдийн өсөлт (2000-2014 он)

3) Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын бүтэц

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын нийт борлуулалтын хэмжээг авч үзэхэд, 40% дээш хувийг хүнсний бүтээгдэхүүний салбар эзэлж, түүний дараа кокс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн (18%), сүлжмэл бүтээгдэхүүн (12%), пластик, резин (8%) орсон байна. Монгол улсын үйлдвэрлэлийн салбарыг төлөөлөх ноолуур, ноос зэрэг сүлжмэл бүтээгдэхүүний эзлэх хувь одоо болтол доогуур үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн, эдгээр 4 салбар нь үйлдвэрлэлийн салбарын бараг 80% ийг эзэлж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн салбар мөн адил хэсэг салбараас хараат бүтэцтэй байгаа нь бас нэгэн онцлог гэж хэлж болно (зураг 2.4.4).




Эх сурвалж: Монголын Үндэсний Статисткийн Хороо

Зураг 2.4.4 Бүтээгдэхүүн тус бүрийн үйлдвэрлэлийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь (2014 он)

Үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээг авч үзэхэд, хүнсний бүтээгдэхүүний салбар гаргуу өсөлттэй байна. Хүнсний үйлдвэрлэл дундаа ялангуяа социалист нийгмийн үеийн хуучин үйлдвэрүүдийг үр дүнтэй ашиглаж, шинэчилж чадсан ус, ундаа үйлдвэрлэлийн салбар ихээхэн хувь нэмэр оруулж байна. Хүнсний үйлдвэрлэлийн дараа кокс, шахмал түлш орж байгаа, түүний дараагаар оёмол бүтээгдэхүүн, өнгөт төмөрлөг, төмөрлөгийн боловсруулалтын бүтээгдэхүүн эзэлж байна. Бусад салбарын хувьд 2005 оноос хойш үйлдвэрлэлтийн нийт хэмжээ 100 тэрбум төгрөгөөс дээш гараагүйв (Зураг 2.4.5).

Тоног төхөөрөмж-төмөрлөгийн салбарт дотоодын болон экспортын зах зээл хумигдмал байгаа учир, үйлдвэрийн хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүйд хүрэн, үйлдвэрлэлийн зогсонги байдал үргэлжилсээр байна. Мөн бусад хэрэглээний барааны хувьд ч экспортын бүтээгдэхүүн давамгайлж, дотоодын үйлдвэрлэлийн салбарын суурь тогтоц сул байна.




Эх сурвалж: Монголын Үндэсний Статисткийн Хороо

Зураг 2.4.5 Бүтээгдэхүүн тус бүрийннийтборлуулалтын хэмжээ

4) Импортын бүтэц

Монголын гадаад худалдааны дүнгээс харахад экспортын хувьд эдийн засгийн өсөлт хурдацтай байсан 2011 оноос 2012 оны ойролцоогоор 4.4~4.8 тэрбум ам.долларын хэмжээнээс нэлээд буурсан хандлагатай байгаа хэдий ч, 2014 онд ойролцоогоор 5.8 тэрбум ам.доллар хүртэл өсч, 2015 онд ойролцоогоор 4.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь Оюутолгойн уурхайн ашиглалт эхэлсэнтэй холбогдон зэсийн экспорт нэмэгдсэнтэй холбоотой юм. Нөгөөтэйгүүр, импортын хувьд 2012 онд ойролцоогоор 6.7 тэрбум ам.доллар байсан нь оргил үе болж, 2015 онд ойролцоогоор 3.8 тэрбум ам.доллар болтлоо буурсан үзүүлэлттэй байна (зураг 2.4.6). Монгол улс импортоос хараат байдалтай байдаг ба 2011 оноос энэ хандлага улам даамжирсан. 2014 оны гадаад худалдааны тэнцэл нэмэх байгаа хэдий ч, энэ нь импортыг орлох бүтээгдэхүүний үр дүнд гадаад худалдааны тэнцэл сайжирсан гэхээсээ эдийн засгийн уналтаас шалтгаалан импортын хэмжээ багассантай холбоотой гэж үзэж байна. Уул уурхай, барилгын салбарын уналтаас дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, машин тэрэг, барилгын материалын импорт их хэмжээгээр багассан нь импортын хэмжээ буурах гол шалтгаан болж байна.



Эх сурвалж: Монголын Үндэсний Статисткийн Хороо

Зураг 2.4.6 Импорт, экспортын хэмжээ, гадаад худалдааны тэнцэл


Гадаад худалдаа хийдэг голлох улсуудыг харахад, импортын хувьд БНХАУ-аас хэт хамааралтай, экспортын 90 хувийг БНХАУ эзэлж байна. Импортын хувьд ч бараг 30 гаруй хувийг БНХАУ эзэлж байгаа бөгөөд ОХУ мөн адил 30 аад хувийг эзэлж байна. Гадаад худалдааны тал дээр хөрш 2 орноос хараат бүтэцтэй байна (Хүснэгт 2.4.2).

Хүснэгт 2.4.2 Гадаад худалдааны бүтэц (сая ам.дол)

Unit: mil. USD	Экспорт		Импорт	
Total	5,774.3		5,236.7	
<i>China</i>	5,073.4	87.9%	1,767.9	33.8%
<i>United Kingdom</i>	398.7	6.9%	26.4	0.5%
<i>Russian Federation</i>	61.6	1.1%	1,549.3	29.6%
<i>Italy</i>	51.4	0.9%	45.3	0.9%
<i>Switzerland</i>	28.1	0.5%	9.1	0.2%
<i>Japan</i>	24.5	0.4%	367.8	7.0%
<i>USA</i>	15.4	0.3%	229.5	4.4%
<i>Germany</i>	15.0	0.3%	159.2	3.0%
<i>Singapore</i>	14.2	0.2%	52.8	1.0%
<i>South Korea</i>	13.5	0.2%	352.6	6.7%

Эх сурвалж: Монголын үндэсний статисткийн хороо


Бүтээгдэхүүн тус бүрээр гадаад худалдааны бүтцийг авч үзэхэд, экспортын хувьд уул уурхайн бүтээгдэхүүн зонхилж, нийт экспортын хэмжээний 90 гаруй хувийг эзэлж байна. Түүний дараа сүлжмэл, оёмол бүтээгдэхүүн ойролцоогоор 7%, ХАА гаралтай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн тус тус 2%-ийг эзэлж байна (зураг 2.4.7).



Эх сурвалж: Монголын Үндэсний Статисткийн Хороо

Зураг 2.4.7 Бүтээгдэхүүн тус бүрийн импортын бүтэц (2015 он)

Нөгөө талаас, импортын бүтцийг авч үзэхэд хамгийн их хэмжээг эзэлж байгаа нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн (38%), тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүн (34%) байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнд нефть хамгийн өндөр хувь эзэлж буй бөгөөд Монгол улс ашигт малтмал экспортлогч улс байхын зэрэгцээ эрчим хүч импортлогч улс гэсэн онцлогтой. Түүнчлэн, уул уурхайгаас бусад хүнсний боловсруулалтын салбар дээр ч импортын хэмжээ өндөр (9%) байна (зураг 2.4.8).




Эх сурвалж: Монголын үндэсний статисткийн хороо

Зураг 2.4.8 Бүтээгдэхүүн тус бүрийн импортын бүтэц (2015 он)

5) Үйлдвэрлэлийн салбарын бүс нутгийн онцлог

Үйлдвэрлэлийн салбарын гол онцлог нь хөдөө орон нутгийн ялгаа их, нэг газарт хэт төвлөрч буй явдал билээ. Нийслэл Улаанбаатар хотын бүсэд үйлдвэрлэлийн хэт төвлөрөл үүссэн байна. Улаанбаатарын бүсийн 2014 оны аж үйлдвэрийн салбарын нийт орлого 8.2 их наяд төгрөг байгаа нийт орлогын 74% ийг эзэлж байна. Үүний дараа Орхон аймаг 1.4 их наяд (Улаанбаатарын 1/6), Таван Толгой, Оюу Толгойн орд байрлах Өмнөговь аймаг 0.57 их наяд, Сэлэнгэ аймаг 0.35 их наяд, Дархан-Уул аймаг 0.17 их наяд, эдгээр 5 аймаг нийт орлогын 96.9% бүрдүүлж байгаа бөгөөд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан гэсэн 3 төв нийт Монгол улсын аж үйлдвэрийн салбарыг үүрч байна (Зураг 2.4.9).



Эх сурвалж: МҮСХ, Аж Үйлдвэрийн Яамны мэдээлэл дээр тулгуурлав

Зураг 2.4.9 Орон нутгийн аж үйлдвэр (боловсруулах) борлуулалтын хэмжээ, өсөлт

б) Үйлдвэрийн салбар дахь аж ахуйн нэгжийн онцлог

Монгол улсад бүртгэлтэй нийт 113,602 аж ахуйн нэгж байдаг ба үйл ажиллагааны чиглэл нь тодорхой буюу үйл ажиллагаа явуулж буй 59,843 аж ахуй нэгж байна. Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй 22,793 компани (38.1%), үйлдвэрлэлийн салбарт 4,996 компани (8.3%) үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутгаар нь үйлдвэрлэлийн онцлогоор авч үзэхэд мөн адил Улаанбаатарын бүсэд төвлөрч буй бөгөөд үйл ажиллагаа явуулж буй 37,124 компани (62%), Эрдэнэт, Дархан хотын тоог оруулбал нийт аж ахуйн нэгжийн 70% -ийг эзэлж байна (хүснэгт 2.4.3.)

Хэмжээгээр нь авч үзвэл, 50-аас доош ажиллагсадтай аж ахуйн нэгж хамгийн их буюу 58,019 (96.8%), 10 доош ажилтантай аж ахуйн нэгж 50,932 (85.1%) эзэлж байна.

Хүснэгт 2.4.3 Аж ахуйн нэгжийн бүтэц (2014 он)

by Sector (2014)	Бүртгэлтэй		Ү.А явуулж буй	
total	113,602	100.0%	59,843	100.0%
Agriculture, forestry and fishery, hunting	6,374	5.6%	3,409	5.7%
Mining and quarrying	945	0.8%	608	1.0%
Manufacturing	9,188	8.1%	4,996	8.3%
Electricity, gas and water supply	381	0.3%	297	0.5%
Construction	8,940	7.9%	4,770	8.0%
Wholesale & retail trade, repair, household goods	48,865	43.0%	22,793	38.1%
Hotels and restaurants	3,254	2.9%	2,018	3.4%
Transportat, storage and other business activities	5,063	4.5%	2,294	3.8%
Financial services	2,069	1.8%	915	1.5%
Real estate, renting and other business activities	11,642	10.2%	6,045	10.1%
Public administration and others	1,433	1.3%	1,433	2.4%
Education	3,598	3.2%	2,659	4.4%
Health and social work	3,472	3.1%	2,900	4.8%
Other community, social and personal services	8,353	7.4%	4,681	7.8%
Others	25	0.0%	25	0.0%

Эх сурвалж: Монголын үндэсний статисткийн эмхэтгэл 2014 "Statistics Year Book 2014",

Гадаад худалдааны хувьд уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн (голдуу нүүрс) экспортолж, үйлдвэрлэлийн салбарт түүхий эд, сэлбэг, барилгын салбарт барилгын материал, уул уурхайн салбарт нүүрс баяжуулах тоног төхөөрөмж зэрэг бараа бүтээгдэхүүн зонхилон импортын хараат байдалд байна. 2014 онд гадаад худалдааны орлого нэмэгдсэн харагдаж буй боловч, энэ нь уул уурхайн салбарын уналтаас хамаарч, томоохон хувийг эзэлж байсан уул уурхайн салбарын техник тоног төхөөрөмжийн импорт багассанаас үүдсэн үр нөлөө бөгөөд, аж үйлдвэрийн хөгжсөнөөр экспортын хэмжээ өссөн тоо биш гэж үзэж байн.

Импорт, экспортын онцлогыг улс тус бүрээр нь авч үзэхэд 2014 оны нийт экспортын 90% ийг Хятад улс эзэлж байгаагаас гадна импортын хувьд ч нийт хэмжээний 70% ийг Хятад (37.7%) болон ОХУ (27.6%) аас хараат байдалтай байна. Геополитикийн хувьд далайд гарцгүй, 2 том гүрний дунд байрлаж буй нь ихээхэн нөлөө үзүүлж буй билээ.

(2) Аж үйлдвэрийн стратегийн салбар (Төрөөс аж үйлдвэр талаар баримтлах бодлогод тусгагдсан стратегийн салбар)

1) Аж үйлдвэрийн бодлогын зорилт

2012 оны Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөр тархуу байсан жижиг дунд үйлдвэрийн салбар (Хөдөлмөрийн яам), хөнгөн аж үйлдвэрийн салбар (ХХААЯ) худалдааны салбар (ГХГЯ) зэрэг нь тухайн үеийн Аж Үйлдвэрийн Яаманд нэгдсэнээр аж үйлдвэрийн цогцоор хөгжүүлэх таатай орчин бүрдсэн. 2015 оны 6 сард Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого УИХ аар батлагдан, мөн 9 сард бодлогыг хэрэгжүүлэх эхний шатны үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Аж үйлдвэрийн бодлогод хүснэгт 2.4.4-т харуулсанчилан хууль эрх зүйн болон үйлдвэрлэл хөгжүүлэх орчинг бүрдүүлэх, технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг цогц байдлаар цаашдын чиглэлийг тусгасан бөгөөд ялангуяа хөдөө орон нутгийн нэгдсэн аж үйлдвэрийн хөгжил болон үйлдвэрийн төвлөрөл (кластер, үйлдвэрлэл, технологийн парк) болон түүний сүлжээ (тээвэр логистик)-д анхаарсан байна. Эдгээр нь Улаанбаатар хотоос бусад хөдөө орон нутгийн хотуудад үйлдвэрлэлийн давхарга нимгэн, түүнчлэн төвлөрүүлэн хөгжүүлсний үр ашиг бага, аж үйлдвэрийн салбар нийтдээ бүтээмж, үр ашиг муу байгаатай холбоотой. Мөн геополитикийн хувьд далайд гарцгүй тул далайн ачаа тээвэрлэлтийг хөрш ОХУ, Хятад улсаар дамжин тээвэрлэхээс өөр аргагүй, гадаад худалдааны тээвэрлэлтийн зардал өндөр, ялангуяа экспортын тал дээр харьцангуй давуу тал дутмаг бүтэцтэй. Энэ нь уул уурхайн салбараас бусад аж үйлдвэрийн салбарын гадны шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн саад учруулж байна. Үр ашигтай тээвэр логистикийн сүлжээ нь бүс нутгийн аж үйлдвэрийн төвлөрлийг бодитоор уялдуулахын зэрэгцээ тээврийн зардлыг багасгах чухал суурь болно.

Хүснэгт 2.4.4 Аж үйлдвэрийн хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилт (2015 он 6 сард УИХ-аар батлагдсан)

1. Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх ;
2. Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон Монгол улсын аж үйлдвэрийн нэгдсэн зураглалыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах ;

3. Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх ;
4. Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих ;
5. Дэвшилтэт техник, технологи, иновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих ;
6. Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
7. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчинг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх

Эх үүсвэр : Монгол Улсын Их Хурлын 2015 оны 62-р тогтоолын хавсралт

2) Тэргүүлэх чиглэл

Аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх салбар болгон "Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн", "Уул уурхайн боловсруулах салбарт" анхаарал хандуулан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгон, аж үйлдвэрийг төрөл зүйлийн (diversification) ач холбогдлыг тодорхойлсон. Үүнтэй уялдуулан салбар тус бүр дээр дээрх тэргүүлэх салбарын бүс нутгийн онцлог, аж үйлдвэрийн салбар, хэмжээ, төвлөрөл, логистик талаас хөгжлийн арга хэмжээ, чиглэлийг тусгасан. (Хүснэгт 2.4.)

Хүнэгт 2.4.5 Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ (2015 он 6 сард УИХ-аар батлагдсан)

1. Аж үйлдвэрийн хөгжлийн бүс тус бүрчлэн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлно ;
2. Хүнд, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх стратеги боловсруулна ;
3. ХАА, уул уурхайн нөөц баялгийг дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар хөгжүүлэх ;
4. Түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх систем, бүтээгдэхүүний борлуулалт, тээвэр логистикийн сүлжээг кластерийн системтэй уялдуулан хөгжүүлнэ ;
5. Кластер, чөлөөт бүс, үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх байршил, жагсаалтыг батлан, хэрэгжүүлэх ;
6. Газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрүүдийг цогцоор нь барьж байгуулах


Эх үүсвэр : Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого

3) Бүс нутгийн тэргүүлэх салбар

Бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн чиглэлийн хувьд, аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх салбарыг 5 бүс 27 нутгаар 19 аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын ач холбогдлоор тодорхойлж байна. Бодлын хувьд орон нутгын хэвтээ тэнхлэгээ аж үйлдвэрийн салбарыг босоо тэнхлэгтэй матрицийн дунд байрлуулсан байгааг нэдсэн хүснэгтийн 2.4.10-т үзүүлэв. Энэхүү нэгдсэн хүснэгтээс ХХА-н салбар нь орон нутгийн онцлогоос хамаарч байгаа хэдий ч ерөнхийдөө хөрөнгө оруулалтыг дэмжих хандлагатай, уул уурхайн боловсруулах үйлдвэрийн тухайд хөрөнгө оруулалтыг хязгаарлах бүс нутаг болон дэмжих бүс нутгийг тодорхой бүсчлэн тусгаж өгсөн нь онцлог юм.

ХАА-н салбар нь дотоодын зах зээлтэй шууд холбогдохоос гадна ОХУ-ын зах зээл рүү гаргах боломж өндөртэй ба Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ аймгуудын нутаг хөгжлийн гол бүс нутаг болох бөгөөд, ХАА-н үйлдвэр, технологийн парк (Agro Industrial Technology Park) байгуулах тэргүүлэх бүс нутгаар сонгогдсон Хатгал, Эрдэнэмандал сумдад анхаарал хандуулан, сайн чанарын ноос, ноолууртай Хангайн бүсийн хувьд арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэлийн тэргүүлэх бүс нутаг болох нь харагдаж байна

「Уул уурхайн боловсруулах үйлдвэр」ийн тухайд аж үйлдвэрийн парк байгуулахаар төлөвлөгдөж буй Ховд, цаашид тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангах зорилгоор уул уурхайн үйлдвэрлэлийг төрөлжүүлэхэд (diversification) ач холбогдол бүхий Эрдэнэт, Дархан, Оюу-Толгойн төсөл хэрэгжиж буй Өмнөговь, хойноос урагш чиглэсэн тэнхлэгийн огтлол цэг болох Чойр, Өвөр Монгол, ОХУ-тай харилцах тулгуур болох Чойбалсанд чухал ач холбогдол өгч байгааг харж болно.



Эх үүсвэр: Монгол улсын Аж Үйлдвэрийн Яам

Зураг 2.4.10 Аж үйлдвэрийн талаарх бодлого дахь хөгжлийн бүс, тэргүүлэх салбар

4) Аж үйлдвэрийг төвлөрүүлэн хөгжүүлэх чиглэл

Аж үйлдвэрийн бодлогод, төлөвлөгдөн хэрэгжиж буй аж үйлдвэрийн парк, чөлөөт бүс (FTZ : Free Trade Zone) дээр ХАА н боловсруулах үйлдвэрлэлийг төвлөрүүлэн хөгжүүлэх зорилготой ХАА-н үйлдвэр, төхнологийн парк (Agro Industrial Technology Park) байгуулахаар¹⁵ төлөвлөгдсөн. ХАА-н үйлдвэрлэл, төхнологийн парк нь газар тариалангийн бүтээгдэхүүн (хүнсний ногоо), арьс шир, ноос, ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний 4 төрлийн боловсруулах салбарыг нэг дор төлөвлөснөөр бүтээмжийг нэмэгдүүлэх, логистикийн хүртээмжийг дээшлүүлэхийг зорьж байна. Одоогоор 40 гаруй газар сонгогдсон байгаагаас 8 газрыг тэргүүн ээлжинд төлөвлөж байна.

¹⁵ ХАА-н үйлдвэр, төхнологийн паркийн төслийг анх ХХААЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэлтэс санаачлан, Эдийн Засгийн Хөгжлийн Яамаар дамжин, одоогийн Аж Үйлдвэрийн Яам төрөөс Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогод тусгаж цогцоор төлөвлөж байна.


ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк нь Монголын анхны хөдөө аж ахуйн парк болох бөгөөд улсаас дэд бүтцийн тал дээр дэмжлэг үзүүлэн хэрэгжүүлэх бодлоготой. Энэ нь ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжийн талд нэлээн их дэмжлэг болно. Гэхдээ 2015 оны хэрэгжилтийн явцаас харахад, төсвийн хүрэлцээнээс шалтгаалан төрөөс шууд дэмжлэг үзүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүрсэн. Тиймд, Засгийн газраас орон нутгийн хөгжлийн сан, сумын хөгжил, ЖДҮ-ийг дэмжих сан зэрэг тус тусын салбарын сангийн нийт 200 тэрбум төгрөгийг эдгээр суманд ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад зарцуулж болох эсэх талаар арга замыг хайж байна. Эдгээрээс харахад, ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркард үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн хувьд газрын төлбөрөөс чөлөөлөх зэрэг бодлогын дэмжлэгээс гадна, үндсэн дэд бүтэц, тоног төхөөрөмж шинэчлэх, технологийн дэмжлэг үзүүлэх, шинэ старт-ап бизнесийг дэмжих зэрэг сумын хэмжээнд ойролцоогоор 50 тэрбум төгрөг эдгээр сангаар дамжуулж дэмжлэг авах боломжтой. Одоогоор хэд хэдэн аж ахуйн нэгж паркард үйл ажиллагаа явуулах хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд барилгын ажилдаа орсон газар байна¹⁶.

Зураг 2.4.11-т хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний төвлөрлийг өнгөөр ялгасан байгаа бөгөөд ногоон, шараар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нөөц ихтэй газруудыг тэмдэглэсэн. ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк (тэргүүлэх 8 газар) хөдөө аж ахуйн нөөц бололцоо ихтэй бүс нутагт байршуулахын хамт зүүн баруун бүсийг холбосон корридорын дагуу байрлаж байгааг харж болно.

Мөн чөлөөт худалдааны бүс (FTZ), аж үйлдвэрийн паркийн зүүн баруун бүсийн, өмнөд хойд бүсийн корридор дагуу төлөвлөгдөж байгаа бөгөөд, баруун бүсийн Ховд тэргүүтэй баруун бүсийн эдийн засгийн бүс нутгийг хамруулж байна. Мөн Өмнөговь аж үйлдвэрийн паркийг Таван Толгой, Оюу Толгойн орд газруудыг түшиглэсэн хөгжлийг багтаахын хамт, Улаанбаатар, Өмнөговь, Гашуунсухайтыг холбосон шинэ маршрутын төв цэг болгох асуудал хамрагдсан байгаа.

Иймэрхүү маягаар, тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарын төвлөрлийн талаар ч, бүс нутгийн хөгжлийн тухайд ч бодлогод тусгагдсан байна

¹⁶ Хутаг-Өндөр суманд, дунд оврын мах боловсруулах үйлдвэр орох хүсэлтээ илэрхийлж, орон нутгийн жижиг оврын мах боловсруулах үйлдвэрүүд мөн бэлтгэл ажилдаа ороод байгаа. Түүнчлэн, үүнтэй уялдан паркартай хамтрах эрчимжүүлсэн мал аж ахуйн фермийн туршилт эхэлсэн, нутгийн малчид оролцож байна. Эрдэнэмандал суманд паркийн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүлээлгүй, мах боловсруулах үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна.



- ХАА үйлдвэр технологийн паркийн эхний ээлжинд хэрэгжүүлэх 8 байршил
- бусад 32 байршил

Эх үүсвэр : Аж үйлдвэрийн яамны мэдээллээс бэлтгэв

Зураг. 2.4.11 ХАА үйлдвэр, технологийн парк, аж үйлдвэрийн парк, чөлөөт бүсийн байршил

ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн нэн тэргүүнд хэрэгжүүлэх байршлын тухайд, аж үйлдвэрийн бодлого боловсруулах үед нийт орон даяар (сумын хэмжээнд) хийгдсэн судалгааны үр дүн болох хүн амын хэмжээ, малын тоо толгой, хүнсний боловсруулах үйлдвэрийн тархалт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж зэрэг статистикийн тоо, мэдээллийг ойролцоогоор 40 төрлийн газрын зургийг орон зайн мэдээлэлд (GIS) буулгаж боловсруулалт хийсэн байна. Тэрхүү мэдээллээс хамгийн тохиромжтой хэсгийг тэргүүлэх байршлаар сонгон, бүх орон нутгийн төв (аймаг, сум) дээр хэлэлцүүлэг, судалгаанд (хуучин Аж үйлдвэрийн яамны ажилтнууд өөрсдөө хийсэн) тулгуурлан, эцсийн байдлаар 8 байршлыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх газраар сонгосон¹⁷(Хүснэгт 2.4.6).

¹⁷ 2016 оны 3 сард, хуучин Аж үйлдвэрийн яамны хариуцсан газар бүх сумдад нэмэлт судалгаа явуулсан. Орон нутгийн түвшинд, аймаг, сум мөн бусад хэрэгжүүлэгч байгууллага байгуулах замаар, санаачлагатай 10 байршлыг сонгон тэргүүлэн хөгжүүлэхээр болоод байна.

Хүснэгт 2.4.6 ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн тэргүүлэх 8 байршил

Д/д	Аймаг	Сум	Санаачлага гаргагч	Үйлдвэрлэлийн чиглэл	Тухайн сумын онцлог	Паркийн хэмжээ
1	Архангай	Эрдэнэмандал	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Мах, сүү, хүнсний ногоо боловсруулах, арьс ширний анхан шатны тордолт, хаан түүхий эдийн агуулах	Монгол Улсын хамгийн олон малтай сумын нэг, мах, ноос сайтай хонь ихтэй, хивсний томоохон үйлдвэрүүд түүхий эдээ авдаг. Ус сайтай. Инженерийн дэд бүтцийн хангамж муу.	Жижиг ХААҮТП Ойр.5 га газар /40 сумын нэг/
2	Булган	Хутаг-Өндөр	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Мах, сүү, хүнсний ногоо боловсруулах, арьс ширний анхан шатны тордолт, хаан түүхий эдийн агуулах	Газар тариалан хөгжсөн, гурилын үйлдвэртэй, хүнсний ногоо их тарихаг, УБ-Хөвсгөл аймгийг холбосон автозам дайран өнгөрдөг. Ус сайтай. Инженерийн дэд бүтцийн хангамж дунд зэрэг.	Жижиг ХААҮТП Ойр.5 га газар /40 сумын нэг/
3	Завхан	Тосонцэнгэл	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Хөнгөн үйлдвэр, мах, сүү, хүнсний ногоо боловсруулах, арьс ширний анхан шатны тордолт, хаан түүхий эдийн агуулах	Төлөвлөгөөт эдийн засгийн үед модны үйлдвэртэй байсан. Инженерийн дэд бүтцийн хангамж дунд зэрэг.	Жижиг ХААҮТ Ойр.5 га газар /40 сумын нэг/
4	Хөвсгөл	Хатгал	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Цагаан идээ, цай, жимс жимсгэнэ, загас боловсруулах, аялал жуулчлалтай холбоотой жижиг үйлдвэрлэл	Хөвсгөл нуурыг дагасан аялал жуулчлал хөгжсөн сум. Жимс жимсгэнэ, мөөг, ургамлын цай, эмийн ургамлын түүхий эд элбэгтэй, загас утах, лаазлах, цаа бугын арьсаар хийсэн гутал, цүнх зэрэг орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй. Ус сайтай. Инженерийн дэд бүтцийн хангамж дунд зэрэг.	Жижиг ХААҮТП Ойр.5 га газар /40 сумын нэг/
5	Төв	Баянчандмань	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Малын тэжээл, бордоо, мах, сүү, хүнсний ногоо, фермерийн аж ахуй	УБ-т ойр нийслэл рүү хүнсний ногоо, өндөг нийлүүлдэг, Замын-Үүд-Алтанбулагын автозамын босоо тэнхлэг дээр байрладаг. Инженерийн дэд бүтцийн хангамж сайн.	Том ХААҮТП Ойр.500 га газар /40 сумын нэг/
6	Төв	Жаргалант	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Хүнсний ногоо, сүүний ферм.	Төмс, хүнсний ногооны томоохон сангийн аж ахуй байсан. Хүнсний ногоогоо УБ, Дархан, Сэлэнгэ рүү худалдаалдаг. Сүүний үйлдвэртэй. Ус сайтай. Инженерийн дэд бүтцийн хангамж сайн.	Дунд зэрэг Ойр.200 га газар /40 сумын нэг/
7	Төв	Мандал	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Газар тариалан, гурилын үйлдвэр, хүнсний ногоо, сүүний ферм	Сэлэнгийн хамгийн их газар тариалан, хүнсний ногоо тариалдаг сум. Хүлэмжийн аж ахуйтай. Мөн сүүний чиглэлийн үнээний фермүүдтэй. Ус сайтай. Инженерийн дэд бүтцийн хангамж дунд зэрэг.	Том ХААҮТП Ойр.500 га газар /40 сумын нэг/
8	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалтын газар	Мах, арьс ширний анхан шатны тордолт, хаан түүхий эдийн агуулах	Үзэмчин үүлдрийн шилмэл омгийн хонь ихтэй. Малын бэлчээр, өвс сайтай. Бичигт боомтоор мах экспортлох боломжтой. Шүлхий өвчин гардаг муу талтай. Ус муутай. Инженерийн дэд бүтцийн хангамж муу.	Жижиг ХААҮТП Ойр.5 га газар /40 сумын нэг/

Эх сурвалж: хуучин Аж үйлдвэрийн яам

(3) Аж үйлдвэрийн хөгжилд тулгарч буй асуудал

Энэхүү судалгааны аж үйлдвэрийн хөгжлийн нэг хэсэгт аж үйлдвэрийн салбарыг бодит байдалд тулгуурласан асуудлыг тодруулах үүднээс Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим, СЕО клуб зэрэг эдийн засгийн төлөөлөл, төр, засгийн газрын холбогдох байгууллага, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй ярилцлага уулзалт зохион байгуулсан. Мөн судалгааны байгууллагатай хамтран нийт 160 компанитай шууд ярилцлагын аргаар асуулга судалгаа хийлээ. Судалгааны үр дүнг дор дурдлаа.

1) Ярилцлага уулзалтын дүн

Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим¹⁸, СЕО клуб¹⁹, мэргэжлийн холбоод²⁰, мөн хуучин Аж үйлдвэрийн яам, ХХААЯ зэрэг

¹⁸ “Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим” (MNCCI: Mongolian National Chamber of Commerce and Industry) : 1960 онд байгуулсан. 1990 оны эхээр ТББ болон ЖДҮ голлох аж үйлдвэрийн төлөөлөл байгууллага болон шийнчлэгдсэн. Одоо дотооддоо 19 салбартай. 800 гаруй гишүүн аж ахуйн нэгжтэй. 34 салбарт зөвлөлтэй (council), үйл ажиллагаа явуулдаг.

¹⁹ 2014 онд МХАҮТ ээс тусгаарлан, томоохон аж ахуйн нэгжүүд голлож байгуулсан. Петровис, MCS,

холбогдох төрийн байгууллагатай уулзаж, ярилцлага судалгаа хийсний дүнд, уул уурхайн салбараас хэт хамааралтай бүтцээс ангижирч, "аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэх" асуудлын ач холбогдол, мөн түүний тулд "ХАА салбарын стратеги хөгжил" чухал байр суурьтай болохыг онцолж байсан. Ялангуяа, 60 сая гаруй тоо толгой малтай МАА-н баялгийг аж үйлдвэрийн салбарт оруулах асуудлыг чухалчилж авч үзэхэд, ноос, ноолуур болон арьс ширэн бүтээгдэхүүний хувьд Монголд байгаа асуудал бол "Түүхий эдийг зүй зохистой, тогтмол бэлтгэн нийлүүлэх" болон "бүтээмжийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх" ажлыг дэмжин, олон улсад өрсөлдөх чадвартай болгох асуудал чухал шаардлагатай байгааг онцолж байсан

i). Түүхий эд бэлтгэн нийлүүлэлтэд тулгарч буй асуудал

Ноос, ноолуур, арьс ширний салбарт хамгийн их тулгамдаж буй асуудал бол түүхий эдийг зардал, чирэгдэл багатайгаар тогтмол бэлтгэн нийлүүлэх явдал билээ. Ноос, ноолуурын холбоодоос гаргасан тооцоогоор 2000 оны эхээр ойролцоогоор 90 гаруй хувийг түүхий эдээр нь экспортолж байсан бөгөөд 2003 оноос Засгийн Газраас татаас, хөнгөлөлтийн шийдвэр²¹ гаргаснаар байдал нэлээн дээрдэж байхаа хэдий ч нийт түүхий эдийн 60 хувь нь нэмүү өртөг шингээгдээгүй шатандаа Хятад руу экспортлогдож, ээрсний дараа ноосон утас, ноосон даавуу, бөс даавуу болон эргээд импортоор орж ирэх нь олонтаа. Энэ нь нүүдлийн МАА зонхилсон Монгол улсын МАА салбарын онцлогоос шалтгаалан, байнга нэг газраас түүхий эдээ нийлүүлэх боломжгүй. Томоохон компаниудад ченжүүдтэй хамтран ажилладаг эсвэл өөрсдийн төлөөлөх агент хөлслөн ажиллуулан малчдаас шууд түүхий эд худалдан авч, анхан шатны боловсруулалт (угаах, ангилах) аас эхлэн хийдэг системтэй. Гэвч бусад компаниуд түүхий эдээ бэлтгэн нийлүүлэх асуудал хүндрэлтэй, шинээр анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр үйл ажиллагаа явуулах хэцүү.

Мэргэжлийн холбоод түүхий эд бэлтгэн нийлүүлэх систем (Арьс ширний холбоо 2000 агент гэрээгээр ажиллуулдаг) дан ганц аж ахуйн нэгж,

UFC зэрэг групп компаниуд голлох 29 гишүүнтэй.

²⁰ Бусад мэргэжлийн холбоодын хувьд, Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн холбоо (1997 онд байгуулагдсан, гишүүн 150 компанитай) Ноосны холбоо (гишүүн 360 компанитай), Хүнс үйлдвэрлэгчдийн холбоо (1991 онд байгуулагдсан, гишүүн 300 гаруй компанитай), мөн МҮХАЖТ-ийн зөвлөл (Хүнсний үйлдвэрлэлийн зөвлөл, Ноос, ноолуурын зөвлөл гм) зэрэгтэй уулзаж, санал солилцсон. Мөн хувийн хэвшлийн тухайд ноос, ноолуурын салбарын томоохон төлөөлөл болох Говь ХХК, Сор ХХК, Бэрэн ХХК-ы үйлдвэртэй танилцаж, уулзалт хийсэн.

²¹ Малчид тогтсон бэлтгэн нийлүүлэлтийн цэгт арьс шир, ноос, ноолуураа тушаасан тохиолдолд, хэмжээнээс хамаарч татаас төлөх тогтолцоо.

мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа хэмжээ хязгаартай, илүү их ашигтай, тогтмол байлгах асуудал тулгараад байна. Мөн түүнчлэн, цаашид үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, өндөр нэмүү өртөг шингээх тал дээр ч системтэйгээр дэмжлэг үзүүлэх хэрэгтэй, төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогод төлөвлөгдөж буй ХАА үйлдвэрлэл, технологийн паркийн санаа нь төвлөрөл болон анхан шатны боловсруулалтын үр дүнг нэмэгдүүлэх, төвлөрүүлснээр чанарын үзүүлэлт дээшлэх, нэгдсэн стандарт нэвтрүүлэх зэрэг асуудал анхаарал татаж байна. Цаашид үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээхэд үйлдвэрлэлийн тоноглол сайжруулах, тогтолцоо бий болгох хэрэгтэй бөгөөд техникийн хамтын ажиллагаа шаардлагатай байна.

ii). Бүтээмж дээшлүүлэх, нэмүү өртөг шингээхэд тулгарч буй асуудал

Үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээх тал дээр “технологи нэвтрүүлэх” болон “аж үйлдвэрийн хүний нөөцийн хөгжил” гол асуудал болоод байна. Одоо Монгол улсын ноолуурын салбарын үйлдвэрлэдэг утасны түвшин 26 микроны²² утас голлож, илүү чанартай 40 микрон, 50 микрон, 100 микроны нарийн утасны хэрэглээ их тул ихэнхийг Хятад улсаас импортоор авахаар өөр аргагүй байна²³. Мөн илүү их нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд утасны технологи (ноос, ноолууранд торгон утас хольж ээрсэн технологи, бөс даавууг самнах технологи зэрэг) нэхмэл эдлэлийн эсгүүрийн технологи зэрэг дээр нарийн технологи шаардлагатай. Аж үйлдвэрийн хүний нөөцийн хувьд, оёдлын технологи, тоног төхөөрөмжийн удирдлага ноу хаүд нэвтэрхий мэргэжлийн өндөр түвшний ажилтан, мэргэжилтэний хүрэлцээ дутагдалтай байгаа бөгөөд шинэ технологи нэвтрүүлэн, тоног төхөөрөмж суурилуулсан ч гаднаас мэргэжилтэн урихаас өөр аргагүйд хүрэх зэрэг үр ашиг буурах хандлагатай.

iii). ХАА салбарын шинэ бүтээгдэхүүн бий болгох (нэмүү өртөг шингээх)

Ноос, ноолуур, арьс ширний салбар дээр шинэлэг хөдөө аж ахуйн гаралтай боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой байгааг ч онцолж байсан. Жишээлбэл, чацаргана гэх мэт Монгол улсын хувьд харьцангуй ашигтай, онцлог бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн

²² микрон : утасны өргөн нарийныг илэрхийлнэ. 1 грамм ноосоор 1 м урт утас ээрэх бол 1 микрон гэж тооцно.

²³ Говь ХХК зэрэг томоохон компаниуд 100 микрон хүртэл утас гарган авч хүчин чадалтай, нийт салбарын хэмжээнд ижил түвшинд хүрээгүй.

бүтээгдэхүүн гэсэн үнэ цэнээс гадна боловсруулсан бүтээгдэхүүн (Омега 7²⁴) болгон нэмүү өртөг шингээх, мөн адил мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хувьд ч ингэний сүүнээс Омега 7 гарган боловсруулах, адуу, хонины эхэсээс пласента бүтээгдэхүүн (гоо сайхан, эрүүл мэндийн бүтээгдэхүүн) үйлдвэрлэх зэргээр хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын ач холбогдол их байгаа нь харагдаж байна.

Омега 7 (чацаргана, ингэний сүү), пласента боловсруулах зэрэгт бэлтгэн нийлүүлэлтийн асуудал хүнд ч эдгээр нь шинэ аж үйлдвэрийн салбар тул ашиг нэмэгдүүлэх тал дээр олон янзаар туршиж байна. Чацарганы хувьд UFC Group²⁵ зэрэг томоохон компаниуд хөл тавьж, тариалалтаас боловсруулалт хүртэл нэг дор үйлдвэрлэл явуулах боломжтой болж байгаа, одоогоор нийт 10 гаруй компани хамтран мэргэжлийн холбоо байгуулаад байгаа. Энэхүү салбарт олон улсад өрсөлдөх чадвартай болохын тулд чанарын түвшнээс гадна чацарганы ургац муу байгаа нь гол асуудал бөгөөд ургац, тариалалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Хятадын сорттой харьцуулахад ургацын хэмжээ бага, сайн чанарын сорт гаргах тал дээр технологийн эрэлт, шаардлага өндөр байна²⁶. Пласента боловсруулах тал дээр, гадаадын хөрөнгө оруулалттай гадны (Солонгос) компани эхэс нийлүүлэн бэлтгэх систем бий болгох тал дээр ажиллаж байна. Эдгээр шинэлэг бүтээгдэхүүн хөгжүүлэхийн зах зээлээ олох, бэлтгэн нийлүүлэлтийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

iv). Бусад салбараас ХАА салбарт хүч сорин, үйлдвэрлэлээ төрөлжүүлэх

ХАА-н салбарт бусад салбарын буюу уул уурхайн групп²⁷ компаний үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс улаан буудай тариалан, гурилын үйлдвэрлэлд шинээр орох, гадаадын хөрөнгө оруулалттай төмрийн үйлдвэрлэлийн компани²⁸ гурвалжин будаа тариалалт, үйлдвэрлэлтийг эхлүүлэх зэргээр, өөр салбараас ХАА-н салбарт хүчээ сорих хандлага ажиглагдаж байна. Энэ нь бизнесээ өргөжүүлэн, төрөлжүүлэх зорилгоос гадна ХАА-н боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийг өөрсдөө хийх зэрэг олон янз байгаа хэдий ч иймэрхүү

²⁴ Ханаагүй тосон хүчлийн төрөл. Сүүлийн үед эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүнд өргөн хэрэглэгдэх болсон.

²⁵ Хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг групп компани.

²⁶ Чацарганы Холбоо Ибараки мужтай технологийн хамтын ажиллагаа явуулахаар болсон.

²⁷ Жишээлбэл, Нүүдэлчин групп Эрдэнэт хүнс компанийг үүсгэн байгуулж, гурилын үйлдвэрлэл эхэлсэн.

²⁸ Жишээлбэл, Японы Мегатек компани Халх голын бүсэд гурвалжин будаа тариалж, гурвалжин будаа үйлдвэрлэж эхэлсэн.

хөрөнгийн шилжилт хөдөлгөөн нь цаашдын аж үйлдвэрийг төрөлжүүлэх асуудлыг түргэсгэхэд анхаарах хэрэгтэй асуудал бөгөөд ”ХАА болон боловсруулах салбарын үр ашигтай, үр бүтээлтэй хамтын ажиллагааг дэмжих” асуудал чухал ач холбогдолтой болоод байна.

v). Аж үйлдвэрийн төрөлжүүлэх бодлогод хувь нэмэр оруулах санаа

ХАА-н салбараас гадна, машин механизм, төмөрлөгийн салбарт “шинэ зах зээл нээх”, “гадаадын шууд хөрөнгө оруулалт”-ын эрэлт, хэрэгцээ их байна. Сэлбэг үйлдвэрлэдэг томхон үйлдвэр захиалга багассаны улмаас ихэнх тоног төхөөрөмж ашиглагдахгүй байдалтай байна. Энэхүү үйлдвэр нь хуучин социализмын үед бүрэн тоноглогдсон Монголдоо 2-г орохоор том үйлдвэр юм. Үүний учир нь, уул уурхайн салбарын уналтаас шалтгаалан сэлбэг үйлдвэрлэлийн зах зээл хумигдаж байгаа хэдий ч түүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд сэлбэг, тоног төхөөрөмжөө өөрсдийн улсаас авах эсвэл өөрсдийн нийлүүлэлтийн маршрутаас авах тохиолдол их, Монголын компаниас бараа үйлчилгээ нийлүүлэх явдал хязгаарлагдмал байгааг онцлон анхаарах хэрэгтэй. Уул уурхайн салбарт дотоодын сэлбэг хэрэгсэл нийлүүлэх ажлыг эхлүүлэх зэргээр бусад салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих шинэ зах зээл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түүнээс гадна, “технологи, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, төрийн хамтын ажиллагааг дээшлүүлэх тал дээр гарах асуудал”-ын хувьд, улсын чанартай судалгаа шинжилгээний хүрээлэнгийн тоног төхөөрөмж хуучирсан, ялангуяа хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих технологи, инкубаторын дэмжлэг дутмаг байгааг холбогдох хүмүүс онцолж байсан. Улсын судалгаа, шинжилгээний хүрээлэнд хонины нэхийг самнах машин шинээр үйлдвэрлэх, байгаль орчинд ээлтэй арьс шир будах технологи зэрэг дотоодын үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлэх, хамтын ажиллагааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой ажлууд хийгдэж байгаа хэдий ч бодит үйлдвэрлэлтэй бүрэн дүүрэн зохицож чадахгүй байна. Энэхүү техникийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгийн дэмжлэгээс гадна, мэргэжлийн технологийн дэмжлэг, хамтын ажиллагаа, төлөвлөлтийн асуудал зэрэг дээр гадны дэмжлэг, хамтын ажиллагаа шаардлагатай.

2) Ярилцлага судалгааны үр дүн

Өмнө дурдсанчлан, ярилцлага судалгааг Улаанбаатарын бүс, Дархан, Эрдэнэт зэрэг Төвийн бүс, Чойбалсан, Сайншанд зэрэг Зүүн бүсийн нийт 4 бүс, 15 салбар хамарсан 160 аж ахуйн нэгжийг сонгон явуулсан. Энэхүү судалгааг цөөхөн түүвэртэй хэдий ч зөвхөн үйлдвэрлэгч төдийгүй үйлчилгээний салбарыг оролцуулан нийт аж үйлдвэрийн холбогдох салбар нийтэд нь авч, бодит байдал болон тулгарч буй асуудлын учир шалтгааныг олох зорилгоор явуулсан. Тиймд анхнаасаа статистикийн анализ дүгнэлт гаргах зорилго байгаагүй, нийтэд нь ямар хандлагатай байгааг олж мэдэх зорилготой явуулсан. Эхний хэмжээнд 50 аж ахуйн нэгжээс ярилцлага авахаар төлөвлөж байсан. Гэсэн хэдий ч жишээлбэл, автоматаар бүх салбарын үйл ажиллагаа явуулж буй 59,800²⁹ аж ахуйн нэгжээс 100 аж ахуйн нэгж сонгон, санал авна гэдэг аж үйлдвэрийн бодит байдлаас зөрөх магадлал их байсан (түүвэр хэт цөөн), менежментийн дээд албан тушаалтнаас (гүйцэтгэх захирал) шууд ярилцлага авахгүй бол ач холбогдол багатай, зэрэг судалгааны аргачлалын тухайд гүйцэтгэгч судалгааны байгууллагатай сайтар хэлэлцээний эцэст шууд менежментийн топ албан тушаалтанаас хариулт авахаар түүвэр (нийт 150 аж ахуйн нэгж) сонгон, ярилцлага явуулсан. Нийт түүврийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад дурдсан байгаа, аль болох олон төрлийн салбар, бүс нутгийг хамруулахаар зорьсон (хүснэгт 2.4.7, 2.4.8).

Хүснэгт 2.4.7 Ярилцлага судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж

Бүс нутаг	ДНБ	Аж ахуйн нэгжийн эзлэх хувь	Судалгаанд хамрагдсан	
			Аж ахуйн нэгж	%
Улаанбаатарын бүс	61%	62%	123	77%
Хойд бүс (Дархан, Эрдэнэт)	11%	11%	18	11%
Зүүн бүс (Чойбалсан)	3%	2%	10	6%
Өмнөд бүс (Сайншанд)	2%	1%	9	6%
нийт	77%	76%	160	100%

Эх сурвалж: МҮСХ (ДНБ эзлэх хувь, үйл ажиллагаа явуулж буй нэгж)

²⁹ Үндэсний статистикийн хороо, 2014 он

Аж үйлдвэрийн салбар	ДНБ	Хамрагдсан аж ахуй нэгж	
		Аж ахуй нэгжийн тоо	Хувь хэмжээ
А. Хөдөө аж ахуйн салбар	14%	21	13%
Б. Уул урхайн салбар	18%	17	11%
В.Үйлдвэрлэл	11%	58	36%
Г. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын	2%	5	3%
Д. Цэвэр, бохир усан хангамж ариутгах байгууламж хог хаягдал	0%	5	3%
Е. Барилгын салбар	6%	7	4%
Ё. Жижиглэнгийн худалдаа, Авто машин, мотоцикл засвар	16%	8	5%
Ж. Тэвээр	4%	8	5%
З. Зочид буудал, нийтийн хоол	1%	7	4%
И. Улсын аюулгүй байдал, нийгэм хамгаалал	1%	3	2%
Й. Харилцаа холбоо	2%	2	1%
К. Банк санхүү, даатгалын салбар	4%	7	4%
Л. Бусад үйлчилгээний салбар	3%	6	4%
М. Боловсрол	4%	3	2%
Н. Элүүл мэнд, нийгмийн салбар	2%	3	2%
Нийт	88%	160	100%

Эх сурвалж:ЖАЙКА ийн судалгааны баг

Хүснэгт 2.4.8 Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн салбар³⁰

(i) Судалгааны үр дүнгийн ерөнхий тойм

Монгол улсын ирээдүйн хөгжлийг төсөөлөн, бодит аж үйлдвэрийн хөгжлийг бий болгохын тулд одоо тулгамдаж буй ямар асуудалд түлхүү анхаарах, түүний үндсэн чиг хандлагыг тодорхойлох нь энэхүү судалгааны гол зорилго билээ. Тиймд “хүний нөөцийг хөгжүүлэх”, “хөрөнгө, санхүүгийн асуудал”, “технологи, тоног төхөөрөмж”, “түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт”, “төрийн бодлого, тогтолцоо” гэсэн 5 асуудлыг голлож судалгаа явуулсан.

Судалгааны дүнд, бүх салбарт нийтлэг тулгамдаж буй асуудлаар, хүний нөөц хүрэлцээгүй, “хөрөнгө, санхүүгийн асуудал” тодорсон. Хүний нөөц хүрэлцээгүй асуудал дээр ажиллагсадын а) хувийн зохион байгуулалт, хариуцлага сул, б) ур чадвар дутмаг, в) ажлын байрны тогтворгүй байдал зэрэг асуудал тавигдсан (зураг 2.4.12)


³⁰Салбарын төрлийг аль болох ISIC (International Standard Industrial Classification) –ийн төрөл, ангилалд нийцүүлэн тогтоосон.

Мөн хөрөнгө, санхүүгийн хувьд г) зээлийн хүү өндөр гэсэн хариулт хамгийн их байсан ба түүний дараа д) зээлийн хугацаа богино, е) зээлийн нөхцөл хатуу зэрэг асуудал орсон байна (зураг 2.4.13).



Эх сурвалж:Ярилцлага судалгааны үр дүнгээс


Зураг 2.4.12 Хүний нөөцтэй холбогдох асуудал



Эх сурвалж:Ярилцлага судалгааны үр дүнгээс

Зураг 2.4.13 Хөрөнгө, санхүүтэй холбогдох асуудал


“Шинэ технологи нэвтрүүлэх” тал дээр судалгаанд томоохон компаниуд олноор хамрагдсан байснаас гадна, үйлчилгээний салбарын хувьд технологи нь хүний нөөцийн ур чадвартай холбогдох тул, нийт үр дүнгээс харахад одоо байгаа техник технологи, тоног төхөөрөмж асуудалгүй мэт харагдаж байна. Гэвч, тус тусын ярилцлагаас харахад, ялангуяа ЖДҮ-ийн салбарт ”технологи, тоног төхөөрөмжийн элэгдэл” болон ”шинэ технологи нэвтрүүлэх эрэлт, хэрэгцээ” зэрэг онцолж байсан (зураг 2.4.14)



Эх сурвалж: Ярилцлага судалгааны үр дүнгээс

Зураг 2.4.14 Технологи, тоног төхөөрөмжийн асуудал

Эцэст нь Төрөөс үзүүлэх дэмжлэг, тогтолцооны хувьд төрийн байгууллагын хүнд суртал, бодлого, хуулийн тогтолцоо сайжруулах асуудал хамгийн их анхаарал татаж байгаа үр дүн гарсан. Эдгээр нь ерөнхийдөө төр, засгийн тодорхой бодлого, тогтолцооны эрэлт, найдлага өндөр байгааг харуулж байна (зураг 2.4.16)




Эх сурвалж: Ярилцлага судалгааны үр дүнгээс

Зураг 2.4.15 Түүхий эд бэлтгэн нийлүүлэхтэй холбогдох асуудал

Эцэст нь Төрөөс үзүүлэх дэмжлэг, тогтолцооны хувьд төрийн байгууллагын хүнд суртал, бодлого, хуулийн тогтолцоо сайжруулах асуудал хамгийн их анхаарал татаж байгаа үр дүн гарсан. Эдгээр нь

ерөнхийдөө төр, засгийн тодорхой бодлого, тогтолцооны эрэлт, найдлага өндөр байгааг харуулж байна (зураг 2.4.16).



Эх сурвалж: Ярилцлага судалгааны үр дүнгээс

Зураг 2.4.16 Төрийн бодлоготой холбогдох асуудал

Дээрх судалгааны үр дүнд тулгуурлан, Монголын аж үйлдвэрийн хөгжлийн асуудлыг нэгтгэн үзэхэд хүний нөөцийн хөгжил, санхүү хөрөнгийн эрэлт хэрэгцээ өндөр, хүний нөөцийн тал дээр салбарт хэрэгтэй технологи, тусгай ур чадвар эзэмшсэн хүний нөөц, санхүүгийн тал дээр хөрөнгө оруулалтын зорилгод нийцсэн дэмжлэг хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн асуудлаас, нийлүүлэлтийн гинжин хэлхээний тогтолцоог бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх хэрэгтэй байгаа нь тодорхой болсон бөгөөд, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэх асуудалтай хамтруулан шийдэх нь чухал байгаа нь харагдаж байна. Цаашид эрүүл бизнесийн орчинг бий болгохын тулд, тогтолцоог нь бэхжүүлэх, урт хугацааны үзэл баримтлалд нийцсэн нэгдсэн төрийн бодлого туйлын шаардлагатай байна

3) Аж үйлдвэрийн хөгжлийн асуудлын тойм

Өмнө дурдсанаар, аж үйлдвэрийн онцлог, бодит байдал, аж үйлдвэрийн хөгжлийн бодлого, ярилцлага, судалгааны үр дүнд тулгуурлан, аж үйлдвэрийн салбарын хөгжилд шийдвэрлэвэл зохих асуудлыг дор нэгтгэн тоймлов.

Хүснэгт 2.4.9 Аж үйлдвэрийн хөгжилд тулгарч буй асуудал

А. Аж үйлдвэрийн салбар нийтэд холбогдох асуудал

- а) Тодорхой нэг салбар, бүс нутгаас хараат аж үйлдвэрийн бүтэц (аж үйлдвэрийн сул бүтэц, үр ашиггүй байршил (тархалт))
- б) Импортоос хараат байдал түүхий эд, сэлбэг, өргөн хэрэглээний бараа)
- в) Уул уурхайгаас бусад салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал байдал (тээврийн зардал, сэлбэг хангамж)
- г) Хүний нөөцийн дутагдал (хувийн зохион байгуулалт, ур чадвар, мэргэжлийн ноу хау)
- д) Санхүүгийн дэмжлэг (зээлийн хүү өндөр, хугацаа богино, нөхцөл хатуу)

Б. Тэргүүлэх салбарын хөгжлийн асуудал

- а) Хаа болон боловсруулах салбарын хамтын ажиллагаа (уялдаа) хангалтгүй (үр дүнтэй түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлт хүндрэлтэй)
- б) олноор нь хямд зардлаар үйлдвэрлэх үйлдвэрлэл хоцорсон, нийлүүлэлтийн гинжин хэлхээ бэхжээгүй (бүтээмж, технологи дамжуулах, зах зээл нээх)
- в) нэмүү өртөг шингээх асуудал хоцрогдсон (түүхий эдийн экспорт, бараа бүтээгдэхүүний импорт)
- г) Уул уурхайн боловсруулах салбар хоцрогдмол
- д) Байгаа аж үйлдвэрийн нөөц баялагаа бүрэн ашиглагддаггүй (эрдэм шинжилгээний хүрээлэн, лаборатори түшиглэсэн технологи, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, төрийн хамтын ажиллагааг дэмжих)

Эх сурвалж:ЖАЙКА -ийн судалгааны баг

2.5 Тогтвортой МАА- н хөгжлийг дэмжих “Эрүүл МАА”-н бодит байдал, тулгамдаж буй асуудал

(1) Монгол мал аж ахуйн ерөнхий төлөв

Монгол улс нь Япон улсаас 4 дахин том газар нутагтай, түүний 80% нь тал хээр нутаг эзлэх хэдий ч байгаль цаг уурын хүнд нөхцөлд газар тариалангийн аж ахуй хязгаарлагдмал байдалтай байна. Иймд, энэхүү өргөн уудам тал нутгийг үр өгөөжтэй ашигласан уламжлалт нүүдлийн мал аж ахуй одоо хир нь чухал ач холбогдолтой голлох аж үйлдвэрийн салбар бөгөөд, ХАА салбар ДНБ-ийн 85% ийг эзэлж байна. 2014 оны байдлаар ойролцоогоор 150 мянган өрх³¹ мал аж ахуй эрхэлж байгаа, голлох морь, үхэр, хонь, ямаа, тэмээ гэсэн 5 хошуу мал малладаг, 2015 оны эхний хагас жилийн байдлаар малын нийт тоо 70 сая толгойд хүрээд байна³². Зураг 2.5.1 д үзүүлснээр, Монгол улсын малын тоо толгой урт хугацааны туршид 20 саяд хүрсэн бөгөөд, зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших 20 жилийн хугацаанд 3 дахин их өссөн байна. Энэ хугацааны жил бүрийн өсөлтийн хувийн дундаж 3.4% үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлт нь дэлхийн дундаж 0.8%тай харьцуулахад ч эрс өндөр байна³³.

Мөн малын тоо толгойг төрлөөр ангилан зураг 2.5.2-т харуулсан бөгөөд Монголын таван хошуу мал болох үхэр, адуу, ямаа, хонь, тэмээ 1:1:7:3:0.5 гэсэн харьцаатайгаар үргэлжилж байсан ч, 1990 оноос хойш энэхүү тэнцвэрт байдалд томоохон өөрчлөлт орж, хонь, ямааны тоо толгой нэмэгдэж, сүүлийн үед хонины тоо ямааны тоо толгойтой бараг ижил түвшинд хүрсэн байна.

Монголын хамгийн том онцлог болох нүүдлийн мал аж ахуй нь малын гаралтай аж үйлдвэртэй төстэй хэдий ч бусад гадны орнуудад байдаг хашаа саравчтай, малын тэжээл их шаардагдах фермерийн мал аж ахуйгаас асар их ялгаатай. Товчхон хэлэхэд, Монголын нүүдлийн мал аж ахуй нь сүргийн аж ахуй³⁴ бөгөөд өвсөн тэжээлтэн малтайгаа цуг тэжээллэг өвс ургамал, цэнгэг устай газар луу улирлын чанартай нүүдэл хийн, байгаль, цаг уурыг ашиглан мах, сүү, цагаан идээ, ноос, ноолуур, арьс шир зэргээ боловсруулдаг мал аж ахуйн хэлбэр гэж хэлж болно. Тус судалгааны багаас Монголын энэхүү уламжлалт, тогтвортой мал аж ахуйг ”Эрүүл мал аж ахуй”-н үндсэн загвар хэмээн үзэж байгаа бөгөөд, үүн дээр тулгуурлан орчин үеийн Монголын мал


³¹ Монгол улсын Статистикийн эмхтгэл 2014.

³² МОНЦАМЭ 526:3

³³ FAOSTAT.


³⁴ Ердийн мал аж ахуйд энд дурдсан 5 хошуу малаас гадна гахай ордог боловч, гахай нь сүргийн амьтан биш тул нүүдлийн мал аж ахуйд зохицдоггүй.

аж ахуйн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж ирсэн, ямар асуудал тулгараад байгааг тодруулахаар судалгаа явуулсан. Өөрөөр хэлбэл, судалгааны багийн төсөөлж буй эрүүл мал аж ахуй нь дараах 3 асуудал, **(i) Эрүүл мал**: мал тус бүрийн эрүүл мэнд, **(ii) Эрүүл сүргийн бүтэц**: Малын тоо толгой болон харьцаа нь тухайн орон нутгийн бэлчээр, усны нөөц баялагтай зохицсон байх, түүнчлэн **(iii) Эрүүл мал аж ахуй**: Мал маллагаа, арчилгаа нь малчдыг эрүүл мал аж ахуйг хангадаг байх гэсэн үзэл баримтлал юм.



Эх сурвалж: "Монгол улсын статистикийн эмхтгэл, 2014, МҮСХ

Зураг 2.5.1 5 хошуу малын тоо толгойн өсөлт : 1962-2015 он



Эх сурвалж: FAOSTAT

Зураг 2.5.2 5 хошуу малын харьцаа : 1962-2013 он

(2) Үндсэн судалгааны чиг хандлага, судалгаанд хамрагдсан газрууд

Монголд хийсэн судалгаа цаг хугацааны хувьд хязгаартай байсан тул, урьдчилан судалгааны чиг хандлага, уулзалт хийх газруудыг үр дүнтэй байлгахыг зорьсон. Үндсэн судалгааны чиг хандлага, уулзалт хийсэн газруудыг дараах хүснэгт 2.5.1-д үзүүлээ.

Хүснэгт 2.5.1 МАА-н судалгааны үндсэн чиг хандлага, уулзалтууд

Чиг хандлага	<ul style="list-style-type: none"> • Урьдчилсан байдлаар Монголын МАА-н холбогдолтой цуглуулж болох мэдээлэл, судалгаа шинжилгээний материалыг судласан. • Монголын холбогдох хүмүүсээс МАА өрөнхий төлөв байдал, тулгарч буй асуудлыг тодруулсан. • Дээрх мэдээлэлд тулгуурлан, холбогдох уулзалт хийх газруудыг тодорхойлсон. • Уулзалт ярилцлагаар МАА-н талаарх тодорхой мэдээлэл, салбарын тулгамдаж буй асуудлын талаар тодорхой мэдээлэл авч, санал солилцсон. • Тодорхой болсон асуудлын цаад учир шалтгааны талаар гүнзгий судалж, дүн шинжилгээ хийн, шийдвэрлэх арга замыг хайн санал дэвшүүлсэн. 	
	Уулзалт хийсэн газрууд	Яам, тамгын газар
<ul style="list-style-type: none"> • ХХААЯ Стратеги бодлого, төлөвлөлтийн газар • ХХААЯ Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн газар • ХХААЯ Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори • ХХААЯ Малын удмын сангийн үндэсний төв • ХХААЯ Мал эмнэлэг, үржлийн газар • Сангийн яам Эдийн засгийн бодлогын газар • Төв аймгийн мал эмнэлэг, үржлийн тасаг 		<ul style="list-style-type: none"> • Монголын малын эмнэлгийн холбоо • Монголын махны холбоо • Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн холбоо • Монголын малын эмч, зоотехникчдын холбоо • Монголын сүү судлалын холбоо • Монголын ноосны холбоо • Аж ахуйн нэгж (мах, сүүний үйлдвэрлэгч)
Их, дээд сургууль, хүрээлэн		Бусад
<ul style="list-style-type: none"> • Мал эмнэлгийн хүрээлэн • ХААИС 		<ul style="list-style-type: none"> • Малчид • Монголын Үндэсний Радио, Телевиз

Эх сурвалж: ЖАЙКА ийн судалгааны баг

Гол холбогдох мэдээлэлд тулгуурлан ³⁵, холбогдох албан байгууллага, мэргэжилтэн, үйлдвэрлэгч нартай уулзалт ярилцлага удаа дараа хийсний дүнд, дараах нийтлэг 3 асуудалд төвлөрөн судалгаа явууллаа.

³⁵ Ашигласан ном: Janzen, J. 2005. Mobile livestock-keeping in Mongolia: Present problems, spatial organization, interactions between mobile and sedentary population groups and perspectives for pastoral development. *Senri Ethnological Studies* 69: 69-97., World Bank. 2008. *Mongolia Livestock sector study*, World Bank., USA. Конагая, 2007. Монголын МАА системийн онцлог, өөрчлөлт. *E-journal GEO* 2: 34-

- Бэлчээрийн доройтол
- Зудын хохирол
- Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ

Дээрх, 3 асуудлын учир шалтгаан, тэдгээрийг шийдвэрлэх, хохирлыг багасгах арга хэмжээний талаар цэгцэлнэ.

1) Бэлчээрийн доройтлын шалтгаан, асуудал

Өмнө дурдсанчлан, Монгол оронд эртнээс уламжлан өргөн уудам бэлчээр ашигласан мал аж ахуй эрхэлж ирсэн бөгөөд, энэ утгаараа бэлчээр нь малчдад үе уламжлагдан тогтвортой ашигладан ирсэн гэж хэлж болно. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд ямар нэгэн шалтгааны улмаас бэлчээрийн доройтол хурдацтай явагдаж байгаа талаар судалгааны ном, хэвлэлүүдэд олонтаа дурдсан байна. Энэхүү судалгааны явцад ч уулзсан газар болгон бэлчээрийн доройтлын асуудал тавигдаж байсан ба, олон хүн олон талаас нь авч үзэж байсан нь анхаарал татсан.

Тухайлбал, цөлжилтийн хурдац³⁶, хиймэл дагуулын зургаас харагдах ургамлын аймгийн доройтол³⁷, биомассын тархалт буурсан³⁸, дэлхийн дулаарлын нөлөөллөөс үүдэх хуурайшилт³⁹ гэх мэт макро үзэл баримтлалаас, өмнө дурдсан малын тоо толгойн хэт өсөлт (ялангуяа ямаа⁴⁰) болон хүнд даацын авто машины өсөлт⁴¹, түүнчлэн хэт хурдацтай явагдаж буй хотжилтын асуудал зэрэг газар дээр нь мэдэрч ойлгох асуудал хүртэл өргөн хүрээнд судалгааг хийгдсэн.

42. 31: 1-21 Үэмура, Начин шонхор, Жаргалсайхан, Кодама, Когагая 2013, 6 р бүлэг Монголын МАА, Газар тариалан буюу газар ашиглалт Фүжита, Като, Кусано, Кота, Киото их сургуулийн эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Мори, Гантөмөр, 2002. Махны худалдааны хувьсгал, төлөвлөгөө, Бэлчээрийн МАА Монголын эдийн засгийг өөрчлөх нь, Когагая Юки, Бунка хэвлэлийн компани, Токио

³⁶ Kawamura, K. and Akiyama, T., 2010. Simultaneous monitoring of livestock distribution and desertification. *Global Environmental Research* 14: 29-36.

³⁷ Hilker, T., Natsagdorj, E., Waring, R. H., Lyapustin, A., and Wang, Y., 2014. Satellite observed widespread decline in Mongolian grasslands largely due to overgrazing. *Global Change Biology* 20: 418-428.

³⁸ Sekiyama, A., Takeuchi, W., and Shimada, S., 2014. Detection of grassland degradation using MODIS data in Mongolia. *Journal of Arid Land Studies* 24: 175-178.

³⁹ Бэлчээрийн хяналт талаас, дэлхийн дулаарлын хамгийн их нөлөөлөл нь хуурайшил боловч, Монгол улс өндөрлөг тул энэхүү нөлөөлөл харьцангуй бага, уламжлалт нүүдлийн хэв маягаа үргэлжүүлэх тохиолдолд хуурайшилтын үе шатыг эрчимжүүлэх үр нөлөө бага гэж үзэж байна. Гэхдээ, хурцадмал малын өсөлт хуурайшилтыг нэмэгдүүлэх магадлалтай. Мөн өмнө хэсгийн говь цөлийн бүсийн хуурайшилтын үзэгдэл нийтдээ хойшоо чиглэх болсон тухай судалгаа бий (Үэмура, 2013 он. Маэдэ). Эдгээр нь малчдыг нуггийн төв хэсэг рүү шилжин суухад хүргэж байгаа юм.

⁴⁰ Sekiyama *et al.*, 2014. *Op. cit.*

⁴¹ ХХААЯ, Төв аймгийн мал эмнэлэг, үржлийн газар, Махны холбоо, махны үйлдвэр дээр хийсэн ярилцлагаас.

Нөгөө талаас, жишээлбэл ХХААЯ-ны Стратеги бодлого, төлөвлөлтийн газар дээр “хиймэл дагуулаас авсан ургамлын аймгийн зураг нь ногоон өнгөтэй ургамлын өөрчлөлтийг ерөнхийд нь ойлгохоос, үнэхээр тэр ургамлыг мал идэх эсэхийг мэдэх боломжгүй тул, бэлчээрийн сайн мууг ялгах стандарт биш” гэсэн санаа бодол, уулзалт хийсэн малчид “Бэлчээр доройтож байна гэдэг ч, бидэнд тэгж санагддаггүй “ гэж хэлж байсан зэрэг бэлчээрийн доройтлын асуудал, үзэгдэл нь харах өнцгөөс шалтгаалан ойлголт огт өөр байгаа нь харагдаж байна

Гэхдээ энэхүү ойлголт болон ухагдахуун асуудалгүй хэдий ч мал аж ахуйн талаас бэлчээрийн доройтлыг харах тохиолдолд хамгийн чухал асуудал бол өмнө дурдсан ХХААЯ-ны ярианд байсан шиг малын тэжээлийн тогтвортой хангамж болох хүчин чадал тал хээрийн бэлчээрт бий. Иймэрхүү утгаараа Монгол Засгийн газар боловсруулсан бэлчээрийн доройтлын зураглал⁴² -д тодорхойлсон доройтол эрчимтэй явагдаж буй бүс нутаг нь, угийн өвс ургамал тарчиг өмнө хэсгийн говь цөлийн бүсийг эс тооцвол, сүүлийн үед малын тоо толгой болон нягтшил огцом өссөн бүс нутагтай (Зураг 2.5.3) өргөн хүрээнд давхцаж байгаа зэрэг, Монголын түүхэнд өмнө гарж байгаагүй малын тоо толгойн рекорд өсөлт нь бэлчээрийн доройтолд нөлөөлж байгаа нь гарцаагүй


Малын өсөлт зураг 2.5.3-аас тодорхой харагдаж байгаа бөгөөд бүс нутгаар нь харахад нийслэл Улаанбаатарын нутаг дэвсгэр багтах төвийн бүс болон Эрдэнэт гэх мэтийн томоохон хотыг хамарсан Хангайн бүс буюу энэхүү судалгааны голлох бүс нутаг болох босоо болон хөндлөн тэнхлэгийн корридор дагуу өсөлт ихтэй байгаа нь анхаарал татаж байна. Учир нь тухайн бүс нутаг дахь малын тоо толгойн өсөлтийн хувь нэмэгдсэн бус, малчид олноор шилжин суурьшсантай холбоотой юм⁴³. Энэ нь сүүлийн жилүүдийн Монголын хот суурин газрын асуудлыг авч хэлэлцэхэд чухал цэг юм. Үүний гол шалтгаан нь төвийн бүс рүү шилжин суурьших малчдын дотор зудын хохирол амсан, эцэстээ хотын ойролцоо суурьшиж⁴⁴, бэлчээрийн доройтлоор зогсохгүй, хотын ядуурлыг даамжруулж байгаа тохиолдол цөөнгүй байгаа юм⁴⁵.

⁴² 2.11 бүлгийн зураг 2.11.2 тэмдэглэсэн.

⁴³ Janzen, J. 2005. *Op.cit.*

⁴⁴ Ганбат, Саказумэ, 2012 он. Монголын хүчит тэжээлийн үйлдвэрлэл, логистикийн хөгжил. Хоккайдогийн их сургууль, ХАА эдийн засгийн эрдэм шинжилгээний өгүүлэл 67 : 105-112.

⁴⁵ Janzen, J., Taraschewski, T., and Ganchimeg, M. 2005. Ulaanbaatar at the Beginning of the 21st Century: Massive In-Migration, Rapid Growth of Ger-Settlements, Social Spatial Segregation and Pressing Urban Problems. GTZ.



Эх сурвалж : Монголын Статистикийн эмхтгэлээс ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.5.3 Аймгийн түвшний малын нягтрал

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд ямар учраас ийнхүү малын тоо толгойн огцом өсөлт, малын төрлийн бүтцийн өөрчлөлт, цаашилбал төвийн бүс рүү чиглэсэн

төвлөрөлт гэсэн малын тархалтын тэнцвэргүй байдал үүсэн бий болсон шалтгааныг судалгааны үр дүнд тулгуурлан ерөнхийд нь тоймлон дурдая.

(i) Социалист нийгмийн уналт нэгдэл сангийн аж ахуйн задралын нөлөө


Нэгдэл нь социалист системтэй байсан Монголын улсын хувьд мал аж ахуйн үйлдвэрлэлээс тээвэр худалдаа хүртэл цаашилбал малчдад нийгмийн үйлчилгээг хүргэх гэх мэтчилэн бүгдийг нийтэд нь хамруулсан систем байсан⁴⁶. Социализмын үеийн оргил үед зураг 2.5.4 т харуулснаар бүх суманд нэгдэл байсан. Тиймээс нэгдэл, сангийн аж ахуйн задралын нөлөө нийгэмд ямар хүчтэй байсныг төсөөлж болно. Тэр дундаа малын тоо толгойн өсөлттэй холбоотой шалтгаан нь дараах болно.

- **Малын хувьчлал, маллах малын тооны хязгаар болон малын гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн нормыг хүчингүй болгосон:** Нэгдэл татан буугдсаны дараа тухайн үе хүртэл улсын өмч байсан малыг малчид болон хуучин нэгдлийн ажилчдад хувьчилсан. Үүнээс цааш мал худалдаалах асуудал малчдын мэдэлд шилжиж нэг малчин өрхөд ноогдох малын тоо толгойн хязгаар хүчингүй болсон. Мөн нэгдлийн үеийн жил болгоны намрын мах бэлтгэлийн норм мөрдөгдөхгүй болсон. Дээрх шалтгаанаар малын гаралтай бүтээгдэхүүний тоо хэмжээ буурч, улмаар малын тоо толгой нэмэгдэхэд нөлөөлсөн.
- **Малын гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн системгүй болж, тээврийн зардлын дарамт бий болсон:** Социализмын үед малын гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн бүхий л үйл ажиллагааг нэгдэл хариуцдаг байсан. Аль бүс нутагт байрлахаас үл хамааран нийлүүлэлттэй холбоотой ложистикийн зохицуулалтыг бүхэлд нь нэгдэл эрхлэн явуулдаг байсан. Гэвч нэгдэл сангийн аж ахуй тарснаас хойш, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тээврийн зардал малчдын мал борлуулах үнийн дүнгээс хасагддаг болсон. Ялангуяа зах зээлээс хол байрлах малчид тухайн зардал илүү хүнд тусдаг болсон. Үүнээс шалтгаалан зах зээлд аль болохоор ойрхон холбогдох бүс нутаг руу малчид тэмүүлэх болж тэдгээрийн тоо ч нэмэгдэж улсын хэмжээнд малын тархалт тэнцвэргүй байдалтай болж иржээ.
- **Инфляцаас шалтгаалан малын арилжаа буурсан:** 1990 оноос хойш Монгол хүчтэй инфляцид өртсөн ба, тухайн үед малын зах зээлийн үнэ

⁴⁶ Bruun, O. 1996. The herding household: economy and organization *In* Mongolia in transition. Bruun and Odgaard (eds), Nordic Institute of Asian Studies, UK.


огцом буурч, малаа аль болох арилжихгүй малчид нэмэгдсэн. Үүний үр дүнд малын тоо толгой нэмэгдсэн.

- **Худгийн бүтээн босголт** : Малчдын бэлчээрээ сонгох гол хэмжүүрийн нэг нь худаг, усны асуудлаа шийдэж чадах эсэх юм. Нэгдэл тарсны дараа бүрэн ажиллагаатай бус худгууд ихээр бий болсноор ажиллагаатай худаг тойрсон төвлөрөл ялангуяа төвийн бүсээр хэт их төвлөрөл бий болсон.
- **Экспортын хэмжээ огцом буурсан**: Нэгдэл сангийн аж ахуйн хариуцаж байсан ложистикийн системд мал болон махны экспорт багтсан байдаг. Гэвч нэгдэл тарсны дараа энэ тоо буурч улмаар малын тоо толгой нэмэгдэхэд нөлөөлсөн. Экспортын тоо хэмжээ хамгийн их буурсан үзүүлэлт тэй байгаа нь хонины махны экспорт юм (зураг 2.5.5).



Эх сурвалж: Монгол улсын ХАА нэгдэл

Зураг 2.5.4 Социализмын үеийн нэгдлийн байршил



Зураг 2.5.5 Хонины мах бэлтгэлийн хэмжээ, экспортын хэмжээ : 1962-2013 он

(ii) Ноолуурын олон улсын зах зээлийн үнийн уналт


Монголын малчдын хувьд ямааны ноолуур нь хамгийн их бэлэн мөнгөний хөрвөх чадвар сайн, ашиг сайтай бүтээгдхүүн юм. Тиймээс ноолуурын ямаа нь тун хэрэгцээтэй мал юм. Мөн ямаа нь бусад төрлийн мал иддэггүй тарчиг өвс тэжээлд ч тэсвэртэй мал бөгөөд усны хомсдолтой газарт маллах боломжтой зэрэг давуу талтай учир өмнө бүсийн говийн бүсэд ч тэмээтэй хамтатган ихээр маллагддаг. Энэхүү онцлог чанараас шалтгаалан зарим тохиолдолд бэлчээрийн талхлагч гэж дүгнэгддэг. Учир нь ямаа нь өвсний үндсийг хүртэл иддэгт байдаг⁴⁷. Мэдээж ганцхан өвсний үндсэнд дуртай учир голлон иддэггүй өвс ургамал дутмаг үед л хооллодог. Гэвч малын тоо толгой ихтэй бүс нутагт бэлчээрийн өвс дутмаг байдаг тул үндсийг нь хүртэл иддэг ямаа нь бэлчээрийн доройтлыг улам бүр эрчимжүүлдэг.

Өмнө дурдсанчлан Монголын таван хошуу малын төрлийн бүтэц тэнцвэртэй байсан үед энэ нь төдийлөн том асуудал биш байв. 1993 оны ноолуурын олон улсын зах зээлийн үнийн огцом уналтаас болж 1990 он хүртэл 127 ам.доллар байсан ноолуурын үнэ огцом 37 ам.доллар хүртэл буурсан⁴⁸. Үүнээс шалтгаалан малчдын маллах ямааны тоо өсч тоо толгой нэмэгдэн ямааны нядалгааны тоо огцом буурсан. Үүнийг зураг 2.5.6-с

⁴⁷ Прома консалтинг, 2011. Монголын хөдөө аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн салбарын төрийн бодлогын талаарх судалгаа, дүн шинжилгээ, 2010 оны чөлөөт худалдааны хэлэлцээр судалгаа, дүн шинжилгээ

⁴⁸ Балдан, 2006 он. Монголын ноолуурын зах зээлийг тойрсон асуудал, ERINA судалгааны хүрээлэн

бодитоор харж болно. Нядалгааны хувьд 1995 оноос хойш тоо толгойндоо тохирсон үзүүлэлттэй байгаа боловч ямааны өсөлт түүний дараа өнөөг хүртэл үргэлжилж байгаа нь сонирхолтой үзэгдэл юм. Улмаар энэхүү асуудлыг шуурхай шийдэх шаардлагатай байгаа хэдий ч шууд хязгаарлах арга хэмжээ авах нь үр дүнгүй бөгөөд малчдад ямааг хэт их маллахгүй ч эдийн засгийн үр ашигтай байлгах зах зээлийн систем хэрэгтэй.



Зураг 2.5.6 Ямааны тоо толгой, мах бэлтгэлийн хэмжээ : 1962-2013 он

(iii) Тэжээлийн зардал болон газрын төлбөрийн ид шид

Монголын нүүдлийн мал аж ахуйг бусад орнуудын ерөнхий эрчимжсэн мал аж ахуйтай харьцуулхад хамгийн том онцлог гэж хэлж болох зүйл нь тэжээл болон газрын төлбөр бараг л байхгүйтай адил байгаа явдал юм⁴⁹. Ихэнх мал аж ахуйд малчин малын тоо толгойгоо өсгөх тохиолдолд юуны өмнө тэжээлийн зардал, малаа тэжээхэд шаардагдах газрын төлбөр зэрэг хөрөнгө оруулалтын дүнг тооцоолдог. Гэтэл Монголын хувьд бодит байдал дээр эдгээр зардал хэрэггүй байдаг. Энэ нь малын тоо толгойн огцом өсөлтөнд нөлөөлж байгаа гэж ойлгоход буруудахгүй. Энэхүү Монголын онцлог нь малын тоо толгойг огцом нэмэгдүүлэх шалтгаан болж байгааг ч, нөгөөтэйгүүр энэ нь Монголын давуу тал гэдгийг бас онцлон тэмдэглэх нь зүйтэй. Үр тарианы гаралтай тэжээлд гүн автаж дэлхийд тариалагдаж

⁴⁹ Бат-Үүл, 2004. Монгол улсын ХАА-н төлөв : 1990 оноос хойших зах зээлийн эдийн засгийн шилжилтэд анхаарал хандуулах нь . ХАА менежментийн судалгаа 30: 139-158.

байгаа нийт үр тарианы 30%-с дээш хувийг тэжээлд хэрэглэн⁵⁰ түүний дотор өөрсдийнхөө дотоодын хэрэгцээг ч хангаж чадахгүй улс орон олон байна. Монгол улс өөрийн бэлчээрийн өвс ургамалаар малаа тэжээж ирсэн нь яахын аргагүй газар нутгийн давуу тал гэж хэлэх нь зүйтэй.

(iv) Бусад шалтгаан

Эцэст нь малын тоо толгойн огцом өсөлт, том оврын авто машины хөдөлгөөн нэмэгдсэн зэргээс гадна бэлчээрийн доройтол бий болох шууд ба шууд бус шалтгааны тухай Монголд хийсэн судалгаа, ярилцлагын үр дүнгээс харахад сүүлийн үед гар утасны сүлжээ барьдаг нутаг руу малчид цугласан байх, уул уурхайн нөхөн сэргээлт хангалтгүй хийгдсэнээс үүдсэн бэлчээрийн доройтол зэрэг байна.

2) Зудын хохирлын шалтгаан, асуудал

2000 оноос 2002 он, 2009 оноос 2010 онд болсон зудын гамшгийн талаар зураг 2.5.1-д тодорхой харагдаж байгаачлан, нийт малын 25% нь хохиролд нэрвэгдсэн маш том гамшиг нүүрлэсэн. Энэхүү гамшгийн шалтгаан, ерөнхийдөө цочир хүйтэрсэнээс болсон гэгдэх хэдий ч энэ удаагийн Монголд судалгаа хийх явцад тодорхой болсон зүйл нь зудын гамшиг нь зөвхөн байгалийн хүчин зүйл төдийгүй хүний хүчин зүйлээс ихээхэн шалтгаалж байгаа тал юм. Өөрөөр хэлбэл, өвлийн бэлтгэлээ сайтар базаасан малчин зуднаас хохирол амсахгүй, хохиролтой байсан ч хохирлын хэмжээ бага байсан байна. Сүүлийн жилүүдэд ямар нэгэн шалтгаанаар зайлшгүй хийх шаардлагатай өвлийн бэлтгэлээ хийхгүй цааргалах, эсвэл бэлтгэл хийх чадваргүй малчид их болсонтой холбоотой гэж үзэж байна. Энэ талаар дараагийн хэсэгт тодорхой авч үзье.

(ii) Шинэ малчин өрх нэмэгдсэн

Нэгдэл тарснаар малыг малчид болон хуучин нэгдлийн ажилчдад хувьчилсан. Үүнээс шалтгаалан хуучин нэгдлийн ажилчид шинээр малчин болж нэмэгдсэн. Үүнд өмнө дурдсанаар тухайн цаг үеийн өндөр инфляци бүхий зах зээлд малаа хямд худалдаалахаас сэргийлэх сэтгэл зүй⁵¹, нөгөө талаас мал маллахыг нэг төрлийн амар тайван гэж боддог монгол хүний

⁵⁰ Guyomard, H., Manceron, S., and Peyraud, J. 2013. Trade in feed grains, animals, and animal products: current trends, future prospects, and main issues. *Animal Frontiers* 3: 14-18.

⁵¹ Edstrom, J. 1993. The reform of livestock marketing in Mongolia: problems for a food-security and equitable market development. *Nomadic Peoples* 33: 137-152.

ухамсар⁵² гэх мэт хүчин зүйлс нөлөөлсөн гэж хэлж болно. Зах зээлд шилжихийн өмнө 75,000 байсан малчин өрх 2002 он хүртэл ойролцоогоор 200,000 өрх хүртэл өссөн байна⁵³. Энэхүү шинээр бий болсон малчдын ихэнх нь мал маллах арга ухаанд төдийлөн сайн суралцаагүйгээс гадна эдийн засгийн хувьд тогтвортой байх эрмэлзэлтэйгээс малын тоо толгойг өсгөхөд хамаг хүчээ зарцуулсан байдаг⁵⁴. Иймээс өвлийн бэлтгэл, тодруулбал, өвөлжөөний бэлчээрийн сонголт, хадлан бэлтгэл, өвөлжөөний хашаа хорооны дулаалга гэх мэтийг хийж чадахгүй эсвэл ийм төрлийн бэлтгэл ажлыг төвөгшөөх малчны тоо өссөний нөлөөгөөр зудтай өвөл малын хорогдол эрс нэмэгдсэн байна.⁵⁵

(iii) Бэлэн мөнгөний хөрвөх чадвар сайтай малаа нэмэгдүүлэх сонирхолтой малчны өсөлт

Зах зээлийн системд шилжсэнээс хойш ямаа голлосон бэлэн мөнгөний хөрвөх чадвар сайтай мал өсгөх хандлага ихэссэн нь жамаараа болж буй зүйл мэт боловч энэхүү хандлага нь эцсийн дүндээ зудаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хангалтгүй хийхэд хүргэх талтай байдаг. Хэд хэдэн удаа дурьдсан ямааг ноолуур авах зорилготойгоор маллах учир зах зээлд нийлүүлэхэд хялбар газар төвлөрдөг. Мэдээж эргэн тойронд нь мөн адил зорилго өвөрлөсөн малчид олноор цугласнаар өвлийн бэлчээрийн нөөц, хадлангийн газрын өрсөлдөөн бий болдог. Улмаар дийлэнхээрээ өвлийн бэлтгэл хангалтгүй хийх байдал бий болдог. Мөн үүн дээр Монголын бэлчээрийн мал аж ахуй нь малын өвс тэжээлийн зардал болон газрын төлбөр байдаггүй ч нөгөөтэйгүүр өвлийн бэлтгэлд туйлын их хүч хөдөлмөр шаарддаг гэдгийг малчид хэлж байлаа. Цаашлаад малын тоо толгой олон байхын хэрээр өвлийн бэлтгэл төдий чинээ хүндэрнэ. “Зудын хохирол нь олон малтай айлд хамгийн ихээр нөлөөлнө” гэсэн нь⁵⁶ үүнийг нотолж байгаа хэрэг бөгөөд урьд өмнө нь байгаагүй хохирол амссан 2010 оны зудыг авч үзсэн ч “Зудын хохирол нь малын тоо толгой ихтэй “газар” илүү даамжирдаг” гэж хэлж болохоор байна.

⁵² Fratkin, E. and Mearns, R. 2003. Sustainability and pastoral livelihoods: lessons from East African Massai and Mongolia. *Human Organization* 62: 112-122.

⁵³ Мори, Бүрнээбаатар, 2002. Махны худалдааны хувьсгал, төлөвлөгөө, Бэлчээрийн МАА Монголын эдийн засгийг өөрчлөх нь, Конагаяа Юки, Бунка хэвлэлийн компани, Токио

⁵⁴ Janzen, J. 2005. *Op. cit.*

⁵⁵ Хавсралт 2.6.1 : МАА холбогдох үндсэн мэдээлэл, 1) Нүүдлийн менежментийн өнөөгийн байдал (зудын хохирлын шалтгаан) хэсгийг харна уу.

⁵⁶ Бат-үүл. 2005. Монголын мал аж ахуй эрхлэлт түүний хөгжил болон зуднаас сэргийлэхтэй холбоотой судалгаа, ХАА эдийн засгийн хүрээлэн 31: 1-21

(iv) Нэгдлийн үеийн хадлангийн өвс тараалтын системийн уналт

Нэгдэл задрахаас өмнө өвлийн бэлтгэлд зориулж хадлангийн өвс бэлтгэдэг байсан бөгөөд нийтдээ 22 газар хадлан бэлтгэлийн төв ажиллаж байсан. Энэхүү төвүүд нь улсын тусгай хэрэгцээний газарт байрладаг байсан ба тухайн жилийн байдалд тохируулан өвс дутмаг байгаа бүс нутагт онцгойлон өвс тараадаг систем юм. Мэдээж зуднаас урьдчилан сэргийлэх тал дээр өвс бэлтгэл нь үндсэндээ малчин хүний хийх ёстой ажил боловч нэгдлийн үеийн нөөц бэлтгэх системийн ачаар хохирлыг хамгийн бага хэмжээнд барьж чаддаг байсан юм.

Зудын хохиролтой холбоотой хүний үйл ажиллагааны талаар дурьдсан хэдий ч, хамгийн их анхаарах ёстой зүйл бол зудын хохирол, малын тоо толгойн огцом өсөлтийн байдал нь хоорондоо нягт холбоотойд байгаа юм. Энэ утгаараа бэлчээрийн доройтлын асуудал болон зудын хохирлын асуудал нь ерөнхийдөө нэг асуудлаас үүсэн бий болж байгаа байж магад. Хэрэв тийм бол асуудлыг хэрхэн шийдвэрлэхээс хамаарч энэхүү хоёр асуудлыг хамтатган шийдэх боломжтой юм. Энэ нь тус судалгаанаас дэвшүүлж буй санааны нэн чухал хэсэг билээ.

3) Гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хангалтгүй байдал, үүсэх асуудал

“Эрүүл мал аж ахуй” хөгжүүлэх зорилт тавьсан энэхүү судалгааны хувьд, энэ маш чухал асуудал юм. Тиймд, судалгааны үеэр ХХААЯ-ны Мал эмнэлэг үржлийн газар, Монголын мал эмнэлгийн холбоо зэрэг холбогдох байгууллагуудтай уулзаж, бодит амьдрал дээр тулгарч буй эрүүл ахуйн асуудлын талаар мэдээлэл цуглуулсан⁵⁷. Судалгааны дүнд, Монгол улсад малын бруцеллёз, шүлхий, адууны ям өвчин, хачигт халдвар зэрэг олон янзын гоц халдварт өвчин илэрдэг бөгөөд, 1) Халдварлах хүч 2) Эдийн засгийн хохирол 3) Малчид өөрсдөө арга хэмжээ авах хүндрэлтэй зэргээс анхаарч үзэхэд, улсын хэмжээнд шуурхай арга хэмжээ авах шаардлагатай нь шүлхий өвчин гэж үзэж байна.

Шүлхий өвчин нь шүлхийн вирусээр дамжин халдварладаг малын гоц халдварт өвчин бөгөөд Монголд адуу, илжигнээс бусад бүх мал (салаа туурайтан)-д халддаг. Нэг халдвар туссан малын эдийн засгийн үр ашиг

⁵⁷ Хавсралт 2.6.1 : МАА үндсэн мэдээлэл, 2) Дотоодын МАА эрүүл ахуйтай холбогдох судалгааг харна уу.

алдагдах бөгөөд, халдвар авсан малын шүлс, хаягдал, арьс үс гэх мэтээс халдварладаг. Мөн халдвар хурдан тархалттай тул хяналт төдий чинээ хүндрэлтэй байдаг⁵⁸. Түүнчлэн ийм нөхцөл байдлаас шалтгаалан зах зээлийн үнэ цэнээ алдан, экспортлох боломжоо алдах зэрэг адийн засгийн хохирол их.

Жшиээлбэл, Монголын ноосны холбоо, Монголын арьс үйлдвэрлэгчдын нэгдсэн холбоодын хэлж байгаагаар “Уг нь ноосыг боловсруулалтанд оруулдаг учир шүлхий өвчний халдвар тээгч биш юм. Гэвч Монголд шүлхий өвчин гарсан гэх шалтгаанаар тохиролцоонд хүрдэггүй ” гэж байсан нь дээр дурдсан экспортод нөлөө үзүүлдэгийг баталж байгаа юм.

Арьс ширний салбарт ч мөн адил эдийн засгийн хувьд муугаар нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр аль нэг бүтээгдэхүүн экспортолж чадах эсэх нь эцсийн дүндээ тухайн 2 орон хэрхэн тохиролцоо хийхээс ихээхэн хамаарна. Тиймээс Монгол улс юуны түрүүнд олон улсын шаардлага хангасан шүлхийн хяналтын аргыг хэрэгжүүлж дараа нь харилцагч нь оронтойгоо харилцах нь зүйтэй. Монголын том хэмжээний мах бэлтгэлийн үйлдвэрүүд тус бүрдээ ийм арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн жишээ бий⁵⁹. Гэхдээ, иймэрхүү амжилтын үр дүн үйлдвэрлэгч малчдад хүрж байгаа гэдэг нь эргэлзээтэй, малчдад сайтар мэдээлэл сурталчилгээ хийх зэрэг, шүлхий өвчинтэй тэмцэх цогц арга хэмжээ авах шаардлагатай. Энэ асуудал энэхүү судалгаанаас дэвшүүлсэн саналын гол үзэл баримтлал болно.

⁵⁸ Defra. 2011. Foot and Mouth Disease Control Strategy for Great Britain. UK.

⁵⁹ Монголын 12 компаний мах, махан бүтээгдэхүүнийг БНХАУ-руу экспортлох санамж бичиг зурагдсан байна. (МОНЦАМЭ.2015. 532: 3.).

2.6 ХАА, боловсруулах салбарын өнөөгийн байдал, асуудал

Монгол улсын газар тариалан, боловсруулах салбарын хувьд цаашид өсөх ирээдүйтэй. Энэхүү салбарын өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд дараах 4 асуудлыг авч хэлэлцлээ. Үүнд, 1) Үр тариалангийн өнөөгийн байдал, 2) ХАА боловсруулах технологийн өнөөгийн байдал, 3) Импортын ХАА-н бүтээгдэхүүнээс хамааралтай байдал, түүнчлэн 4) Хүнсний бүтээгдэхүүний нэмүү өртгийн өнөөгийн байдлын талаар дүн шинжилгээ хийлээ. Эдгээрт холбогдох мэдээлэл, тоо баримтыг цуглуулан, цэгцэлж, дүн шинжилгээ хийх замаар цаашдын хөгжлийн асуудлыг тодорхойлон гаргалаа.

(1) Газар тариалангийн өнөөгийн байдал

Монголд 5-аас 9 дүгээр сарын хооронд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг тул цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдаг. Үүгээр голлох бүтээгдэхүүн болох буудай болон төмс, хүнсний ногооны тариалалтын бодит нөхцөл байдлыг судаллаа

1) Улаан буудайн тариалалт

Монголд улаан буудайг хавар тарьж эхэлдэг бөгөөд 4 дүгээр сарын сүүл 5 дугаар сарын эхээр үрээ цацаж, 6 дугаар сард бордож, 7 дугаар сарын дундуур хогийн ургамалтай тэмцэж, 9 дүгээр сарын сүүлээр ургацаа хурааж авна. Хөрс доройтож үржил шим нь буурахаас сэргийлэх зорилгоор уринш хийх аргыг хэрэглэдэг нь тариалангийн үндсэн хэв шинж юм.

1990 оны үед зах зээлд шилжихээс өмнөх 600,000 тонноос илүү ургац хураан авдаг байсан бөгөөд илүү гарсныг нь ЗХУ руу гаргадаг байжээ. Харин зах зээлд шилжсэний дараа улсын САА-г хувьчилсан тул ургацын хэмжээ эрс буурсан байна. Тоног төхөөрөмж хуучирч муудсанаас бүтээмж буурсан (хувьчлагдсан тул шинэчлэх санхүүгийн чадваргүй), ажиллах хүчний хомсдол, хөрсний үржил шим доройтсон (нэгж талбайгаас авах ургацын хэмжээ буурсан) зэрэг шалтгаанаас үүдэн тариалан эрхлэлт багасч, үр тарианы хомсдолд (тариалалтын талбайн хэмжээ буурсан) орсон байна.

Ургацын хэмжээ буурсан тул Монголын Засгийн газар 2008 онд тариалангийн талбайн дээд хязгаарыг 3000 га-гаас 20,000 га хүртэл нэмэгдүүлэх арга хэмжээ авснаас гадна “Атарын 3-р аян”-ыг эхлүүлж хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, үр худалдан авахад улсаас татаас өгсөн тул 2009 онд 390,000 тонн ургац хурааж дотоодын хэрэгцээг 100 хувь хангасан байна. 2009 оноос хойш 2014 он

хүртэл ургацын хэмжээ 350,000 тонноос тогтмол давж дотоодын хэрэгцээгээ хангасан байна (Зураг 2.6.1).




Эх сурвалж : ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА судалгааны баг

Зураг 2.6.1 Улаан буудай тариалалтын талбай, нийт ургац болон нэгж талбайгаас авах ургацын хэмжээ (1985-2014)

Улаан буудайн тариалалтыг аж ахуйн нэгж эрхэлдэг. Улсын хэмжээнд нийт 1100 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуйн нэгжүүдийг хүчин чадлаар нь жижиг, дунд, том гэж ангилна. Томоохон аж ахуйн нэгж 10% (6000 га-гаас дээш), дунд нь 50 % (1000 га-гаас 6000 га хүртэл), жижиг нь 40% (1000 га хүртэл) тус тус эзэлж байна.

Түүнчлэн, тариалалтын аж ахуйн 80 % нь Сэлэнгэ, Төв, Булган, Хэнтий аймаг зэрэг Улаанбаатар хоттой ойрхон хойд болон зүүн бүсийн аймагт байна.


2014 оны нийт тариалалтын талбай болон ургацын хэмжээг аймаг тус бүрээр үзүүлсэн доорх хүснэгтээс харахад улсын хэмжээнд нийт 489,000 тонн улаан буудай хурааснаас Сэлэнгэ, Төв болон Булган гурван аймагт улсын нийт ургацын хэмжээний 77% буюу 378,000 тонн улаан буудай хураасан байна



Эх сурвалж: ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.2 Улаан буудайн тариалалтын талбай, ургацын хэмжээ (2014 он)

2011-2015 оны дотоодын хэрэглээ хангамжийг Зураг 2.6.3-т харуулсан байна, 2013 он болон 2015 оноос бусад онд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан байна. Ялангуяа 2015 онд болсон зудын гамшигаас үүдэн тариалангийн хэмжээ буурч, гадаадаас импортлохоос өөр аргагүйд хүрсэн байна.



Эх сурвалж : ХХААЯ мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.3 Төмсний дотоодын хэрэглээ хангамж (2011-2015 он)

Улаан буудайн тариалалтын талаарх өнөөгийн байдлыг дүгнэж тулгамдсан асуудлыг дараах хүснэгтэд эмхэтгэв.


Хүснэгт 2.6.1 Улаан буудайн тариалалтын тулгамдсан асуудал

- Дотоодын сайн чанарын элит үр гаргах, үржүүлэх, нэвтрүүлэх
- 2015 оны гангийн хохирлоос сургамж аван услалтын систем байгуулж, усалгаатай тариаланг хөгжүүлэх,
- Хуучирсан тоног төхөөрөмжийг шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зээлийн тогтолцоог бий болгох
- Улсаас олгох татаасын тогтолцоог тогтвортой үргэлжлүүлэх (2014 онд 1 тонн тутамд 70,000 төгрөгийн татаас улсаас өгсөн)
- Аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих
- Буудайн экспортыг дэмжих уян хатан тогтолцоог бий болгох

2) Төмсний тариалалт

Зах зээлд шилжсэний дараа улсын САА-нууд хувьчлагдаж төмсний ургацын хэмжээ (улаан буудайтай адил) 2002 он гэхэд 50,000 тонн болтлоо буурсан нь зах зээлд шилжихээс өмнөх үеийнхээс 2 – 3/1 дахин бага юм.


Иймээс 2004 онд Монголын Засгийн газар Швейцарийн Хөгжлийн Агентлагийн (Swiss Agency for Development and Cooperation) санхүүгийн дэмжлэгтэйгээр “Төмс хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн байна. Хөтөлбөр 3 үе шаттайгаар хэрэгжиж (I үе шат 2004-2007, II үе шат 2008-2011, III үе шат 2012-2015) шилдэг элит үрийг сонгон, Монголд нутагшуулан үржүүлж, хангамжийн тогтолцоог бий болгосон тул ургацын хэмжээ жил ирэх тусам нэмэгдсээр байна. Үүний үр дүнд 2009 онд дотоодын хэрэгцээг 100 хувь хангасан. Түүнээс хойш жил бүр 150,000 тонн төмс тогтмол хураан авсаар байна (Зураг 2.6.4).



Эх сурвалж : ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.4 Төмс тариалалтын талбай, ургацын хэмжээ (1985-2014 он)


2014 оны нийт тариалалтын талбай болон ургацын хэмжээг аймаг тус бүрээр үзүүлсэн доорх зураг 2.6.5 харахад улсын хэмжээнд нийт 163,000 тонн төмс хурааснаас Сэлэнгэ, Төв хоёр аймагт улсын нийт ургацын хэмжээний 62% буюу 102,000 тонн төмс хураасан байна.



Эх сурвалж : ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.5 Аймаг тус бүрийн төмс тариалалтын талбай, ургацын хэмжээ (2014 он)

2010—2014 оны дотоодын хэрэгцээ хангалтыг зураг 2.6.6 харууллаа, жил бүр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, илүүдэл үүссэн байдалтай байна.



Эх сурвалж : ХХААЯ ны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.6.6 Төмсний дотоодын хэрэгцээ хангамж (2010-2014 он),


Төмс тариалалттай холбогдох тулгамдаж буй асуудлыг дараах хүснэгтэд нэгтгэлээ.

Хүснэгт 2.6.2 Төмс тариалалтын тулгамдсан асуудлууд

- Ургац хадгалах зорьны хүрэлцээ хангалтгүй: Ургац хураасны дараа борлуулах үнэ өвөл, хаврын улиралд борлуулах үнээс 2 дахин бага. Зах зээлд тохирсон ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгосноор тогтмол нийлүүлэлтийн систем бэхжүүлэх шаардлагатай.
- Тээвэрлэлт, борлуулалтын тогтолцооны асуудал: Ченжүүд талбай дээрээс нь шууд хүссэнээр үнийг хямдруулж авах хандлагатай. Үйлдвэрлэгч хооронд зах зээлийн талаар мэдээлэл солилцох, хамтарч нийлүүлэх зэрэг үйлдвэрлэгч талын мөн чанарыг бэхжүүлэх, дуудлага худалдааны бирж бий болгох зэрэг борлуулалтын тогтолцоог орчин үеийн шийдлээр сайжруулах хэрэгцээтэй.
- Импортыг орлох цардуулын үйлдвэр байгуулах: Дотоодын хэрэгцээгээ 100% ханган, цаана нь үлдэх хэмжээнд байдаг хэдий ч, дотоодод цардуулын үйлдвэр байхгүй, одоо болтол гадаадаас импотолж байгаа. Нийлүүлэлтийн тэнцвэртэй байдлыг бодолцсон үйлдвэрлэлийн хэмжээг бодолцох хэрэгтэй ч хэдий ч иймэрхүү боловсруулах үйлдвэрлэлийг нэн даруй хөгжүүлэх хэрэгтэй.

3) Хүнсний ногоо тариалалт


Хүнсний ногоо тариалалт улаан буудай, төмсний тариалалттай адил, зах зээлд шилжсэний дараа 6 жил дараалан ургац буурсан байна. Харин 1998 оноос эхлүүлсэн хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн I (1998-2004 он) болон II үе шат (2005-2012он) хэрэгжсэнээр худаг усалгааны тогтолцоо бэхжиж, хүлэмжийн аж ахуйн технологи хөгжиж, үр суулгац, бордооны нийлүүлэлт сайжирч, тариалалтын хэмжээ нэмэгдсэн тул ургац хураалт мөн нэмэгдсэн байна. 2014 онд дотоодын хэрэгцээний 52 хувийг хангажээ (Зураг 2.6.7).



Эх сурвалж : ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.7 Хүнсний ногоо тариалалтын талбай, ургацын хэмжээ (1985-2014)


2014 оны нийт тариалалтын талбай болон ургацын хэмжээг аймаг тус бүрээр үзүүлсэн доорх хүснэгтэд харуулахад улсын хэмжээнд нийт 102,000 тонн хүнсний ногоо хурааснаас Сэлэнгэ, Дархан-Уул, Ховд, Төв дөрвөн аймагт улсын нийт ургацын хэмжээний 68% буюу 69,000 тонн хүнсний ногоо хураасан байна.



Эх сурвалж : ХХААЯ, <http://www.mofa.gov.mn/new/images/banners/sector/gazar01> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.8 Аймаг тус бүрийн ногоо тариалалт, ургац хураалтын хэмжээ (2014 он)

2010–2014 оны дотоодын хэрэглээ зураг 2.6.9-т харуулсанчлан дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байдал үргэлжилсээр байна.



Эх сурвалж : ХХААЯ-ны мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА -ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.6.9 Хүнсний ногооны дотоодын хэрэгцээ хангамж (2010-2014 он)

Сүүлийн үед эрүүл мэнддээ анхаардаг болсон тул ялангуяа Улаанбаатар хот зэрэг томхон хотуудад ногооны төрөл олширч байна. Түүнчлэн, өнөөгийн байдлаар БНХАУ аас хүнсний ногоо импортлодогос хүнсний аюулгүй байдал санаа зовоож байдаг тул дотоодод тарьсан хүнсний ногооны хэрэгцээ өсч байга абилээ. Цаашид, тогтмол нийлүүлэлт хийх боломжтой хүнсний ногооны үйлдвэрлэл хөгжих боломжтой байгаа хэдий ч дор дурдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.


Хүснэгт 2.6.3 Хүнсний ногоо тариалалтын тулгамдсан асуудал

- Орон нутагт тохирсон таримал ургамал тариалах технологийг дэмжих: Олон төрөл, янзын хүнсний ногооны тариалалтын технологийг хөгжүүлэх, тухайн орон нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохирсон үрийг үржүүлэн хөгжүүлэх ажлыг түргэвчлэх хэрэгтэй. Үүнд, хуучин социалист нийгмийн сангийн аж ахуйн үед өргөн ашиглагдаж байсан тариалангийн технологи, үр үржүүлэг зэргийг дахин үнэлэх ажил орно.
- Хүйтний улиралд дотооддоо хүнсний ногоо үйлдвэрлэх, нийлүүлэх тогтолцоог бий болгох: Тохиромжтой хүнс тариалалтын технологи дотор хүйтний улиралд ногоо тарих хүлэмжийн технологи орох боловч, дулааны зардал зэргийг тооцоход тогтвортой тариалахад хүндрэлтэй асуудал их бий. Газрын гүний дулаан ашиглах зэрэг дэвшилтэт технологиос суралцангаа, Монголын нөхцөлд тохирсон үйлдвэрлэл, нийлүүлэлтийн аргачлалыг судлах судалгаа, шинжилгээний хүрээлэн байгуулах гэх мэт төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
- Хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн баталгаатай, аюулгүй хүнсний ногоог найдвартай ханган нийлүүлэх тогтолцоог бий болгох: Аюулгүй, баталгаатай хүнсний ногоо, жимс нийлүүлэлттэй холбогдон, дотоодын хүнс, ногооны хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж буйн дээр импортын хүнсний ногооны шинжилгээний тогтолцоог сайжруулах хэрэгтэй.
- Сайн чанарын үр нийлүүлэх тогтолцоог бий болгох: Дээрх асуудалтай давхардах хэдий ч, сайн сортын үрүржүүлэх, хөгжүүлэх тогтолцоог бий болгоход, улсын хэмжээнд арга хэмжээ авах шаардлагатай. Одоо байгаа "ХАА шинжилгээ, судалгааны лаборатори"-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, түүний тулд судалгаа, шинжилгээний хүний нөөц бэлдэх зэрэг ажлыг цогц хөтөлбөр байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

(2) ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах технологийн өнөөгийн байдал

1) Гурилын үйлдвэрлэл

Голлох бүтээгдэхүүн болох улаан буудайн гурилын үйлдвэр Монголд 70 орчим байдаг. Эдгээр нь нийтдээ 1,500,000 тонн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай. Гэвч 2014 оноос хойш зөвхөн 47 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас Булганд 7, Дархан-уул болон Хөвсгөлд 6, Орхон болон Увс аймагт 5 үйлдвэр тус тус байна (зураг 2.6.10)



Эх сурвалж : ХХААЯ
http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=125&Itemid=197

Эх сурвалж : ХХААЯ
http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=125&Itemid=197 тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 2.6.10 Гурилын үйлдвэрийн байршил

Тэдний нэг шилдэг жишээг танилцуулъя. 2014 онд ашиглалтад орсон Эрдэнэт хотод байдаг гурилын үйлдвэрийн анхны хөрөнгө оруулалт 20 тэрбум төгрөг. Үйлдвэр нь Туркийн Алапала фирмийн босоо технологи бүхий тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Үр тариагаа татах, угаах, бутлах, савлах шатны боловсруулалт хийдэг. Сардаа 4,500 тонн улаан буудай боловсруулах хүчин чадалтай. Бүтээгдэхүүнийхээ 50-60 хувийг Дархан, Улаанбаатар, 20-25 хувийг Эрдэнэт, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, үлдсэн хувийг бусад аймгуудад нийлүүлдэг. Өөрөөр хэлбэл, Монгол улсын нийт 21 аймагт нийлүүлэлт хийж дотоодын гурилын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэлтээрээ 4-т ордог үйлдвэр юм. Энэ үйлдвэрт хэдийнэ 5S-ийг нэвтрүүлсэн бөгөөд одоо GMP/GHP⁶⁰、НАССАР (Hazard Analysis and Critical Control Point) зэрэг олон улсын эрүүл ахуйн стандарт нормыг нэвтрүүлэхээр зорьж байгаа. Тус компани нь ОХУ руу хөх тарианы гурилыг экспортлож эхэлсэн бөгөөд бусад бүтээгдэхүүнээ мөн экспортлох зорилт тавин ажиллаж байна

Зураг 2.6.11т 2010-2015 онд жил бүрийн 4 дүгээр сард Улаанбаатарын зах дээрх 1 кг гурилын бөөний дундаж үнийг харууллаа. 2013 оноос хойш дотоодын болон ОХУ-ын 1 кг гурилын үнэ аль аль нь 1000 төгрөгөөс давжээ. Оросын гурил дотоодын гурилаас үнэтэй байгаа нь Монголын Засгийн газар дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжихээр импортын бараанд НӨАТ ноогдуулсантай холбоотой. Импортын бараа дотоодын үйлдвэрлэгчдийн бараанаас 26.5 хувь илүү татвар төлдөг байна.

⁶⁰ GMP (Gross Manufacturing Practice) GHP (Gross Hygiene Practice)



Эх сурвалж: Economic & social situations of Ulaanbaatar Statistical monthly bulletin for 2015

Зураг 2.6.11 Улаан буудайн бөөний үнийн дундаж : Улаанбаатар (2010-2015 оны 4 сард хийсэн судалгааны дүн)

2) Хүнсний ногооны боловсруулалт

Ногоог давслах, даршлах гэх зэрэг энгийн аргуудаар боловсруулж хадгалах нь ихээхэн үр ашигтай. Намрын ургац хураалтын үеэр айл өрхүүд хэрэгцээндээ өргөст хэмх, лууван, байцаа гэх зэрэг ногоог энгийн аргаар даршилдаг. Мөн хүнсний ногоо тариалагчдын дунд намар зохион байгуулдаг худалдааны үеэр даршилсан ногоо их худалдаалдаг.

Даршилсан импортын ногоо зах зээлд их байдаг хэдий ч дотоодын томоохон болвсруулах үйлдвэр ногоо тариаланчидтай тусгай гэрээ байгуулан, дотоодын хүнсний ногоо ашиглан, БНХАУ-ын боловсруулалтын тоног төхөөрөмжөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үйлдвэрлэлийн процесс ердийн эрүүл ахуйн шаардлагыг хангасан. Лаазалсан, даршилсан бүтээгдэхүүн ойролцоогоор 20 гаруй нэр төрөл байхаас гадна, 500г нь 2000 төг орчмоор супермаркетуудаар худалдаалагдаж байна.

3) Жимс жимсгэний боловсруулалт

Жилд нийтдээ 2,000 тонн жимс боловсруулдаг 38 үйлдвэр Монголд байдаг. Голцуу чацаргана, үхрийн нүд жимсийг боловсруулж ундаа, шүүс эсвэл чанамал хийдэг. Увс аймагт жилд нийтдээ 128 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 14 үйлдвэр, Ховд аймагт жилд нийтдээ 206 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 8 үйлдвэр байгаа боловч бүгд боловсруулах хүчин чадал муу. Баян-Өлгий аймагт жилд нийтдээ 1,500 тонн бүтээгдэхүүн боловсруулах 2 үйлдвэр бий. Ер нь жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэлт баруун аймгуудад төвлөрсөн бөгөөд жилд

нийтдээ 3,100 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

4) Хүнсний боловсруулалт (Сүү цагаан идээ, мах)

Анхан шатны боловсруулалт хийсэн, удаан хадгалахад тохиромжтой малын гаралтай утсан, хатаасан махан бүтээгдэхүүн (борц, жерк г.м) сүүлийн үед их үйлдвэрлэж байна. Монголын хуурай, хүйтэн уур амьсгалд их тохирсон бяслаг мөн хатаасан бүтээгдэхүүнд орно. Хүйтний улиралд, ялангуяа махыг “байгалийн хөргөгчинд” хадгалах боломжтой тул удаан хадгалах гэж удаан боловсруулах шаардлагагүй үе байдаг нь хадгалалтын нэг онцлог. Дотоодын хүнсний томоохон үйлдвэрүүд нь ердийн эрүүл ахуйн шаардлагыг хангахын зэрэгцээ, бүтээгдэхүүнээ гадагш экспортлох зорилгоор олон улсын норм стандартыг хангахуйц эрүүл ахуйн хяналт чанарын норм стандартыг нэвтрүүлж (ISO22000, HACCP, ISO9001 зэрэг) үйлдвэрлэлээ явуулж байна. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн боловсруулах тоног төхөөрөмж нь ихэнхдээ Европоос орж ирсэн, ялангуяа Германы тоног төхөөрөмж байна. Нөхцөл байдлыг дүгнээд боловсруулах технологийн талаарх асуудлыг дэвшүүллээ.

Хүснэгт 2.6.4 ХАА боловсруулах технологийн талаар асуудал

- Ган, үер г.м. цаг агаарын нөхцлөөс шалтгаалан ургац алдаж үр тариа, түүхий эдийн хомсдол бий болох: гурилын үйлдвэр (улаан буудай)
- Цаг агаарын өөрчлөлт ургацын хэмжээнд шууд нөлөөлөх үйлдвэрлэл: хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цагаан идээний боловсруулалт
- Үйлдвэрлэлийн цар хүрээ хязгаарлагдмал: Хүнсний ногоо, жимс жимсгэний боловсруулалтад олноор үйлдвэрлэн, ашигтай ажиллах үйлдвэрлэлийн нөхцөл хүндрэлтэй.
- Боловсруулалтын арга технологи муу: Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах сүүний боловсруулалтанд уламжлалт боловсруулалтын түвшинд зогссон байдалтай, орчин үеийн нэмүү өтрөг шингэсэн боловсруулалт хоцрогдмол байна.
- Хүйтэн хөргүүрийн систем хангалтгүй: Сүү цагаан идээ, махны боловсруулалтын хувьд нийлүүлэлтийн шатанд бүтээгдэхүүний шинэлэг байдал зэрэг чанарын хяналт хангалтгүй байдгаас зах зээлд өрсөлдөх чадвараа алдахад хүрдэг. Хүйтэн хөргүүрийн систем зайлшгүй шаардлагатай.
- Олон улсын чанарын стандарт, нормыг хангахуйц эрүүл ахуй, чанарын хяналт муу: Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, мах боловсруулах шатанд эрүүл ахуй, чанарын хяналтын аргачлалыг барууны шилдэг арга технологи нэвтрүүлэх хэрэгтэй.
- Зах зээлийн өрсөлдөөн сул: Гурилын үйлдвэр, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, мах боловсруулах үйлдвэрлэлд нийтлэг байгаа асуудал бол боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, хяналтыг чандлан мөрдөх, үнийн өрсөлдөөнийг харгалзан бүтээмжийг тогтолцоог үр ашигтай болгох, автоматжуулах зэрэг зах зээл олохын төлөө хийж гүйцэтгэх ёстой нөхцөл олон бий. Гэхдээ түрүүний гурилын үйлдвэрийн жишээн дээрээс харсан шиг эдгээр асуудлыг шийдэж буй аж ахуйн нэгжүүд бий болсон тул цаашдын хөгжил найдлага төрүүлж байна.。

(3) ХАА-н импортын бүтээгдэхүүнээс хараат байдал

Богино хугацаанд буюу дулааны улиралд тариалсан ногоо хүрэлцээгүй учраас жилийн хэрэгцээний хүнсний ногоо, жимс жимсгэнээ хөрш Хятад, Орос зэрэг улсаас импортлодог нь хүйтний улирал урт цаг агаарын онцлогтой холбоотой. Иймээс хүнсний ногооны хангалт импортоос ихээхэн хамааралтай байна.

Хүнсний ногоо, жимс жимсгэний импорт сүүлийн жилүүдэд эргээд нэмэгдэх хандлагатай байгаа нь дараах Зураг 2.6.12-2.6.17 дахь ХАА-н бүтээгдэхүүний импортын графикаас харагдаж байна



Эх сурвалж: МҮСХ, Статистикийн эмхтгэлээс ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав. (бусад график адил)


Зураг 2.6.12 Улаан буудайн импортын хэмжээ (2002~2014 он)



Зураг 2.6.14 Төмсний импортын хэмжээ (2002~2014 он)




Зураг 2.6.16 Жимсний (алим, лийр ороогүй) импортын хэмжээ (2002~2014 он)



Зураг 2.6.13 Гурилын импортын хэмжээ (2002~2014 он)



Зураг 2.6.15 Сонгино, сармисны импортын хэмжээ (2002~2014 он)



Зураг 2.6.17 Алим, лийрний импортын хэмжээ (2002~2014 он)

Хүйтний улиралд ч хүнсний лангуунууд дээр импортын хүнсний бүтээгдэхүүн их байдаг (зураг 2.6.18). Дотоодын хүнсний ногоо борлуулагддаг ч төмс, лууван зэрэг удаан хадгалах боломжтой цөөн нэр төрлийн ногооноос илүү гардаггүй.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.18 Хүйтний улирлын хүнсний зах дээрх жимс, хүнсний ногоо


Зураг 2.6.19 дээр 2010-2015 онд жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотын захууд дээр зарагдсан 1 кг лууван, сонгино, байцаа зэргийн бөөний үнийн дундажийг харуулсан байна.



Эх сурвалж: Economic & social situations of Ulaanbaatar Statistical monthly bulletin for 2015

Зураг 2.6.19 Хүнсний ногооны бөөний үнийн дундаж: Улаанбаатар (2010-2015 оны 4 сар хийгдсэн үнийн судалгааны дүн)

Гэхдээ жимсний импортын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа гэсэн хэдий ч, зарим нэг төрлийн тухайд зураг 2.6.20-д харуулсанчлан, дотоодын жимс, жимсгэний тариалалтын талбай 2014 онд 56,400 га, ургацын хэмжээ 1,743 тонн болжээ. Үүнийг 2009 онтой харьцуулбал тариалалтын талбай 5.8 дахин, ургацын хэмжээ 4.5 дахин нэмэгджээ. Гэхдээ жимсний төрлийн бүтээгдэхүүний 90-94% нь чацаргана бөгөөд үлдсэн хувь нь алим, үхрийн нүд зэрэг жимс байна.



Эх сурвалж: XXААЯ <http://www.mofa.gov.mn/new/images/banners/monitoring/2014> ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.6.20 Жимс жимсгэний тариалалтын талбай, ургацын хэмжээ

Урт хатуу хүйтний улирлын хүнсний ногоо, жимсний тариалалтын нөхцлийг бодолцон, олон төрлийн хүнсний ногоог импортлохоос татгалзах хүндрэлтэй гэж хэлж болно. Гэхдээ хэд хэдэн асуудал дээр цаашид сайжруулах боломжтой.

- Импортын хүнсний бүтээгдэхүүний хорио цээрийн тогтолцоо (үлдэгдэл химийн бордоо гм) сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд "Хүнсний эрүүл ахуйн хяналт"-ийг чангатгах хэрэгтэй.
- Одоогоор хорио цээрийн хяналт нь бараа эргэлт ихтэй Замын Үүд боомт эсвэл Алтанбулаг боомт, Буянт Ухаа онгоцны буудалд явагддаг боловч бусад 5 боомтод хорио цээрийн хяналтын тоног төхөөрөмж хүрэлцээгүй, хангалттай хяналт хийгдэхгүй байна.
- Жилийн турш хүнсний ногоо нийлүүлэх боломжтой тариалалтын технологи, байгууламж бий болгох, жишээлбэл хүйтний улиралд ногоо тариалах боломжтой хүлэмж, ногооны үйлдвэр байгуулах ажлыг дэмжих хэрэгтэй. Ингэхийн тулд, эхний хөрөнгө оруулалтын санхүүгийн хөнгөлөлт, тариалалтын технологийн дэмжлэг зэрэг төрөөс үзүүлэх дэмжлэгийг бодолцох хэрэгтэй.
- Хүйтний улиралд ч тарих боломжтой жимс, жимсгэний тариалалтын технологийг дэлгэрүүлэх хэрэгтэй.

Хүйтний улиралд хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт эрхэлж буй дотоодын аж ахуйн нэгжүүдийн жишээг хавсралт 2.6.2-д нэгтгэн танилцуулав.

2.7 Хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээ бий болгох, зах зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэх өнөөгийн байдал, тулгарч буй асуудал

Энэхүү судалгаагаар Монгол улсын ХАА үйл ажиллагааны нэгэн хэлхээ буюу “Үйлдвэрлэлийн өмнөх” ⇒ “Үйлдвэрлэл” ⇒ “Үйлдвэрлэлийн дараа” ⇒ “Боловсруулалт” ⇒ “Тээвэрлэлт, борлуулалт”-ын шатны өнөөгийн байдал тулгамдсан асуудлыг дараах 2.7.1 зургаар нэгтгэн үзүүллээ.



Эх сурвалж: ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.7.1 Хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээн өнөөгийн байдал, асуудал

Дээрх зургаар ерөнхийд нь нийтлэг тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд үйлдвэрлэгчдээс өөрөөс шалтгаалах зүйл, төрөөс салбарын тогтолцоо, санхүүгийн дэмжлэг хэрэгтэй аль эсвэл хөгжингүй орны туршлага, технологи нэвтрүүлэх шаардлагатай асуудал холилдон орсон байгаа (5.5.2 бүлэгт тэр тухай авч хэлэлцсэн).

Түүнчлэн мэдээж бүх шатлалын асуудлын нөхцөл байдал, эрэмбэ дараалал нь бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалан өөр байгаа. Доорхийн дагуу бүтээгдэхүүний нэр төрлөөр нь өнөөгийн нөхцөл байдал болон тулгарч буй асуудлыг дэвшүүлж тоймлоно.

1) Улаан буудайн тариалалт

Улаан буудайн тариалалт Монголд үндсэн хэв шинжээ олсон хэдий ч тариалалтын өмнөх үе шатанд хамаарах хүндрэлтэй асуудал бол дотоодын сайн чанарын үр олж авах асуудал юм. Үүнээс гадна тариалалтын үе шатад бүтээмж нэмэгдүүлэх, чанар сайжруулах, услалтын байгууламжийг хөгжүүлэх зэрэг бэрхшээлтэй асуудлууд байдаг. Мөн тариалалтын дараах үе шатанд хамаарах асуудал бол хадгалах зоорьгүй аж ахуйн нэгжүүд хураасан ургацаа гурилын үйлдвэрүүдэд хэтэрхий хямд борлуулахаас өөр аргагүй болдог хандлагатай.

2) Төмс, хүнсний ногооны тариалалт

Төмс, хүнсний ногооны тариалалтын (улаан буудайн адил) үндсэн хэв шинж тогтсон ч гэсэн хүнсний ногооны хувьд тариалалтын өмнөх үе шатад хамаарах хүндрэлтэй асуудал бол сайн чанарын үр олж авах асуудал юм. Үүнээс гадна тариалалтын үе шатад бүтээмж нэмэгдүүлэх, чанар сайжруулах, услалтын байгууламжийг хөгжүүлэх зэрэг бэрхшээлтэй асуудлууд байдаг. Мөн тариалалтын дараах үе шатанд хамаарах хүндрэлтэй асуудал бол ченжүүд талбай дээрээс төмс, хүнсний ногоог хэт хямд үнээр худалдан авах асуудал юм. Иймээс чанарын стандарт нормыг тогтоож, түүнийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлж тоо хэмжээг чухалчилсан өнөөгийн тариалалтын хэв шинжээс чанарыг эрхэмлэсэн хэв шинж рүү шилжих шаардлагатай байна. Мөн хадгалах зоорь хангалттай байгуулж жилийн турш борлуулах бололцоог бий болгох нь чухал. Үүнээс гадна тээвэрлэлт, борлуулалтын үе шатад хамаарах чухал асуудал бол тариалан эрхлэгчдийн зах зээлд нэвтрэх ⁶¹ маркетингийн чадавхийг дээшлүүлж, зах зээлийн үнийн тогтолцоог нэн даруй бүрдүүлж, тогтворжуулах шаардлагатай байна.

3) Хүнсний боловсруулалт (сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн)

Тариалалтын дараа болон тээвэрлэлт, борлуулалтын үе шатанд авах шаардлагатай арга хэмжээ бол бол түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг муутгалгүй шинэлэг байдлаар нь тээвэрлэх, борлуулах, хадгалах технологийг нэвтрүүлэх юм. Харин боловсруулалтын үе шатад боловсруулах технологийг сайжруулах, олон улсын шаардлагыг хангах эрүүл ахуйн хяналт, чанарын стандарт нормуудыг (ISO22000, HACCP, ISO9001) нэвтрүүлэх шаардлагатай.

⁶¹ Зах зээлийн хэрэглэгч хайж эрэлхийж буй зүйлийг үйлдвэрлэх

2.8 Уул уурхайн, эрчим хүч салбарын өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлууд

(1) Уул уурхайн салбарын ерөнхий төлөв

Монгол улс нь уул уурхайн нөөц боломж ихтэй, 1,947 орд, ойролцоогоор 9,000 гаруй илрэл, 80 гаруй төрлийн ашигт малтмал судалгаагаар тогтоогдсон байна. Хүснэгт 2.8.1-д ашигт малтмалын төрөл болон нөөцийн хэмжээг үзүүлээ. Уул уурхай нь Монгол уосын эдийн засгийн өсөлтийг дэмжих гол тулгуур салбарын нэг бөгөөд, 2014 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувь, экспортын 90%, төсвийн орлогын 19%-ийг эзэлдэг. Гэвч уул уурхайн салбарын ажиллагсад нийт ажил эрхлэгчдийн зөвхөн 5%-ийг эзэлж байна.

Хүснэгт 2.8.1 Монгол улсын ашигт малтмалын нөөц (2013)

Ашигт малтмал	Нэгж	хэмжээ	Ашигт малтмал	Нэгж	хэмжээ
Алт (хатуу)	Тонн	2,550	Нүүрс	1 тэрбум тн	175.5
Алт (элс)	Тонн	292	Метан (~1,200m)	10 тэрбум м ³	3,118
Зэс	1 сая тонн	117	Газрын тос	1 сая тонн	333
Мөнгө	Тонн	42,137	Занар	1 тэрбум тн	788
Молибдин	1000 тонн	1,268	Шохойн чулуу	1 сая тонн	1,864
Төмрийн хүдэр	1 сая тонн	1,634	Жонш	1000 тн	47,843
Хар тугалга	1000 тн	2,090	Барилгын чулуу	1000 тн	531,537
Цайр	1000 тн	6,215	Элс	1000 тн	466,901
Гянт болд	1000 тн	561	Шавар	1000 тн	371,267
Тугалга	1000 тн	127	Магни	1000 тн	2,764
Ховор метал	1000 тн	2,985	Фосфатын чулуу	1000 тн	54,053
Уран	1000 тн	181	Цеолит	1000 тн	53,586


Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар (MRAM) Уул уурхайн яам (MOM)

Төмөр, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний дотоодын эрэлт бага байдгаас шалтгаалан цэвэршүүлэх, хайлуулах, ган гаргах гм боловсруулах үйлдвэрлэл хоцрогдож, ашигт малтмалыг түүхийгээр нь импортолж, экспортын бүтээгдэхүүнээс хараат байдалтай. Зөвхөн улсын дотоодын хэрэгцээнд зориулан үйлдвэрлэдэг хүрэн нүүрс, битумтай тослог нүүрсний хувьд цахилгаан, дулааны нийлүүлэлтийн гол бүтээгдэхүүн болдог бөгөөд дотоодын зах зээл дээр эрэлт өндөртэй.

Нөгөө талаар, Монгол улс нь БНХАУ, ОХУ 2-ын хооронд оршдог төв азийн орон бөгөөд өөрийн гэсэн найдвартай эскпортын гарцгүй, хэдэн цөөн экспортлогч оронтой харьцдаг. Хөрш зэргэлдээ оршдог дэлхий дээр хамгийн их хүн амтай БНХАУ-тай хийж буй экспорт нийт үнийн 88 хувийг эзэлдэг

бөгөөд ялангуяа уул уурхайн ашигт малтмалын хувьд БНХАУ-ын дотоодын эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байдаг. Энэ нь цаашид анхаарах асуудлын нэг юм. Мөн ашигт малтмал нь олон улсын зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай бүтээгдэхүүн билээ. 2012 оноос хойш ашигт малтмалын үнэ буурч байгаа нь Монгол улсын уул уурхайн салбараар зогсохгүй улсын нийт эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Ашигт малтмалын үнийн бууралт болон 2009 оны “Тол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн нөлөөгөөр 2008 онд улсын нийт нутаг дэвсгэрийн 44 хувийг эзэлж байсан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл 2014 онд 9.1 хувиар буурчээ. Эдгээрийн 0.5 хувь нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бөгөөд зөвхөн 0.01 хувийг үйлдвэрлэл эзэлж байна. Тусгай зөвшөөрлийн тоо ч мөн адил 2008 онд 5,202 байсан бол 2014 онд 2,732 болтлоо буурч, 2015 онд 2,997 болон бага зэрэг өссөн статистик тооцоо байна.⁶²



Эх сурвалж: “Статистикийн эмхтгэл 2014” Статистикийн Үндэсний Хороо

Зураг 2.8.1 Экспортын бүтээгдэхүүний төрөл, үнийн дүнгээр (зүүн тал) Экспортлогч улс тус бүр, үнийн дүнгээр (баруун тал)

(2) Нүүрс

Монгол улсын чулуун нүүрс зураг 2.8.2 үзүүлсэнчлэн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархан оршдог, нөөцийн хэмжээгээрээ дэлхийн топ 10 орны тоонд багтдаг. Нийт нөөцийн хэмжээг 176 тэрбум тонн хэмээн тооцоолсон. Нутгийн өмнөд хэсгээс баруун хэсэгт битумтай нүүрсний орд хөгжиж байгаа ба харин

⁶² MRAM; Mining and Geology Statistics, 2015 mid-year data

нутгийн төвөөс зүүн хэсэгт битумтай тослог нүүрс, хүрэн нүүрсний орд ашиглагдаж байна.

Чулуун нүүрсний үйлдвэрлэлийн хэмжээ 2008 онд 9,700,000 тн байснаа огцом өсч 2011 онд хамгийн их хэмжээтэй буюу 33,000,000 тн болсон. Нийт үйлдвэрлэсэн нүүрсний 23 сая тн нүүрсийг зөвхөн БНХАУ-руу экспортолсон байна. Мөн голдуу коксжсон нүүрсний түүхий эд болох хүрэн нүүрсийг түүхийгээр экспортолжээ. Гэвч БНХАУ-ын дотоодын зах зээл дээр нүүрсний эрэлт багасан олон улсын хэмжээнд үнэ унаснаас шалтгаалан үйлдвэрлэл болон экспортын хэмжээ буурч 2014 онд үйлдвэрлэлийн хэмжээ 25,000,000 тонн, экспортын хэмжээ ойролцоогоор 20,000,000 тонн болжээ. (Зураг 2.8.3). Экспортын дундаж үнэ 2011 онд 1 тонн нүүрс 107 ам.доллар байсан бол 2014 онд 43 ам доллар болон 50-иас дээш хувиар буурсан байна.⁶³ Үүнээс шалтгаалан, 2013 онд нүүрс олборлох тусгай зөвшөөрөлтэй 190 аж ахуйн нэгжийн зөвхөн 45 нь л үйл ажиллагаа явуулж байна. Экспортод нүүрс гаргадаг орд бүхий 14 компанийн тал нь л олборлолтоо зогсоолгүй үйл ажиллагаагаа явуулж байна.⁶⁴




Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар (MRAM)

Зураг 2.8.2 Монголын чулуун нүүрсний ордын тархалт

⁶³ Япон Монголын эдийн засгийн зөвлөл, 2014 оны Монгол уоцлсын гадаад худалдаа, 2015 оны 3 сар

⁶⁴ Oxford Business Group; ; The report Mongolia 2015



Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар (MRAM)

Зураг 2.8.3 Нүүрсний олборлолт, экспорт, дотоодын хэрэглээний хэмжээ

Зураг 2.8.4-т Дотоодын хэрэгцээнд зориулсан нүүрс нь /битумтай тослог нүүрс, хүрэн нүүрс/ цахилгаан дулааны хангамжийн гол эх үүсвэр болдог бөгөөд, анхдагч эрчим хүчний 81% /2012 он/⁶⁵, цахилгаан эрчим хүчний 79%-ийг /2013он/ эзэлдэг⁶⁶.Томоохон нүүрсний цахилгаан станц барих төлөвлөгөө болон эдийн засгийн хөгжлөөс хамаараад дотоодын нүүрсний хэрэгцээ цаашдаа баттай өсөх хандлагатай байна. Нөгөө талаар төрийн өмчит нүүрсний уурхай үнийн хяналтаас шалтгаалан их хэмжээгээр зардлаа танах шаардлагатай тулгарч байна. Жишээлбэл, дотоодын хэрэгцээнд зориулсан нүүрс /хүрэн нүүрсний/ үйлдвэрлэж буй Улаанбаатар хотын ойролцоох Багануурын нүүрсний уурхайн нэг тонн нүүрсний үнэ 2014 онд 25,500 төгрөг байсан бол, үйлдвэрлэлд зарцуулсан зардал нэг тонн 27,882 төгрөг буюу худалдаалах үнээс давсан байна⁶⁷.

Экспортод чиглэсэн нүүрсний ордуудын ихэнх нь Өмнөговьд төвлөрдөг. Гэвч төмөр замын бүтээн байгуулалтын төлөвлөгөө хоцорч байгаагаас зардал өндөртэй хүнд даацын ачааны машинаар тээвэрлэж байна. Энэ нь экспортын зардал өндөр болох нэг шалтгаан болж байгаа юм. Импортын чиг хандлагатай нүүрсний ихэнхи нь Таван толгойн уурхайгаас хилийн Гашуун сухайт боомт хүртэл 250 км хүнд даацын ачааны машинаар тээвэрлэгдэн, өөр машинаар БНХАУ-ын хилээр гарсны дараа Ганц мод боомтод хүргэгдэн, БНХАУ-ын

⁶⁵ Ministry of Energy (MOE) : Situation of Mongolian Power Sector, GSEP PowerWorking Group Workshop, Oct 2014, Ulaanbaatar

⁶⁶ Ulaanbaatar Electricity Distribution Company (UBEDN) : Mongolian Power Sector, IEEJ, 2014


⁶⁷ Багануурын нүүрсний уурхай асуулга судалгаа

төмөр замын вагонд шилжин ачигдах нь ердийн болоод байгаа ч, энэхүү тээвэрлэлтийн зардал нь 27 ам.доллар/тонн⁶⁸ байдаг гэх агаад, Австрали улсаас хэдэн мянган км усан онгоцоор тээвэрлэсэн үнээс 3 дахин их гэсэн үг юм. Ихэнхи нүүрсийг угаалгүй, тэр чигээр нь гаргаж байгаа тул үнэд хүрэхгүй, хямд зарагдана. Нүүрс угаах үйлдвэртэй уурхай дээр угаах шатанд нүүрсний нийт хэмжээний 20 орчим хувь нь хаягддаг. Энэхүү хаягдал энгийн нүүрсийг дулааны цахилгаан станцад ашиглах боломжтой. Импортын чиг хандлагатай нүүрсийг угаан, нэмүү өртөг шингээхэд энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Одоогийн төлөвлөж буй нүүрс угаах үйлдвэрүүд бүрэн ашиглалтанд орвол 10 сая тонн гаруй энгийн нүүрс хаягдал болох магадлалтай. Нөгөөтэйгүүр, Өмнөговийн бүсэд усны хүрэлцээний асуудал хурцадмал, нүүрс угаах үйлдвэрт их хэмжээний ус ашиглах тул, Японоос хуурай аргаар нүүрс угаах технологи нэвтрүүлэх эрэлт хэрэгцээ бий, NEDO (Япон улсын шинэ эрчим хүч, аж үйлдвэрийн технологийн нэгдсэн хөгжлийн хүрээлэн) хуурай аргаар нүүрс угаах технологи туршилт явуулахаар төлөвлөж буй)⁶⁹ (хүснэгт 2.8.2). Хуурай аргаар нүүрс угаахад хаягдал ус гарахгүй, боловсруулагдсан нүүрсийг хатаах хэрэггүй, усны хүрэлцээ муутай газарт ч ажиллуулах боломжтой зэрэг давуу талтай. Зардлын хувьд, нэгэнт баригдсан нүүрс угаах үйлдвэрийн нэг хэсгийг хуурай аргаар солих тохиолдолд зардал тооцоход хүндрэлтэй. Харин анхнаас нь хуурай аргаар нүүрс угаах үйлдвэр барих нь нойтон аргаар нүүрс угаах үйлдвэрээс бага зардалтай. Ялангуяа, ашиглалтын зардал хуурай аргаар угаах үйлдвэрийн хувьд маш бага байх тооцоолол бий.⁷⁰

⁶⁸ Erdenes TT ; Overview of Tavantolgoi Project, 2015

⁶⁹ Мицүи Мацүшима сангё ХХК : http://www.mitsui-matsushima.co.jp/pdf/other_552773cf5a026.pdf

⁷⁰ Нагата инжинеринг ХХК : материалын сериал дугаар 12-003, Хуурай аргаар угаах төхөөрөмж



Эх сурвалж: MOE and UBEDN

Зураг 2.8.4 2012 оны Анхдагч эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн эзлэх хувь /зүүн тал/, 2013 оны эрчим хүчний үүсвэр тус бүрийн хангамжийн эзлэх хувь /баруун тал/

Хүснэгт 2.8.2 Одоогийн баяжуулах станц болон барих төлөвлөгөө

No.	Компанийн нэр	Уурхай	Төрөл	Боловсруулах хүчин чадал (Мянган тонн/жилд)
Одоогийн Баяжуулах станц				
1	Energy Resorce LLC	Ухаахудаг Өмнөговь аймаг	Нойтон	15,000
2	MAK Company	Элдэв нүүрсний уурхай Дорноговь аймаг	Хуурай	75
3	Mo En Co LLC	Хөшөөтийн нүүрсний уурхай Ховд аймаг	Хуурай	2,400
4	Sharyn Gol Co., Ltd.	Дархан-Уул аймаг	Нойтон	600
Төлөвлөж буй				
5	Edrenes Tavantolgoi	Зүүн цанх Өмнөговь аймаг	Нойтон	20,000
6	Erdenes Tavantolgoi	Таван толгой Өмнөговь аймаг	Хуурай (NEDO)	300

Эх сурвалж: MRAM

(3) Зэс болон төмөр

2013 оноос Оюутолгойн ордын /ОТ/ ашиглалт эхэлснээр зэсийн баяжмалын экспортын хэмжээ, экспортын үнийн дүн их хэмжээгээр нэмэгдэж, 2014 оны нийт уул уурхайн бүтээгдэхүүний үнийн дүнгийн 44 хувийг эзэлж, нүүрсний оронд /15%/ тэргүүлж эхэлсэн (зураг 2.8.5). Оюутолгой нь Канадын Turquoise

Hill Resources /Рио тинто групп нийт хувьцааны 52 хувийг нь эзэмшдэг/ 66 хувийг, Монголын засгийн газар 34 хувийг эзэмшдэг Оюутолгой ХХК нь 2014 онд зэсийн баяжмал 540,000 тонныг үйлдвэрлэсэн. Зэсийн агууламж өндөртэй Оюутолгойн далд уурхайн олборлолт 2020 оноос эхлэх төлөвтэй байна. Далд уурхайгаас жилд 450 мянган тонн зэсийн баяжмал, 650 мянган унц алт, 3 сая унц мөнгө үйлдвэрлэнэ. Ил уурхайтай нийлүүлбэл 2020 он хүртэлх хугацаанд ДНБ-ний 30 хувийг эзлэх дэлхийд 2-рт тооцогдох зэсийн үйлдвэрлэл болон өсөх тооцоо байна.

Нөгөө талаар, Өмнөговь аймгийн цахилгааны эрчим хүчний дутагдалаас болоод Оюутолгойн үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчийг Хятаас импортлодог хараат байдалтай. Цаашдаа цахилгаан эрчим хүчний үйлдвэр байгуулж дотоодын эрчим хүчээр хангах шаардлагатай.

1978 оноос Зөвлөлт Холбоот улсын дэмжлэгтэйгээр байгуулагдаж үйлдвэрлэлээ эхэлсэн Эрдэнэтийн уурхайг одоогийн байдлаар Монгол улсын засгийн газар 51 хувийг, Оросын холбооны улсын засгийн газар 49 хувийг нь эзэмшдэг Эрдэнэтийн уурхай ХХК олборлодог. 2014 онд 520 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэжээ. Үүнээс гадна зэсийн баяжмал 300 мянган тонныг үйлдвэрлэдэг уурхай Өмнөговь аймагт байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулдаг ба хэсэг хугацааны туршид зэсийн баяжмалын экспортод эдгээр аж ахуйн нэгжүүд тэргүүлэх хандлагатай байна.



Эх сурвалж: “Статистикийн эмхтгэл 2014” Статистикийн ерөнхий газар

Зураг 2.8.5 Экспортын үнийн дүн, бүтээгдэхүүний төрлөөр (2014 он)


Засгийн газрын уул уурхайн бодлогын дагуу нэлээд хэдэн томоохон хэмжээний зэсийн баяжмалын үйлдвэр байгуулах төлөвлөгөө байгаа ч, их хэмжээний анхан шатны хөрөнгө оруулалт шаардлагатай мөн ашгийн хувь бага байдаг,

цэвэршүүлсэн зэсийн худалдан авагч хязгаарлагдмал байгаагаас болоод дорвитой үр дүнд хүрч чадаагүй байна. Зэсийн баяжмалын үйлдвэр барихаар төлөвлөж буй Сайншандын үйлдвэрлэлийн паркийн төлөвлөгөө зогсонги байдалтай байна.

Том хэмжээний уурхайн овоолгонд агуулагдах исэлдсэн зэсийг, цахилгаанаар уусгах олоорлолын аргыг (SX-EW) ашиглан катодын зэс үйлдвэрлэдэг 2 аж ахуйн нэгж байдаг /үйлдвэрлэлийн нийт хэмжээ 13,000 тонн/. 1 компани нь кабель зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төхөөрөмж эзэмшдэг ч дотоодын хэрэгцээ бага байдгаас, үйлдвэрлэлийн хүчин чадлын 12 хувьтай тэнцэх 180 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Төмрийн хүдрийг 100 хувь БНХАУ-руу экспортолж байгаа бөгөөд 2012, 2013 онд экспортын хэмжээ, үнэ огцом өсчээ. 2014 онд төмрийн хүдрийн үнийн уналтаас шалтгаалан экспортын үнийн дүн их хэмжээгээр буурсан.

Жилийн 500 мянган тонн шууд ангижруулсан төмөр /DRI/ үйлдвэрлэдэг төмөрлөгийн үйлдвэр /Дархан/ 100 мянган тоннын ширэм үйлдвэрлэх хүчин чадал бүхий төмөрлөгийн үйлдвэр /Эрдэнэт хот/ байгуулах төлөвлөгөө хэрэгжиж байна. Эдгээр үйлдвэрүүд дотоодын зах зээлд нийлүүлэх барилгын материал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй боловч барилгын оргил үе өнгөрөөд байгаа өнөөгийн нөхцөлд дотоодын хэрэгцээ 400 мянган тонноор хязгаарлагдаж байгаа тул бүрэн хэмжээгээрээ ажиллах боломжгүй болох нь тогтоогдоод байна.



Эх сурвалж: MRAM

Зураг 2.8.6 Баяжуулсан зэс /зүүн/, төмөрлөгийн үйлдвэрлэл, экспортын хэмжээ/баруун/

(4) Бусад ашигт малтмал

Газрын тосны үйлдвэрлэл 1950-иад оноос эхлэн олборлолт, боловсруулалт хийж эхэлсэн, Зураг 2.8.7 үзүүлсэнчлэн сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа

гэж үзэж байгаа ч, олон нийтэд ил тавигдсан мэдээлэлд жилийн тайлан байхгүй байна. 2011 он хүртэл 28,300km² т 2 хэмжээст чичирхийллийн хайгуул судалгаа, 5,920km² т 3 хэмжээст чичирхийллийн хайгуул судалгаа хийн, 844 ш гүний цооног өрөмдөн, 239 ш цооногоос олборлолт хийж байна⁷¹. Нийт нөөцийн тухайд олон улсын байгууллага зэргээс гаргасан тоо баримт одоогоор алга байна. Нөгөөтэйгүүр, гасрын тосны үйлдвэрлэлийн хэмжээ огцом нэмэгдэж байгаа нь Петро Чайна болон Синопек зэрэг БНХАУ-ын газрын тосны томоохон компаниуд их хэмжээний олборлолт хийж эхэлсэнтэй холбоотой. 2012 оны байдлаар 14 Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдсан байгаагаас 39% нь БНХАУ-ын компани, 33% нь Монголын компани, 28% нь бусад гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байна⁷². Түүн дотор БНХАУ-ын компани бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан ажиллаж байгаа говийн урд хэсэгт байрлах (Сайншандаас урагшаа 50 км) Зүүнбаян орд 2012 оны 2 сарын байдлаар 2.66 барелл, Монгол улсын зүүн хэсгийн Тамсаг ордоос 2.07 барелл зэргээр нийт газрын тос үйлдвэрлэлийн дийлэнхи хувийг эзэлж байна⁷³.

Одоогоор Монгол улсад боловсруулах тоног төхөөрөмж хангалтгүй байгаа тул, олборлосон газрын тосны дийлэнхи хэсгийг БНХАУ-руу экспортолж, дизель, бензин зэрэг нефтийн бүтээгдэхүүний ихэнхийг ОХУ-аас импортолж байна. 2014 онд газрын тосны үнэ буурснаар, импортын хэмжээ буурсан байгаа ч, газрын тосны экспортын борлуулалтын дүн 63 тэрбум ам.доллар байгаатай харьцуулахад нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 111 тэрбум ам.долларт хүрсэн байна. Нефтийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн, энэ асуудлын шийдвэрлэхийн тулд Дархан-Уул аймагт жилд 2 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр барих төлөвлөгөө батлагдан, Японы худалдааны болон инженерийн компани тендерийн ажил хийхээр сонгогдсон гэх мэдээ цацагдаж⁷⁴ байсан хэдий ч төсөл зогсонги байдалтай байна. Нөгөөтэйгүүр, Хэнтий аймгийн Бор-өндөрт жилд 2.3 сая тонн боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, орд хүрэх хоолой тавих төсөл 2016 оны 2 сард Засгийн газраар батлагдсан байна⁷⁵. Энэхүү үйлдвэр 2020 онд ашиглалтанд орох төлөвлөгөөтэй.


⁷¹ Petro Matas Ltd.: Oil in Mongolia, <http://www.petromatad.com/mongolia/oil-in-mongolia/>

⁷² Petro Matas Ltd.: Oil in Mongolia, <http://www.petromatad.com/mongolia/oil-in-mongolia/>

⁷³ Hart Nurse Ltd, Mongolian Eighth EITI Reconciliation Report 2013, December 2014.

⁷⁴ InfoMongolia.com: <http://www.infomongolia.com/ct/ci/5482>, January 2013

⁷⁵ МОНЦАМЭ No.07 (547) 2016 оны 2 сар



Эх сурвалж: USEIA



сурвалж: "Статистикийн эмхтгэл 2014", МҮСХ

Зураг 2.8.7 Газрын тосны үйлдвэрлэл (зүүн), импорт, экспортын хэмжээ

Алт олборлолтыг голын ай сав, ой модноос 200 метрийн дотор газар хориглосон хуулийн нөлөөгөөр 2009 оны оргил үеэсээ буурч байгаа ч Засгийн газрын дэмжлэгээр 2014 онд олборлолтын хэмжээ сэргэх хандлагатай байна. Бага оврын олборлолт хийдэг аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор, нөөц ашигласны төлбөрийг нэгэн жигд 2.5 хувь болгон буулгаж, Монгол банкны худалдан авалтын хэмжээг 2013 оны 4.5 тонноос 2014 онд 10 тонн болгон нэмэгдүүлсэн. Мөн Голомт банкаар дамжуулан 120 сая ам.долларын хөнгөлттэй зээлийн төслийг хэрэгжүүлсэн⁷⁶. Алтыг ихэвчлэн Англи /94%/, Канад /6%/ улсад экспортолдог бөгөөд Хятадаас бусад улсад экспортолдог цөөн бүтээгдэхүүний нэг юм. Шинээр олболох уурхайн тоо нэмэгдэж байгаа.

Цайрын баяжмалыг /45-52%/ жилд 100 мянган тонн олборлож бараг бүгдийг нь экспортолдог. Цагаан тугалгыг ойролцоогоор 120 тонн орчмыг олборлож бүгдийг нь экспортолдог.



Жонш Дэлхийд жонш олборлолтоороо 3-рт жагсдаг бөгөөд 2014 онд 310 мянган тонныг экспортолсон. Цайр нь бүтээгдэхүүний хувьд металлургийн доогуур төвшинтэй.⁷⁷ Өндөр агууламж бүхий хүчиллэг төвшинтэй⁷⁸ жонш үйлдвэрлэхийн тулд боловруулах үйлдвэр шаардлагатай.

Өнгөт метал болох молибденийг Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрт үйлдвэрлэдэг. Молибдений баяжмалыг /бүтээгдэхүүний хэмжээ 50 хувь/ 2014 онд 4000 тонныг экспортолсон. Гянт болдыг мөн баяжмал хэлбэрээр бүгдийг нь экспортолдог. 2014 онд 1,500 тонныг экспортолжээ.

⁷⁶ Oxford Business Group; ; The report Mongolia 2015

⁷⁷Хайлуулах үе шатанд хольж ашиглагддаг фторт кальци (CaF₂) хэмжээ нь 97% оос доош

⁷⁸Химийн үйлдвэрийн түүхий эдээр ашиглагддаг фторт кальци (CaF₂) хэмжээ 97% оос дээш




Эх сурвалж: MRAM

Зураг 2.8.8 Алт /зүүн/, Молибденийн баяжмал /баруун тал/ үйлдвэрлэл, экспортын хэмжээ

Уран ашиглахтай холбоотой Францын компани тэргүүлэх үүрэгтэй зүүн бүсэд хайгуулын ажил, туршилтын олборлолт хийгдэж байна. Энэхүү үйл ажиллагаанд Японы компаниуд ч оролцож байна.

Газрын ховор металлын хувьд одоогийн байдлаар хайгуулын шатандаа явж байна. Өнөөг хүртэл Германы компаниуд 3 газар хайгуулын судалгааг 3 удаа хийж, 4 газарт ирээдүйтэй орд газар байгааг илрүүлсэн. Зураг 2.8.9 Газрын ховор металлын албан ёсны хайгуулын ажил хараахан хийгдээгүй байна. Зэсийн хайгуулын дүнд дагалдах бүтээгдэхүүн болох гянт болд, моллебиден, цагаан тугалгын орд бүхий газар илэрсэн. JOGMEC-тай хамтран газрын ховор металл, ховор металлыг хайх хамтарсан хайгуулын ажиллагаа явагдаж байна.⁷⁹



Эх сурвалж: MRAM

Зураг 2.8.9 Ирээдүйтэй ховор металлын орд

⁷⁹ JOGMEC : <http://www.jogmec.go.jp/news/release/release0276.html>

(5) Эрчим хүчний шинэ нөөцийг хөгжүүлэх технологи

Монгол улсын хувьд арвин баялаг нүүрсний нөөцтэй ба дотоодын эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд цаашдаа ч нүүрснээс хараат байдал үргэлжлэх хандлагатай байна. Гэвч нүүрсний хэрэглээ /шаталт/ -нээс болоод агаарын бохирдол, нүүрсхүчлийн хий ихээр ялгарах зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Иймээс байгаль орчинд нөлөө бага үзүүлэх нүүрс эрчим хүчний нөөцийг хөгжүүлэх технологи зайлшгүй шаардлагатай байна. Нүүрсийг олборлож шууд шатаалгүйгээр нүүрсэнд агуулагдах энергийг цуглуулах технологи болох Нүүрсний давхаргад байх метан хийг гаргах Coalbed Methane: CBM технологи болон, нүүрсийг газрын гүнд хий болгох Underground Coal Gasification: UCG технилогийн талаар танилцуулъя.

1) Нүүрсний давхаргаас метан гаргаж авах (CBM)

Нүүрсжих явцад дулааны үйл ажиллагаа болон бичил биетнээс үүсдэг CH_4 зэрэг ялгардаг бөгөөд CBM гэж тэрхүү CH_4 нүүрсний давхаргаас гадагшлуулалгүйгээр нүүрсэнд шингэх тэрхүү байдлыг хэлнэ. Бүрхэгдсэн хэмжээ нь чулуун нүүрсэнд хамгийн ихээр агуулагддаг зураг 2.8.10-ыг харна уу. CBM нь CH_4 –ийг үндсэн бүрэлдэхүүн хэсгээ болгодог цэвэр хий бөгөөд байгалийн хий боловсруулахтай холбоотой үйлдвэрлэлийн технологи болон ашиглалтын технилогийг хэрэглэх боломжтой. CBM-ийг боловсруулахдаа зорилтот нүүрсний давхарга хүртэл өрөмдлөгө хийдэг тул нүүрсний олборлолттой харьцуулахад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай. Мөн үйлдвэрлэсэн CBM нь шаталтын явцдаа ялгаруулах CO_2 болон бохирдуулагч бодис нь нүүрснээс бага байдаг байна.


Монгол улсад, нэлээд хэдэн нүүрсний уурхайд U.S. EPA⁸⁰-ийн дэмжлэгтэйгээр CBM-ийн нөөцийн судалгааг хийсэн⁸¹. Бүрэн хэмжээний нөөцийн үнэлгээ хараахан хийгдээгүй байгаа бөгөөд бүс нутаг тус бүрээр нүүрсний тогтоогдсон нөөцийн хэмжээ болон CBM агуулагдах нөөцийн хэмжээний тооцоон дээр үндэслэн CBM-ийн нийт нөөцийн хэмжээг 3 их наяд M^3 хэмээн тогтоожээ⁸². Америкийн нэгдсэн Улс, Канад, Австрали, Хятад зэрэг оронд CBM-ийг бизнесийн зорилгоор үйлдвэрлэж ашиглаж байна. CO_2 -ийг нүүрсний давхаргад даралтаар шахаж тогтоосноор CBM-ийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх

⁸⁰ АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (United States Environmental Protection Agency)

⁸¹ Жишээлбэл U.S. EPA (United States Environmental Protection Agency, Pre-feasibility Study for Coal Mine Methane Recovery and Utilization at Baganuur Mine, Mongolia, 2014)

⁸² Mongolian Nature and Environment Consortium ; Coal Mine Methane (CMM) Resource Assessment and Emissions Inventory Development in Mongolia, 2014

технологи шинээр гарсан. Японы Юбари бүс нутагт Эдийн засаг аж үйлдвэрийн яамны дэмжлэгтэйгээр батлах туршилт хэрэгжиж байна⁸³.



Эх урвалж: Schulumberger, Oilfield Review 2003


Зураг 2.8.10 Нүүрсжих явц болон хийн агуулагдах хэмжээ

Нүүрсжих явц болон хийн агуулагдах хэмжээ

Зураг 2.8.2-т үзүүлсэнчлэн, Монгол улсын Өмнөговийн бүс нутгаас баруун зүгт том хэмжээний чулуун нүүрсний орд тархан байрласан. Энэ бүс нутагт СВМ-г хөгжүүлэн бүрэн бололцоотой юм. Мөн төвийн бүсийн хойд хэсгийн битумтай тослог нүүрсний ордуудыг ашиглан СВМ-г хөгжүүлж болно гэсэн судалгаа байна. СВМ-г боловсруулж ашиглахын тулд хийн агуулагдах хэмжээ, нүүрсний давхаргын шингээлтийн хувийн талаар нарийн судалгаа хийх шаардлагатай байгаа бөгөөд ил олборлолтод тохиромжгүй гүний нүүрсний давхаргаас цэвэр энерги ялган авах технологи болгон ашиглах боломжтой. Эрдэнэс Таван Толгой компани Солонгосын KOGAS компанитай хамтран бүрэн хэмжээний судалгааг Таван толгойд эхлүүлээд байна. Газрын гүн 800 метрт 5 ш СВМ-ийн цооног суурилуулан өрөмдлөгийн ажил хийж байна⁸⁴. Монголд СВМ нөөц ихтэй хэмээн таамаглагдаж байгаа хэдэн зуун м гүний нүүрсний давхаргын хувьд одоогоор хайгуул, судалгаа хийгдээгүй, цаашид СВМ үйлдвэрлэл хөгжүүлэхэд чиглэсэн хайгуулын ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.

⁸³Байгаль орчны нэгдсэн технологи : CO₂ ашиглан СВМ үйлдвэрлэх технологийн туршилтын үр дүнгийн тайлан, 2008

⁸⁴Эрдэнэс Монгол ХХК дээр хийсэн ярилцлагын дүнгээс



Эх сурвалж: Газрын гүний нөөцийн инновацийн сүлжээ

Зураг 2.8.11 CBM боловсруулах технологийн бүдүүвч зураг /CO₂ ашиглан CBM үйлдвэрлэх/

2) Газрын гүнд нүүрсийг хийжүүлэх (UCG)

UCG нь, хүчилтөрөгч зэрэг исэлдэгч бодис шахахад газрын гүнд агуулагдаж буй нүүрсийг байгаа байранд нь хий болгон CO, H₂, CH₄, CO₂ зэргийг үндсэн бүрэлдэхүүнээ болгодог Syngas/ нийлэг шатдаг хий/ -г газрын гадаргуугаас өрөмдөх үйлдвэрлэлийн цооногоор дамжуулан цуглуулах технологи. Зураг 2.8.12. UCG нь ердийн олборлолтын аргаар ухах зорилтот хэсэгт хамаардаггүй бүтээгдэхүүний агууламж доогуур нүүрс болон газрын хэт гүнд байршиж байгаа нүүрсийг ашиглахад тохиромжтой технологи юм. Энэхүү технологийг нэвтрүүлснээр нүүрсний олборлолт их хэмжээгээр нэмэгдэх боломжтой.

Ер нь UCG нь исэлдүүлэгч бодисыг илгээх шахагч цооног, Syngas-ийг цуглуулах үйлдвэрлэлийн цооног, эдгээрийг холбох холбогч цооногоор бүрддэг⁸⁵. Сүүлийн жилүүдэд нүүрсний давхарга дотор чөлөөтэй ухалт хийдэг чиглэл бүхий технологи хөгжиж байгаатай холбоотой өрөмдлөгө хийж холбох хоолойг хялбархнаар тавьдаг болсон. Иймээс дэлхийн хэмжээнд тус технологит анхаарлаа хандуулж байгаа юм.

UCG технологиор нүүрсний олборлолт, газ боловсруулах станц барих шаардлагагүй тул өмнө нь ашиглагдаж байсан IGCC⁸⁶) -гээс хямд төсөр эрчим

⁸⁵ Linking: нүүрсний судалд бий болдог Антиоксидант агуулсан бодис эсвэл боловсруулсан хийг холиж хийсэн замыг бий болгох юм. UCG хэрэгжүүлэх чухал элемент технологи, өндөр даралтын агаар урсаж, цахилгаан хэрэглэж байсан гэхэд ан цав өргөжүүлэх уламжлалт арга юм.

⁸⁶ Integrated Coal Gasification Combined Cycle

хүчээр хангах боломжтой болно. Carbon Energy компани 300MW зэрэглэлийн нийлмэл мөчлөг бүхий эрчим хүчтэй хавсран цахилгааны нэгжийн үнийг 0.035\$/квт болгох тооцоо хийсэн⁸⁷. Мөн USG-гийн Syngas нь газрын гадаргуугийн нүүрс газны станцын газтай нэгэн адил химийн үйлдвэрлэлийн түүхий эд болгон олон төрлийн зориулалтаар ашиглагдах боломжтой. Цаашилбал USG-д нүүрснээс гарах үнсний асуудал үүсэхгүй, хортой элемент харьцангуй бага ялгардаг гм олон давуу тал байдаг. Нөгөө талаар, USG нь хий алдагдсанаас үүсэх газрын гүний бохирдол болон газрын гадаргуугийн суулт зэрэг риск дагуулдаг ч зохих ёсны гүн болон газрын чанарын нөхцөлийн шалгалт, хяналтыг хэрэгжүүлбэл сэргийлэх бүрэн боломжтой. Энэ технологийг Австрали, Канад, Өмнөд Африк, Хятад зэрэг оронд нэвтрүүлэн, том хэмжээний туршилт хийгдсэн байна. Австралид 5 MW-ийн хийн цахилгаан станц⁸⁸ FT процесс⁸⁹ оор гаргаж авдаг шингэн түлшний үйлдвэрлэлийг⁹⁰ амжилттай хэрэгжүүлж чадсан байна.


Гэхдээ USG-ийн хувьд, Монголд төдийлөн их сонирхохгүй, одоогоор мэргэжлийн түвшинд буюу шинжилгээний лабораторит туршилт хийх талаар яригдаагүй, технологийн тухай мэдлэг, мэдээлэл бага байна. Цаашид, USG технологи нэвтрүүлсэн шинэ эрчим хүчний үйлдвэрлэл, химийн үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд, USG технологийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай.

⁸⁷ C. Mallett; Underground Coal Gasification in the Surat Basin -The Logical Clean Coal Option, Clean Coal 2007

⁸⁸ <http://www.carbonenergy.com.au/>

⁸⁹ Fischer-tropsch process: Нүүрстөрөгчийн исэл ба устөрөгчөөс нь катализаторын урвалыг ашиглан шингэн нүүрс устөрөгчийн нийлэх нь үйл явцын

⁹⁰ http://www.lincenergy.com/clean_energy_australia.php



Эх сурвалж: Carbon Energy Co.

Зураг 2.8.12 UCG боловсруулах технологийн ойлголт

(6) Сэргээгдэх эрчим хүч

Уул уурхайн салбар нь, олон төрлийн байгууламжийн эрчим хүч, олборлох төхөөрөмж тээврийн хэрэгслийн шатахуун зэрэг эрчим хүч ихээхэн шаарддаг салбарын нэг юм. Уурхайн шинэ бүтээн байгуулалт эсвэл өргөтгөл хийхэд шаардлагатай эрчим хүчний эрэлт нэмэгдэхэд импортоос хараат эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүний импортийн хэмжээ нэмэгдэнэ. Монгол улсад анхдагч эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хувьд нь, хувьд нүүрс 81%, нефьт 15%, бусад /сэргээгдэх эрчим хүч/ 4%-ийг эзэлдэг. Мөн цахилгаан эрчим хүчний хангамжийн хувьд нүүрс 79%-ийг эзэлдэг бөгөөд 19%-тай тэнцэх хэмжээний эрчим хүчийг импортолж, сэргээгдэх эрчим хүч 2% байдаг байна. Үүнээс харахад эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийн бүтэц нүүрснээс хэт хараат байдалтай байна. Энэ нөхцөл байдал нь агаарын бохирдол, хүлэмжийн хий /GHG/ хэт их ялгарч байгаа тул цаашид зайлшгүй арга хэмжээ авах асуудлын нэг гэж дүгнэж болно

Монгол улсын NAMA /Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зохистой арга хэмжээ - Nationally Appropriate Mitigation Actions /-гийн хүрээнд эрчим хүчний нийлүүлэлтийн салбарт сэргээгдэх эрчим хүчийг сонголтын нэг болгон нэмэх, нүүрсний чанарыг дээшлүүлэх /кокжсон нүүрс, чанарыг сайжруулах/, дулаан дамжуулдаг уурын генераторын бүтээмжийг дээшлүүлэх, ахуйн хэрэгцээнд

ашиглагдаж буй зуухыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа тусгагдсан байна.

Монгол улсад салхины, нарны, усан, газрын дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүч ашиглах боломж нэлээд өндөр бөгөөд Монголын сэргээгдэх эрчим хүчний төвийн тооцоолсноор салхи 7 MW/km², нар 66MW/ km² газрын дулаан болон усан цахилгаан станцын нийт боломж 2.6 TW эрчим хүч гаргах хүчин чадалтай гэсэн тооцоо байдаг (зураг 2.8.13). Засгийн газар 2020 он хүртэл эрчим хүчний үйлдвэрийн хүчин чадлыг 20%-иар, 2030 он хүртэл 20%-иар тус тус нэмэгдүүлнэ хэмээн сэргээгдэх эрчим хүчнийг нэвтрүүлэх зорилтдоо дэвшүүлэн тавьжээ.⁹¹


2013 онд 50 MW-ийн салхин цахилгаан станцыг Салхитад барин ажиллаж эхэлсэн. Том хэмжээний усан цахилгаан станцийн хувьд БНХАУ-ын экспорт импортын банкны 1 тэрбум ам долларын хөнгөлттэй зээлийн 827 сая доллороор 315MW хүчин чадал бүхий Эгийн гол усан цахилгаан станц барих ажлыг хэрэгжүүлж байсан. Харин ОХУ Байгаль нуурын байгаль орчид сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэн, 2016 оны 11 сарын байдлаар зогсонги байдалтай байгаа.⁹²

2012 онд 450 кв-ийн хүчин чадал бүхий Монголд анхдагчид тооцогдох сүлжээнд холбогдсон нарны эрчим хүчний станц ЖАЙКА-гийн буцалтгүй тусламжаар байгуулагдаж, мөн 2014 онд 10MW-ийн хүчин чадалтай нарны цахилгаан станц барихтай холбоотой Японы Байгаль орчны яамны JCM судалгаа⁹³ хийгдсэн. Иймээс цаашдын үйл ажиллагаа ихээхэн найдлага төрүүлж байна. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах боломж бүхий сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний хэмнэлттэй холбоотой технологи, байгууламжийг нэвтрүүлэхэд JCM системийг ашиглах нь үр дүнтэй юм.

⁹¹ State Policy on Energy (Parliament resolution No. 63, 2015), Green Development Policy 2014.

⁹² Жишээ нь: <http://www.infomongolia.com/ct/ci/9929>,
<http://www.globalconstructionreview.com/news/russian-objections-ha7lt-1bn-mongolian-da7m/>

⁹³ JCM web page, GEC; http://gec.jp/jcm/projects/14ps_mgl_01.html



Эх сурвалж: Mongolian National Renewable Energy Center

Зураг 2.8.13 Сэргээгдэх эрчим хүчний потенциал

(7) Уул уурхай, эрчим хүчний салбрын нийгэм, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөө


Хүн ам ихээр төвлөрөн суурьшдаг Улаанбаатар зэрэг томоохон хотуудад бага оврын дулааны хангамжийн байгууламж-уурын зуух /НОВ / болон гэр хорооллын оршин суугчид өргөнөөр ашигладаг ахуйн хэрэглээний зууханд бүтээгдэхүүний доогуур агууламжтай нүүрсийг хэрэглэж байгаа нь агаарын бохирдлыг үүсгэж байна. Энэ асуудал нийгмийн асуудал болон хурцадсан.

Үүний эсрэг арга хэмжээ болгон Засгийн газраас хагас коксжсон болон LPG-г дэлгэрүүлэхээр зорьж байгаа боловч бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн хэмжээ, нэгжийн үнэ зэрэг шалтгаанаас болоод нүүрсний хэрэглээг эдгээрээр солих хэмжээнд хүрч чадахгүй байна. Мөн дулааны цахилгаан станцын нүүрсний үнсний асуудал анхаарал татаж байна.

Олборлолтын дараах нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдох тохиолдол олонтоо гарч, байгаль орчинд ноцтой хохирол учруулж байна. Ашигт малтмалын газрын /MRAM/ статистик мэдээллээс харахад, 2006 оноос 2014 онд олборлолт хийгдсэн нийт талбайн хэмжээ 26,299 га байна (Зураг2.8.14). Олборлолт явуулсан газрын 68%-д нөхөн сэргээлт хийгдсэн ч, нийт нөхөн сэргээлтийн дөнгөж 27% нь ургамлыг бүрхэвчийг сэргээх хэмжээнд хүрчээ. Харин үлдсэн

хэсэг нь өнгөцхөн шороогоор булаад орхисон нүд хуурсан нөхөн сэргээлтийн байдалтай байна.

Олборлолт явуулж буй аж ахуйн нэгжийн нөхөн сэргээх үйл ажиллагааг хуулинд үүрэг болгон заасан ч, газар дээр энэ байдал хэрэгжихгүй байх тохиолдол олонтой гарч байна. Техникийн удирдамж байхгүйгээс болоод үйл ажиллагаа явуулж байхдаа олборлолт дууссаны дараа хийгдэх нөхөн сэргээлт зардлын санд хуримтлал үүсгэх функц ажиллахгүй байна. Энэ нь нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа нэг шалтгаан болж байна хэмээн үзэж болох юм⁹⁴. Зарим нэг нүүрсний уурхай тухайн орон нутгийн цаг агаар болон газрын хөрсөнд тохиромжтой ургамлыг судлах, туршилтын журмаар ургуулах ажлыг хийж байна.



Эх үүсвэр: MRAM; Mining and Geology Statistics, 2015 mid-year data

Зураг 2.8.14 Олборлолтын дараах нөхөн сэргээлтийн хувь хэмжээ (2006-2014 он нийт дүн)

Төмөр замын бүтээн байгуулалт хоцрогдож байгаагаас шалтгаалан шороон замаар хүнд даацын машинаар уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлохоор тээвэрлэж байна. Эдгээр орон нутгийн зам эвдэрч сүйдэн, хүний амь эрсдсэн осол, аваар гарч, тоосжилт, ойр орчмын бэлчээр устах зэрэг байгаль орчны сүйрэл тулгамдсан асуудал болоод байна(Зураг 2.8.15). Иймд хатуу хучилттай авто зам барих, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай.

⁹⁴ Монголын уул уурхайн холбоотой хийсэн ярилцлагаас



Эх сурвалж: <http://mongoliaeconomy.blogspot.jp/2010/12/coal-transportation-damages-roads.html>

Зураг 2.8.15 Шороон замаар нүүрс тээвэрлэж буй хүнд даацын машинууд

“Нинжа” хэмээн нэрлэгддэг хувиараа алт, жонш, нүүрс гар аргаар хууль бусаар олборлодог хүмүүсийн тоо 100 мянгад хүрсэн гэсэн судалгаа байдаг (Зураг 2.8.16). Монголын нийт хүн амын тоо 3 сая орчим бөгөөд хөдөө орон нутгийн ажиллах хүчний 20 гаруй хувийг нинжа нар эзэлж байна⁹⁵. Нинжагийн тоо 1997 оноос 2002 оны хооронд огцом өссөн. Энэ нь ган, зуд⁹⁶ зэрэг байгалийн гамшгаас болоод мал аж ахуй эрхлэх аргагүйд хүрсэнтэй холбоотой. Хууль бус олборлолт хийж байгаагаас ашигт малтмалын нөөцийн хомсдол, мөнх цэвдэг устсанаас шалтгаалан гол мөрний систем алдагдах, мөнгөн усны хэрэглээнээс үүдэлтэй гол, газрын хөрсний бохирдол, бэлчээр сүйдэх, цөлжилт үүсэх зэрэг байгаль орчинтой холбоотой ноцтой асуудлууд бий болжээ.

Харин цөөн тооны уул уурхайн бүсэд эдгээр хууль бусаар ашигт малтмал олборлогсдыг хуулиар хүлээн зөвшөөрч аж ахуйн нэгж хэмээн тооцон, татвар, нөхөн сэргээлтийг үүрэг болгох бодлого баримталж байна.⁹⁷ Гэвч томоохон орд газар уул уурхайн компаниудын эзэмшилд байгаа бөгөөд нинжа нар олборлолт хийж болох газар хязгаарлагдмал байна. Улмаар нинжа нарт сонголт бага байгаагаас дахин хууль бусаар ашигт малтмал олборлохоос өөр замгүй болдог байна.

⁹⁵ Villegas C.; Ninja miners and rural change in Mongolia, <http://www.asm-pace.org/blog/item/11-ninja-miners-and-rural-ch>

⁹⁶ 2.6 бүлгийн Тогтвортой МАА хөгжлийг дэмжих “Эрүүл МАА” өнөөгийн байдал, асуудал хэсгийг харна уу

⁹⁷ Уул Уурхайн Яам Швецарийн Хөгжлийн Агентлагийн дэмжлэгээр 2005 оноос 2014 онд “Sustainable Artisanal Mining Project” төсөл хэрэгжүүлсэн. 2010 онд ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Орлогын албан татварын тухай хуульд шинэчлэл хийгдэн, бичил уурхай н тухай шинээр заалт оруулсан.



Эх сурвалж:ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.8.16 Налайхын нүүрсний уурхайн хууль бус олборлогчид

(8) Уул уурхай, эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, асуудал

Монгол улс нь уул уурхайн хөгжлийн боломж өндөртэй, 1947 орд газар, 9000 орчим илрэл, 80 төрлийн ашигт малтмал батлагдаад байна. Уул уурхай нь Монгол улсын эдийн засгийг дэмжих гол багана үйлдвэрлэл бөгөөд 2014 оны дотоодын нийт бүтээгдэхүүний 17%, экспортын 90% (5.7 тэрбум 75 сая ам.доллар), төсвийн орлогын 19%-ийг бүрдүүлдэг. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээ бага байдгаас, түүхий эдийн үйлдвэрлэл, экспорт голлох ба бараа бүтээгдэхүүний хувьд импортоос хараат байдалтай байна. Дотоодын хэрэгцээнд шороон нүүрс, хүрэн нүүрсийг дулааны цахилгаан станцад голлох эрчим хүчний эх үүсвэр болгон ашигладаг.

Нөгөөтэйгүүр, Монгол улс ОХУ болон БНХАУ-ын дунд орших далайд гарцгүй улс тул бие даасан экспортын маршруттай болох хүндрэлтэй, экспортын 88%-ийг дэлхий дээр хамгийн олон хүн амтай БНХАУ-руу гаргадаг. Ялангуяа ашигт малтмал зэрэг бүтээгдэхүүн нь БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдлын нөлөөнд ихээхэн автдаг асуудал бий. Түүнчлэн, ашигт малтмал нь олон улсын зах зээлийн үнэ ханшны хэлбэлзэл Монгол улсын уул уурхайн салбар төдийгүй нийт улсын эдийн засгийн өсөлтөд асар их нөлөө учруулдаг.

Эцэст нь, уул уурхай, эрчим хүчний салбарын тулгамдаж буй асуудлыг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.


Хүснэгт 2.8.3 Уул уурхай, эрчим хүчний салбарын асуудал

- а) Уул уурхайн салбараас хэт хараат эдийн засаг (ашигт малтмалын ханшны хэлбэлзэл)
- б) Уул уурхайн бүтээгдэхүүний импорт БНХАУ-аас хараат (БНХАУ-ын эдийн засгийн нөлөө)
- в) Уул уурхайн боловсруулах, нэмүү өртөг шингээх ажил удаашралтай (Түүхий эдийн засгийн экспорт/эцсийн бүтээгдэхүүний импорт)
- г) Олборлолт/тээвэрлэлтээс үүсэх байгаль орчны хөнөөл (нөхөн сэргээлт, хатуу хучилтгүй зам, хууль бус олборлолт)
- д) Дотоодын эрчим хүчний нүүрснээс хараат байдал (байгаль орчны хөнөөл, агаарын бохирдол)
- е) Импортын түлш, импортын цахилгаанаас хараат байдал (эрчим хүчний аюулгүй байдал)
- ё) Мэргэжилтэн, хүний нөөцийн дутагдал (өндөр боловсрол, мэргэжлийн боловсрол)

2.9 Аялал жуулчлалын салбарын хөгжлийн боломж, цогцоор хөгжүүлэхэд чиглэсэн өнөөгийн байдал, асуудал

(1) Өнөөгийн бодлого, төлөвлөтийн асуудал

Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой бодлого боловсруулах болон хууль эрхзүйн орчинг сайжруулах асуудлыг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам (цаашид БОАЖЯ гэнэ) хариуцдаг. Аялал жуулчлалын салбар байгаль орчны салбартай нэгдсэн нь 2014 оны 12 сарын Засгийн газрын шинэ бүрэлдэхүүний дараагаас бөгөөд 2016 оны шинэ Засгийн газрын бүтцээр бага зэрэг өөрчлөлт гарсан ч аялал жуулчлалын салбар хэвэндээ байгал орчны салбарт харъяалагдаж байгаа. Өнөөг хүртэлх бүтцээс харахад, Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийг байгаль орчны бодлоготой цогцоор нь уялдуулж шийдэх шаардлагатай тул, одоогийн бүтэц хамгийн оновчтой бүтэц гэж хэлж болно. БОАЖЯ нь 2016 оны 1 сарын байдлаар зураг 2.9.1-т үзүүлсэнчлэн, аялал жуулчлалаас, ногоон хөгжил, байгаль орчны нөөц баялаг хүртэл өргөн хүрээний үйл ажиллагаа явуулдаг 8 газартай



Эх сурвалж: БОАЖЯ-ны бүтэц (2016 оны 1 сарын байдлаар), ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.9.1 БОАЖЯ-ны бүтэц

1990 онд ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш салбарын төрөл бүрийн хууль, эрхзүйн орчинг сайжруулах хийгээд аялал жуулчлалыг хөгжүүлэх компани ажлуудыг хэрэгжүүлж ирсэн. Эдгээр дотор ЖАЙКА-аас “Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (1998-99он)” болон “Монгол улсын ус намгархаг газрын экосистемийг хамгаалах болон тогтвортой хэрэглээг бий болгох” техникийн хамтын ажиллагааны төсөл (2005-2010) хэрэгжүүлэх зэрэг,

аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь баазыг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжсээр ирсэн билээ.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.9.2 Аялал жуулчлалын хууль тогтоомж, төлөвлөлт, томоохон арга хэмжээ

2015 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулагдан, батлагдсан билээ. Агуулгын хувьд Монголын аялал жуулчлалын салбар дахь бүхий л тулгамдаж буй асуудлыг дэвшүүлсэн давуу талтай байгаа хэдий ч, хэт дэлгэрэнгүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалал ойлгомжгүй сул талтай хөтөлбөр болсон гэж үзэж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт болон хүний нөөц хомсдолтой байгаа тул нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой болгох нь бодлогын хэрэгжилтэнд зайлшгүй шаардлагатай юм. Иймд уг судалгаагаар үндэсний хөтөлбөр доторх хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой болгоход чиглэсэн хөгжлийн боломжийн талаарх ойлголт холбогдох байгууллага, албан тушаалтнуудын дунд нээлттэй бус байгаа байдал ба, үүнийг Монгол улсын аялал жуулчлалын салбар дахь хамгийн том тулгамдсан асуудал гэж үзэж байна.

Монгол орныг зорин ирэх жуулчдын 95 хувь нь нийслэл Улаанбаатар хотоор дамжин өнгөрдөг⁹⁸ учраас, Улаанбаатар хотын аялал жуулчлалын талаар баримталж буй бодлого Монгол улсын аялал жуулчлалын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлнэ. Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө болох “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр нь “Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр”-тэй төстэй асуудлуудыг дэвшүүлж байгаа бөгөөд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалал нь ойлгомжгүй сул талтай.

⁹⁸ Монголын аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэгийг гүйцэтгэх захирал, Орхон их сургуулийн доктор Д. Мөнхтөмөрийн санал

“Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр” болон “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн агуулгыг тус тус тоймлон авч үзье.

1) Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр

Уг хөтөлбөр нь “Тогтвортой хөгжлийн түгээмэл үзэл баримтлал, олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэн, аялал жуулчлалын салбарын хөгжлийг хязгаарлаж буй асуудлуудыг шийдвэрлэж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох, олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх”-ийг зорилгоо болгож байгаа билээ. Уг зорилгыг биелүүлэхийн тулд доор дурдах 6 стратегийн зорилтыг дэвшүүлж байна.

- (i) Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх
- (ii) Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсронгуй болгох
- (iii) Аялал жуулчлалын салбарын судалгаа, мэдээллийн системийг хөгжүүлэх, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- (iv) Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжил болон чадавхийг дээшлүүлэх
- (v) Аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх
- (vi) Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийн аялал жуулчлалд хандах хандлагыг сайжруулах

Эдгээр стратегийн зорилтийг үе шаттайгаар авч үзэж, богино (2016-2020 он) болон урт хугацаа (2016-2025он)-нд хэрэгжүүлэхээр ангилж, 2020 онд Монгол улсад ирэх жуулчдын тоог 2 саяд, 2025 онд 3 сая жуулчин болгож нэмэгдүүлэхийг зорилтуудын нэг болгон дэвшүүлж байна.

Мөн хавсралтаар тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээр дурдсан 6 зорилтыг биелүүлэхэд шаардлагатай 74 үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдсан бөгөөд, хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэгч байгууллага тус бүр тодорхой

заагдсан байна. 74 үйл ажиллагааны төлөвлөгөөний 52-г БОНХАЖЯ хариуцан хэрэгжүүлэгч байгууллага болж байгаа бөгөөд (бусад байгууллагатай хамтран оролцохыг оролцуулан тооцов) ялангуяа дээрх (ii)-(iv) БОНХАЖЯ хариуцан хэрэгжүүлэх магадлал өндөр байна.

2) Найрсаг Улаанбаатар хөтөлбөр

Уг хөтөлбөр нь Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 2020 оныг зорилтот жил болгож, “Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр”-тэй адилаар 2020 онд 2 сая гадаадын жуулчин хүлээж авах зорилт тавьсан. Хэдийгээр 2020 оныг зорилтот жил болгож байгаа боловч, 2030 он гэхэд 5 сая гадаадын жуулчинг хүлээж авна гэсэн урт хугацааны зорилтыг хамтатган төлөвлөсөн байна⁹⁹. Тус хөтөлбөрт 2 сая жуулчин хүлээж авахын тулд дараах 7 зорилтыг дэвшүүлж байна

- (i) Аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нийгэм эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багагсгах, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого зохицуулалтыг оновчтой болгох
- (ii) Аялал жуулчлалын төвүүдийг (амралтын газар, аялал жуулчлалын төв, алжаал тайлах тав тухтай байгууламж гэх зэрэг) бий болгох
- (iii) Гадаад маркетинг сурталчилгааг сайжруулах;
- (iv) Улаанбаатар хотын онцлог, давуу талыг тусгасан, жуулчдын хэрэгцээнд нийцсэн аялалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх
- (v) Жуулчдыг татах олон нийтийн арга хэмжээ (урлагийн концерт, спортын наадам)-г зохион байгуулах
- (vi) Бүх төрлийн үйлчилгээнд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж, хотын соёлыг дэлгэрүүлэх;

Эдгээр зорилтуудыг “Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр”-тэй адил 1-р үе шат (2014-2016)-д хөтөлбөрийн 30 хувь, 2-р үе шат (2016-2018он) - д 30 хувь, 3-р үе шат (2018-2020он)-д 40 хувийг хэрэгжүүлнэ гэж заасан байгаа боловч, тусгагдсан 85 хөтөлбөрийн хэрэгжүүлэх дэс дараалал тодорхой бус байгаа гэдгийг энд дурдаж болно.

⁹⁹ 2014 оны байдлаар гадаадын жуулчдын тоо ойр. 400 мянга байгаа, 2030 онд 5 сая болгохын тулд жилийн 17% дээш өсөлтийн хувьтай нэмэгдүүлэх шаардлагатай, хүлээж авах тогтолцоо, хүчин чадлаас харахад биелэхэд хэцүү зорилт байгаа тул, 2016оны 2 сард УИХ аар батлагдсан Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030-д (Mongolia Sustainable Development Vision-2030) 2 сая жуулчин хүлээн авна гэж засагдан орсон.


Дээр дурдсанчлан, БОАЖЯ болон Улаанбаатар хот, цаашлаад Монгол улсын аялал жуулчлалын салбарын байгууллагын хүний нөөцийн хомсдол болон төсөв хүрэлцээгүй байгаагаас гадна, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дараалал тодорхой бус байгаа гэх асуудал байна. Хэдийгээр, үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан боловч, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжгүй болж байна. Тус судалгаагаар энэхүү хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой болгохын тулд тэргүүлэх салбаруудад анализ хийж, тухайн салбар дахь шийдвэрлэвэл зохих асуудал болон шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх болно.

(2) Монгол улсын аялал жуулчлалын хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааны дарааллыг тодорхой болгохын тулд, аялал жуулчлалын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох шаардлагатай.

Зураг 2.9.3 -т Дэлхийн Эдийн Засгийн Форум (World Economic Forum: WEF) - оос жил бүр зарлаж буй аялал жуулчлалын салбар дахь Монгол улсын өрсөлдөх чадварын талаар 2015 онд хийсэн анализын үр дүнг харуулж байна. 14 үзүүлэлтээр үнэлгээ хийгдэж, соёлын нөөц баялаг болон бизнесийн аялал жуулчлал, байгалийн баялаг, авто зам, боомт зогсоол гэх зэрэг дэд бүтцийн хөгжил, онгоцны буудал зэрэг үзүүлэлт дээр маш бага үнэлгээтэй байна. Үүний үр дүнд нийлбэр дүнгийн жагсаалтаар 141 орноос 99-р байранд орсон байна. Тус жагсаалт үзүүлэлтээр Япон улс 9-р байранд, бусад Азийн дундаж хөгжилтэй орнууд (Хятад 17-р байр, Малайз 25-р байр, Тайланд 35-р байр г.м) -тай харьцуулахад 99-р байр нь маш доогуур үзүүлэлт юм.

Судалгааны багийн зүгээс, аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт хийх, бодит байдалтай танилцах үеэр үнэлгээ доогуур байсан асуудал нь мөн тавигдаж байсан юм. Тус судалгааны багийн зүгээс, Монгол улсын аялал жуулчлалын хөгжилд тэргүүлэх салбараар 2.9.3-т үзүүлж байгаачлан бизнес аялал жуулчлал, байгаль соёлын нөөцийг хамгаалах, зам, харилцааг сайжруулах гэсэн 3 салбарыг сонгон дэвшүүлж байна.



Эх сурвалж: WEF, Travel & Tourism Competitiveness Index Ranking 2015, ЖАЙКА-ийн Судалгааны баг


Зураг 2.9.3 Монгол Улсын аялал жуулчлалын салбар дахь өрсөлдөх чадварын анализ, тэргүүлэх чиглэл

1) Бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх

(i) Өнөөгийн байдал

Зураг 2.9.4-т 2014 оны байдлаар Монгол улсад ирсэн гадаад жуулчдын тоо 400.000, хүснэгт 2.9.1-т 70 гаруй хувийг Хятад, Орос, Солонгос улсын жуулчид эзэлж байгааг харуулж байна. Албан ёсны мэдээлэл байхгүй боловч, орон нутгийн мэргэжилтнүүдийн таамаглалаас үзвэл, амралтын зорилгоор ирж байгаа жуулчид нийт жуулчдын 1/4-1/3¹⁰⁰ орчмоос хэтрэхгүй, үлдсэн хувь нь бизнесийн зорилгоор ирж буй жуулчид, тэдгээрийн ихэнх нь эдгээр эхний байранд орсон 3 улсаас ирж байгаа жуулчид гэж таамаглагдаж байна. Энэхүү өнөөгийн бодит байдлыг зураг 2.9.4-т үзүүлж байгаа жуулчдын тоо буурч байгаа хандлага, зарим аж үйлдвэр (бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын үйлдвэрлэл гэх мэт)-ийн салбарын уналтын аль аль нь 2012 оноос үргэлжилж байгаатай холбоотой гэж харуулж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсад ирж байгаа гадаад жуулчдын тоо бизнесийн зорилгоор ирж байгаа жуулчдын хандлагаас ихээхэн шалтгаалж байгаагийн нөгөөтэйгүүр бизнес жуулчид зонхилж байгаа учраас бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц бололцоо өндөр байгаа гэж үзэж болно.

¹⁰⁰ Oxford Business Group, The Report – Mongolia, 150-р хуудас



Эх сурвалж : National Statistical Office

Зураг 2.9.4 Гадаадын жуулчдын тоо

Хүснэгт 2.9.1 Гадаадын жуулчдын тоо (улс тус бүрээр, 2014 он)

дэс	Улсын нэр	Жуулчны тоо (хүн)
1	Хятад	157,561
2	Орос	73,055
3	Өмнөд Солонгос	45,476
4	Япон	18,282
5	Америк	13,987
6	Казакстан	13,562
7	Герман	9,551
8	Франц	7,733
9	Их Британи	5,758
10	Австрали	5,118
Нийт		392,844

Эх сурвалж: Монголын Үндэсний Статистикийн Хороо

(ii) Тулгамдаж буй асуудал

Гадаадын жуулчдын тоонд амралт аялал жуулчлалын зорилгоор Монголд ирж буй жуулчин, бизнесийн зорилгоор ирж буй жуулчдын ангилал, тэдгээр жуулчдын тоог улс тус бүрээр нь ангилан гаргасан тоо зэрэг аялал жуулчлалын салбарын хөгжилд чухал үүрэг бүхий статистик тоо баримт, мэдээ мэдээлэлийг үнэн зөвөөр гаргах боломжгүй байдалтай байна. Дотоодын жуулчдын тухайд авч үзвэл, найз нөхөд, хамаатан садныдаа айлчлан очиж байгаа гэх зэргээр ямар нэгэн байдлаар ангилалд оруулахад хүндрэлтэй гэх шалтгаанаар зарим аялал жуулчлалын гол бүс нутгийг эс тооцвол статистик тоон мэдээлэл байхгүй байна. Бодит, үнэн зөв статистик мэдээлэлгүйгээр жуулчдын урсгал хөдөлгөөн, хандлагыг баримжаалах боломжгүй, аялал жуулчлалын тогтвортой хөгжилд зайлшгүй шаардлагатай стратеги бүхий маркетингийг хэрэгжүүлэх боломжгүй болж ирнэ. Энэхүү мэдээллийн суурь бааз сайн хөгжөөгүй байгаа явдал нь аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэт дэлгэрэнгүй, дэс дарааллыг нь ойлгомжгүй болгож байгаагийн нэгэн шалтгаан болж байна гэж үзэж байна.

Мөн бизнес аялал жуулчлалыг илэрхийлэх MICE (Meeting, Incentive, Conference/Convention, Exhibition) -ийг хөгжүүлэхийн тулд олон улсын хурал зохион байгуулахад шаардлагатай томоохон хурлын заалтай зочид буудал байх хэрэгтэй. Өнөөгийн байдлаар 500 гаруй хүнийг хүлээн авах хүчин чадалтай хурлын заалтай зочид буудал ганцхан Шангрила байгаа бөгөөд, 5 одтой зочид буудал дөнгөж 4 байгаа юм. Ирэх жил Улаанбаатар хотод Ази Европын дээд хэмжээний уулзалт буюу АСЕМ (Asia-Europe Meeting: ASEM) зохион байгуулагдах болсонтой холбогдуулан Улаанбаатар хотод одоогийн байдлаар 4 том зочид буудал (Radison, Holiday Inn, Sheraton, City Tower) баригдаж байгаа, баригдах төлөвлөгөөтэй байгаа. Улмаар MICE-ийг зохион байгуулах тохиолдолд олон улсын хэмжээний сүлжээ зочид буудлуудыг оруулж ирэх хэрэгтэй болно. Гэвч томоохон сүлжээ зочид буудлуудын хөрөнгө оруулалтанд саад учруулж байгаа зүйл нь өвлийн улиралд жуулчдыг татах стратеги хангалттай бус хэмжээнд байгаа жуулчдын тооны сөрөг үзүүлэлт юм.

Бүтэн жилийн турш тогтмол орлогогүй байгаа бодит байдал нь аялал жуулчлалын салбар дахь ажлын байрны асуудалд ноцтой нөлөө үзүүлж байна. Монголын аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Орхон Их Сургуулийн доктор профессор Д. Мөнхтөмөрийн ярианаас үзвэл, орлого болон ажлын байрны тогтворгүй

байдлаас үүдэн сүүлийн үед аялал жуулчлалын мэргэжлээр суралцах оюутнуудын тоо цөөрч, аялал жуулчлалын тэнхим татан буугдах, багш нарын тоог цөөлөх их сургуулиуд нэмэгдсэн зэргээр аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг бэлтгэхэд улам бүр хүндрэлтэй болж ирж байна. Тиймээс, дээд зэрэглэлийн, чанартай үйлчилгээгээр дэлхий дахинд үнэлэгддэг Япон улсын тусламж дэмжлэг чухал байна гэсэн саналтай байгаагаа илэрхийлж байсан. Мөн адил санал Монголын Зочид Буудлуудын Холбоо болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим зэрэг олон аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүдтэй хийсэн уулзалтан дээр тавигдсан. Хүний нөөцийг бэлтгэх асуудал бол арвин туршлагатай зочид буудлын ажилтан, гадаадын зах зээлд борлуулж чадахуйц маркетингийн мэргэжилтэн зэрэг бизнес аялал жуулчлалын хөгжилд шаардлагатай хүний нөөц дутагдалтай байгаатай шууд холбоотой. Түүнчлэн, аялал жуулчлалын салбарын уналтаас үүдсэн хүний нөөцийн бэлтгэл хомс байгаагаас боловсон хүчний дутагдалд орсон.

Өвлийн улиралд бизнесийн зорилгоор жуулчдыг татах талаар БОНХАЖЯ-ны зүгээс олон улсын байгууллагуудад хандан, хурал семинарыг өвлийн улиралд Улаанбаатарт зохион байгуулахаар санал тавьж, томоохон зочид буудлууд ч өвлийн улиралд үнээ буулгах гэх зэргээр арга хэмжээ авч байгаа боловч хангалттай үр дүнгээ өгөхгүй байсаар байна. Үүний гол шалтгаан нь бизнесийн зорилгоор ирэх жуулчид өвлийн улирлыг харзалзахгүйгээр барилга байгууламж дотор цагийг зөв зохистой өнгөрөөх үзвэр үйлчилгээ, зугаа цэнгээний болон соёлын арга хэмжээ Улаанбаатар хотод цөөхөн байгаагаас гадна, бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг нийслэл хотын агуулах шинж чанар дутмаг байгаа зэргийг дурдаж болно¹⁰¹.


2) Байгаль орчин, соёлын өвийн хамгаалалт

(i) Өнөөгийн байдал

Монгол улсад зураг 2.9.5-т үзүүлж байгаачлан нийт 99 Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-аас гадна олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (11 газар) болон Шувуудад чухал газар (Important Bird Area: IBA, 70 газар), Дэлхийн шим мандлын нөөц газар (Biosphere Reserve: BR,

¹⁰¹ Хүйтний улиралд, долоо хоног болгонд болдог дуурь, балетийн тоглолт олон улсын түвшний, өндөр зэрэглэлтэй гэж үнэлэгддэг хэдий ч хөтөлбөрийн талаарх мэдээллийг онлайнгаар цаг тухайд нь олж авахад хүндрэлтэй зэрэг үйлчилгээний тал дээр анхаарах зүйл олон бий.

6 газар) гэх зэргээр байгалийн асар их баялагтай. ТХГН-нь нийт 28 сая га гаруй газар нутгийг эзэлдэг бөгөөд, Монголын нийт нутаг дэвсгэрийн 18%-ийг эзэлдэг. ЮНЕСКО-гийн дэлхийн өвд Увс нуурын байгалийн ай сав газар (байгалийн өв), Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (соёлын өв), Монгол Алтайн нурууны хадны сүг зургийн цогцолбор (соёлын өв), Бурхан Халдун Уулын тахилгат газар (соёлын өв) гэсэн 4 газар 2015 оны байдлаар бүртгэгдээд байна (нөөц баялаг газруудын тархалтыг зураг 2.9.8-аас харна уу). ЮНЕСКО-гийн дэлхийн өвд дээрхээс гадна наадам болон монгол ардын уламжлалт бүжиг, бие биелгээ, тууль, үндэсний цуур хөгжим, лимбэ гэх мэт 7 биет бус соёлын өв санд бүртгэгдэж байгаа бөгөөд, Дэлхийн Эдийн Засгийн Форум (WEF)-аас гаргасан аялал жуулчлалын салбар дахь аялал жуулчлалын өрсөлдөх чадварын жагсаалтанд энэ талаараа өндөр үнэлгээ (141 улсаас 6-р байр) авсан



Эх сурвалж: Эх сурвалж: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, ЖАЙКА ийн судалгааны баг захиргаа

Зураг 2.9.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, менежментийн бүтэц

(ii) Тулгарч буй асуудал

Байгалийн баялаг, соёлын нөөц баялагтай атлаа үнэлэмж доогуур байна гэдэг нь нөөц баялагаа зөв зохистой хамгаалаагүйтэй холбоотой. Байгаль соёлын өвийг тогтвортой хадгалж хамгаалахад юун түрүүнд нутгийн иргэд тэрхүү үнэ цэнийг бүрэн ухамсарлаж, ойлгодог байх хэрэгтэй. Өнөөгийн байдлаар тухайн орон нутгийн байгаль, соёлын нөөц баялагийн талаарх ойлголт ч сайтар танигдаагүй байна. Түүний гол шалтгаан нь байгаль, соёлын нөөцийг хамгаалах үйл ажиллагаа нь улс, аймаг орон нутгийн төсвөөс хамаарч байгаа байдал, нутгийн иргэдийн дунд нөөц баялагийг

хамтран хамгаалах гэсэн ухамсар доогуур байгаа зэргийг дурдаж болно. Одоогийн байдлаар ТХГН, байгаль, соёлын нөөцийг хамгаалах үүрэг бүхий байгууллага болох БОНХАЖЯ-ны хүний нөөц болон төсөв хангалтгүй байгаа төдийгүй, аймаг болон тухайн орон нутаг тэрхүү хомсдлыг хэрхэн яаж нөхөх вэ гэдэгтэй холбоотой үүрэг хариуцлагын хувиарлалт тодорхой бус байна. БОНХАЖЯ болон бусад холбогдох яам, тамгын газрууд одоогийн олгогдож буй төсвөө хэрхэн үр ашигтай зарцуулах, хэрхэн аймаг орон нутагтай нягт холбоотой ажиллах хэрэгтэй вэ гэсэн чиглэлээ тодорхойлоогүй байгаагаас байгаль болон соёлын нөөцийг хамгаалахад шаардлагатай санхүүгийн төлөвлөгөө ч байхгүй байна. Тухайлбал, орон нутгийн аялал жуулчлалын бүс нутаг руу аялах аялалыг төлөвлөдөг аялалын компани болон тур операторын ихэнх нь Улаанбаатар хотод харьяалалтай аж ахуйн нэгжүүд байдаг тул аялал жуулчлалын бүс нутаг харьяалагдаж байгаа аймаг орон нутагт татвар төлөхгүй гэх мэт нөөц баялаг нутаг дэвсгэрт нь оршдог тухайн орон нутагт аялал жуулчлалын ашгийг хүртэх механизм байхгүй байна.

Зураг 2.9.6 бол ТХГН -ийн нэг болох БЦГ (Байгалийн Цогцолборт Газар: БЦГ)-ын тохижуулалт, тогтвортой удирдлагын системийг илэрхийлж байгаа бөгөөд, өмнө дурдсанчлан улсын хэмжээнд байгалийн цогцолборт газрын тогтвортой удирдлага болон түүний хэрэгжилтэнд шаардлагатай төсвийг бүрдүүлэхтэй холбоотой цогц шийдэл байхгүй байгаа учраас аймгийн хэмжээнд ч гэсэн тодорхой баримжаа, чиглэл байхгүй байгаа гэсэн үг юм.


Үнэн хэрэгтээ аймаг болон БЦГ бол бодит ажил хэрэг удирдан явуулахад уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй байдаг хэдий ч, аймгаас хэрэгжилтэнд зориулсан төсөв бүрдүүдэлт хүндрэлтэй байгаа учраас бодит хэрэгжилтийн үр дүн маш бага. Улмаар, улсаас БЦГ-т олгогддог тогтвортой удирдлагын зардал бага ба, ажилчдын цалинд л зарцуулагдаад дуусдаг гэх БЦГ цөөнгүй бөгөөд, олонх БЦГ үйл ажиллагаа явуулах зардлынхаа дийлэнхийг гадаадын донор байгууллагуудаас авч байна. Учир нь БЦГ-нь одоогоор гадаадын жуулчдаас хурааж буй 3000 төгрөг (дотоодын жуулчид үнэ төлбөргүй)-ийн нэвтрэх хураамж бүгд ТХГНХЗ (Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа)-аар дамжин улсын төсөвт орж, БЦГ захиран зарцуулах төсөв байхгүй. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд, нэвтрэх хураамжийн үнийг нэмэгдүүлэх, дотоодын жуулчин 2000 төгрөг, гадаад жуулчин 5000 төгрөгийн нэвтрэх хураамж төлдөг болгохын хамт, нэвтрэх хураамжийн зарим хэсгийг БЦГ захиран

зарцуулж болохуйцаар нэмэлт өөрчлөлт оруулан ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн бариад байна. Улсын төсвөөс хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулж байгаа БЦГ бол Хустай БЦГ юм. Төрийн бус байгууллага гэсэн ангилалаар бие даан үйл ажиллагаа явуулж байгаа ба, тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд, гадаадын жуулчдаас авах нэвтрэх хураамжийн үнийг 15000 төгрөгөөр тогтоогоод байна.

Хустай БЦГ төвийн захирал Ц. Дашпүрэвийн ярианаас үзвэл, нэвтрэх хураамжийн үнийг 15000 төгрөгөөр тогтоосон хэдий ч, тогтвортой үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг хослуулахын тулд, дэлхийн улс орнуудын их сургуулийн эрдэмтэн судлаачдыг урихаас гадна, донор байгууллагуудын төсөлд хамрагдаж, анкет судалгаа гэх зэргийг сайтар явуулах шаардлагатай байгаа бөгөөд байгаль соёлын нөөцийг хамгаалахад шаардлагатай боловсон хүчин болон санхүүжилтийн тал дээр хүндрэлтэй байгаа гэж ярьж байлаа.¹⁰²

Хустай БЦГ төв нь Голландын засгийн газрын тусламжаар БЦГ төдийгүй орчны бүсийг зөв зохистой удирдан явуулахад хэрэгтэй төсвийг бүрдүүлж, БЦГ-ийн орчны бүсэд мал хариулж байгаа малчдад бага хүүтэй зээл олгож, газар тариалан болон зочин гэр гэх зэрэг үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлж, малчин иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн хамт бэлчээрийн даац хэтрэлтээс үүдэх экосистемийн доройтлыг зогсоохыг зорин ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагааг Хустай БЦГ төв улсын төсвөөс хараат бус, бие даасан төсвийн тогтолцоотой байгаа учраас хэрэгжүүлж чадаж байгаа гэж үзэж байна. Бусад ТХГН-ийн тухайд авч үзэхэд дийлэнх үйл ажиллагаа нь хангалттай бус, улсын төсвөөс хараат байхын зэрэгцээ, улсаас бие дааж орлого олох явдал зөвшөөрөгддөггүй тул, орчны бүс болон БЦГ-ын дотоод бүсийн үйл ажиллагаагаа ч хангалттай явуулж чадахааргүй байдалтай байна. Иймээс зарим олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдах боломжтой ТХГН-т төсөл хөтөлбөрөөр дамжуулан санхүүжилтийн асуудлыг шийдэж, тогтвортой удирдлагаар хангах ТББ-ыг байгуулж, Хустай БЦГ төв шиг бие даасан төсөв бүхий тогтолцоог бий болгож болохоор загвар байна (Тухайлбал, Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-өөс хэрэгжүүлж буй “Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Сүлжээг Бэхжүүлэх(SPAN)” төсөл хэрэгжсэн Их Нарт Байгалийн нөөц газрыг нэрлэж болно).


¹⁰² “ Хустай ТХГН”-ийн дарга Цэрэндэлэгийн хэлснээр тогтвортой үйл ажиллагаа явуулах, арчилгаа үйлчилгээ явуулхад хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байдаг.



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 2.9.6 Байгалийн цогцолборт газрын менежментийн бүтэц

Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийг харахад, хамгаалалтын газар нутаг дотор хамгийн чанга дэглэмтэй болох ”Дархан цаазат газар” дотор уул уурхайн олборлолт, жуулчны бааз (Tourist Camp: TC) барих зэргийг эрс хориглодог. Гэтэл зураг 2.9.7-т үзүүлснээр дархан цаазат газар болон шувуудад чухал газар (IBA), Дэлхийн шим мандлын нөөц газар (BR) зэргийн байгалийн төрөл зүйлийг хамгаалах шаардлагатай газар нутаг болон түүний орчимд олон тооны уул уурхайн олборлолт хийгдэж байгаагаас гадна, жуулчны баазууд ч Хөвсгөл нуур болон Горхи Тэрэлжийн БЦГ зэрэг ихэнхи аялал жуулчлалын бүс нутагт олноор байна.



Эх сурвалж: BirdLife Asia. 2009. Safeguarding Important Areas of Natural Habitat alongside Economic Development. Mongolia Discussion Papers. East Asia and Pacific Region Sustainable Development Department, World Bank

Зураг 2.9.7 ТХГХ болон уул уурхайн олборлолтын зөвшөөрөлтэй ордоос 20 км бүс, жуулчны баазын тархалт

Монгол улсын аялал жуулчлалын хуулийг харахад, жуулчны баазын тоо, байршлыг Засгийн газраар шийдвэрлэнэ гэсэн заалт байгаа бөгөөд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, тогтвортой үйл ажиллагааны тулд жуулчны бааз хооронд багадаа 5 км байх зэрэг удирдамж байдаг

боловч ихэнхи жуулчны баазууд мөрддөггүй. Түүнчлэн, улсаас үйл ажиллагааны зөвшөөрөл авах шаардлагатай жуулчны баазууд, хог хаягдал, бохир ус цэвэрлэх талаарх стандарт, нормыг дагах хэрэгтэй бөгөөд, тогтсон хяналт явагддаг хэдий ч Монгол улсад жуулчны баазын стандарт хангаагүй ”жуулчны гэр бааз”, хувийн эзэмшлийн байрны нэг хэсэгт байгуулсан guest ger, guest house олон байдаг. Иймэрхүү байгууламжийн хаягдал, бохир усны хяналт хангалтгүй явагддаг.

Томхон жишээ болгон Хөвсгөл нуурын талаар дурдмаар байна. Хамгийн олон жуулчин очдог аялал жуулчлалын бүс болох Хөвсгөл нуур орчимд дотоодын аялагчдын тоо эрс нэмэгдсэнээр байгаль орчны бохирдлын асуудал хурцдаж байна. Энэ талаар аялал жуулчлалын цөм болох Хатгал сумын засаг захиргаа болон орон нутгийн жуулчны баазуудын холбоо зэрэг холбогдох байгууллагууд жилд 2 удаа цуглан, асуудлыг хэлэлцэж, асуудлыг шийдийг эрэлхийлдэг хэдий ч шинэ цэвэрлэх байгууламж барих хөрөнгө, санхүү шийдэгдээгүй хэвээр байна. Одоо байгаа 1 хогийн цэг (open dumping) байдаг ч хэдий ч хэдийнэ дүүрсэн, мөн адил 1 байдаг цэвэрлэх байгууламжид жуулчны баазууд бохир усаа зөөвөрлөж авчирдаг ч аюулгүй байдал болон тээврийн зардал асуудал болоод байна. Энэ чигээр нь орхивол байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх аюултай байдалтай байна.

Иймэрхүү нөхцөл байдлаас, 2015 оноос АХБ Ядуурлыг бууруулах Япон сан (Japan Fund for Poverty Reduction: JFPR) хөрөнгөөр “Хөвсгөл БЦГ, түүний орчмын бүсийн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл” хэрэгжүүлж байгаа боловч туршилтын төслөөр дамжуулан нутгийн иргэдийн зүгээс хог хаягдлын хяналт тавих тогтолцоо бий болгох, эко ариун цэврийн газар (eco toilet) нэвтрүүлэх зэрэг ажлууд хийгдэх бөгөөд хог хаягдал, цэвэрлэх байгууламжийн асуудал тусгагдаагүй, БЦГ болон түүний орчмын асуудлыг цогцоор нь шийдэх хэмжээнд хүрэхгүй. Холбогдох байгууллагуудтай хийсэн уулзалт, ярилцлагаас үзэхэд цэвэрлэх байгууламжийн асуудлаас гадна, огцом нэмэгдэж буй дотоодын аялагчдын жуулчны баазаас гадна хоноглох, хог хаях зэрэг асуудал хурцдаж байгааг онцолж байсан. Иймд, аялал жуулчлалын хөгжлөөр байгаль орчны нөлөөллийг бууруулахад дэд бүтцийг хөгжүүлэхийн зэрэгцээ дотоодын аялагчдын ухамсарыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг идэвхитэй явуулах хэрэгтэй.

3) Зам харилцааг сайжруулах

(i) Өнөөгийн байдал

Монгол улсын гол аялал жуулчлалын нөөц болон авто замын байдлыг зураг 2.9.8-д үзүүлж байна. Улаанбаатар хоттой холбох авто замын хучилтын ажил урагшилж байгаа боловч, уулархаг болон баруун бүс нутагт хараахан хучилтгүй замтай газрууд олон байна. Авто замын хучилтын ажил нь дотоодын аялал жуулчлалын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, Хөвсгөл нуур чиглэлд 2015 онд авто зам бүрэн хучигдсанаар 2014 оны дотоодын аялагчдын тоо (ойролцоогоор 50000 хүн) нэмэгдэж, 60000 гаруй жуулчин 2015 оны 5 сарын сүүлээс 7 сарын дунд үе хүртэлх 1.5 сарын хугацаанд ирсэн байдалтай байна. Нөгөөтэйгүүр, Хөвсгөл далайн БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэдээнээс үзвэл, гадаадын жуулчид 2015 оноос өөрчлөлт байхгүй, жилд 5000 орчим жуулчин ирэх магадлалтай.



Эх сурвалж: WWF Mongolia, Administration of Land Affairs, Geodesy and Cartography, UNESCO website, Ramsar Site Information Services, The Alliance of Religions and Conservation


Зураг 2.9.8 Аялал жуулчлалын голлон нөөц, автозамын нөхцөл

Төмөр замын тухайд авч үзвэл, 2015 оны BRICS (Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд Африк) дээд хэмжээний уулзалтанд зураг 2.9.7-д үзүүлж байгаачлан, Бээжингээс Улаанбаатараар дайрч Москва хүртлэх 3000 км

гаруй аялал жуулчлалын маршрутыг бий болгох талаар Орос, Хятад, Монгол 3 улс санал нэгдсэн байна. Тус нээлт нь одоогийн байгаа төмөр замаа ашиглаж, түүхт цайны худалдааны замд хүрэх “Цайны зам”-аар сэдэвчилсэн аялал жуулчлалын галт тэргийг үйл ажиллагаанд оруулж хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх эхлэл болж байгааг илэрхийлж байна.

Агаарын замын хувьд 2016 оны 4 сарын байдлаар олон улсын нислэг хийдэг төрийн өмчит МИАТ компани Бээжин, Хонгконг, Москва, Берлин, Токио, Сөүл гэх 6 том хотууд руу нислэг хийж байгаагаас гадна, Монголын хувийн аж ахуйн нэгж болох Хүннү Эйр ӨМӨЗО-ны Манжуур, Хайлаар руу, Аэро Монголиа ӨМӨЗО-ны Хөх хот, ОХУ-ын Иркутск руу нислэг үйлдэж байна. Гадаадын нислэгийн компаниуд ОХУ (Аэро Флот), БНХАУ (Эйр Чайна), Солонгос (Корэйн Эйр), Турк (Турк Эйрлайн) гэх зэрэг компаниуд тус бүр Москва, Бээжин, Сөүл, Истанбултай Улаанбаатарыг холбох нислэгүүдийг үйлдэж байна.

Олон улсын нислэгүүд бүгд Улаанбаатарт газардаж байна. Дотоодын нислэгийн талаарх мэдээллийг зураг 2.9.9-д Хүннү Эйр, Аэро Монголиа зэрэг дотоодын нислэгийн компаниуд Чойбалсан, Даланзадгад, Алтай, Улиастай, Ховд, Өлгий, Улаангом, Мөрөн, Овоот зэрэг 9 газар луу тогтмол нислэг хийж байна (Даланзадгад, Мөрөн рүү зуны улиралд л нислэг үйлддэг).



Эх сурвалж : The Tourist Map of Mongolia, 2015, Hunnu air Homepage, Aeromongolia Homepage

Зураг 2.9.9 Дотоодын нислэгийн маршрут

(ii) Тулгарч буй асуудал

Өмнө дурдсанчлан, гадаадын жуулчдын 95% -нь Улаанбаатараар дамжин өнгөрч, агаарын замын бүх нислэгүүд Улаанбаатараас хөөрч, бууж байгаагаас үзвэл, гадаадын жуулчдыг хүлээн авах томоохон хөшүүрэг буюу Улаанбаатарт буух болон Улаанбаатараас хөөрөх олон улсын нислэгүүдийн тоог нэмэгдүүлэх нь нэн тэргүүний шийдвэрлэх асуудал юм.

Өнөөгийн байдлаар Чингис Хаан олон улсын нисэх буудлын олон улсын болон дотоодын нислэгээр үйлчлүүлж байгаа нийт зорчигчдын тоо 2008 онд 610.000 зорчигч байснаас, 2013 онд 1 сая 100 мянга болж бараг 1.8 дахин эрс өссөн байгаа¹⁰³ нь Улаанбаатар хотоос дэвшүүлж байгаа гадаадаас ирэх жуулчдын тоон (2020 он гэхэд 2 сая, 2030 он гэхэд 5 сая) -д хүрэхэд тийм ч хол биш байгаа юм. Тиймээс, ЖАЙКА-ийн хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлын бүтээн байгуулалтыг хийж байгаа бөгөөд шинэ онгоцны буудлын жилд хийх дотоодын болон олон улсын нислэгүүдийн тоог нийлүүлэн авч үзвэл, жилд 2 сая зорчигчийг хүлээж авахыг зорьж байгаа. ЖАЙКА –ийн тусламжтай Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудалд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, үйл ажиллагаа явуулах, удирдах чадавхийг дээшлүүлэх төслийг мөн хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү байгууламж болон удирдлагын тал дээрх асуудал төдийгүй агаарын замын тал дээр ч гэсэн МИАТ нислэгийн зах зээлийг монополчилсон байдалтай байгаа нь гадаадын хөрөнгө оруулалттай нислэгийн компаниуд нислэг үйлдэхэд хүндрэлтэй байдаг гэсэн шийдвэрлэх ёстой асуудал ч байсаар байна. Орхоны Хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хийсэн уулзалтаар Турк Эйрлайнаас Истанбул-Хархориныг холбосон олон улсын нислэгийг санал болгоод байгаа ба, 2015 онд Туркийн засгийн газар болон Монголын засгийн газрын хооронд онгоцны буудлыг сайжруулахтай холбоотой харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан боловч, өнөөгийн байдлаар бодит үйл хэрэг болоогүй байна. Гадаадын хөрөнгө оруулалттай нислэгийн компаниуд төлөвлөгөөт нислэгээ нэмэгдүүлж чадахгүй, зуны ид оргил үед гадаадын жуулчдад суудал хүрэлцээгүй байдаг учраас, тухайн үеийн онгоцны тийзний үнэ нэмэгдэж, Монгол руу аялах хүсэлтэй гадаадын жуулчдыг алдсаар байна.

Иймээс өмнө дурдсанчлан, “Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нислэгийн тоог нэмэгдүүлэх

¹⁰³ ЖАЙКА Хэвлэлийнхэнд зориулсан мэдэгдэл 2015 оны 4 сарын 16

болон үнийн уян хатан бодлоготой болохыг дэвшүүлсэн бөгөөд, агаарын замыг чөлөөлөхийг дэмжих чиглэлийг гаргасан байгаа хэдий ч хариуцан хэрэгжүүлэгч байгууллагаар Зам Тээврийн Яам-ыг, БОАЖЯ-ыг нислэгийн авиа компаниуд болон аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг зэрэгтэй адил хамтран оролцогч байгууллага гэж тусгасан байна. БОАЖЯ голлон хариуцаж, Зам тээврийн яам болон бусад холбогдох байгууллагууд хамтран ажиллан, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаадын жуулчдыг татаж чадахгүй байгаа өнөөгийн байдал нь дотоодын нислэг болон төмөр замын үйл ажиллагаанд нөлөө үзүүлж байна. Дийлэнх гадаадын жуулчид урт замыг туулахдаа авто замаас илүүтэйгээр онгоц болон төмөр замыг сонгох хандлагатай байх нь олонтаа байдаг. Гадаад жуулчдын тоо хангалттай их биш байгаагийн дээр, дээрх тээврийн хэрэгслүүдийн билетийг худалдан авах онлайн систем хөгжөөгүй, бусад гадаад хэл дээр хангалттай үйлчилгээ үзүүлж чаддаггүйн улмаас, төмөр зам, дотоодын нислэг дотоодын зорчигч үйлчлүүлэгчдийн хандлагаас шалтгаалж байна. Дотоодын зорчигчид зам хатуу хучилттай болсноор багахан цаг зарцуулсан ч гэсэн авто замыг сонгох хандлагатай байдаг учраас дотоодын нислэгийн тоо багасах, нислэг үйлдэхээ болих гэсэн үзэгдэл ээлж дараалан гарсаар байна. Тухайлбал, өмнө Хөвсгөл нуурын тийш засмал зам тавигдсанаар хот Мөрөн рүү дотоодын нислэг хийдэг 4 компани байснаас 1 компани л одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, нислэг цуцлагдах болон чиглэлээ өөрчлөх зэрэг асуудал гарсаар байна. Хөвсгөл нуур нь Оросын Байгаль нуурын дараагаар цэнгэгээр дэлхийд 2-р байранд ордог Монголын байгалийн үзэсгэлэнт газар бөгөөд, дотоодын нислэгээр Улаанбаатараас 1.5 цаг зарцуулан, онгоцны буудлаас 30 орчим минут яваад нуурын хажууд орших Хатгал тосгонд очдог. Гэвч дотоодын нислэг багассанаар өмнө нь зочдод үйлчилж байсан Мөрөн онгоцны буудал-Хатгал тосгон чиглэлийн автобус явахаа больсон бөгөөд, гадаадын жуулчид ая тухгүй аялахад хүргэж байна. Иймд, засмал зам тавигдсаар дотоодын жуулчдын тоо эрс нэмэгдэж байгаа бол гадаадын жуулчдын тоонд гарсан өөрчлөлт харагдахгүй байна.

Мөн Дорноговь аймгийн аялал жуулчлалаараа алдартай Сайншанд хотын ойролцоох Энергийн төв болон Хамрын хийд рүү Монголын Төмөр Зам Улаанбаатараас шөнийн вагоноор хөдлөж тухайн газар хоноглох шаардлагагүй амралтын 2 өдрийн аялалын багцыг төлөвлөн, сурталчилж байгаа боловч, Дорноговь аймгийн БОАЖГ-аас авсан мэдээллээр, засмал

зам. тавигдсанаар авто машинаар явах нь илүү бага цаг зарцуулдаг болсон учир төмөр замаар зорчих жуулчдын тоо багасах таамагтай гэж байв.

Зураг 2.9.8-д аялал жуулчлалын гол бүс нутаг руу явах чиглэлийн замын хучилтын ажил урагшилсаар байгаа боловч, ТХГН-ийн бүс доторх авто замын дийлэнх нь хучилтгүй байгаа нь тойрон аялал хийхэд тохиромжгүй, нэг БЦГ-аар тойрон аялахад хэдэн өдөр зарцуулах нь олонтоо. Ялангуяа гадаадын жуулчдыг татахад томоохон саад тотгор болж байна гэж үзэж байна. Энэ нь авто замыг сайжруулах ажил улсын төсвөөс хараат, хувийн аж ахуйн нэгжтэй холбоо харилцаатай ажиллах гэх мэт арга механизм хангалттай сайн судлагдаагүй байгаатай холбоотой.

Түүнчлэн, зураг 2.9.8т харуулснаар голлох аялал жуулчлалын газрууд руу хатуу хучилттай авто зам тавигдсаар байгаа хэдий ч ТХГН доторх авто зам хучилтгүй, ирж очиход хүндрэлтэй, БЦГ ыг тойрон аялахад ч хэдэн өдөр шаардагдах зэрэг ялангуяа гадаадын жуулчид авчиргахад саад бэрхшээл болж байна. Бодит байдалд авто замын бүтээн байгуулалтыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хийх шинэ хэлбэрийн талаар хэлэлцэх хэрэгтэй.

Өмнө дурдсан, Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 91 төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгасан байгаа.

Үүнд нислэгийн тоог нэмэгдүүлэх, нислэгийн үнийн уян хатан бодлого барих зэрэг “Open Air Policy”-г дэмжих чиг хандлага байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллага нь ЗТХЯ байгаа тул, энэхүү бодлого цаашдын Монгол улс олон улсын аялал жуулчлалын бүс нутаг болон хөгжихөд зайлшгүй шаардлагатай нөхцөл гэж хэлж болох чухал ач холбогдолтой асудал гэдгийг холбогдох яам сайтар ойлгох хэрэгтэй гэж бодож байна. Үүний зэрэгцээ БОАЖЯ, Иргэний нисэхийн газар, Аялал жуулчлалын мэргэжлийн зөвлөл болон холбогдох байгууллагууд оролцож байгаа тул, ЗТХЯ болон холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй.

Түүнээс гадна, голлох аялал жуулчлалын маршрутыг бэхжүүлэх тал дээр ЗТХЯ, БОАЖЯ, орон нутгийн засаг захиргааны байгууллага хэрэгжүүлэгчээр орсон байгаа тул хамтын ажиллагаа, төлөвлөлтөө уялдуулах шаардлагатай.

Хөвсгөл мөрөн орчмын аялал жуулчлалын бүс шиг автозам сайжруулсанаар аялагч, жуулчдын тоо эрс нэмэгдэн, байгаль орчныг

сүйтгэх асуудал гарч болохгүй бөгөөд байгаль орчны хүчин чадлын (Carrying Capacity) цар хүрээг сайтар анхааран, жуулчдын тоог уялдуулах замаар байгаль орчны хамгаалалтын асуудалтай холбогдох нь бусад улсын туршлагаар батлагдсан байдаг. Аялал жуулчлалын бүс рүү чиглэх зам харилцааг сайжруулах нь байгаль орчны хамгаалалттай нягт уялдаатай байх тогтолцоог бий болгох нй чухал.

2.10 Зам тээвэр, логистикийн салбарын өнөөгийн байдал, асуудал


(1) Авто зам

Монгол улсын замыг улсын чанартай болон орон нутгийн (аймгийн) чанартай гэж ангилдаг. Улсын чанартай замын нийт урт 12,722 км бөгөөд зураг 2.10.1-т үзүүлж байгаачлан, нийслэлийг аймагийн төвүүдтэй холбож, аймагийн төвийг хилийн боомттой холбох, аймагийн төвүүдийг хооронд нь холбох, улмаар Азийн хурдны авто замын нэгдсэн сүлжээ(АНЗ, АН4, АН32)-нд орсон ба, улсын чанартай замын томоохон сүлжээг бүрдүүлж байна. Эдгээр улсын чанартай замыг бүгдийг хатуу хучилттай зам болгох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд сүүлийн хэдэн жилд улсын чанартай замын хатуу хучилтын ажил урагшилж, 2014 оны байдлаар 41.6% хувь хатуу хучилттай байгаа ба, 2016 онд бүх улсын чанартай зам хатуу хучилттай болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна (Зураг 2.10.1).


Хүснэгт 2.10.1 Авто замын сүлжээний бүтээн байгуулалт

Хувьсагч	2010		2014		2016	
	Нийт зам	Улсын чанартай зам	Нийт зам	Улсын чанартай зам	Нийт зам	Улсын чанартай зам
Нийт урт, km	49,250	12,615	49,250	12,722	49,250	12,722
Хатуу хучилттай зам, km	3,015.6	2,470.6	6,461.0	5,291.4	13,891.6	12,722
Хатуу хучилттай зам/Нийт,%	6.12%	19.58%	13.1%	41.6%	28.2%	100%

Эх сурвалж: Зам тээвэрийн яам



Эх сурвалж: Asian Infrastructure Research Institute, based on the data from the Ministry of Transportation



Зураг 2.10.1 Авто замын орон зайн мэдээллийн сан, авто замын сүлжээний төлөвлөгөө)

Хүснэгт 2.10.2 2016 онд тавигдсан авто замын төсөл

No.	Project Name / Road Section	Length	Progress	Funding Source	Contractor
1.	Uliastai-Tosontsengel	67 km remaining	51%	Development Bank	"Zansnii zam" LLC
2.	Ulgii-Hovd	189.7 km		ADB	"China Huashi interprices" LLC
3.	Myangad Bridge – Saihairhan	20 km	58%	National Budget	"Tum delgereh" LLC
4.	Hovd aimag center Hovd, Jargalant	5 km		National Budget	
5.	Hovdaimag Zereg soum	3 km		National Budget	
6.	Bagaulaan – Manhan	103.3 km	82%	ADB	China Jiangsu Jianda Construction Co.,Inc
7.	Bulgan-Uyench-Hovd	60 km	59%	National Budget	"Jiangsu Junjian Janshin" LLC /China/
8.	Zavhan,Tosontsengel	3 km		National Budget	
9.	Zavhan, Ih-Uul Ider River Bridge Construction	169.08m	94%	National Budget	"Tosgol" LLC
10.	Bayanhongor aimag	2 km		National Budget	
11.	Elsentasarhai – Harhorin	77 km	82%	National Budget	"Hurdnii zam" LLC
12.	Elsentasarhai-Arvaiheer	40 km	94%	National Budget	"Uilsiin zam" LLC, "Suuri" LLC, "Och naran" LLC consortium
13.	Tuv	1.5 km		National Budget	
14.	Dornogovi, Urgun	18.25 km	39%		"Shine hugjil zam" LLC
15.	Hentii, Bayanmunkh Herlen Bridge	217.2 m	60%	National Budget	"Zamch ireedui" LLC
16.	Undurkhaan-Munkhhaan-Baruun-Urt	132.6 km	95%	Development Bank	Arj capital LLC
17.	Undurkhaan-Choibalsan	53.6 km	73%	National Budget	"China geo engineering corporation" LLC
18.	Batsumber area	29.6 km	54.6%	KFW	China Railway First Group & Ochir Nyam LLC concersum
19.	Undurkhaan-Choibalsan	143km	73%	Development Bank	"Badrah oil" LLC, "Uvur zalaat" LLC, "Hansuun zam" LLC, "Arj capital" LLC, "Nasnii zam" LLC
20.	Dornod, Hulunbuir Herlen River Bridge	290.1 m		National Budget	"ZMZ" LLC
21.	Uvs, Tes River Bridge	127 m		National Budget	"HKB International Holdings" LLC
22.	Tsahir-Tosontsengel	127.1 m	37.8%	Development Bank	"Hurdnii zam" LLC
23.	Halzanburged-Solongot	100 km	53%	Development Bank	"Monroad" LLC
24.	Hanh-Mond	22.08 km	48%	National Budget	"HUVsgul zam" LLC
25.	Huvsgul, Murun	9.8 km		Development Bank	"Hotgor zam" LLC
26.	Huvsgul, Rashaant	253.3 m		Transferred from National Budget to Development Bank	"Erdenet suvraga" LLC

1) Авто замын сүлжээ

Дээрх зурагт үзүүлж байгаачлан, улсын чанартай замын сүлжээ нь замын хатуу хучилтын ажлууд урагшилсаар байгаа боловч, нөгөөтэйгүүр улсын чанартай замтай холбосон орон нутгийн чанартай замыг засч сайжруулах ажил чухал асуудал хэвээр байсаар байна. Орон нутгийн чанартай авто замуудаас аймгуудыг сумын төвтэй холбох тээвэр логистикийн тогтолцооны зарим хэсгийг бүрдүүлэх тусгай зориулалтын замыг бий болгох шаардлага бүхий зам ч байгаа.

Мөн, хатуу хучилттай улсын чанартай замын сүлжээ нь өглөө эрт юмуу орой засварын ажил явагддаг ба, ихэнх улсын чанартай зам нь 2 урсгалтай 3-р зэрэглэлийн зам (ачааллын хэмжээ: тэнхлэг тус бүр 10 тонн), даац хэтрүүлсэн ачааны машин, өвлийн улирлын хахир хүйтэн цаг агаар гэх зэргээр улсын чанартай замд тогтмол засвар үйлчилгээ явуулахад томоохон хүндрэл бэрхшээлтэй байгаа. Түүнээс гадна, улсын авто замын засвар үйлчилгээний зардалд зарцуулах төсөв хөрөнгө хангалтгүй байгаагаас зүй зохистой тогтвортой удирдлага байхгүй байна.

2) Ачаа тээвэрлэлт

Ачаа тээвэрлэлтийн тухайд, Монгол улс дотооддоо төвлөрсөн логистикийн систем байхгүй ба, ачааны машинд тавих хяналт сул байгаагаас үүдэн, хөдлөх ба хүрэх газрын мэдээлэл бүхий ачаа тээврийн талаарх ерөнхий мэдээлэл байхгүй байгааг юун түрүүнд дурдах нь зүйтэй. Улмаар, даац хэтрүүлсэн ачааны машинд авах арга хэмжээ сул, ачааны машины жолоочийн хөдөлмөрийн аюулгүй байдал, даатгалын тогтолцоо, зам тээврийн аюулгүй байдлын хяналт шалгалтын тогтолцоогүй, нэгдсэн хууль эрхзүйн орчин бүрдээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа гэх зэрэг шийдвэрлэхүйц асуудлууд байна.

3) Зорчигч тээвэр

Хот хоорондын автобус тээврийн тухайд авч үзвэл, Зам Тээврийн Яам (цаашид, ЗТЯ)-ны харьяа Авто Тээврийн Үндэсний Төвөөс үйл ажиллагааны байдалд хяналт тавьж байгаа боловч, уг системийг нийлүүлсэн Болгар улстай хийсэн гэрээ 2015 оны 6 сард дууссанаас хойш, хяналт шалгалт явуулаагүй байдалтай байна. Тийм учраас, орлуулах системийг нэвтрүүлэх гэх зэрэг яаралтай ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай байна. Түүнээс гадна, зөвшөөрөлгүй зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулах асуудал, даатгалын тогтолцоо, машин техникийн үзлэгийн систем байхгүй байгаа зэрэг цогц хууль эрхзүйн орчин

бүрдээгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг асуудлуудыг дурдаж болно. Мөн, энгийн зорчигч тээврийг ч энд хамруулан авч үзэж, зам дагуух үйлчилгээний цэгийг барьж байгуулах нь ч чухал асуудал юм.


Түүнчлэн, өргөн уудам нутгийг аюулгүй зорчихын тулд, зорчигч тээвэр болон авто зам ашиглагчдад зориулсан зам дагуух байгууламж байгуулах талаар хуулинд заагдсан бөгөөд, түүнд зориулан нэгдсэн үйлчилгээний байгууламжийг бүхий л улсын чанартай зам дагуу 100-150 km зайтайгаар байрлуулах төслийг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү Японд Мичино эки гэгддэг зам дагуух байгууламж нь хүйтэн сэрүүний улирайд авто замаар зорчигчдод туйлын хэрэгцээтэй бөгөөд жишээлбэл, шатахууны станц, автомашины засвар, үйлчилгээ, ресторан, ариун цэврийн өрөө, замын ослын шуурхай, түргэн тусламжийн үйлчилгээ, цаг агаарын мэдээлэл хүргэх зэрэг үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.

(2) Төмөр зам

Монгол улсын төмөр зам нь одоогийн байдлаар урдаас хойш чиглэсэн тээврийн корридор буюу Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд (Эрдэнэтийн туслах зам орно)-ийн 1,577км, улсын зүүн хойд хэсэгт орших Баянтүмэн-Эрээнцавын хоорондох 238 км, нийт 1,815 км замын үйл ажиллагаатай байна (Зураг 2.10.2). Одоогийн төмөр замын үйл ажиллагааг удирдан явуулж байгаа газар бол Улаанбаатар Төмөр Зам (УБТЗ) бөгөөд, ОХУ болон Монголын 50/50 хувийн эзэмшил бүхий хамтарсан компани юм. Түүнчлэн, өнөөгийн төмөр замын тээвэрт доор дурдах асуудлууд байхын зэрэгцээ, төмөр замын тээврийн талаарх бодлого боловсруулах асуудлыг Монголын тал дангаараа шийдвэрлэх боломжгүй байдаг. Гэхдээ босоо корридорын хувьд 1993 оноос 2000 оны хооронд буцалтгүй тусламжаар төмөр зам, вагон, засвар үйлчилгээ сайжруулах төсөл хэрэгжсэн.

Одоогийн байдлаар зүтгүүр Монголын төмөр замын мэдлийн 156, ачааны вагон 2,949 байгаа боловч, ихэнх нь элэгдэж хуучирсан байдалтай байна. Царигийн тухайд авч үзвэл, нэг урсгалын өргөн цариг (1,520мм) , цахилгаан бус ба, огцом эргэлт олон ихтэй байдаг учраас хурд удаан. Ачаа тээвэрлэлтийн ачаалал ихтэй, цаашид нэмэгдэх ачаа тээврийн эрэлт хэрэгцээнд тааруулан үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалтай тул цаашид тээвэрлэлтийн хүчин чадал багатай Улаанбаатар хотын орчимд, транзит тээвэр болон аюултай ачаа тээвэрлэлтийн маршрут болох Богдхан төмөр замын төсөл хэлэлцэгдэж байна (5 бүлэг 5.7 (2) 2) харна уу). Хот хоорондын зорчигч тээврийн ачаалал хэтэрсэн хэдий ч авто замыг сайжруулснаар автомашины тээвэр нэмэгдэн,

төмөр замаар зорчих зорчигчийн тоо нэмэгдэнэ гэдэг эргэлзээтэй байна. Нөгөөтэйгүүр, Улаанбаатар хотод метро барих төсөл байгаа бөгөөд нийтийн тээвэрт метро нэвтрүүлснээр авто машины хаягдал хий, замын түгжрэл, замын осол зэрэг багасч, хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаа нэмэгдэн, нийслэл хотын бүсийн төвлөрлөөс үүдсэн хотжилтийн асуудал хөнгөрнө.



№	Section	Length (km)	№	Section	Length (km)
1	Tavan Tolgoi ~ Gashuun Sukhait	230	6	Choybalsan ~ Hoot ~ Sainshand	550
2	Tavan Tolgoi ~ Zuunbayan	400	7	Choybalsan ~ Hoot ~ Bichigt	320
3	Tsagaan Suvraga ~ Zuunbayan	200	8	Choybalsan ~ Nomrog	540
4	Arts Suuri (Tsagaantolgoi) ~ Erdenet	670	9	Choybalsan ~ Ereentsav	238
5	Naiin Sukhait ~ Shiveekhuren	45	10	Existing railway's double track	1,111

Эх сурвалж: Asian Infrastructure Research Institute, based on the data from the Ministry of Transportation

Зураг 2.10.2 Төмөр замын сүлжээ


1) Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврийн ачаа тээвэрлэлтэнд хөрш орнууд болох БНХАУ болон ОХУ төдийгүй Тяньжин боомт (БНХАУ), Находка боомт (ОХУ)-оор дамжуулан 3-дагч оронтой хийх экспорт, импортын тээвэр чухал юм. Улмаар, БНХАУ болон ОХУ-ын хооронд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг ч татан

оролцуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, төмөр замын ачаа тээвэрлэлтийн багтаамжийг нэмэгдүүлэх, хөргүүртэй ачааны вагон зэрэг тусгай зориулалтын ачааны вагоны хэрэгцээг нэмэгдүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг явуулах хэрэгтэй.

2) Цаашдын төлөвлөгөө

Монгол улсын төмөр замын талаар баримталж байгаа төлөвлөлтөөр голчлон ашигт малтмал тээвэрлэх зорилготой байгаа бөгөөд, зураг 2.10.2-т үзүүлж байгаа олон төрлийн зам баригдахаар төлөвлөгдөж байгаа боловч, эдгээр дотроос бодит ажил хэрэг болон урагшилж байгаа нь Таван Толгой-Гашуун Сухайтын (Зурган доторх хөх цэнхэр өнгөөр тэмдэглэсэн) хоорондох зам ба, далангийн ажил хэдийнэ дууссан байдалтай байна. Үндсэндээ бүх төлөвлөгөөт замыг ажиллагаанд оруулах ажлыг Монголын Төмөр Зам (МТЗ) хариуцан явуулахаар болсон бөгөөд олон тооны төмөр замын ажилчин, албан хаагчид байгаа боломжинд түшиглэн төмөр замын хөдөлгөөний хяналт, удирдлага болон дохиололын системийг сайжруулах зэрэг асуудал ЗТХЯ-ны шийдвэрлэх чухал асуудал болж байна.



Эх сурвалж: Монголын төмөр зам

Зураг 2.10.3 Таван толгой- Гашуун сухайт төмөр замын төсөл

Үндсэнээ төлөвлөж буй төмөр замын бүтээн байгуулалтын ажил болон менежментийн ажлын хөрөнгийг 100% Монголын засгийн газраас хийх ба “Монголын төмөр зам” харицахаар болсон хэдий ч Зам, Тээврийн Яамнаас хэд хэдэн хэдэн төмөр замын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн аж ахуй нэгжид тус төмөр замын үйл ажиллагаа, хяналт шалгалт, гэрлэн дохионы системийн сайжруулах гэсэн чухал асуудлуудыг талаар хэлэлцэж байгаа.

(3) Агаарын тээвэр

Өнөөгийн байдлаар, Монгол улстай олон улсын нислэг хийдэг улс 6 улс байдаг. Япон руу шууд нислэг хийдэг нислэгийн компани бол төрийн өмчит компани болох МИАТ бөгөөд, Улаанбаатар-Нарита (долоо хоногт 3-6 нислэг) болон Улаанбаатар-Кансай (зөвхөн зун) гэсэн нислэг үйлдэж байна. Агаарын хөлөг В737-800 ба, 162 зорчигчийн суудалтай, 4 тоннын ачааны даацтай. Үүнээс гадна, Корэйн Эйр, Эйр Чайна тус бүр Сөүл юмуу Бээжингээр дайрч Улаанбаатар болон Японы хотууд руу нислэг үйлдэж байна. Харин дотоодын нислэгийн тухайд авч үзвэл, Улаанбаатараас дотоодын 12 онгоцны буудал руу 2 (Аэро Монголиа, Хүннү Эйр) авиа компани тогтмол нислэг үйлдэж байна (эдгээрээс 6 онгоцны буудал руу зун л нислэг хийдэг).

Улаанбаатарын баруун өмнөд хэсэгт ойролцоогоор 10 км зайд орших Чингис Хаан онгоцны буудлын яг доод талд нь транзит зорчигч тээвэрт зориулсан транзит танхим баригдаж байна (2015 оны 11 сард баригдаж дуусгахаар төлөвлөж байна). Мөн агаарын ачаа тээврийн бэрхшээлтэй асуудал бол өнөөгийн агаарын ачааны терминал маш жижиг гэдэг асуудал тавигдана. Улмаар, Улаанбаатарын өмнө хэсэгт 30км гаруй зайд 2017 оны 6 сард үйл ажиллагаагаа эхлүүлэх шинэ онгоцны буудал баригдаж байгаа бөгөөд, тийш холбох автозам болон төмөр зам барих ажил төлөвлөгдөж байна.

(4) Ложистик

Монгол улс БНХАУ болон ОХУ-ын дунд оршиж, өргөн уудам газар нутаг, эрс тэс уур амьсгалтай эх газрын улс бөгөөд, хүн ам харьцангуй цөөн, тээврийн дэд бүтэц ч хөгжөөгүй байгаа учраас дотоод болон олон улсын ложистикийн салбарт тал бүрийн хүндрэл бэрхшээл гарч байна. Дэлхийн банкнаас хил гаалийн үйлчилгээний чанар, дэд бүтцийн хөгжил, нийлүүлэлтийг өрсөлдөөнт үнээр зохион байгуулах боломж, ложистик үйлчилгээний чанар, ачаа тээврийн замыг оновчтой сонгох боломж, нийлүүлэлт төлөвлөсөн хугацаандаа эзэндээ хүрэх давтамж гэсэн 6 үзүүлэлтээр үнэлэгддэг Логистикийн Гүйцэтгэлийн Индекс (LPI)-ээр улс орнуудын олон улсын ложистикийн үйлчилгээний үнэлгээг 2007 оноос хойш 2 жил тутамд явуулж байгаа бөгөөд, тэрхүү

жагсаалтын хэсгээс хүснэгт 2.10.2-т үзүүлж байна. Нийтдээ 160 гаруй улс болон бүс нутгаас Монгол улс 135-140-р байранд ороод байгаа доогуур үзүүлэлттэй байна.

Нөгөөтэйгүүр, Монгол улстай адил эх газрын улс болох ашигт малтмалын нөөц баялаг ихтэй Боцвана улс Дэлхийн Банкны тусламжаар логистикийн дэд бүтцээ хөгжүүлснээр сүүлийн жилүүдэд Логистикийн Гүйцэтгэлийн Индекс (LPI)-ийн жагсаалтанд 68-р байранд орж урагшилсан үзүүлэлттэй байна. Монгол улс ч нэгэн адил гадаад худалдааг саадгүй явуулахад чиглэсэн тусламжийг Дэлхийн Банкнаас авч байсан боловч, объект нь зөвхөн гааль байсан учраас дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулаагүй байна. Хөрш орны хамтын ажиллагаагаар логистикийн системийг сайжруулах шаардлагатай ч, Монгол улсын тухайд логистикийн дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулах ажлыг нэн тэргүүнд явуулах шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 2.10.3 Ложистикийн чадварын индекс (LPI) эрэмбэ


Economy	LPI rank			LPI score				% of highest performer	Customs		Infrastructure		International shipments		Logistics quality and competence		Tracking and tracing		Timeliness	
	Rank	Lower bound	Upper bound	Score	Lower bound	Upper bound	Rank		Score	Rank	Score	Rank	Score	Rank	Score	Rank	Score	Rank	Score	
	Germany	1	1	1	4.12	4.07	4.17		100.0	2	4.10	1	4.32	4	3.74	3	4.12	1	4.17	4
Netherlands	2	2	5	4.05	3.97	4.12	97.6	4	3.96	3	4.23	11	3.64	2	4.13	6	4.07	6	4.34	
Belgium	3	1	6	4.04	3.96	4.13	97.5	11	3.80	8	4.10	2	3.80	4	4.11	4	4.11	2	4.39	
United Kingdom	4	2	5	4.01	3.96	4.07	96.6	5	3.94	6	4.16	12	3.63	5	4.03	5	4.08	7	4.33	
Singapore	5	2	7	4.00	3.95	4.06	96.2	3	4.01	2	4.28	6	3.70	8	3.97	11	3.90	9	4.25	
Sweden	6	1	20	3.96	3.68	4.24	94.9	15	3.75	9	4.09	3	3.76	6	3.98	7	3.98	8	4.26	
Norway	7	1	19	3.96	3.69	4.22	94.8	1	4.21	4	4.19	30	3.42	1	4.19	31	3.50	5	4.36	
Luxembourg	8	1	21	3.95	3.65	4.24	94.4	10	3.82	15	3.91	1	3.82	14	3.78	22	3.68	1	4.71	
United States	9	6	10	3.92	3.87	3.97	93.5	16	3.73	5	4.18	26	3.45	7	3.97	2	4.14	14	4.14	
Japan	10	6	12	3.91	3.85	3.97	93.4	14	3.78	7	4.16	19	3.52	11	3.93	9	3.95	10	4.24	
Ireland	11	5	17	3.87	3.73	4.01	91.9	12	3.80	16	3.84	27	3.44	9	3.94	3	4.13	16	4.13	
Canada	12	9	17	3.86	3.77	3.95	91.6	20	3.61	10	4.05	23	3.46	10	3.94	8	3.97	11	4.18	
France	13	9	17	3.85	3.77	3.92	91.2	18	3.65	13	3.98	7	3.68	15	3.75	12	3.89	13	4.17	
Switzerland	14	11	17	3.84	3.78	3.91	91.1	7	3.92	11	4.04	15	3.58	16	3.75	18	3.79	21	4.06	
Hong Kong SAR, China	15	11	17	3.83	3.77	3.89	90.5	17	3.72	14	3.97	14	3.58	13	3.81	13	3.87	18	4.06	
Australia	16	11	17	3.81	3.74	3.88	90.0	9	3.85	12	4.00	18	3.52	17	3.75	16	3.81	26	4.00	
Mongolia	135	102	155	2.36	2.09	2.62	43.4	132	2.20	120	2.29	110	2.62	126	2.33	149	2.13	147	2.51	
Equatorial Guinea	136	85	158	2.35	1.98	2.73	43.4	118	2.35	139	2.11	153	2.11	143	2.20	110	2.53	112	2.86	
Zimbabwe	137	87	158	2.34	1.98	2.70	42.9	154	1.89	123	2.25	143	2.25	108	2.50	143	2.22	104	2.93	
Tanzania	138	108	154	2.33	2.10	2.56	42.6	135	2.19	114	2.32	137	2.32	145	2.18	150	2.11	107	2.89	
Togo	139	105	158	2.32	2.04	2.59	42.2	139	2.09	145	2.07	124	2.47	150	2.14	116	2.49	140	2.60	
Turkmenistan	140	107	158	2.30	2.04	2.57	41.8	122	2.31	146	2.06	116	2.56	155	2.07	134	2.32	153	2.45	

Эх сурвалж: Дэлхийн Банк (2014)

2.11 Байгаль орчны салбарын өнөөгийн байдал, тулгарч буй асуудал

(1) Өнөөгийн байдал : Экологийн чухал бүс нутаг (Ой мод, нуур, Тусгай Хамгаалаттай Газар)

Ойн бүс нь нутгийн 9-оос илүү хувийг эзэлдэг бөгөөд (Зураг 2.11.1). Хойд хэсгийн ойн бүс нь усны нөөцийн гол бүс бөгөөд газрын гадаргуугийн урсгал усны нөөцийн 70% нь газар нутгийн 30%-ийг эзэлдэг уулархаг бүс (Хангайн нуруу, Хэнтийн нуруу, Хөвсгөл нуур орчмын нутаг) -д оршдог байна.



Эх сурвалж: Integrated Water Management National Assessment Report Volume II, Strengthening Integrated Water Resource Management in Mongolia Project & MEGD, 2012

Зураг 2.11.1 Экологийн хувьд чухал бүс нутаг (Ой, нуур, дархан цаазат газар нутаг)

(2) Үржил шимгүй газар нэмэгдэж байгаа нь (Газрын эвдрэл)

Газрын эвдрэл тулгамдсан асуудал болж байна. Түүний 3 үндсэн шалтгаан нь ой модны эвдрэл, тал хээрийн өвс ургамлын доройтол, цөлжилт юм.

1) Ой модны эвдрэл, доройтол

1994 онд ой мод 11,161,000 га газрыг эзэлж байсан бол 2012 онд 10,755,300 га¹⁰⁴ болж ойролцоогоор 4%-иар багассан бөгөөд мод огтлох, ойн түймэр,

¹⁰⁴ Ойн талбайн хэмжээг FAO, Global Forest Resources Assessment 2015 Country Report Mongolia-аас

хортон шавьжны хор нөлөөнөөс болсон байна. Ой модны өсөлт удаан тул аажмаар хээр талын ургамал зонхилох болж байна. Үүний шалтгаан нөхцлийн талаар олон талын судалгааны үр дүнгээс авч үзсэн бөгөөд хүснэгт 2.11.1-т харуулсанчлан ойн менежментийн тогтолцооны сүйрэл зэргийг оролцуулаад хүний хүчин зүйлээс үүдэлтэй хэд хэдэн шалтгаан байна.


Хүснэгт 2.11.1 Ойн эвдрэл, элэгдлийн шалтгаан

Үзэгдэл	Шалтгаан
Ойн эвдрэл, элэгдэл → Ой модны өсөлт удаан тул тал хээр болж хувирч байна.	(1) Ойн ашиглалтанд том машин техник, тээврийн хэрэгсэл хэрэглэх болсноор ой хатаж байна.
	(2) Ойн түймэр
	(6) Хортон шавьж, өвчин
	(7) Барилгын материал бэлтгэх зорилгоор зүй зохисгүй мод бэлтгэх, хууль бусаар түлээ бэлтгэх
	(8) Ойд замбараагүйгээр мал бэлчээх
	(9) Газрын эвдрэл

Эх сурвалж: “Байгаль орчин хүн судлал ба бүс нутаг Монголын тал хээрийн экологийн системийн эвдрэл ба нөхөн сэргээлт” Киотогийн Их Сургууль ЭШС-ы нийтлэл (2013 он)-ээс авав.

2) Тал хээрийн доройтол

Тал хээрийн байдал улам бүр дордсоор байна. Бэлчээрийн доройтол нь голын сав газар, хүн ам суурьшсан газар нутаг орчмын хээр талын бүсэд гол төлөв ажиглагдаж байна (Зураг 2.11.2). Тал хээрийн бүсийн газрын эвдрэл доройтлын талаар энэ судалгааны тайлангийн 2.5 хэсэгт малын хэт бэлчээрлэлт, малын бүтэц зэрэг шалтгаантай холбон судалж үзсэн ба урьд хийгдсэн судалгааны дүгнэлтийг хүснэгт 2.11.2-т харуулав.



Эх сурвалж: Integrated Water Management National Assessment Report Volume II, Strengthening Integrated Water Resource Management in Mongolia Project & MEGD, 2012

Зураг 2.11.2 Тал хээрийн доройтлын тархалтын зураг

Хүснэгт 2.11.2


Тал хээрийн өвс ургамлын доройтлын шалтгаан

Ажиглагдаж буй үзэгдэл	Шалтгаан	
Тал хээрийн өвс ургамлын доройтол Ургамлын төрөл зүйл цөөрөх Ургамлын өсөлт буурах Мал идэхэд тэсвэртэй ургамлын төрөл зүйл болж өөрчлөгдөх →1. Малыг тэжээх чадвар доройтох 2. Хөрсний эвдрэлээс үүдэн өвс ургамал багасах	1) Хуурай бүс нутгийн хүйтэн газар тул тал хээрийн газар маш эмзэг	
	2) Орох хур тунадасны хэмжээ бага, тал хээрийн газар нь газрын гадаргуугаас доош 20-30 см орчим нордог (хөрсөнд ус шингэдэггүй)	
	3) Ууршилтын түвшин өндөр	
	4) Автомашин давхих (Ердийнхээс 150 дахин хатуу болж, 10~15 жил хуучин хэвэндээ буцаж ордоггүй)	
	5) Бэлчээр (Худаг, хүн амьдардаг газрын ойр орчимд бэлчээрийн ачаалал маш өндөр болж, өвс ургамал муудсан, өвсгүй халзарсан газар бий болсон)	
	6) Бэлчээрийн даац хэтрүүлэх (Бэлчээрийн даацыг хэтрүүлэх, нэг газраа олон жил ашиглах, малын нягтрал г.м)	A. Тэжээлийн хомсдлын улмаас үндэстэй нь идсэнээр олон наст ургамал, бут сөөг ургах чадваргүй болж нөхөн сэргэлт нь муудна.
B. Өвсийг уртаар хадах явдал байнга давтагдсанаас (Ямаа, хонь 3 см, адуу, үхэр 5 см-ээс дээш урттайгаар өвс иддэг), олон наст ургамлын газар доорх шим тэжээл муудаж, мал идэхэд тэсвэртэй ургамлын төрөл зүйл болж өөрчлөгдөж, хөрс шүлтлэг болно. (Урт хугацааны нөлөө)		
C. Бэлчээрийн даацыг хэтрүүлэх явдал үргэлжилсээр байвал жижиг бут сөөгний ургах чадвар суларч устаж үгүй болно. (Урт хугацааны нөлөө)		

Эх сурвалж: “Байгаль орчин хүн судлал ба бүс нутаг Монголын тал хээрийн экологийн системийн эвдрэл ба нөхөн сэргээлт” Киотогийн Их Сургууль ЭШС-ы нийтлэл(2013 он)-ээс авав.

3) Цөлжилт

Өмнө хийгдсэн судалгаанаас харахад Монголд цөлжилт эрчимтэй явагдаж байгаа бөгөөд газар нутгийн 72.8% нь эмзэг байдалтай байгаагаас 59.4% (929,600 км²) нь туйлын эмзэг байдалд байгаа гэсэн судалгааны дүгнэлт гарсан¹⁰⁵. Цөлжилтийн үндсэн шалтгаан нь цаг уурын өөрчлөлт, ган гачигийн улмаас гол мөрөн ширгэх зэрэг байгалийн хүчин зүйлээс гадна газар, усны нөөцийг зүй зохисгүй ашиглах, аж ахуйн үйл ажиллагааны улмаас бий болсон эвдрэл зэрэг хүний хүчин зүйлтэй холбоотой гэдгийг үгүйсгэхийн аргагүй юм.



Эх сурвалж: Integrated Water Management National Assessment Report Volume II, Strengthening Integrated Water Resource Management in Mongolia Project & MEGD, 2012

Зураг 2.11.3 Цөлжилт (2008 он)

(3) Дулаарал

1940-өөд оноос хойш дэлхийн дулаарлын дараах нөлөө Монгол улсад илэрч ирсэн бөгөөд цаашид дэлхийн дулаарлын нөлөөгөөр хуурай ба хагас хуурай бүс зонхилсон цаг уурын бүсэд шилжиж эхэлнэ гэж үзэж байна¹⁰⁶.

¹⁰⁵ Integrated Water Management National Assessment Report Volume II, Strengthening Integrated Water Resource Management in Mongolia Project & MEGD, 2012

¹⁰⁶ “Байгаль орчин хүн судлал ба бүс нутаг Монголын тал хээрийн экологийн системийн эвдрэл ба нөхөн сэргээлт” Киотогийн Их Сургууль ЭШС-ы нийтлэл (2013он) .

- 1940 оноос 2007 оны хооронд жилийн дундаж агаарын температур 2.1С болж өссөн. Жилийн дундаж агаарын температур дотор хамгийн мэдэгдэхүйц өссөн нь өвлийн дундаж температур бөгөөд 3.6°C болж өссөн байна. Түүнээс гадна хавар 1.8°C, намар 1.3°C, зун 0.5°C болж өссөн байна.
- Жилийн дундаж хур тунадасны хэмжээний өөрчлөлтийг авч үзэхэд зарим бүс нутагт буурсан байхад зэргэлдээ бүс нутагт нэмэгдсэн байна. Улирлаар нь үзэхэд намар, өвөл орох хур тунадасны хэмжээ 4-9 % нэмэгдэж, хавар, зуны хур тунадасны хэмжээ 7.5~10% буурсан байна.
- Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 1940 оноос 5~2.5%-ийн хооронд буурч эсвэл нэмэгдсэн байна. Төвийн бүсэд 30~90 мм буурсан бол баруун хэсэгт 2~60 мм, зүүн өмнө хэсэгт 30~70 мм тус тус нэмэгдсэн байна.
- Хамгийн урт үргэлжилсэн хуурай өдрийн тоо жилийн дундажаар өөрчлөгдөөгүй. Хамгийн урт үргэлжилсэн хуурай өдрийн тоо нь жилд орох хур тунадас багассан төвийн бүсэд бага зэрэг нэмэгдсэн бол жилд орох хур тунадасны дундаж хэмжээ ихэссэн зүүн өмнөд хэсэгт багассан байна.
- Далд ууршилтын хэмжээ 7~12% өссөн байна.

Энэ судалгаагаар цаг уурын өөрчлөлтийн чиг хандлагад тулгуурлан цаг уур цаашид яаж өөрчлөгдөх талаар таамаглал хийв (Хүснэгт 2.11.3). Үүн дотроос анхаарал хандуулах ёстой зүйл бол “Ургамлын бүс хойд зүг рүү шилжиж, хагас цөл болон тал хээрийн бүс улам бүр тэлэх” гэсэн өвс ургамлын өөрчлөлтийн дүр зураг бөгөөд түүний улмаас мал сүргийн нөхцөл байдал өөрчлөгдөх явдал юм. Өөрөөр хэлбэл “Мал бэлчихэд тохиромжгүй газар нутгийн хэмжээ одоогийн 40%-аас 2050 он хүртэл 70% орчим болж нэмэгдэнэ” гэсэн зураглал гарч байна.

Энэ таамаглал бодитой (эсвэл хүний оролцоотойгоор өөрчлөх боломжгүй) гэж үзвэл Монголын газар тариалан, мал аж ахуй эрхлэлтийн одоогийн хэлбэрийг цаашид эрчимжсэн аж ахуй болгон өөрчлөх шаардлагатай. Зах зээлийн эдийн засгийн үр ашгийн талаас нь авч үзвэл эрчимжсэн аж ахуй нь илүү үр дүнтэй байж болох боловч Монголын бэлчээрийн мал аж ахуй, уламжлалт амьдралын хэв шинж алдагдаж болзошгүй юм.

Хүснэгт 2.11.3 Ирээдүйн цаг уурын таамаглал

Цаг уурын талаар	<ul style="list-style-type: none"> • Хуурай халуун зун, ердийнхөөс дулаан цас ихтэй өвөл • Орох хур тунадасны хэмжээнээс ууршилтын хэмжээ илүү байх • Ган гачиг зэрэг цаг уурын онцгой үзэгдлийн давтамж 2080 хүртэл 2 дахин нэмэгдэнэ
Цаг уурын бүс болон ургамлынталаар	<ul style="list-style-type: none"> • Ургамлын бүс хойшоо шилжиж, хагас цөл болон тал хээрийн бүс нэмэгдэнэ . 2020 оноос 2080 он хүртэл өвс ургамлын хэмжээ багасаж, түүний чанар муудна
Усны нөөцийн талаар	<ul style="list-style-type: none"> • 2020 он хүртэл гол мөрний урсацын хэмжээ маш бага хэмжээгээр нэмэгдэх бөгөөд хэрвээ илүү хурдтайгаар нэмэгдэх тохиолдолд тооцоолсон ууршилтын дундаж хэмжээ(Далд ууршилтын хэмжээ)-тэй тохирохгүй
Мал сүрэг	<ul style="list-style-type: none"> • Бэлчээрт тохиромжгүй газар нутгийн хэмжээ одоогийн 40%-аас 2050 он хүртэл 70% орчим, 2090 он хүртэл 80% орчим нэмэгдэнэ • Цаг уурын өөрчлөлтийн улмаас улам бүр нэмэгдэх цаг уурын онцгой үзэгдэл нь мал аж ахуйн хөгжилд муугаар нөлөөлөх ба цаашдын 80 жилд энэ нөлөө их хэмжээгээр нэмэгдэнэ.

Эх сурвалж: “Байгаль орчин хүн судлал ба бүс нутаг Монголын тал хээрийн экологийн системийн эвдрэл ба нөхөн сэргээлт” Киотогийн их сургуулийн ЭШС-ийн нийтлэл (2013он)

(4) Усны нөөцийн хэмжээ ба газар тариалан, мал аж ахуйн боломжит хязгаар

Дээр өгүүлсэнчлэн дэлхийн дулаарлын нөлөө нь ашиглах боломжит усны нөөцөд ч нөлөөлнө гэж үзэж байна. Орох хур тунадасны хэмжээ болон ууршилтын хэмжээ нь адил тул усны нөөцийн хэмжээ өөрчлөгдөхгүй байж болох боловч ган гачгийн давтамж нэмэгдэнэ гэж тооцвол зүй зохистой усны менежмент, хэрэглээг нэвтрүүлэх нь чухал . Усны нөөц талаас нь авч үзэхэд Монголын “Усны байдал”-ын онцлогийг дараах маягаар тодорхойлж болно.

Маш хязгаарлагдмал усны нөөц:1 хүнд ноогдох хэрэглэх боломжтой усны хэмжээгээр Монгол улс харьцангуй өндөр боловч нийт газар нутаг дахь усны хэмжээ багатай улсад орно¹⁰⁷. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 220 мм-ээс хэтрэхгүй бөгөөд түүний 90% орчим нь ууршиж алга болдог тул үнэндээ орсон хур тунадасны 10% орчим нь л газар нутагт үлддэг. Энэ 10% орчмын 4% нь л гүний ус болж үлдэж,6% нь гадаргуугийн ус болж гол мөрөн, нууранд ордог. Гэвч гол мөрөнд орсон усны ихэнх нь Орос, Хятад руу урсдаг учраас эцсийн дүндээ гадагшаа гарч Монгол улс дотроо үлддэггүй. Тиймээс маш бага

¹⁰⁷ Ministry of Environment and Green Development. 2013. Integrated water management plan: Mongolia. Ministry of Environment and Green Development. Mongolia.

хур тунадасны нийт хэмжээнээс Монгол улсад ашиглах боломжтой усны хэмжээ 3~4% болж байна¹⁰⁸.

Гүний уснаас өндөр хамааралтай байх: Дээр өгүүлсэн зүйл дээр нэмж хэлэхэд жилийн хагас зарим бүс нутагт хагасаас илүүд нь Монголын гол мөрөн хөлдүү байдаг тул урсгал усны хэрэглээ хязгаарлагдмал байдаг. Түүнчлэн өмнө зүгийн говийн бүс нутаг болон тал хээрийн бүсэд угаасаа гол мөрөн, нуургүй газар нутаг байгаа бөгөөд эдгээр бүс нутаг нь гүний уснаас хамааралтай байна. Гүний усыг ашиглах арга хэрэгсэл (худаг г.м) байхгүй эсвэл тэр нь ажиллагаагүй газарт газар тариалан эрхлэх боломж бараг байхгүй юм. Нөгөө талаас малчдаас асууж ярилцаж байхад эдгээр бүс нутагт цас, мөс хайлуулан малаа услах боломжтой учраас өвлийн улиралд ч малын бэлчээр болгон ашиглах боломжтой байна.

Гүний усны түвшин доошлох: Мал аж ахуй, газар тариаланд гүний ус хэрэглэдэг зарим бүс нутгуудад гүний усны түвшин доошилж байгаа тухай жишээ дурьдагдах болсон. Сүүлийн үеийн тайлангаас харахад 20 жилийн өмнө 25 м-т гүний усны давхаргад хүрдэг байсан бол одоо 90 м ухахаас нааш ус гарч ирэхгүй болсон байна.

Хужиртай усны тархалт: Өмнө зүгийн говийн бүс зэрэг хужир бүхий усны давхарга өргөн тархсан бүс нутгуудийн ус нь давжилт өндөр байдаг тул усаар гачигддаг бүс нутаг ч байдаг. Уул уурхайд хужиртай усыг ихээр хэрэглэдэг ба хужрыг нь тунгааж ялгасан ус буцаад хужиртай болдог эсэхийг нягталж тогтоогоогүй.

Одоогийн байдлаар нийт газар нутгийн 80% нь тал, 1% нь газар тариаланд ашиглагдаж байгаа бөгөөд цаашид ч гүний уснаас хамаарах байдал үргэлжилсээр байх юм бол бэлчээрийн газар, газар тариалангийн газрын харьцаа улам бүр доошилно байх гэж бодож байна. Эрчимжсэн газар тариалан хөгжихийн хирээр мөн мал олноор төвлөрсөн газруудад ус ширгэж хатах явц хурдсахыг анхаарах хэрэгтэй.

(5) Өвлийн улирлын халаалт ба агаарын бохирдол

Өвлийн улиралд агаарын бохирдол орон нутгийн хотуудын байгал орчны асуудал асуудлын нэг болж байна. Гэрийн зууханд шатааж буй бага илчлэгтэй нүүрсны утаа агаарын бохирдлын шалтгаан болж байна. Гэхдээ төвийн дулаан хангамж (СНР) маягийн эсвэл төвлөрсөн дунд оврын бойлууртой дулааны систем бүхий хотууд ч байна.

¹⁰⁸ Altansukh, N. 1995. Mongolia: country report to the FAO international technical conference on plant genetic resources. FAO.

Эрчим хүчний яамны судалгаанаас харахад 4 том хот СНР маягийн, 9 хот дунд оврын төвлөрсөн бойлерын системтэй (Булганд 2014 онд барьж дууссан), бусад 9 хотод хэд хэдэн жижиг уурын зуух хэрэглэж байна. Агаарын бохирдлыг бууруулахын тулд өндөр үр ашигтай төвлөрсөн дунд оврын бойлуурын систем бүхий дулааны системг нэвтрүүлэхээр судалж байна (Зураг 2.11.4).



Эх сурвалж: Эрчим хүчний Яам

Зураг 2.11.4 Орон нутгийн хотуудын дулаан хангамжийн систем

(6) Орон нутгийн хотууд дахь хог хаягдал боловсруулалт

Хог хаягдал боловсруулахдаа ердийн булж нягтруулах гэсэн хамгийн зардал багатай аргыг хэрэглэж байна. Гэвч цаашид булах газар улам бүр дүүрч, хогийг зохих аргаар боловсруулалгүй орхисны улмаас хог талаар нэг тархан салхинд хийсч байгаа дүр зураг судалгааны явцад ажиглагдлаа. Дараах хүснэгтэнд гол гол хотуудын хог боловсруулалтын байдалтай танилцсан зүйлийг нэгтгэн харуулав.

Хүснэгт 2.11.4 Хотуудын хог хаягдлын боловсруулалтын байдал

	Дархан	Эрдэнэт	Чойбалсан	Сайншанд	Чойр	Чингис
Боловсруулах арга	Landfill	булж нягтруулах	Хаях	Хаях	Landfill	Хаях
Талбайн хэмжээ	15 га	80 га	40 га	–	14 га	10 га
Цаашид ашиглах боломж (Landfill тохиолдолд)	4–5 жил	Бага	Бага	10 жил	5 жил	Бараг 0
Хотын төвөөс зай	8 км	18 км	4 км	5 – 6 км	–	5 км
Ялгаж ангилдаг эсэх	Yes	No	Yes	Yes	хог ангилан боловсруулах үйлвэрийн суурь судалгаа хийгдэж байгаа	No
Ялган ангилалтын байдал	Хуванцар савыг ангилан дахин боловсруулдаг (Сан Оргуй ХХК)	–	Ангилан боловсруулах үйлдвэр байгуулсан боловч эвдэрсэн тул ажилладаггүй	Усны сав цуглуулж (Цэвэр агаар ХХК) УБ-т худалддаг	Зөвхөн усны сав (4 компани) цуглуулж УБ-т худалддаг	–
Шатаах зуух барих төлөвлөгөө байгаа	Хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэрийн суурь судалгаа хийгдэж байгаа (Тахь Гоо ХХК)	Германы ТХА-ы судалгаа хийгдэж байгаа	Хог шатаах үйлдвэр байгуулах талаар судалж байгаа	Байхгүй	–	БНСУ-ын тусламжаар суурь судалгаа хийгдэж байгаа
Асуудал	Хогийн цэгт метан хий үүсдэг	булж нягтруулах багтаамж байхгүй болсон	Хог шатаах үйлдвэр байгуулах төсөв хүрэлцэхгүй	Байхгүй	Аймгийн түвшинд хог боловсруулах төлөвлөгөө боловсруулж байгаа	Булж нягтруулдаг гүйсалхинд хийссэн байдалтай

Эх сурвалж : Хотуудын холбогдох ажилтнуудтай хийсэн ЖАЙКА-ийн судалгааны баг ярилцаж хийсэн ярилцлагаас

Хогны бүтцийг аваад үзэхэд хуванцар хог их хэмжээтэй байгаа тул ангилан цуглуулах ажлыг системжүүлж нүүрстэй холин өндөр хүчин чадалтай бойлерт шатааж түлш болгон ашиглах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Одоо Японы нийслэлийн ойр орчмын бүс нутагт олон тооны орчин үеийн том оврын зууханд хуванцарыг шатамхай хогтой хольж шатаадаг болсон. Хлорид, флуорид, хүнд металлын төрлийн хольц бүхий хуванцар хогийг ямар ч асуудалгүй шатааж устгадаг болсон. Одоо ашиглаж буй нүүрсний бойлерт

хуванцарыг нүүрстэй холин шатаах боломжтой бөгөөд зуухны овор хэмжээ, хэлбэр, хаягдал утааны талаар судалж үзэн, боловсронгуй болгох шаардлагатай. Ялангуяа доор дурьдсан асуудлыг тусгасан төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.

Зуухны хэт халалт, температур өндөрсөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. Хуванцар нь нүүрснээс илүү дулаан ялгаруулах учраас бойлороос ялгарах утааны температурыг хянах төдийгээр хязгаарлавал зуух эвдрэх магадлалтай тул ус шүрших зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй.

3 Макро эдийн засгийн өсөлтийн хувилбар, дунд хугацааны таамаглал

3.1 Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөх нөхцөл

(1) Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал

Энэхүү тайлангийн 2 дугаар бүлэгт дурдсанчлан Монгол улсын аж үйлдвэрийн голлох салбар нь уул уурхай, мал аж ахуй боловч уул уурхай нь ДНБ-ий 17%-ийг, аж үйлдвэрийн салбар тус бүрээр авч үзэхэд нийт борлуулалтын 60%-ийг эзэлдэг буюу уул уурхайн баялгаас хараат эдийн засгийн бүтэц бий болсон байна. Экспортын хувьд ч уул уурхайн бүтээгдэхүүн 83% (2014 оны байдлаар) -ийг эзэлдэг, мөн 90% орчим нь БНХАУ-руу экспортолдог, цаашилбал БНХАУ-д нийлүүлсэн экспорт нь 2014 оны ДНБ-ий 42%-ийг эзэлж байсан ба уул уурхайн баялгаас, БНХАУ-аас хамааралтай, сул эдийн засаг бий болжээ.

2000 оноос хойш байгалийн арвин нөөц баялгийн ашгийг хүртсэнээр эдийн засаг маш хурдацтай хөгжиж, уул уурхайн томоохон хэмжээний төслүүдэд гадаад орнуудаас шууд хөрөнгө оруулалт урсан орж ирж, эдийн засгийн тэлсэн бодлогыг хэрэгжүүлсэнээр 2010-2013 оны хооронд Монгол улсын эдийн засаг эрс өссөн. Хүснэгт 3.1.1-д үзүүлсэнчлэн 2010 он гэхэд ДНБ-ий өсөлтийн хувь 20%-с давж, түүнээс хойш 2 оронтой тоонд хадгалагдсаар байна. Гэвч байгалийн баялгийн национализмаас үүдсэн хөрөнгө оруулалтын бүрхэг орчин дээр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан, ашигт малтмалын үнэ буурсан нь нэрмээс болж уул уурхай болон Хятадаас ихээхэн хамааралтай Монгол улсын эдийн засагт хүндээр туссан. Ингэснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт, нүүрсний экспортын үнэ огцом унаж (Зураг 3.1.1 харна уу), эдийн засгийн өсөлт саарах хандлагатай болж ирсэн байна. Нүүрсний экспорт 2013, 2014 онуудад тус тус 41%, 24.3% буурч, 2014 онд ДНБ-ий өсөлт 7.8% болтлоо буурсан. 2015 оны эхний хагаст ч 3.0% буюу буурсан хэвээр байна.


Хүснэгт 3.1.1 Монгол улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (бодит үнэ)

	2009	2010	2011	2012	2013	2014	2015
ДНБ-ий өсөлт	-1.3%	6.4%	17.3%	12.3%	11.6%	7.9%	2.3%
Уул уурхайн баялгийн экспорт (сая ам.доллар)	1,132	1,478	1,827	1,782	2,161	3,688	3,205
Өсөлт	-39.4%	30.6%	23.6%	-2.5%	21.3%	70.6%	-13.1%
Нүүрсний экспорт (сая ам.доллар)	305	882	2,273	1,902	1,122	849	556
Өсөлт	65.2%	189.0%	157.7%	-16.3%	-41.0%	-24.3%	-34.5%
Арьс шир, хувцас, утасны экспорт (сая ам.доллар)	1,903	2,909	4,817	4,385	4,269	5,775	4,669
Өсөлт	-24.9%	52.9%	65.6%	-9.0%	-2.6%	35.3%	-19.1%
Нийт экспорт (сая ам.доллар)	2,138	3,200	6,598	6,738	6,358	5,237	3,797
Өсөлт	-34.1%	49.7%	106.2%	2.1%	-5.6%	-17.6%	-27.5%
Нийт импорт (сая ам.доллар)	376,899	454,438	437,353	463,038	591,392	640,344	685,538
Өсөлт	34.6%	20.6%	-3.8%	5.9%	27.7%	8.3%	7.1%
Нэхмэл эд, материалын үйлдвэрлэл (сая төг)*	177,180	143,369	187,349	151,878	192,529	230,514	247,705
Өсөлт	21.0%	-19.1%	30.7%	-18.9%	26.8%	19.7%	7.5%
Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (сая төг)*	2,796	1,524	2,213	7,068	7,741	11,188	16,532
Өсөлт	-0.8%	-45.5%	45.2%	219.4%	9.5%	44.5%	47.8%
ЗГ-ын худалдан авалт (сая төг)*	984,199	1,237,928	1,402,441	1,738,650	1,931,190	2,015,323	1,877,653
Өсөлт	4.4%	25.8%	13.3%	24.0%	11.1%	4.4%	-6.8%
Хувийн хэрэглээний зардал (сая төг)*	4,074,810	5,387,294	5,891,872	6,814,702	8,007,495	8,810,531	9,309,547
ДНБ-ий өсөлт	12.5%	32.2%	9.4%	15.7%	17.5%	10.0%	5.7%

Эх сурвалж : ҮСХ

*ОУВС-гийн ДНБ-ий дефляторыг ашиглан ЖАЙКА-ийн судалгааны баг бодит утга руу хөрвүүлэв


Нэгж : сая ам.доллар



Эх сурвалж : НҮБ-ийн Худалдаа, хөгжлийн бага хурлын материалыг үндэслэн

ЖАЙКА -ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.1 Гадаадын шууд хөрөнгө оруулалт




Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.2 Дотоодын ба гадаадын хөрөнгө оруулалтын харьцаа Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав


Зураг 3.1.3-д үзүүлсэнчлэн, олон улсын санхүүгийн хямралын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт буурсан 2009 оныг эс тооцон дотоодын хэрэглээ ба хөрөнгө оруулалтын ДНБ-ий өсөлтөд оруулах хувь 2012 оныг хүртэл өндөр байсан боловч 2013 оноос хойш хөрөнгө оруулалт огцом буурсан. Түүнчлэн 2014 онд цэвэр экспорт огцом өссөн боловч энэ нь Хүснэгт 3.1.1 ба Зураг 3.1.4-д үзүүлсэнчлэн Оюутолгойн зэсийн уурхай ажиллаж эхэлсэнээр уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн, дотоодын эдийн засгийн өсөлт саарсантай холбогдон импорт багассанаас шалтгаалж байна.

Мөн аж үйлдвэрийн салбаруудын ДНБ-д оруулсан хувь нэмрийг авч үзвэл 2012 оноос хойш барилгын салбар, бөөний болон жижиглэн худалдааны салбарын бууралт нь ДНБ-ий өсөлтийг доош татаж байна. Уул уурхайн салбарын хувьд нүүрсний үйлдвэрлэл багассаар байгаа боловч бодитоор ажиллаж эхэлсэн зэсийн үйлдвэрлэл гол тулгуур болж нийт салбараар авч үзэхэд ДНБ-д ихээхэн хувь нэмэр оруулжээ.




Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.3 ДНБ-ий эцсийн ашиглалт



Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.4 Экспорт импортын өсөлт




Эх сурвалж : ҮСХ-мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.5 Салбар тус бүрийн ДНБ-ий өсөлтөд эзлэх хувь хэмжээ

Сүүлийн жилүүдийн эдийн засгийн уналтаас шалтгаалан 2015 онд улсын татварын орлого төлөвлөгөөт хэмжээнээс эрс багасч, улсын төсөв улам хүнд байдалтай болж байна. Импорт багассанаар НӨАТ болон гаалийн татвар буурсанаас гадна аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, уул уурхайн роялти зэрэг бүх орлого буурч,

нийтдээ 1 их наяд төгрөгөөр¹ багасна гэж таамаглаж байна. 2015 оны сар бүрийн татварын орлого (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) -ыг авч үзэхэд оны эхэнд нэмэх байсан бол 2015 оны 12-р сар гэхэд -1,3% 2016 оны 3 сард -10% болж, өмнөх онтой харьцуулахад татварын орлого буурсан нь ажиглагдаж байна.




Эх сурвалж : Монгол банк, ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.6 Сар бүрийн татварын орлогын өөрчлөлт (өмнөх оны мөн үетэй харьцуулалт)

Гадаадын шууд хөрөнгө оруулалт багассанаас олон улсын төлбөрийн тэнцэл муудаж, хүндхэн байдалтай байна.


Зураг 3.1.7 -д үзүүлсэнчлэн 2008 онд урсгал тэнцэл хасах руу орсоноос хойш 2011 оноос 2013 онд -25% орчим болж эрс муудсан байна. Мөн төсвийн алдагдал 2012 оноос хойш ДНБ-ий 10% орчимд хэлбэлзэж, төсвийн тэнцэл муудаж байгааг харж болно. Гадаад валютын нөөц 2012 оны 12-р сард хамгийн өндөр байсан бөгөөд 2013 онд эрс багассан. 2015 оны 9-р сарын байдлаар 1,4 тэрбум ам.доллар, 4 сарын импортын (2014 оны 10-р сар-2015 оны 9-р сарын импортын сарын дундаж хэмжээ ойролцоогоор 330 сая ам.доллар) хэмжээтэй тэнцэхүйц байна.



Эх сурвалж : ОУВС-гийн мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.1.7 Төсвийн тэнцэл, урсгал тэнцэл (ДНБ-тэй харьцуулсан байдал)

¹ Mongolia Economic Update November 2015, World Bank



Эх сурвалж : ҮСХ-ны мэдээллийг үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.1.8 Гадаад валютын нөөц

Төсвийг сэргээн босгохын тулд Засгийн газраас төсвийн болон мөнгөний хатуу бодлого явуулсанаар 2015 онд төсвийн алдагдлыг бууруулж, инфляцийн түвшинг ч нэг оронтой тоонд оруулж чадсан зэрэг сайжрах хандлага ажиглагдаж байна. Гэвч Монгол улсын Засгийн газар гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсанаас үүдэлтэй олон улсын төлбөрийн тэнцлийн дутагдлыг нөхөхийн тулд 2015 оны 5, 6-р сард дараалуулан гадаад бонд гаргасан. Өмнө нь гаргасан бондын эхний эргэн төлөлт 1.29 тэрбум ам.доллар 2017 оны нэгдүгээр улиралд төлөгдөх ёстой, нэмж гаргасан бондыг тооцвол 2018 онд 657 сая долларын эргэн төлөлт хүлээгдэж буй тул Засгийн газар төсвийн хатуу бодлогоо цаашид ч үргэлжлүүлэхийн зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг сэргээж гадаад валютын нөөцөө хангалттай нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

Түүнчлэн банкны салбарт ч нийт зээлийн 5%-ийг чанаргүй зээл, 6.1%-ийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж нөхцөл байдал улам муудаж байна. Мөн өрхийн хэрэглээ багассан хэдий ч нэмэх үзүүлэлттэй байгаа боловч өрхийн бодит орлого хасах үзүүлэлттэй гарсан² нь эдийн засгийн уналтын нөлөө хавтгайрсаныг харуулж байна.

² MONGOLIA ECONOMIC UPDATE NOVEMBER 2015, World Bank

Хүснэгт 3.1.2 Гадаад бондын эргэн төлөлтийн хуваарь

Бонд гаргагч	Гаргасан өдөр	Эргэн төлөлт эхлэх	Үлдэгдэл (сая)	Валют	Ам.долларт шилжүүлсэн үлдэгдэл (сая)	Купон	Жилийн хүүгийн төлбөр (сая ам.д)
Худалдаа хөгжлийн банк	2014/1/21	2017/1/21	700	CNY	110	10.000	11.0
Хөгжлийн банк	2012/3/21	2017/3/21	580	USD	580	5.750	33.4
“Монголиан майнинг” корпораци	2012/3/29	2017/3/29	600	USD	600	8.875	53.3
МУ-ын Засгийн газар	2012/12/5	2018/1/5	500	USD	500	4.125	20.6
МУ-ын Засгийн газар	2015/06/30	2018/06/30	1,000	CNY	157	7.500	11.7
Худалдаа хөгжлийн банк	2015/05/19	2020/05/19	500	USD	500	9.375	46.9
МУ-ын Засгийн газар	2012/12/5	2022/12/5	1,000	USD	1,000	5.125	51.3
Хөгжлийн банк	2013/12/25	2023/12/25	30,000	JPY	244	1.520	3.7
Нийт					3,690		202.5

USD1= 122.93 JPY

6.39 CNY

2015 оны 12-р сарын 1-ний ОАНДА биржийн ханш

Эх сурвалж: Олон улсын валютын хүрээлэн/ИМА “Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал ба тулгамдсан асуудал ~ Анхаарал татаж буй олон улсын төлбөрийн тэнцлийн чиг хандлагын асуудал ~” нийтлэлийн хүснэгтийг ЖАЙКА судалгааны баг.

(2) Тогтвортой өсөлтийн нөхцөл

1)-д өгүүлсэнчлэн Монгол улсын эдийн засаг нь хөдөө аж ахуй, уул уурхайд тулгуурласан, газар тариалан, мал аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэлийн 3 салбар нийт үйлдвэрлэлт болон ДНБ-ий 40 хувийг эзэлдэг. Ялангуяа байгалийн арвин баялагт тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татан эдийн засаг хурдацтай өссөн бөгөөд аж үйлдвэрийн салбар хоорондын харилцааны дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд ч уул уурхайн экспорт эдийн засгийн өсөлтөд томоохон үүрэг гүйцэтгэж байна. Цаашид ч уул уурхай, хөдөө аж ахуйг голлох салбар хэвээр байлгахын зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлд чухал нөлөөтэй үйлдвэрлэлийн салбарыг өргөтгөх нь тогтвортой хөгжлийг үргэлжлүүлэх үндэс болох болов уу.

Гэвч уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа нь сүүлийн жилүүдэд Монгол улсын эдийн засгийн байдал муудах томоохон хүчин зүйл болж байна. Байгалийн баялгаас хамааралтайгаас гадна экспорт нь БНХАУ-аас ихээхэн хамааралтай тул ашигт малтмалын үнэ өссөн, БНХА-ын эдийн засаг суларсанаас үүдэн нүүрсний экспорт нэлээд буурсан. Мөн БНХАУ-аас болгоомжлох үүднээс гадаадын хөрөнгө оруулалтын нөхцлийг чангатгасан, түүнчлэн Оюутолгойтой холбоотойгоор Засгийн

газар ба Рио Тинто группийн хооронд гэрээ хэлэлцээр, татварын асуудлаар маргаан үүссэн зэрэг хөрөнгө оруулалтын бүрхэг орчин нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг багасгахад хүргэж Монгол улсын эдийн засагт хүчтэй цохилт үзүүлсэн. Ингэснээр хэрэглээ ч буурч нийт эдийн засгийн өсөлт саарч, олон улсын төлбөрийн тэнцэл, татварын орлого буурч улсын төсвийн нөхцөл байдал хүндэрч байна.

Иймээс эдийн засгийн тогтвортой хөгжлийг үргэлжлүүлэхийн тулд дараах нөхцлүүдийг бүрдүүлэх нь зүйтэй.

1) Уул уурхайн салбарын экспортыг тогтворжуулах, нүүрсний дотоодын үйлдвэрлэл, дотоодын хэрэглээг дэмжих

Уул уурхайн салбарын экспорт нь Монгол улсын эдийн засгийн өсөлтөд томоохон хувь нэмэр оруулдаг болохыг бид өмнөх дүн шинжилгээнээс харж болох ба олон улсын төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх талаас авч үзсэн ч Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал суурь болж байна. Гэвч экспорт нь БНХАУ-аас ихээхэн хамааралтай, олон улсын зах зээл дээрх үнийн нөлөөнд өртөмтгий тул илүү олон төрлийн худалдан авагчтай болох, хөрөнгө оруулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлэх, нэмүү өртөгийг нэмэгдүүлэх зэргээр уул уурхайн тогтвортой үйлдвэрлэл, экспортын орчинг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Иймээс нэн түрүүнд өмнөд бүсэд худалдан авдаг эрчим хүчний импортыг орлуулахын тулд нүүрсний дотоодын ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх бодлого шаардлагатай. Мөн уул уурхайн салбарын өсөлт нь Монгол улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй тул хүний нөөцийг бэлтгэх, технологийг шинэчлэх замаар дотооддоо өөрийн хэрэгцээг хангах чадварыг нэмэгдүүлэх нь чухал юм.

2) Үйлдвэрлэлийг өргөтгөх

Уул уурхайн салбараас хамааралтай байдал нь зах зээлийн уналт зэрэг уул уурхайн салбарын удаашралаас хамааран эдийн засагт хүчтэй нөлөөлдөг, эрсдэл өндөртэй гэдгийг сүүлийн жилүүдийн эдийн засгийн бууралтаас ч харж болно. Харин үйлдвэрлэл нь дотоодын нийт үйлдвэрлэлд өргөн цар хүрээгээр нөлөөлдөг, ялангуяа хөдөө аж ахуйд үзүүлэх нөлөө ихтэй. Тиймээс үйлдвэрлэлийг өргөтгөх, төрөлжүүлэх нь эдийн засгийн бүтцийг тогтворжуулж, өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

3) Макро эдийн засгийн зохистой бодлого

Монгол улсын Засгийн газар чухалчлан авч үзсээр ирсэн улсын төсөв, өрийн удирдлагын асуудал ноцтой байдалд ороод байна. Төсвийн орлогын хэтийн төлөв, өрийн удирдлага сул байгаа нь эдийн засаг удааширч, гадаадын хөрөнгө оруулалт багасан, хямрал үүсэх шалтгаан болсон нь тодорхой бөгөөд бондын зах зээл дээр босгох хөрөнгө нэмэгдсэн ч эргэн төлөх чадвараас хамаарсан санхүүжилтийн төлөвлөгөө, хатуу хяналт шаардлагатай, мөн төсвийн хувьд ч орлогын хэтийн төлөв,

зардлын төлөвлөгөөг хянамгай боловсруулах, тэнцлийг хянах асуудал маш чухал. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар өрийн хязгаарыг тогтоосон бөгөөд одоо зохистой удирдаж чадах эсэхээс цаашдын тогтвортой өсөлт шалтгаална.

4) Гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчинг бүрдүүлэх

Баялгийн национализмаас шалтгаалан Монгол улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бүрхэг бөгөөд шударга бус бодлого явуулж ирсний улмаас гадаадын хөрөнгө оруулалт эрс багасч гадаад валютын хомсдолд орсон. Ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх нь уул уурхайн салбарт чиглэсэн байдаг ба тус салбарыг тогтворжуулах, тохиромжтой орчинг бүрдүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтыг сэргээх боломжтой. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд хууль эрх зүйн орчинг шинэчлэх зэрэг ажлуудыг хийх шаардлагатай юм.

5) Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой өсөлтийг хангах үйлдвэрлэлийн суурийг бий болгох

2015 онд ган болсонтой холбогдон хөдөө аж ахуйн салбарын гарц багасч, улмаар зуд болбол асар ихээр нэрвэгдэх тул хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг дэмжих тогтолцоог бүрдүүлсэнээр эдийн засгийг илүү тогтворжуулж чадна. Хөдөө аж ахуйн салбар өсөх потенциал өндөртэй, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хөрөнгө санхүүжилт болон техник технологийг нэвтрүүлж, улмаар дотоодод болон гадаадад зах зээл бий болгох чиглэлээр идэвхтэй арга хэмжээ авах хэрэгтэй байна.

3.2 Монгол улсын эдийн засгийн хэтийн төлөв

(1) Олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн судалгааны байгууллагуудын таамаглал

3.1-д тоймлон үзсэнчлэн 2014 оноос хойш Монгол улсын эдийн засаг мөнгө, санхүүгийн хүндхэн байдалд байгаа ба 2015, 2016 онд ч энэ байдал үргэлжилнэ гэж таамаглаж байна. ОУВС болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд, хувийн хэвшлийн судалгааны байгууллагууд ч энэхүү нөхцөл байдлыг үндэслэн бүгд таамаглалаа буурууллаа. 2015 онд уул уурхайн үйлдвэрлэл өссөн боловч гадаадын шууд хөрөнгө оруулалт багассанаар бусад салбарын өсөлт удааширч, мөн зун хур багатай байснаас хөдөө аж ахуйд нөлөөлөн ургац хураалт 3-р улирлын байдлаар үр тариа 2014 оны 28%, төмс, хүнсний ногоо 2014 оны 66%, 83%-тай тэнцэж байна. Эдийн засгийн ийм нөхцөл байдлаас үүдэн байгууллагууд 2015 оны ДНБ-ий өсөлтийг 2~3% байна гэж таамаглаж байна. 2016 онд ч байдал хэвээр байх боловч оны дундаас Оюутолгойн төслийн 2-р үе эхэлж, зэс, алтны үйлдвэрлэл өргөжих төлөвтэй байгаа тул бага багаар эргэн сэргэнэ гэж үзэж байгаа юм. 2016-2017 онд зэсийн баяжмалын нөөц багассанаар уурхайн үйлдвэрлэл буурч, зах зээл муудна гэж таамаглаж буй Дэлхийн банкнаас бусад нь 2016 онд 3% ~ 4%-ийн өсөлттэй байна гэж таамаглажээ.

Татварын орлогыг сэргээхэд нэлээд хугацаа шаардагдах тул улсын төсөв хүнд байдалтай хэвээр байх ба олон улсын төлбөрийн тэнцлийн хувьд ч 2015 онд гадаад худалдааны тэнцэл сайжирсанаар урсгал тэнцлийн алдагдал багасах боловч 2016 онд Оюутолгой төслийн 2-р үе шат эхэлсэнээр импорт нэмэгдэж урсгал тооцооны алдагдал нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн 2017 оноос гадаад бондын эргэн төлөлт эхэлж, 2017 оны эхний улиралд 1.3 тэрбум доллар шаардлагатай болно. Тиймээс баялгийн экспорт нэмэгдэж, эдийн засаг сэргэх нь тодорхой болох хүртэл санхүү, мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэхээс гадна гадаадын шууд хөрөнгө оруулалтыг сэргээх арга хэмжээг авах шаардлагатай.

Ийнхүү богино хугацаанд бүрхэг бөгөөд хүндхэн байдалтай байх боловч урт хугацаанд авч үзвэл Оюутолгой төслийн 2-р үе шат эхэлсэнээр гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэж, баялгийн экспорт нэмэгдэн эдийн засаг өсөх магадлалтай бөгөөд 2018 оноос хойш эдийн засаг сэргэх замдаа орж, 2020 он гэхэд ДНБ-ий өсөлт 9~11% болно гэж таамаглаж байна.

Байгууллагуудын эдийн засгийн өсөлтийн таамаглалыг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

**Хүснэгт 3.2.1 Олон улсын байгууллага, хувийн хэвшлийн судалгааны байгууллагын хийсэн
Монгол улсын ДНБ-ий өсөлтийн таамаглал**

	2015	2016	2017	2018	2019	2020	Тайлбар
ОУВС	3.5%	3.6%	3.7%	6.2%	6.6%	9.1%	2015 он 10 сар
ДБ	2.3%	0.8%	3.0%	6.4%	7.9%	11.0%	2015 он 11 сар
АХБ	2.3%	3.0%	-	-	-	-	
Бизнес Мониторинг Интернешнл	3.1%		4.5%		Дунджаар 7.5%		XX судалгааны байгууллага

Эх сурвалж :World Economic Outlook Database October 2015, IMF; Mongolia Economic Update November 2015, WB;
Asian Development Outlook 2015 update, ADB; Mongolia Country Risk Report, BMI research

(2) Хэтийн төлөв

3.1-д өгүүлсэнчлэн 2014 оноос хойш Монгол улсын эдийн засгийн эргэн тойрны орчин нөхцөл өөрчлөгдөж, байгалийн баялагт тулгуурласан өсөлтийн төлөв эрс өөрчлөгдсөн. Богино хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт бууралтаас шалтгаалан олон улсын төлбөрийн тэнцэл муудаж, гадаад санхүүгийн эрсдэл ихэссэнээр хүнд нөхцөл байдал хэвээр үргэлжлэхээр байна. Нөгөөтэйгүүр Оюутолгойн зэсийн уурхайн төслийн 2-р үеийн гэрээ 2015 оны 5-р сард хийгдсэн зэрэг дунд ба урт хугацааны эдийн засгийн сэргэлтэд чиглэсэн ололт ч байна³. ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллагаас дунд, урт хугацаанд Оюутолгойгоос эхлээд уул уурхайн хөгжүүлэлтэд чиглэсэн хөрөнгө оруулалт, байгалийн баялгийн экспортыг дөрөөлөн эдийн засаг хөгжиж, хүн амын орлогын түвшин нэмэгдэнэ гэж таамагласан байна. Гэвч 3.1.3-д тогтвортой өсөлтийн нөхцөл болгон авч үзсэн макро эдийн засгийн тохиромжтой бодлого цаашдын чиг хандлагыг тодорхойлох ба бодлого оновчтой байж чадахгүй бол урт хугацаанд ч эдийн засгийн хүнд нөхцөл үргэлжилсээр байх тул дунд, урт хугацааны хэтийн төлвийг тодорхойлоход хүндрэлтэй байна. Ийм ч утгаараа засгийн эрх баригчдад маш чухал үе тулгараад байгаа бөгөөд 2016 оны сонгуулийн үр дүнгээс цаашдын бодлого шалтгаалах юм.

³ 2015 оны 12-р сарын 6, Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын зардал нийт 6 тэрбум доллараас 4.4 тэрбумын санхүүжилт шийдэгдэж, гэрээнд гарын үсэг зурсан тухай мэдээлсэн. (МОНЦАМЭ, 2015 оны 12-р сарын 18-ны дугаар). 2016 оны эхний хагасаас ажил нь эхэлнэ гэжээ. Улс төрийн асуудлуудаас ангид байж саадгүй урагшилна гэсэн хүлээлттэй байна.

3.3 Хийгдсэн таамаглал ба богино, дунд хугацааны эдийн засгийн төлөвлөлтийн хувибар

(1) Макро эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлийн судалгаа

1) Аргачлал ба урьдчилсан нөхцөл

Энэ хэсэгт дээр тоймлон үзсэн Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал, аж үйлдвэрийн бүтцийг үндэслэн, цаг хугацааны мэдээнээс Монгол улсын эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлсийг шинжлэхийн тулд дараах төсөөлөл, нөхцөлтэйгөө регрессийн аргаар шинжилнэ.

- Төсөөлөл : Голлох салбар болох уул уурхайн экспорт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулдаг
- Тайлбарлагдагч хувьсагч : ДНБ-ий хэмжээ
- Тайлбарлагч хувьсагч : Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, нүүрсний экспортын хэмжээ, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ
- Мэдээ : 2008-2015 оны улирлын мэдээ (2015 оны 2-р улирал хүртэл)
- Өгөгдөлийн тоо : 32

2) Өсөлтийн хүчин зүйлийн шинжилгээний үр дүр

Регрессийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв. ДНБ-ий регрессийн хамаарлыг шинжлэхэд уул уурхайн баялгийн экспорт, нүүрсний экспорт, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 1% -ийн магадлалын түвшинд ач холбогдолтой, тус тусын өсөлт нь ДНБ-ий өсөлтөд хувь нэмэртэй гэсэн үр дүн гарчээ. Харин нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл ач холбогдолтой гараагүй буюу ДНБ-ий өсөлтөд оруулах хувь нэмэр батлагдсангүй.

Хүснэгт 3.3.1 Регрессийн хамаарлын үр дүн

Жишээ тоо = 32
Log likelihood = -442.1465 Wald chi2(6) = 530.02***

ДНБ	Coef	Std.Err.	P>z
Уул уурхайн бүт. Экспорт	812,743	(302,952)	0.007***
Нүүрсний экспорт	240,524	(115,298)	0.037**
Нэхмэл сүлжмэл үйлдвэрлэл	-176,951	(270,959)	0.514
Арьс шир үйлдвэрлэл	88,726	(109,437)	0.418
Хувцас, арьсан үйлдвэрлэл	189,589	(188,088)	0.313
Хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэл	1,268,775	(550,117)	0.021**
1-р улирал загвар	-95,379	(195,404)	0.625
2-р улирал загвар	583,328	(296,706)	0.049**
3-р улирал загвар	435,178	(203,369)	0.032**
Тогтмол	-26,000,000	(3,386,478)	0***

* P<0.1, **P<0.05, ***P<0.001 (P нь *** бол 1% ач холбогдолтой)

Wald chi2 : Загварын таарамжийг илтгэгч

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

(2) Салбар тус бүрийн хувилбарыг авч үзэх нь

1) Салбар тус бүрийн төлөвлөлтийн хувилбараар ДНБ-ийг тооцох нь

Өмнө хийсэн регрессийн хамаарлыг ашиглан дараах 4 хувилбараар ДНБ-ийг тооцож үзье. Хувилбар бүрийн дундаж өсөлтийг:

Хувилбар 1: Уул уурхай, ХАА салбар аль аль нь тогвортой өсөх

Хувилбар 2: Уул уурхай уналтын байдалд, ХАА салбар тогвортой өсөх

Хувилбар 3: Уул уурхайн экспорт уналтын байдалд, нүүрсний экспорт буурсан, ХАА өсөх

Хувилбар 4: Уул уурхайн экспорт тогвортой, нүүрсний экспорт буурсан, ХАА салбар тогвортой өсөх

Хүснэгт 3.3.2-г нэгтгэн үзүүлсэн.

Хувилбар 1: Уул уурхай, ХАА салбар аль аль нь тогвортой өсөх

Хувилбар 2: Уул уурхай уналтын байдалд, ХАА салбар тогвортой өсөх

Хувилбар 3: Уул уурхайн экспорт уналтын байдалд, нүүрсний экспорт буурсан, ХАА өсөх

Хувилбар 4: Уул уурхайн экспорт тогтвортой, нүүрсний экспорт буурсан, ХАА салбар тогтвортой өсөх

Хүснэгт 3.3.2 Салбар тус бүрийн жилийн дундаж өсөлтийн төсөөлөл

	он	Ашигт татмал экс	Нүүрсний экспорт	ХАА үйлдвэрлэл
Хувилбар 1	2020 хүртэл	15%	10%	10%
	2025 хүртэл	15%	20%	15%
	2030 хүртэл	12%	18%	15%
Хувилбар 2	2020 хүртэл	8%	4%	10%
	2025 хүртэл	4%	2%	13%
	2030 хүртэл	3%	2%	15%
Хувилбар 3	2020 хүртэл	4%	-14%	20%
	2025 хүртэл	2%	-8%	15%
	2030 хүртэл	2%	-10%	18%
Хувилбар 4	2020 хүртэл	10%	4%	10%
	2025 хүртэл	10%	2%	13%
	2030 хүртэл	12%	4%	15%

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

2) Салбар тус бүрийн хувилбар дахь ДНБ-ий тооцооллын үр дүн

Дээр дурдсан төсөөллийн дагуу 4 хувилбараар ДНБ-ий тооцоог хийсэн. Үр дүнг хүснэгт 3.3.3 болон зураг 3.3.1-д үзүүлээ. Уул уурхай, ХАА аль аль нь тогтвортой өсөх хувилбар 1-д ДНБ-ий өсөлт сайн буюу 2020 он хүртэлх жилийн дундаж өсөлт 13.7%, 2025 он хүртэлх нь 15.2%, 2030 он хүртэл 12.9% байна. Хувилбар 4-т 2020, 2025, 2030 оны өсөлт тус бүр 9,8%, 10,6%, 12,7%, болон 2 оронтой тоо болж тогтвортой харагдаж байна. Харин хувилбар 2, хувилбар 3-т ДНБ-ий өсөлт 1 оронтой тоонд байх ба эдийн засаг өсөхгүй байна.

Эдгээр үр дүнгээс 1) ашигт малтмал, нүүрсний экспортын уналт ДНБ-ий өсөлтийг ихээхэн сааруулдаг, 2) ашигт малтмал, нүүрсний экспортын дутагдлыг ХАА-н салбар нөхөх боломж байгаа хэдий ч найдвартай өсөлтийг хангах шаардлагатай гэсэн 2 зүйл харагдаж байна. Иймээс ашигт малтмал, нүүрсний экспортыг тогтвортой үргэлжлүүлэхийн зэрэгцээ ХАА-н салбарыг өсөлтийн замд нь оруулах явдал нь эдийн засгийн өсөлтийн түлхүүр болно.

Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд ашигт малтмалын үнийн уналт, Хятадын эдийн засгийн зогсонго байдал, түүнчлэн ашигт малтмалыг тойрсон тодорхойгүй орчин зэргээс хархад цаашид уул уурхайн экспортын өсөлт үргэлжлэх найдвар багатай юм.


Дээрх нөхцөл байдлын доор 2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” (дэлгэрэнгүй мэдээллийг 3.4-с харна уу)-д Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 2030 он хүртэл 6.6% болгох зорилтыг дэвшүүлсэн. Уул уурхайн экспорт их хэмжээгээр өснө гэж үзсэн тохиолдолд 6.6%-ийн өсөлтөд хүрхийн тулд ХАА салбарын өсөлт чухал үүрэг гүйцэтгэнэ. (Хүснэгт 3.3.1) харуулсанчлан “Хувилбар 2”-т уул уурхайн экспорт болон нүүрсний экспорт тогтвортойгоор өсөж ХАА салбар 2 оронтойгоор өсөх тохиолдолд 2030 оны зорилтот өсөлтөнд хүрэх дүр зураг харагдаж байна. Үүнээс харахад ХАА салбар 2 оронтойгоор тогтвортой өссөн тохиолдолд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” эдийн засгийн зорилтот өсөлтөнд хүрнэ гэж үзэж байна

Хүснэгт 3.3.3 Салбар тус бүрийн ДНБ-ий тооцооллын үр дүн

Нэгж : сая төгрөг

		2015	2020	2025	2030
Хувилбар 1	Бодит ДНБ	15,796,681	30,012,019	60,814,624	111,479,982
	Өсөлт		13.7%	15.2%	12.9%
Хувилбар 2	Бодит ДНБ	15,796,681	22,105,126	30,651,443	42,303,433
	Өсөлт		7.0%	6.8%	6.7%
Хувилбар	Бодит ДНБ	15,796,681	23,624,203	34,556,328	55,349,048
	Өсөлт		8.4%	7.9%	9.9%
Хувилбар 4	Бодит ДНБ	15,796,681	25,210,243	41,662,939	75,808,711
	Өсөлт		9.8%	10.6%	12.7%

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 3.3.1 Салбар тус бүрийн өсөлтийн хувилбараар авч үзсэн ДНБ-ий таамаглал

3.4 Монгол улсын эдийн засгийн хөгжлийн дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөлт

(1) Монгол улсын хөгжлийн бодлогын тойм

1) Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль

2015 онд улсын хөгжлийн бодлогын талаар дахин хэлэлцэгдэж 2015 оны 11-р сарын 26-ны өдөр “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” батлагдсан. Тус хуулийг батлагдахаас өмнө улсын хөгжийн бодлогын талаар улсын болон орон нутаг, салбарын хэмжээнд тус бүртээ тогтсон хугацааны хүрээнд стратегийн бодлого төлөвлөлт олон байдаг байсан хэдий ч хууль эрх зүйн орчин бүрдээгүй, бодлого хоорондын уялдаа холбоо, төлөвлөлтийн систем, аргачлал бүрэлдээгүй, түүнчлэн хөгжлийн бодлогод зориулагдсан санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байсан. Дээрх хүчин зүйлүүдээс улбаалан хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний талаарх үндсэн зарчим, журмыг тодорхойлж, хариуцсан байгууллагуудын эрх үүргийг тогтоон нэгдсэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн системийг бүрдүүлэх зорилготойгоор уг хуулийг боловсруулсан.

Тус хуулинд хөгжлийн бодлогыг хугацаагаар нь болон төв, орон нутаг, салбарын хэмжээнд ангилан уялдаа холбоо, хяналтын систем, хэрэгжүүлэх байгууллагыг тусгаж өгсөн (Хүснэгт 3.4.1). Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь Монгол улсын хөгжлийн суурь болж, богино, дунд хугацааны бодлого, хөгжлийн үзэл баримтлалд заасны дагуу тодорхой төлөвлөгөө, үйл ажиллагааг боловсруулна.

Хүснэгт 3.4.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заагдсан бодлого

	Policy Document	Duration (years)	Related Policy Document	Monitoring and Evaluation (M&E) Period	Approval Authority
1	National Development Vision	15-20 Long	-	M&E in 2 years Independent monitoring in 4 years	State Great Khural
2	State Policy	8-10 Medium	National Development Vision	M&E in 2 years Independent monitoring in 4 years	Government of Mongolia
3	Regional Development Policy	8-10 Medium	National Development Vision	M&E in 2 years Independent monitoring in 4 years	Government of Mongolia
4	Aimag, Capital city Development policy	8-10 Medium	Regional Development Policy	M&E in 2 years	Local representative khural
5	Government Action Programme	4 Medium	National Development Vision, State Policy	M&E in 2 years Independent monitoring in 2 years	State Great Khural
6	Governor Action Programme	4 Medium	Regional Development Policy, Aimag, Capital City Development Policy	M&E in 2 years	Local representative khural
7	State Investment Plan	4 Medium	Government Action Programme, National Programme	M&E in 2 years	Government of Mongolia
8	National Programme	3-5 Medium	Government Action Programme	M&E every year, if necessary independent monitoring	Government of Mongolia
9	Sub Programme	3-5 Medium	Government Action Programme, National Programme	M&E in 2 years, if necessary independent monitoring	Local representative khural
10	Annual Socio-economic Development Guideline	1 year Short	Government Action Programme, National Programme	M&E every year	State Great Khural
11	Local Socio-economic Development Guideline	1 year Short	Government Action Programme, National Programme	M&E every year, if necessary independent monitoring	Local representative khural

Эх сурвалж : Хуулийн төслийг хариуцсан мэргэжилтэний боловсруулсан материалд үндэслэн ЖАЙКА -ийн судалгааны баг боловсруулав.

2) Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд суурилан УИХ-ын намын бүлгийн гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг 2030 он хүртэлх үндэсний хэмжээний урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулж 2016 оны 2 сард “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл батлагдсан. Үүнд 2030 он хүртэлх гол зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх 20 үндсэн үзүүлэлтийг тодорхойлжээ.

2030 оны зорилтууд

1. Дунд орлоготой орнуудыг тэргүүлэгч улс орнуудын эгнээнд орно. 2016-2030 оны ДНБ-ий жилийн дундаж өсөлт 6.6%, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17,500 ам.долларт хүрнэ.
2. Орлогын тэгш бус байдлыг багасгаж, орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг 30 хүргэн бууруулж, нийт хүн амын 80% нь чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
3. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.
4. Эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78 хүргэнэ.
5. Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно.
6. 2017-2024 онуудад төсвийг алдагдалгүй болгож, хуримтлал үүсгэх замаар Засгийн газрын өрийг барагдуулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийн нөхцөлийг хангана.
7. Ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.
8. Ойжуулалтыг нэмэгдүүлж, цөлжилтийг бууруулж, усны нөөцийг үр ашигтай ашиглах зорилтыг хэрэгжүүлж, байгаль орчны багц үзүүлэлтээр дэлхийн эхний 90 орны нэг болно.
9. Төрийн алба нь цэвэр тунгалаг, хариуцлагатай, ардчилсан иргэний нийгмийн засаглалыг төлөвшүүлж, засаглалын хүрээнд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлж, авлигыг устгана.
10. Бизнесийн орчинг сайжруулж, бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийд эхний 40 орны нэг болно.

Хүснэгт 3.4.2 2030 оны зорилтууд

	Үзүүлэлт	Суурь түвшин (2014)	Зорилтот түвшин (2030)
1	Жилийн дундаж өсөлт	7.8%	6.6% (2016-2030 дундаж)
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	4,166 ам.доллар	17,500 ам.доллар
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	103-р байр	70-р байр
4	Дундаж наслалт	69.8	78
5	Ядуурлын түвшин	21.6%	0%
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	104-р байр	70-р байр
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	56-р байр	40-р байр
8	Байгаль орчны багц үзүүлэлт	111-р байр	90-р байр
9	Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь	84.4%	99%
10	Жини коэффициент	36.5	30
11	1000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	15.1	8
12	100,000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	30.6	20
13	ЕБС-ийн анги дүүргэлт, улсын дундаж	27.3 хүүхэд	20 хүүхэд
14	Олон улсын худалдааны хорио цээрт нээлттэй болсон газар нутгийн эзлэх хувь	0%	60%
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь	78.2%	60%
16	Экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	17%	30%
17	МУ-д аялах гадаадын жуулчдын тоо	39.2 сая хүн	200 сая хүн
18	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн ам	84%	100%
19	Экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	17%	50%
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	0%	100%

Эх сурвалж : Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016-2030

Мөн доорх зурагт харуулсан 4 үндсэн бодлогын хүрээнд бодит зорилтуудыг дэвшүүлж, 5, 5 жилээр 3 үе шатад хуваан жишгийг тогтоосон байна. Эдгээр зорилтуудыг дунд урт хугацааны хөгжлийн бодлого, засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсөвтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

1. Эдийн засгийн тогтвортой хөгжил	2. Нийгмийн тогтвортой хөгжил	3. Байгаль орчны тогтвортой байдал	4. Засаглал
<ul style="list-style-type: none"> • ХАА • Аялал жуулчлал • Аж үйлдвэр • Уул уурхай • Эрчим хүч, дэд бүтэц • Макро ЭЗ-ийн бодлого • Бизнесийн орчинг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> • Хүртээмжтэй өсөлтийн үндсэн дээр нийгмийн тэгш байдлыг хангах • Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй шуурхай тогтолцоо • Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх, ур чадвар бүхий иргэдийг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Усны нөөцийн нэгдсэн менежмент • Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох • Экосистемийн тэнцвэртэй байдал 	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжилт, хяналтыг сайжруулах • Төрийн байгууллгын удирдлагыг сайжруулан, засаглалын ил тод шударга, хариуцлагатай ажиллагааг хангах • Улс төрчид болон төрийн албан хаагчидын ёс суртахууныг сайжруулж, авилгалыг арилгах

Эх сурвалж: “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-аас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Зураг 3.4.1 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 4 үндсэн бодлого

Ялангуяа 1-р бодлого болох “Эдийн засгийн тогтвортой хөгжил”-ийн хүрээнд ХАА, аялал жуулчлал, аж үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн голлох салбаруудаас гадна макро эдийн засгийн бодлого, стратегийг авч үзсэн ба эдгээрийг Зураг 3.4.2, Зураг 3.4.3-г нэгтгэн үзүүлэв. Энэхүү стратеги нь ХАА-н салбарын чадавхийг бэхжүүлэх, боловсруулах үйлдвэрлэлд шилжих, уул уурхайн экспортыг дэмжих зэрэг аж үйлдвэрийг төрөлжүүлэх, экспортын олон улс дахь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангаж, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулах үүднээс цахилгаан эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын эх үүсвэрээр хангадаг болох, зам тээврийн сүлжээг өргөжүүлэх, аялал жуулчлалын хөгжлийг дэмжихүйц дэд бүтцийг бүрдүүлж, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын имижийг бүрдүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Мөн макро эдийн засгийн бодлогын хүрээнд дунд хугацааны өрийн стратегийг хэрэгжүүлж, үйлчилгээний зардлыг бууруулж, өрийн дээд хязгаарыг хатуу мөрдөх зэрэг өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ улсын төсвийн хяналтыг (орлого зарлагын төлөвлөгөө, зарцуулалт) оновчтой хэрэгжүүлнэ гэжээ.

Макро эдийн засгийн үндсэн зарчмууд


- Тогтвортой эдийн засгийн дундаж өсөлт 6.6% -с дээш
- Төсвийн алдагдлыг бууруулах
- Төсвийн тэнцвэртэй байдлыг хангах
- Өрийн хязгаарыг тогтоох
- Олон улсын зах зээл, үнийн хэлбэлзлийн эрсдлээс сэргийлэх
- Гадаад валютын нөөцийг хадгалах
- Гадаад хдалдааны тэнцэлийг ашигтай болгон, гадаад валютын тогтвортой байдал
- Банк санхүүгийн салбарын тогтвортой байдал, найдвартай, хариуцлагатай байдлыг хангах, зээлийн хүүгийн бодлого
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллах
- Төр, хувийн хэвшлийн уялдаа хобоог сайруулах, олон улсын хамтын ажиллагааны сан болон урт хугацааны хөнгөлөлттэй санхүүжилтыг авах, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах

Салбарын хөгжлийн үндсэн зарчмууд

- Бүтээмж өндөртэй үйлдвэрлэлийг бий болгох шин технологийг нэвтрүүлэх, инновацийг ашиглан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэлийг дэмжих
- Нөөцийн үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжих
- Эдийн засаг, нийгмийн бүх салбарт үр ашигтай, үр дүнтэй аргыг дагаж мөрдөх

Эх сурвалж: “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-аас ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.4.2 Макро эдийн засгийн бодлого, салбарын хөгжлийн үндсэн зарчим



Эх сурвалж : Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-г үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 3.4.3 Бодлого 1. “Эдийн засгийн тогтвортой хөгжил”

Дээр дурдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулинд урт хугацааны хөгжлийн бодлого болох “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” болон богино дунд хугацааны бодлого төлөвлөлт боловсруулах тухай тусгагдсан. Тус хуульд урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь Монгол улсын хөгжлийн үндэс болоод зогсохгүй УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшиж буй нэр улс төрийн нам болон дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах үүрэгтэй хэмээн тусгаж өгсөн.

(2) Монгол улсын тогтвортой, тасралтгүй хөгжлийн хувилбар

3.1-т дурдсанчлан тасралтгүй, тогтвортой хөгжихийн тулд уул уурхайн салбарын экспорт, макро эдийн засгийн бодлого чухал бөгөөд дээр дурдсан Урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (төсөл)-д ч уул уурхайн салбарын экспортыг дэмжиж, макро эдийн засгийн бодлогыг бэхжүүлэх стратегийг дэвшүүлсэн байна. Мөн малын гаралтай боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг нэмүү өртөг ихээр шингэсэн бүтээгдэхүүнийг бий болгох, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдгээр аж үйлдвэрийн салбаруудын хөгжлийг дэмжихүйц зам тээвэр, дэд бүтцийг бий болгох замаар эдийн засгийн тогтвортой, тасралтгүй өсөлтийг хангах боломжтой болно.

Тогтвортой, тасралтгүй хөгжлийг хангах хөгжлийн төсөөллийг Зураг 3.4.3-д үзүүлэв. Макро эдийн засгийн бодлогоор улсын төсөв, санхүүгийн тогтолцоо тогтворжихын зэрэгцээ хэрэглээ, хөрөнгө оруулалт өргөжиж, зам тээвэр, эрчим хүч зэрэг дэд бүтцийг бий болгосноор аж үйлдвэрийн төвлөрөл, логистикийн үндэс суурийг бий болгоно. Ийм үндэс суурийг ашиглан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх зэргээр аж үйлдвэрийг төрөлжүүлж, нэмүү өртгийг бий болгон, уул уурхай болон бусад салбарын экспортыг нэмэгдүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр аж үйлдвэрийн голлох салбаруудын өсөлтийг дэмжих нь Монгол улсын тогтвортой, тасралтгүй хөгжлийн хувилбар юм.

Тухайлбал, боловсруулах үйлдвэрлэлийн хувьд, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын төсөлд дурдсанчлан ялангуяа хүнсний үйлдвэрлэл голлох салбар болно. Мөн мал аж ахуйн салбар нь хүнсний бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуурын боловсруулалтын боломж бололцоо өндөртэй, гадаад орнуудын дэмжлэг тусалцаатайгаар техник, технологийг сайжруулж, дэд бүтцийг бий болгох замаар орчинг бүрдүүлж, мах, сүүн бүтээгдэхүүн, ноолуур зэрэг үйлдвэрлэлтэй уялдуулан аж үйлдвэрийг өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой болно. Улмаар тогтвортой техник, технологи, хяналтын дор бүтээгдэхүүний нэмүү өртөг, чанар ч сайжирч, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтээр экспорт ч нэмэгдэнэ.

Түүнчлэн макро эдийн засгийн зохистой бодлогоор эдийн засгийг тогтворжуулж, хөрөнгө оруулалтын бодлого зэрэг орчин нөхцлийг бүрдүүлсэнээр Оюутолгойн төслийн 2-р үе шат эхэлж уул уурхайн үйлдвэрлэл өргөжихийн хэрээр уул уурхай

ба холбогдох салбаруудад чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт дахин сэргэнэ гэж үзэж байна. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт ч салбар хоорондын уялдаа холбоо, аж үйлдвэрийн хуримтлал нэмэгдсэнээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжин, хөрөнгийн урсгалтай хамт техник технологийг нутагшуулсанаар үйлдвэрийн бүтээмж дээшилж, нэмүү өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэх юм. Улмаар өндөр потенциалтай боловч хангалттай хөгжөөгүй байгаа аялал жуулчлалын салбар ч дотоодын дэд бүтэц, тогтолцоог бүрдүүлж, институцийн бүтцийг бэхжүүлэн, хүний нөөцийг хөгжүүлсэнээр хөгжлийн үндсийг тавьж, аж үйлдвэрийн салбар болгон бэхжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, Монгол улсын эдийн засгийн нэг тулгуур голлох салбар болгон хөгжүүлнэ.

Дүгнэн хэлбэл тээвэр логистик, эрчим хүч, дэд бүтцийг бүрдүүлэх замаар аж үйлдвэрийн хуримтлал, түгээх системийн суурийг тавьж, макро эдийн засгийн бодлогоор макро эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчинг тогтворжуулж гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин, эдгээр суурин дээр үндэслэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, нэмүү өртөгийг ихээр шингээж, экспортыг дэмжсэнээр Монгол улсын эдийн засгийн тогтвортой, тасралтгүй өсөлтийг хангаж чадна.



Эх сурвалж : ЖАЙКА -ийн судалгааны баг

Зураг 3.4.4 Тогтвортой, тасралтгүй хөгжлийн хувилбар

4 Улсын орон зайн бүтэц, стратеги цогц хөгжлийн бодлого

4.1 Хэрэгжиж буй Үндэсний хөгжлийн бодлого болон стратеги хөгжлийн корридорын байр суурь

Энэхүү бүлэгт, 3-р бүлгийн 3.4 хэсэгт дурдсан Монгол улсын эдийн засгийн хөгжлийн дунд болон урт хугацааны зорилтыг тодорхойлсон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдахаас өмнөх хөгжлийн бодлогуудыг эмхэтгэв. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлагдсаны дараа боловсруулагдан батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 нь үндэсний хэмжээний дээд бодлого болно.

(1) Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008 он- 2021 он)

2008 онд УИХ-аар батлагдсан Монгол улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого нь “Бидний Монголчууд түүх, соёлоо эрхэмлэн хүндэлж, үндэсний бахархалтай, өндөр боловсролтой, өөрсөддөө итгэлтэй байж, эх орондоо тав тухтай, чинээлэг, сэтгэл хангалуун аж төрнө” гэсэн алсын хараатай үндэсний хөгжлийн цогц бодлогод (зорилтот жил 2021) үндэслэн, 2015 он хүртэл Мянганы хөгжлийн зорилтыг хангах, 2021 он хүртэл мэдлэгт суурилсан эдийн засгийг төлөвшүүлэхийн тулд салбар тус бүр дээр 2007-2015, 2016-2021 гэсэн 2 үе шаттай стратегийн зорилт тавигдсан. Түүнчлэн Үндэсний хөгжлийн цогц бодлогод тулгуурласан орон нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулагдсан байдаг.

Бүс нутаг, хотын хөгжлийн бодлогын бичиг баримтын хувьд, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр болон хэрэгжилт (тэр дундаа Ховд, Өвөрхангай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Чингис, Чойбалсан зэрэг аймаг) , Хөдөөгийн хөгжил хөтөлбөр, Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах (Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур) зэрэг хот хөдөөгийн ялгааг багасгах, хөдөө орон нутагт мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх чиг хандлага тусгагдсан байна.

Хүснэгт 4.1.1 Одоо хэрэгжиж буй хөгжлийн бодлогын бичиг баримт

<p>Тэргүүлэх 6 чиглэл</p>	<ol style="list-style-type: none"> 1) Мянганы хөгжлийн зорилтыг хангах болон Монгол хүний хөгжлийг тэргүүлэх чиглэл болгоно. 2) Экспортод чиглэсэн, хувийн хэвшил тэргүүлсэн өндөр технологид суурилсан боловсруулах салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх замаар мэдлэгт тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бий болгоно. 3) Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газруудыг ашиглан, эдийн засгийн өсөлтийг дэмжих хуримтлалыг бий болгож, орчин үеийн аж үйлдвэрийг хөгжүүлнэ. 4) Хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах зорилгоор орон нутгийн хөгжил болон дэд бүтцийг бэхжүүлнэ. 5) Агаар мандал, газар, түүний хэвлийн баялаг, ой, ус, ан амьтан, ургамлын олон янз байдлыг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах замаар тогтвортой хөгжлийг хангана. 6) Улс төр, ардчиллын тогтолцоог гүнзгийрүүлэн хөгжүүлж, авилгал, хүнд суртал зэрэг улс төр, засаг захиргааны үйл ажиллагаанд саад тотгор учруулдаг зүйлсийг халж, хариуцлагатай, шуурхай, ил тод, үр ашигтай удирдлагыг төлөвшүүлнэ.
<p>Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр</p>	<ul style="list-style-type: none"> ● Баруун, Зүүн, Төвийн , Хангайн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр ● Аж үйлдвэр, технологи, бизнесийн инкубатор парк (Улаанбаатар хотын 3 дагуул хот : Налайх, Багахангай, Багануур) Аэро үйлчилгээний олон улсын парк ● Дархан аж үйлдвэр, технологийн парк ● Сэлэнгэ аж үйлдвэр, технологийн парк ● Алтанбулаг аж үйлдвэр, технологийн парк ● Дорнод аж үйлдвэр, технологийн парк ● Эрдэнэт аж үйлдвэр, технологийн парк ● Хархорин сургалт, технологийн парк ● Ховд, Улиастай, Өндөрхаан аж үйлдвэр, технологийн парк ● Замын үүд, Алтанбулаг, Цагааннуур эдийн засгийн чөлөөт бүс (Free Economic and Trade Zone)

Эх сурвалж : Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021) -оос ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

(2) Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол)

Улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, байгаль орчиндоо зохицсон бэлчээрийн мал аж ахуйн орон зайн зохион байгуулалтын дэвшилттэй бүхнийг орчин үеийн суурин соёл иргэншлийн ололттой зүй зохистой хослуулах зарчмыг баримтална. ”Мянганы зам”-ыг байгуулах болон


нийт нутгийг хамарсан нэгдсэн төлөвлөгөө "Хүн амын нутагшилт, суурьшлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах зэрэг үйл ажиллагаа төлөвлөгдсөн байна. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БХБЯ боловсруулахаар ажиллаж байна.

Түүнчлэн, бүс тус бүрийн хөгжлийн хөтөлбөр 2006 оноос 2010 он хүртэл хугацаанд боловсруулагдсан байна (Хүснэгт 4.1.2).

Хүснэгт 4.1.2 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын товч агуулга

	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатарын бүс
Тэргүүлэх салбар	МАА, газар тариалан, жижиг дунд боловсруулах үйлдвэр	МАА, газар тариалан, аялал жуулчлал, сувилал, ЖДҮ, уул уурхайн боловсруулах үйлдвэр, модны аж ахуй	МАА, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэр, ЖДҮ, сувилал, орчин үеийн технологит үйлдвэр	Уул уурхайн боловсруулах үйлдвэр, газар тариалан, МАА, ЖДҮ, аялал жуулчлал	Орчин үеийн технологи бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ, олон улсын санхүүгийн сүлжээ
Олон улсын сүлжээ	Цагааннуур, Хандгайт, Арт суурь, Булган, Бургастай чиглэлээр ОХУ, БНХАУ-ын гадаад худалдаа, эдийн засгийн сүлжээнд холбогдож цаашид Таван Богдын чиглэлээр баруун зүүн тэнхлэгийг Төв Азийн бусад улстай холбогдох боломжийг судлана.	Бага Илэнх, Ханх, Тэшиг, Шивээ Хүрэн чиглэлээр ОХУ, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн сүлжээтэй шат дараалан холбогдоно.	Алтанбулаг-УБ-С айншанд-Замын-Үүд чиглэлээр Азийн авто болон төмөр замын сүлжээнд холбогдож, Ази Европыг дамжсан улс хоорондын худалдаа тээврийн харилцааны гол талбар болно.	Чойбалсан Эрэнцав, Чойбалсан Сүмбэр Рашаантын чиглэлээр Азийн төмөр замын сүлжээнд холбогдоно.	

Эх сурвалж : Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.



Эх сурвалж : ESRI, ГХГЗЗГ мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА -ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 4.1.1 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар тогтоогдсон 5 бүс нутаг

(3) “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр (2010-2016)

2010 онд УИХ аар батлагдсан, Монгол улсын хэмжээнд бүтээн байгуулалтыг өрнүүлсэнээр хот төлөвлөлт, эрчим хүч, инженерийн дэд бүтэц, авто замын сүлжээг олон улсын жишигт хүргэх, хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийг ажлын байраар хангах замаар улсын хэмжээнд тулгараад байгаа эдийн засаг, нийгмийн бэрхшээлтэй асуудлуудыг цогцоор шийдэн хөгжлийг жигд хангах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган баталгаажуулах зорилготой хөтөлбөр юм. Хот байгуулалт болон төлөвлөлт, инженерийн дэд бүтэц, орон сууцны хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх, түүнчлэн боловсролыг дэмжих, Улаанбаатар хотын агаарын бохирдолтой тэмцэх, хөдөө орон нутгийн хөгжил, хувийн хэвшил болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж үйлдвэрийг дэмжих, шилжилт, хөдөлгөөнийг багасгах зорилт болон хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Хөтөлбөрийн гол цөм нь Улаанбаатар хот хэдий ч тээвэрлэлтийн нөхцлийг сайжруулахын тулд, Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам болон ложистикийн төвүүдийг хөгжүүлэх асуудал төлөвлөгдсөн байна. Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд боловсруулагдсан зорилтот хөтөлбөр юм.

(4) Аймаг, төвүүдийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд

Аймгийн хэмжээнд дунд хугацааны төлөвлөгөө болон хөгжлийн хөтөлбөр боловсруулагдсан байдаг. Хөгжлийн хөтөлбөр нь засаг даргын томилгооны 4 жилийн хугацаан дахь мөрийн хөтөлбөртэй дүйцэх бөгөөд аймгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулагдаагүй зүйл ч бий. Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг Мянганы хөгжлийн бодлогод тулгуурласан Монгол улсын Үндэсний цогц бодлогод боловсруулан хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд ихэнхи аймгууд боловсруулсан, дахин тодотгол хийж буй аймгууд ч байна. Мөн сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан аймаг байхаас гадна, зарим аймгийн төвүүд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан байдаг (хавсралт 4.1.1).

Аймгийн хөгжлийн хөтөлбөр болон сумын хөгжлийн төлөвлөгөөнөөс гадна аймгийн ерөнхий архитектур аймгийн замын сүлжээ, инженерийн дэд бүтэц зэрэг хотын барилга байгууламж, орон сууцны байршил зэрэг газар зохион байгуулалтыг төлөвлөн гаргадаг.

(5) Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага

Монгол улсын Хот байгуулалтын тухай хуулинд тулгуурласан нийслэл хотын бүсийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын бичиг баримт 2013 онд УИХ-аар батлагдсан. Энэхүү бичиг баримт нь 2007-2009 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн хөгжлийн судалгаа Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний судалгааны үр дүн дээр тулгуурлан, өмнөх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийн, зах зээлийн эдийн засгийн тогтолцооны шинэ хот төлөвлөлт боловсруулсан билээ. Улаанбаатар хотын шинэ ерөнхий төлөвлөгөөний 5 жилийн хэрэгжилтийн төлөвлөгөө нь 2016 оны 3 сард УИХ-аар батлагдсан.

2002 онд батлагдсан Газрын тухай хуулиар Монгол улсын иргэнд (өрхийн хэрэгцээнд) газар өмчлүүлэх тухай заалт гарснаас хойш (2008 онд Улаанбаатар хотод иргэн бүрд 700м² газар өмчлөхийг зөвшөөрсөн заалт оруулсан) чөлөөт эдийн засгийн хөгжлийн хамт хөдөөгөөс хот руу шилжин суурьшигчдын тоо огцом өсөн нэмэгдэж, гэр хороолол гэх төлөвлөлтгүй суурьшлын бүс тэлж улмаар амьдрах орчны бохирдол, дэд бүтцийн хүрэлцээгүй байдал, автозамын түгжрэл зэрэг хотжилтын олон асуудалтай тулгарах болсон. Ялангуяа, зуд болсон жилүүдэд малаа олноор алдсан малчид Улаанбаатар хотод шилжин ирсэн нь хотын хүн ам нэмэгдэх гол хүчин зүйл болсон. Нийслэл Улаанбаатар хотын хөгжил болон түүнийг дагасан эдийн засгийн хэт төвлөрөл нь газрын тогтолцооны томоохон өөрчлөлт, социалист нийгмийн үед байсан хоршоо, сангийн аж ахуйн үйл ажиллагааны хумигдсан өөрчлөлт зэрэг ихээхэн нөлөө үзүүлсэн гэж хэлж болно.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага бодлогын бичиг баримтанд 2030 он гэхэд хотын хүн ам 1 сая 800 мянга байхаар тооцоолж, түүнээс гаднах хүн амыг дагуул хотуудыг хөгжүүлснээр тараан суурьшуулахаар төлөвлөсөн хэдий ч, бодит байдал дээр хотын хүн амын өсөлт хэвээр үргэлжилсээр байгаа бөгөөд, дараагийн шатны хотжилтын асуудлууд (ялангуяа, агаарын бохирдлыг бууруулах, хотын тээврийг сайжруулах, цэвэр, бохир усны хангамж, цахилгаан, дулаан зэрэг дэд бүтцийн байгууламжийн өргөтгөл, орон сууцны асуудлыг шийдвэрлэх зэрэг яаралтай арга хэмжээ авах шаардлагатай асуудал) улам бүр хурцдаж байна. ЖАЙКА нь хотын ерөнхий төлөвлөгөөний бодит хэрэгжилт, хотын дахин төлөвлөлтийг дэмжих хууль эрх зүйг бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэг, хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Гэвч, үндсэндээ Улаанбаатар хотод төвлөрсөн хүн амын өсөлтийг бууруулах хэрэгтэй бөгөөд, түүний тулд төрийн бодлогоор хөдөө, орон нутгийн хотын хөгжлийг дэмжин, түргэтгэх шаардлагатай болоод байгаа билээ.

(6) Хэрэгжиж буй улсын хөгжлийн бодлогод эзлэх стратеги хөгжлийн корридорын байр суурь

Энэхүү судалгааны гол стратеги хөгжлийн корридор нь судалгаа хийхэд зориулагдан дэвшүүлэгдсэн бөгөөд, дээрх бодлогын бичиг баримтуудад тусгагдаагүй. Дээрх Үндэсний хөгжлийн цогц бодлого болон бусад Монгол улсын ихэнх бодлогуудад тусгагдсан хөгжил, бүтээн байгуулалт нь зөвхөн нэг тулгуур цэг болон шугаман хөгжлийн төсөл байдаг бөгөөд цогц байдлаар хөгжүүлэх санаа бараг алга байна. Түүнчлэн, тулгуур цэг болон шугаман хөгжил байсан ч газрын зураг дээр буулган дүрслэл (визуал) маягаар харах тохиолдол байдаггүй тул тус тусын хөгжлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед хоорондын зохицуулалт хийх, эсвэл бусад хөгжлийн төслийн хэрэгжилттэй уялдуулан бүтээн байгуулалт явуулах гэсэн санаа санаачлага дутмаг байна.

Судалгааны багийн зүгээс Монголын талд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тулгуурласан байдлаар хөгжлийн тэнхлэг, корридорыг санал тавьж байгаа бөгөөд, Монгол улсын засгийн газар хэрэгцээтэй гэж үзсэн хөгжлийн тулгуур цэг болон тэнхлэгийн хөгжлийн зохицуулалт хийх замаар хөгжлийн корридор болгон хөгжүүлэх боломжтой хэмээн үзэж байна.

Түүнчлэн энэхүү судалгааны стратеги хөгжлийн корридорыг одоо хэрэгжиж буй Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан 5 бүс нутагт хамруулан хэлэлцэх хэрэгтэй гэсэн санал байгаа ч нутгийн хойд болон өмнөд хэсгийн байгаль орчин болон эдийн засгийн үйл ажиллагааны хэлбэр хооронд ихээхэн ялгаатай өргөн уудам нутаг дэвсгэрийг босоо 5 бүс нутагт хуваах нь ач холбогдол багатай, орон зайн хөгжлийн төлөвлөлт хэлэлцэхэд оновчтой бус тул дахин авч хэлэлцэх шаардлагатай.

(7) Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Өмнөх 3.4 хэсэгт танилцуулсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын бичиг баримт 2016 оны 2 сард УИХ-аар батлагдсан. Улс төрийн намууд хамтран улсын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон. Энэхүү урт хугацааны үзэл баримтлал нь эдийн засаг, нийгэм, ногоон хөгжил буюу засаглал болон бизнесийн орчинг сайжруулах 4 үндсэн бодлогын багана боссон.

Ийнхүү тодорхойлогдсон шинэ бодлогын үзэл баримтлал нь өмнөх 2008 онд УИХ аар батлагдсан “Мянганы хөгжлийн зорилгод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлоготой (2008-2021)” хэрхэн уялдах, эсвэл шинээр ямар төлөвлөлт, ямар бүс нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох вэ, 2016 оны 5 сарын байдлаар, тодорхой шийд гараагүй байна. Гэхдээ, шинээр батлагдсан “ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын хэрэгжүүлэхийн тулд түүнтэй уялдуулан “Улсын хөгжлийн цогц төлөвлөгөө” боловсруулах зайлшгүй шаардлагатай байгаа нь тодорхой бөгөөд, түүн дотор “Стратеги хөгжлийн корридорын үзэл баримтлал” нь үр ашигтай бүсчилсэн хөгжлийн чиг хандлага болно гэдэгт найдлага тавьж байна.

4.2 Судалгаанд хамрагдсан бүс нутгийн (4 бүс нутаг) нийгэм, эдийн засгийн онцлог

Юуны түрүүнд статистикийн мэдээлэл дээр тулгуурлан аймаг тус бүрийн нийгэм, эдийн засгийн онцлогийг хэлэлцэхийн хамт, энэхүү судалгааны хүрээнд авч хэлэлцэх 4 бүс нутгийг онцлон, тус бүрийн хөгжлийн хэм хэмжээ, нөөц бололцооны талаар авч хэлэлцэнэ.

2014 оны аймгуудын хүний хөгжлийн индекс (HDI)


¹ харахад, судалгаанд хамрагдсан аймгуудын үзүүлэлт өндөр байна. Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгаас бусад ихэнхи аймгууд 0.7-оос дээш байгаа бөгөөд, ялангуяа Орхон, Улаанбаатар хотод 0.8 байгаа бөгөөд улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм.

Аймаг тус бүрийн 2014 оны байдлаарх ДНБ-ний хэмжээг Зураг 4.2.1-т харьцуулсан байдлаар харууллаа. Зураг дээр тойргоор хүрээлсэн байгаа орон нутгууд энэ удаагийн судалгаанд хамрагдсан голлох аймгууд юм. Улаанбаатар хотын бүс, төв хэсгийн аймгуудын ДНБ-ний хэмжээ дунджаас өндөр байгаагаас гадна, энэхүү судалгаанд хамрагдсан хойд хэсгийн эдийн засгийн үйл ажиллагаа голлох байр эзэлж байна. ДНБ-ний бүтцийг авч үзэхэд, Улаанбаатар хотын ДНБ 13 их наяд 332 тэрбум 900 сая төгрөг байгаа бөгөөд нийт улсын ДНБ хэмжээ 21 их наяд 937 тэрбум 200 сая төгрөг байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хот дангаар улсын ДНБ-ний 61%-ийг дангаар эзэлж байгаа, эдийн засаг хэт төвлөрсөн байдалтай байгааг харж болно. Орон нутгууд хоорондоо зөрүү ихтэй, Орхон аймаг (1 их наяд 197 тэрбум 600 сая) Улаанбаатар хотын дараа 2-т, түүний дараа нэлээд их зөрүүтэйгээр Дорнод аймаг (619 тэрбум 500 сая), Сэлэнгэ аймаг (586 тэрбум 100 сая) , Өмнөговь аймаг (574 тэрбум 500 сая) , Төв аймаг (484 тэрбум 300 сая) Хөвсгөл аймаг (464 тэрбум) Дархан Уул аймаг (415 тэрбум 900 сая) орж байна.

ДНБ хэмжээ өндөр нутгууд ихэвчлэн төвийн бүсэд байрлаж байгаа, ялангуяа энэхүү судалгаагаар дэвшүүлж буй хойд хэсгийн стратеги хөгжлийн тэнхлэг эдийн засгийн үйл ажиллагааны гол цөм болж байна.

Аймаг тус бүрийн нэг хүнд ногдох ДНБ хэмжээгээр, Орхон аймаг 12 сая 920 мянган төгрөг (ойр. 6,500 ам. доллар) / хүн хамгийн өндөр, Улаанбаатар хот 10 сая 140 мянган төгрөг (ойр. 5,100 ам.доллар) / хүн, Өмнөговь аймаг 9 сая 620 мянган төгрөг (ойр. 4,840 ам.доллар) /хүн, Дорнод аймаг 8 сая 270 мянган төгрөг (ойр.4,160 ам.доллар) / хүн байна.

¹ Эдийн засаг, нийгмийн нэгдсэн үзүүлэлт болгон “Хүн өөрийн хүсэл зорилгод тулгуурлан, өөрийн амьдралын сонголт болом боломжийг өргөтгөх” зорилготой хүний хөгжлийг урт наслалт, мэдлэг чадвар, зохистой амьдралын түвшин гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэдэг цогц индекс юм. ХХИ нь 0 оос 1 ийн хооронд хэмжигдэх ба, 1-д ойрхон байх тусам хувь хүний үндсэн сонголт өргөн, өөрөөр хэлбэл хүний хөгжил дэвшилттэй байна гэсэн үг юм.




Эх сурвалж : Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2014 он

Зураг 4.2.1 Аймгуудын ДНБ

Аймаг тус бүрийн ДНБ-ний аж үйлдвэрийн бүтцийг харахад, ихэнх аймгуудад ХАА салбар голлох аж үйлдвэрийн салбар болж байна. Стратеги хөгжлийн тэнхлэг дагуух Төв, Булган, Дорноговь, Хэнтий аймгуудад ХАА-н салбар нийт ДНБ-ний 60 – 65% эзэлж байна. Нөгөөтэйгүүр, үйлдвэр, барилгын салбар голлож байгаа нь Орхон (86%) , Өмнөговь (59.5%), Дорнод (58.5%), Сэлэнгэ (43.6%), Говьсүмбэр

(42.4%), Дархан-Уул (39.7%), Улаанбаатар (36.2) болон Улаанбаатар хотын хойд хэсэгт төвлөрч байна. Ялангуяа Улаанбаатар хот, худалдаа, үйлчилгээний салбарын 88%, тээвэр, мэдээллийн технологийн салбарын 86%, санхүү, бизнесийн салбарын 83%, үйлдвэр, барилгын салбарын 62%-ийг эзэлж, эдийн засгийн үйл ажиллагаа хэт их төвлөрөл үүсгэсэн байна.



Эх сурвалж : Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2014 он

Зураг 4.2.2 Аймгуудын ДНБ бүтэц

“Эдийн засгийн бодлого, өрсөлдөөний чадварын судалгааны төв (EPCRC)” нийт 21 аймгийн өрсөлдөх чадварыг үнэлж, харьцуулсан судалгааг 2011 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Өрсөлдөх чадварыг үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр харьцуулан үнэлж, аймгуудын өрсөлдөх чадварын боломж, өөрчлөлтийн мэдээллийг бүрдүүлж байна. Шалгуур үзүүлэлт нь, “Эдийн засгийн тамир тэнхээ”, “Засаглалын үр ашиг”, “Бизнесийн үр ашиг”, “Дэд бүтэц” гэсэн 4 үндсэн бүлэг, тэдгээрийг нарийвчлан үнэлэх 4 дэд бүлэг буюу нийт 16 дэд бүлгийн хүрээнд² аймгуудын өрсөлдөх чадварыг олон талаас нь тодотгон харуулах 180 шалгуур үзүүлэлт ашиглан харьцуулалт хийсэн байна.

² Эдийн засаг, нийгмийн нэгдсэн үзүүлэлт болгон “Хүн өөрийн хүсэл зорилгод тулгуурлан, өөрийн амьдралын сонголт боломжийг өргөтгөх” зорилготой хүний хөгжлийг урт наслалт, мэдлэг чадвар, зохистой амьдралын түвшин гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэдэг цогц индекс юм. ХХИ нь 0 оос 1 ийн хооронд хэмжигдэх ба, 1-д ойрхон байх тусам хувь хүний үндсэн сонголт өргөн, өөрөөр хэлбэл хүний хөгжил дэвшилттэй байна гэсэн үг юм.


Эдгээр үнэлгээний үр дүнг, судалгаанд хамрагдсан аймгуудын үр дүнг хүснэгт 4.2.1 нэгтгэн харууллаа. Аймаг тус бүрийн хөгжлийн давуу болон сул талыг зураг 4.2.3-г харууллаа.

Хүснэгт 4.2.1 Аймгуудын ерөнхий онцлог

Судалгаа	Аймаг	Эрэмбэ 2014 (2013)	Өрсөлсөх чадварын нийт оноо 2014 (2013)	Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйл	Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлийн үнэлгээ
Хойд бүс	Дархан Уул	3 (3)	86.4 (82.0)	Бизнесийн үр ашиг дээшилсэн	Менежментийн хэвшил: Удирдах ажилтаны бизнесийн овсгоо самбаа, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар, нийгмийн хариуцлага, нягтлан бодох бүртгэл, аудитын зарчмыг сайн мөрддөг болсон.
	Сэлэнгэ	6 (6)	69.1 (75.5)	Эдийн засгийн үзүүлэлт, бизнесийн үр ашиг дээшилсэн	Эдийн засаг: ДНБ-ий аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 11%-аас 19% болон нэмэгдэж, аж үйлдвэрийн салбарын борлуулалт 34.8 тэрбумаас 26.7 тэрбум болтол буурсан. Үр тарианы ургац 240,733 тн-оос 186,986 тн болж буурсан. Эдийн засгийн төрөлжилт удааширч байна. Менежмент: Удирдах ажилтаны овсгоо, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар буурсан.
	Орхон	1 (1)	100.0 (100.0)	Засаглал, бизнесийн үр ашиг, дэд бүтэц сайжирсан	Эдийн засаг: Шинээр ажилд орогсдын тоо 668 аас 2003 болж өссөн. Дэд бүтцийн хүрээ: Авилгал буурч, шилэн дансны хэрэглээ өсч, хүнд суртал буурсны дүнд бизнесийн орчин сайжирсан.
	Булган	13 (12)	53.2 (57.2)	Дэд бүтэц, эдийн засгийн үзүүлэлт буурсан	Эдийн засаг: ДНБ оруулах хувь 1.57% аас 1.52% болтол буурсан. Боловсрол-соёл: Дунд сургуульд суралцагсад 90.4%-аас 88.1% хүртэл буурсан. Соёлын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт болох, мэргэжлийн урлагийн тоглолт, концертын тоо 187 оос 192 болж өссөн. Номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо буурсан. Нэг багшид оногдох сурагчдын тоо 35-аас 38 өссөн. Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин: Амьдралын чанар сайжраагүй байна. 1,000 хүнд ногдох нас барсан хүний тоо 5 байснаа 7 болсон. Нялхсын эндэгдэл 1,000 амьд төрөлтөд ногдох хүүхдийн эндэгдэл 14 байснаас 21 болсон.
	Хөвсгөл	16 (18)	51.1 (49.7)	Засаглалын үр ашиг, дэд бүтэц сайжирсан	Тогтолцооны хүрээ: Албан хаагчдын авилгал, хээл хахууль буурсан, аймгийн шийдвэр, бодлогын ил тод байдал нэмэгдсэн. Үндсэн дэд бүтэц: Дэд бүтцийн засвар үйлчилгээ, хөгжлийн төлөвлөгөөнд зориулсан санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. Аймгийн төвийн бүтээн байгуулалт нэмэгдсэн. Дулаалгын асуудлыг шийдвэрлэсэн. Замыг сайжруулсан. Технологийн дэд бүтэц: Иргэдийн мэдээллийн сүлжээ, харилцаа сайжирсан.
	Архангай	19 (21)	49.8 (41.1)	Эдийн засгийн үзүүлэлт, хөгжлийн түвшин, бизнесийн үр ашиг дээшилсэн	Амьдралын түвшин: 1 хүнд ногдох дундаж хадгаламжийн хэмжээ 431,000 Төг байснаас 521,000 төг хүртэл нэмэгдсэн. Малчин өрхийн малын тоо 249-ээс 275 болж өссөн. Нийгмийн бүтэц: Орлогын тэгш бус байдал, гэмт хэргийн гарц буурсан. Хүний хөгжлийн индекс (HDI) нэмэгдсэн. Бизнесийн орчин: Бизнесийн орчин бүрдэж, хувийн хэвшлийн тоо 510 аас 567 нэмэгдсэн. Хөдөлмөрийн зах зээл: Мэргэшсэн ажиллах хүч, банк, санхүүгийн үйлчилгээ дээшилсэн. Хөдөлмөрийн бүтээмж (нэг ажилтанд ногдох ДНБ) дээшилсэн.

Судалгаа	Аймаг	Эрэмбэ 2014 (2013)	Өрсөлсөх чадварын нийт оноо 2014 (2013)	Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйл	Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлийн үнэлгээ
Өмнө бүс	Өмнөговь	2 (2)	86.8 (90.0)	Эдийн засгийн үзүүлэлт, бизнесийн үр ашиг буурсан	Эдийн засаг: Эдийн засгийн хөгжлийн хувь өмнөх жилээс багассан. Хэрэглэгчийн үнийн индекс 112.1% иас 116.1% болсон. Менежментийн хэвшил: Удирдах ажилтаны (бизнес) , зах зээлд зохицох чадвар, бизнесийн нийгмийн хариуцлага, аудит, санхүүгийн өнгөрсөн жилээс бага зэрэг багассан.
	Дорноговь	7 (4)	68.7 (80.6)	Эдийн засгийн үзүүлэлт, засаглалын үр ашиг буурсан	Эдийн засаг: Хэрэглэгчийн үнийн индекс 113.8% байснаа 118.6% болж өссөн. Эдийн засгийн хөгжлийн түвшин буурсан. Амьдралын түвшин: Амьдралын түвшин буурч, 1 хүнд ногдох зээлийн хэмжээ 1.7 тэрбумаас 2.5 тэрбум төг болсон. Улсын төсөв: Аймгийн төсвийн хяналт урьдын адил үр дүн муутай. Тогтолцоо: Аймгийн төрийн ажилтнууд авилгалд холбогдон, орон нутгийн засаг захиргааны ил тод байдал муу, хүнд суртал бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.
	Говьсүмбэр	8 (8)	65.7 (70.8)	Эдийн засгийн үзүүлэлт, бизнесийн үр ашиг буурсан	Ажлын байр: Ажил эрхлэгч залуучуудын эзлэх хувь 68%-аас 85%-болж, дундаж ажлын хөлс 734,000 төгрөгөөс 844,000 төгрөг болж өссөн. Нийт хүн амд ажил эрхлэгч хүн амын эзлэх хувь 22.3% аас 35.7% болж өссөн. Банк, санхүү: Банк, санхүүгийн үйлчилгээний дэмжлэг үр ашиг муутай. Банк, санхүүгийн байгууллагын эзлэх хувь 38.9% аас 40.7% болж өссөн.
УБ	Төв	5 (5)	69.2 (76.1)	Бүх үзүүлэлт доошоо буурсан	Эдийн засаг: Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 34 тэрбумаас 32 тэрбум төг болж буурсан. Бөөний, жижиглэнгийн борлуулалт 23.2 тэрбумаас 15.1 тэрбум болтол буурсан. Үр тарианы ургац 112,177 тн 78,725 тн болж 30%, түүн дотор улаан буудайн тариалалт 107,871 тн байснаас 80,979 тн болж 25% буурсан.
Зүүн бүс	Дорнод	9 (9)	65.6 (65.0)	Эдийн засгийн үзүүлэлт өссөн	Эдийн засаг: 1 хүнд ногдох ДНБ 2,089,000 төг-с 5,350,000 төг болж өссөн. Эдийн засгийн хөгжлийн үнэлгээ 4.3 аас 6.1 болж нэмэгдсэн. Хэрэглэгчийн үнийн индекс 116.7% байснаас 110.7% болж буурсан. Хөдөлмөр эрхлэлт: Цалингийн дундаж хэмжээ 559,000 төг байснаас 681,000 төг болж өссөн. Хөдөлмөр эрхлэлтийн хувь өсч, 92.5% болсон.
	Хэнтий	14 (16)	52.5 (54.1)	Эдийн засгийн үзүүлэлт, засаглалын үр ашиг, дэд бүтэц	Эдийн засаг: Хэрэглэгчийн үнийн индекс нь 109.7% байснаа 110.0% болж өссөн. Тогтолцоо: Хүнд суртал даамжирч, бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин: 1,000 хүнд ногдох нас барсан хүний тоо 5 байснаа 7 болтол өсж, 1,000 хүнд ногдох хорт хавдраар өвчлөгсөдийн тоо 14-с 20 болж нэмэгдсэн.

Эх сурвалж : Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2014 тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.



Эх сурвалж : Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2014 тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 4.2.3 Аймгуудын давуу болон сул тал

Дээрх үзүүлэлтэнд тулгуурлан, тус судалгаанд хамрагдсан бүс нутгуудын нийгэм, эдийн засгийн онцлогийг хүснэгт 4.2.2 т нэгтгэв.

Хүснэгт 4.2.2 Судалгаанд хамрагдсан бүс нутгуудын нийгэм, эдийн засгийн онцлог

Стратеги хөгжлийн корридорын бүс	Нийгэм, эдийн засгийн онцлог
Хойд бүс (ХАА бүс)	<ul style="list-style-type: none"> • Дархан, Эрдэнэт хот төвтэй эдийн засгийн үйл ажиллагаа, ялангуяа аж үйлдвэр, барилгын салбар идэвхитэй, УБ хотын дараах хүн ам болон эдийн засаг төвлөрсөн нутаг бөгөөд, нийгмийн хөгжлийн нөхцөл байдал сайн. • Гэхдээ, Эрдэнэтээс хойшоо ХАА голлох аж үйлдвэртэй, эдийн засгийн нөхцөл байдал бусад корридортой харьцуулахад бага зэрэг доогуур. Түүнчлэн, хүний хөгжлийн индекс бага зэрэг доогуур, бичиг үсгийн боловсрол Архангай, Булган аймагт 100% хүрэхгүй. Ядуу хүн амын тоо ялангуяа Хөвсгөл, Архангай аймагт их байгаа зэрэг нийгмийн хөгжлийн байдал жил ирэх тусам сайжирч байгаа хэдий ч бусад бүс нутагтай харьцуулахад сайн үзүүлэлттэй биш байна.
Өмнөд бүс (уул уурхайн бүс)	<ul style="list-style-type: none"> • Өмнөговь аймаг уул уурхайгаар улсдаа тэргүүлэх аймгийн хувьд эдийн засгийн нөхцөл байдал тун сайн. Говьсүмбэр аймгийн аж үйлдвэр, барилгын салбар ДНБ ий 40% эзэлж, Дорноговь аймгийн хувьд ХАА салбар голлож, аль аль нь эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайн. Гэхдээ, ажилгүйдлийн хэмжээ 10% хэтэрсэн байна. Мөн, бизнесийн орчин сайн бүрэлдээгүй байна. • Ядуурал томоохон асуудал нь биш хэдий ч хүний хөгжлийн индекс улсын дунджаас доогуур. Ялангуяа Дорноговь аймагт эх, хүүхдийн эрүүл мэндийн холбогдолтой асуудал бий, Говьсүмбэр аймаг гэмт хэргийн тоо өндөр.
Улаанбаатар хотын бүс	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын нийслэлийн хувьд, хүн ам, эдийн засгийн бүхий л үйл ажиллагаа төвлөрсөн байдалтай байна. Улаанбаатараас 30~50 км орших Налайх, Багануур, Багахангай гэсэн алслагдсан дүүрэгтэй. Налайх нь ложистик төв буюу шинэ аж үйлдвэрлэлийн бүсийн байршлын боломжит хувилбар, Багануур нүүрсний баялагтаа тулгуурлан цахилгаан, эрчим хүчний төв болох ирээдүйн хөгжил харагдаж буй. Төв аймгийн Зуунмод хот 2017 онд ашиглалтанд орох “Улаанбаатар шинэ олон улсын онгоцны буудал”-тай зэргэлдээ нутгийн хувьд шинэ хөгжлийн хот, онгоцны буудлын хот болох төсөөлөлтэй. • Улаанбаатар нийслэл хотын бүсийн хувьд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал жигд сайн.
Зүүн бүс	<ul style="list-style-type: none"> • Дорнод аймаг зүүн бүсийн төв бөгөөд, Хятадтай хиллэдэг тул аж үйлдвэр, барилгын салбар идэвхитэй хөгжиж буй хэдий ч ажилгүйчүүдийн хувь 10% аас дээш хэмжээнд байна. • Нөгөөтэйгүүр, Хэнтий аймаг ХАА голлодог, эдийн засгийн хэмжээ том биш. Түүнчлэн, ажилгүйчүүд 17% өндөр бөгөөд, эдийн засаг төдийлөн сайн биш. • Хүний хөгжлийн индекс улсын дундажаас доогуур бөгөөд ядуу хүн амын хэмжээ их, нийгэм эдийн засгийн нөхцөл төдийлөн сайнгүй.

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

4.3 Бүсчилсэн цогц хөгжил болон стратеги корридор хөгжлийн үндсэн нөхцлийг авч хэлэлцэх нь

Энэхүү хэсэгт бүсчилсэн цогц хөгжил болон стратеги хөгжлийн корридорын тухай хэлэлцэхийн өмнө үндсэн нөхцөл болох геополитик, газар ашиглалт, байгалийн нөөц баялаг болон хөгжлийн нөөц бололцоо гэсэн 3 асуудлын талаар ерөнхийд нь дурдана.

(1) Геополитикийн нөхцөл (Том гүрнүүд дундах эх газрын улс)

1) Аюулгүй байдал

Монгол улс эх газрын улс бөгөөд, өмнөд хойд хэсгээрээ БНХАУ, ОХУ-ын дунд байрладаг, ОХУ-ын нефть, нефтийн бүтээгдэхүүнээс хараат байдалд байдгаас гадна, гадаад худалдааны хамгийн том түнш нь БНХАУ бөгөөд эдийн засгийн хувьд 2 том гүрний нөлөөнд байдаг.


Тийм учир, улсын аюулгүй байдлын үзэл баримтлалд³ “Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын хувьд, гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтлана” хэмээн, гуравдагч оронтой хийх хамтын ажиллагааг бэхжүүлж, хөрөнгө оруулалтын олон тулгуурт бүтцийг бий болгох зорилт тавьж байгаа билээ.

2) Тээвэрлэлтийн асуудал

Эх газрын улсын хувьд экспорт, импортын тээвэрлэлт зайлшгүй хөрш улсаар дамжин өнгөрөх шаардлагатай тул хөрш орноос гадна гуравдагч улстай хийх гадаад худалдааг өргөжүүлэхийн тулд, газраар тээвэрлэх маршрут, гадаад худалдааны корридортой болох нь амин чухал асуудал юм.

Монгол улс болон Алс Дорнод Азийн бүсийн зах зээлийг холбох хувилбар зам харилцааны корридорын төсөөллийг зураг 4.3.1т үзүүллээ. Японтой төмөр замаар холбогдох тээвэрлэлтийн маршрутын хувьд, одоогоор БНХАУ-аар дамжих 1)“Улаанбаатар-ЗамынҮүд-Тянжин боомт-Ёкохама” маршрут болон ОХУ аар дамжих 2)“Улаанбаатар-Сибирийн төмөр зам-Владивосток-Япон (Нийгата, Акита)” маршрутаас өөр байхгүй хэдий ч түүнээс гадна шинэ маршрутын талаар олон жилийн туршид хэлэлцэгдэж ирсэн БНХАУ-аар дамжих 3) “Улаанбаатар-Гирин-Түмэн-Нийгата” зэрэг тээвэрлэлтийн маршрутын төсөөлөл бий. Гэхдээ 3) маршрутыг бий болгоход Монгол дотроо шинэ төмөр зам бүтээн байгуулах шаардлагатай.

³ УИХ-аар 2010 онд батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бодлого”-оос иш татав.




Тайлбар : улаан шугам=маршрут 1) Улаанбаатар-ЗамынҮүд-Тяньжин-Ёкохама, цэнхэр шугам=маршрут
2)Улаанбаатар-Сибирийн төмөр зам-Владивосток-Нийгата • Акита, шар шугам=маршрут 3)
Улаанбаатар-Гирин-Түмэн-Нийгата

Эх сурвалж : ЗТХЯ-ны мэдээлэл дээр тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 4.3.1 Монгол улсын олон улсын тээврийн корридорын төсөөлөл

3) Зүүн Азийн бүсийн олон улсын эдийн засгийн корридорын төсөөлөл

Монгол улсын төлөвлөж буй олон улсын тээврийн корридороос гадна АХБ удирдаж буй "Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC)"-өөс дэвшүүлж буй олон улсын эдийн засгийн корридор байгуулах асуудал хэлэлцэгдэж буй (Зураг 4.3.2). Энэхүү төсөөлөл нь Азийн хурдны замын сүлжээнд тулгуурлан, Монгол улсын хөрш орнуудтай хийх харилцаа, хамтын ажиллагааг зөвхөн одоо байгаа хөндлөн корридор төдийгүй, төв Азийн зах зээлийг анхааран, баруун урд чиглэлд ч байгуулахаар төлөвлөж байна.



Эх сурвалж : CAREC

Зураг 4.3.2 Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа(CAREC) дэвшүүлж буй Монгол улсын эдийн засаг, дэд бүтцийн корридор

Түүнээс гадна, Монголтой хамааралтай олон улсын гадаад худалдааны маршрутын төлөвлөлтийн тухайд, ОХУ-ын “Алс Дорнодын хөгжлийн үзэл баримтлал”, Монголыг хойноос урагш дайрч, ОХУ, БНХАУ руу чиглэсэн “Тал нутгийн зам” төсөл, (БНХАУ-ын санаачилж буй “Нэг бүс, нэг зам” төсөл), түүнчлэн НҮБ Хөгжлийн Хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагууд эртнээс анхаарал хандуулж буй “Түмэн голын санаачлага” төвтэй ”Хятадын зүүн хойд корридор” зэрэг төслүүд байдаг, тус бүрдээ улс төрийн бодлого агуулагдаж байгаа. Гэхдээ Монгол улсын хувьд далайд гарцгүй байдлаас ангижрах, ОХУ, БНХАУ-ын олон улсын тээвэрлэлтийн системийг ашиглан, олон улсын гадаад худалдааны маршрутаа бэхжүүлэх нь туйлын ач холбогдолтой юм.

Гадаад худалдааны маршруттай болох нь зөвхөн тогтвортой бараа нийлүүлэлт бий болгох төдийгүй, бүс нутгийн хүн, эд бараа, хөрөнгө мөнгөний урсгалыг чөлөөтэй болгосноор корридор дагуух бүс нутгийн зах зээлийг өргөтгөх, гадаад худалдаа, бараа эргэлтийг хөгжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зэрэг эдийн засгийн томоохон үр ашиг авчрах найдлагатай.

4) Монгол угсаат үндэстнүүдийн хамтын ажиллагаа

Одоогийн байдлаар Монгол улсын хүн ам 3 сая гаруй байгаа хэдий ч, сүүлийн үеийн ОХУ, БНХАУ-д үүссэн улс төрийн хагаралаас гадаад руу гарсан иргэд болон, эртний Монголын эзэнт гүрний үед эзэлж авсан нутагт шилжиж суурьшсан эцэг өвгөд зэрэг Монгол угсаат үндэстэн (халимаг, буриад, ойрад зэрэг) БНХАУ, ОХУ,

Каспийн тэнгисийн Кавказийн нуруу, Өмнөд Азиас Төв Азийн нутгуудад тархан суурйшиж байсан байсан бөгөөд, ойролцоогоор 23 сая хүн бий гэгддэг. Өнөөгийн цаг үед, үндэстэний хамтын нэгдлийн талаар хүчтэй ойлголт байхгүй хэдий ч, хил орчмын нутгуудад гадаад худалдаа хөгжсөн, цаашид тээвэр, тээвэрлэлтийн сүлжээг бэхжүүлснээр (гадаад худалдааны корридор) эдгээр Монгол үндэстэн амьдардаг бүс нутагт чиглэсэн шинэ гадаад худалдааны томоохон хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж байгааг үгүйсгэх аргагүй. Монголчуудын соёл, нүүдэлчин амьдарлаас урган гарсан хоол унд, хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох зах зээл болгох тал дээр ч анхаарал хандуулах хэрэгтэй.

(2) Монгол улсын газар ашиглалтын өнөөгийн байдал, төлөвлөлт

Монгол улсын газар ашиглалт, газрын өнөөгийн нөхцөл байдлын талаар “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (УГЗБЕТ)” тодорхой тусгагдсан байгаа. УГЗБЕТ-нд, хүснэгт 4.3.1 харуулсанчлан 10 төрлийн нөхцөл байдлын талаар нарийвчлан тогтоон, үүнд тулгуурлан хүснэгт 4.3.2 үзүүлсэн 21 төрлийн төлөвлөгөө буюу үндсэн чиглэл газрын зураг дээр тэмдэглэгдсэн байна.

Хүснэгт 4.3.1 УГЗБЕТ дэхь газрын зургийн жагсаалт

	Зургийн жагсаалт
1	The unified land territory foundation of Mongolia
2	Land of forest foundation Mongolia
3	Communication and electricity network map of Mongolia
4	Mongolia road and railway network map
5	Special protected area map of Mongolia
6	Surface water map of Mongolia
7	Land use map of Mongolia
8	Soil map of Mongolia
9	Vegetation map
10	Population settlement map by aimag

Эх сурвалж : УГЗБЕТ

Хүснэгт 4.3.2 УГЗБЕТ Төлөвлөгөөний зургийн жагсаалт

	Газрын зураг
1	Plan of Agricultural intensify region
2	Plan of Aimag Level Otor Reserved Area
3	Pastureland irrigation
4	Industrial land use plan
5	Settlement areas plan
6	Settlement areas waste water treatment plant plan
7	Urban structure (Regional center, Aimag center, Settlement center) of settlement area
8	Developing direction of satellite cities of Ulaanbaatar
9	Mineral resource exploration and mining restricted area
10	Exploration and mining licenced area of Mineral Resources
11	Eco-tourism plan map
12	Special tourism
13	Road network plan 2013-2023
14	Railway network plan 2013-2023
15	Plan of power production plant
16	Plan of power supply network
17	Plan of forest land foundation
18	Water fund protected area
19	Water basin management zoning map
20	Plan of special protected area
21	Oil production sharing contracted area

Эх сурвалж : УГЗБЕТ

Монгол улсад орон нутгийн засаг захиргаа хариуцдаг “Газар ашиглалтын төлөвлөгөө” нь орон нутгийн бүсчлэлд тохируулан 4 төрөл байдаг бөгөөд, төлөвлөгөөний хугацаа нь тус бүр өөр (хүснэгт 4.3.3). төлөвлөгөөний хугацаа нь өөр тул, төлөвлөгөө хооронд бага зэргийн зөрүүтэй талууд бий.

Хүснэгт 4.3.3 Монгол улсын газар ашиглалтын төлөвлөгөө

	Төлөвлөгөөний нэр	Хугацаа
1	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (УГЗБЕТ)	16 – 20 жил
2	Бүсийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	10–15 жил
3	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	12–16 жил
4	Сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	1 жил

Эх сурвалж : ГХГЗЗГ

Одоогийн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2003 онд батлагдан, зорилтот хугацаа нь 2004 оноос 2023 он хүртэл юм. Хүснэгт 4.3.4-т газар ашиглалтын зорилго тус бүрээр ангилан хэмжээ болон эзлэх хувийг харуулсан, мөн 4.3.3-т улсын газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөөний зургийг харуулав. Энэхүү төлөвлөгөөнөөс үзэхэд ой мод нийт газрын 9%, тусгай хамгаалалтын газар 13%-ийг

эзэлж байна. Мөн улсын нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 74%-ийг ХАА чиглэлээр ашиглах боломжтой, 71% нь бэлчээрийн газар байна.

Нутгийн хойд хэсгээр ой модот бүс нутаг болон ХАА бүс, хотын бүс, зүүн хэсгээр ХАА, МАА бүс нутаг юм. Өмнөд хэсэгт уул уурхай түлхүү хөгжиж байгаа хэдий ч, уул уурхайн зориулалтын газар нийт нутаг дэвсгэрийн 0.1% ийг эзэлж байна.

**Хүснэгт 4.3.4 Улсын газрын нэгдмэл сангийн газар ашиглалтын ангилал,
ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ**

Газар ашиглалтын зориулалт		Хэмжээ (км ²)	Хувь (%)
Хөдөө аж ахуйн газар	Хөдөө аж ахуйн газар	115,399,856	73.8%
	Бэлчээр	111,032,541	71.0%
	Хадлан	1,712,303	1.1%
	Атаржсан	1,031,099	0.7%
	ХАА барилга байгууламжийн газар	701,968	0.4%
Хот, тосгон бусад суурингийн газар	Хот, тосгон бусад суурингийн газар	701,968	0.4%
	Үйлдвэржилтийн бүс	31,056	0.0%
	Уурхай	215,127	0.1%
Зам, шугам сүлжээний газар	Зам, шугам сүлжээний газар	435,279	0.3%
Ойн сан бүхий газар	Ойн зурвас	14,256,535	9.1%
Усны сан бүхий газар	Усны сан бүхий газар	686,805	0.4%
Улсын тусгай хэрэгцээний газар	Улсын тусгай хамгаалалтын газар	20,948,321	13.4%
	Хилийн бүс	3,111,994	2.0%
Нийт бүс		156,411,575	100.0%-

Эх сурвалж : ГХГЗЗГ

(3) Баялагийн тархалт болон хөгжлийн нөөц бололцоо


1) Тусгай хамгаалалттай газар нутаг

Хүснэгт 4.3.5 болон зураг 4.3.4-т тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал, төлөвлөгөөг харуулав. Өмнөх 2.9 бүлэгт дурдсанчлан, тусгай хамгаалалтын газар нь дархан цаазтай газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газарт ангилагдах бөгөөд, ойролцоогоор 2,720,000 га, нийт нутгийн 17% эзэлж байна. Дархан цаазтай газар нутаг нь хилийн ойр орчимд байрласан хандлагатай, байгалийн цогцолборт газар нь нутгийн төв хэсгээс баруун тийш тархсан байрлалтай байна. Түүнчлэн, 2013 оноос 2016 онд шинээр тусгай хамгаалалтын газар болгон бүртгэхээр төлөвлөгдөж буй газрууд бий (Зүүн бүсэд, шинэ тусгай хамгаалалтын газар болгон ойролцоогоор 310,000 га газар төлөвлөгөөнд орсон байна). Цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дахин хэлэлцэн, эдгээр хамгаалалттай газар нутгуудын хөгжлийн хориг, хязгаар, холбогдох дүрэм, журмыг сайжруулах хэрэгтэй.

Хүснэгт 4.3.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ

	Газар	Хэмжээ (га)
Одоо байгаа	Дархан цаазтай газар	12,411,006
	Байгалийн цогцолборт газар	11,711,815
	Байгалийн нөөц газар	2,958,142
	Дурсгалт газар	126,848
Төлөвлөгөө	Төлөвлөсөн ТХГ 2013-2016	3,107,598

Эх сурвалж : УГЗЕТ



Эх сурвалж : УГЗБЕТ

Зураг 4.3.4 Тусгай хамгаалалтын газрын байршил


2) ХАА, МАА-ын зориулалттай газар нутаг

Бэлчээр, усалгаатай газар тариалан, тариалангийн газар, атаржсан, хадлан, усан сан бүхий газар гэсэн талаас ХАА, МАА-н нөөц боломжийг аймаг тус бүрээр нь цэгцлэн хүснэгт 4.3.6-т харууллаа. Хүн ам төвлөрсөн Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв аймгийн хойд хэсэг хадлан бэлтгэх өвс ургамал, усны эх хангалттай байдаг тул УГЗБЕТ-д нэн тэргүүнд ХАА хөгжүүлэх бүс нутаг хэмээн төлөвлөн тусгасан байна (Зураг 4.3.5). Түүнчлэн, дараагийн шатанд ХАА бэхжүүлэх газар нутаг хэмээн ХАА гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөгжлийн бүсийг төлөвлөсөн байгаа бөгөөд голдуу аймгуудын төвүүдийг хамруулсан байна. Эдгээр төлөвлөгөөнд түшиглэн, ХАА хөгжүүлэх бүсийг стратеги бодлогын дагуу бэхжүүлэх хэрэгтэй.

Хүснэгт 4.3.6 Хөдөө аж ахуйн зориулалттай нөөц газар

Байршил	Бэлчээр	Хадлан	Тариалан талбай	Агаржсан талбай	Нөөц	Усны нөөц
Түвшин 1. Нягтшил ихтэй төвийн бүс						
Төв аймаг хойд бүс	1,410,189.9	32,103.7	84,977.6	79,749.7	Хангалттай	Сайн
Улаанбаатар, Багануур, Багахангай	227,633.0	5,588.0	7,003.4	3,220.5	Хангалттай	Сайн
Сэлэнгэ аймаг	1,630,485.1	123,410.0	313,705.5	28,724.5	Хангалттай	Сайн
Дархан-Уул аймаг	178,442.7	9,072.5	34,819.1	5,741.9	Хангалттай	Сайн
Орхон аймаг	39,589.5	1,400.0	4,938.6	427.0	Хангалттай	Сайн
Түвшин 2. Аймгийн төв						
Булган, Булган	111,677.3	9,148.4	2,757.5	789.1	Боломжтой	Сайн
Өлгий, Баян-Өлгий	613,859.4	1,609.5	338.7	0.5	нөхөн сэргээх	Муу
Улаангом, Увс	575,871.3		2,917.1		Боломжтой	Дунд
Ховд, Ховд аймаг	572,035.6	7,233.2	3,570.3	1,182.3	Хангалттай	Сайн
Улиастай, Завхан	536,952.7		1,000.0	1,640.6	Боломжтой	Сайн
Алтай, Говь-Алтай	671,125.4				нөхөн сэргээх	Муу
Мөрөн, Хөвсгөл	465,972.0	4,227.2	392.2	1,293.3	Хангалттай	Дунд
Цэцэрлэг, Архангай	423,470.8		3,077.1	5,975.8	Хангалттай	Сайн
Арвайхээр, Өвөрхангай	613,339.9	1,517.0	512.3	2,794.0	Боломжтой	Дунд
Даланзадгад, Өмнөговь	503,054.7		29.7		нөхөн сэргээх	Муу
Ханбогд (Гашуунсухайт), Өмнөговь	445,302.3				нөхөн сэргээх	Муу
Цогтцэций, Өмнөговь	402,067.7		2.4		нөхөн сэргээх	Муу
Мандалговь, Дундговь	783,193.1		27.8		нөхөн сэргээх	Муу
Чойр, Говь-Сүмбэр	405,758.2		166.9		нөхөн сэргээх	Муу
Сайншанд, Дорноговь	644,571.2		45.5	0.5	нөхөн сэргээх	Муу
Өндөрхаан (Чингис) Хэнтий	591,203.1	20,530.0	365.3	15,203.8	Хангалттай	Сайн
Баруун- Урт, Сүхбаатар	611,932.4		3.8	10,383.8	нөхөн сэргээх	Муу
Чойбалсан, Дорнод	497,961.5	85,623.0	3,282.0	5,874.2	Хангалттай	Дунд

Эх сурвалж : УГЗБЕТ



Эх сурвалж : УГЗБЕТ

Зураг 4.3.5 ХАА хөгжүүлэх төлөвлөгөө

Энэхүү газар ашиглалтын төлөвлөгөөнд “Отрын газар”-ын бодит байдал болон төлөвлөгөөг мөн тусгасан байгаа. Отрын газар гэдэг нь хүйтний улирал болон байгалийн гамшигт бэлдэн, зуны улиралд мал бэлчээлгүй хамгаалан нөөцөлж үлдээсэн тал нутаг юм (Хүснэгт 4.3.7). Зудын хохирлыг хамгийн бага хэмжээнд барихын тулд, энэхүү отрын газрыг зохистой хянах хэрэгтэй билээ.

Хүснэгт 4.3.7 Отрын газрын бодит байдал төлөвлөлт

Аймаг	Одоо байгаа отрын газар	Төлөвлөж буй отрын газар
Архангай		12,981
Баянхонгор	51,860	9,879
БаянӨлгий	8,000	
Булган	26,989	
ГовьСүмбэр	55,074	
Дорнод	124,400	192,127
Завхан	68,300	10,740
Өвөрхангай	20,282	
Сүхбаатар		30,621
Төв	24,786	23,449
Увс	20,900	
Хөвсгөл		23,749
Хэнтий	185,623	7,236
Нийт дүн	586,214	310,781

Эх сурвалж : УГЗБЕТ

Сүүлийн жилүүдэд газрын доройтол ихсэж байгаа нь газар зохион байгуулалтын томоохон асуудал болоод байгаа. Түүний гол шалтгаан нь ХАА, МАА эрхлэлтийн


төрлөөс шалтгаалах бөгөөд 2-р бүлэгт дурдсанчлан, малын хувьчлал, нэгдэл, сангийн аж ахуйн задрал, бэлэн мөнгөнд хувирах чадвар өндөртэй ямаа тэжээх сонирхол ихтэйгээс малын тоо толгой хэт олширсон зэрэг болно. Түүнчлэн, байгалийн бэлчээр тул өвс, тэжээлийн зардал бага байгаагаас шалтгаалан малын тоо толгойн өсөлтийг хянах хүндрэлтэй байгаа нь бэлчээрийн доройтлыг улам бүр дэвэргэж байж болох юм. Ялангуяа, малчид хадлан, тэжээл, малын тээвэрлэлтэнд амраа бодон автозам дагуу төвлөрч, авто зам дагуух бэлчээрийн доройтол нэмэгдэж байна. Ирээдүйн урт хугацаанд авч үзэхэд бэлчээрийн газар хүрэлцээгүй болох аюултай. Газар ашиглалтын хувьд МАА эрхлэлтэнд тусгайлан анхаарах шаардлагатай. Мөн ирээдүйд бага багаар дэлхийн дулаарлын нөлөөнөөс үүдэн ургамлын аймаг хойшоо шилжин, хагас элсэн цөл болон тал хээр нутаг нэмэгдэн, малын бэлчээрт тохиромжгүй газар нутаг нэмэгдэх хандлагатай байна (өмнөх бүлэг 2.11 харна уу).

3) Байгалийн баялаг, аялал жуулчлалын нөөцийн тархалт

Өмнөх 2.9 бүлэгт авч хэлэлцсэн байгаль орчинд тулгуурласан аялал жуулчлалын нөөц баялаг нь Монгол улсын нийт нутагт элбэг байна. Өргөн уудам нутагтай Монгол улсад, бүс нутгаас хамааран газрын гадарга өөрчлөгдөх ба нутгийн баруун хэсэгт уул нурууд сүндэрлэж, өмнөд хэсэгт говь цөл, хойд хэсэгт ой мод, Хөвсгөл нуур зэрэг нуур орчмын үзэсгэлэнт байгаль, түүнчлэн өргөн уудам тал хээр гэсэн олон янзын байгалийн дүр зураг бий.

Аргаль Алтайн нуруу болон говь цөлийн бүсэд, янгир Алтайн нуруу болон төвийн бүсэд, буга Сэлэнгэ болон Төв аймгийн ой мод, Алтай нуруунд ихээр амьдардаг. Сэлэнгэ болон Амар мөрний ай сав нутагт, яргай загасны нэг зүйл төрөл гэгддэг “тул загас” тархсан байдаг. Шувууны төрөл зүйл нутаг нутгаар харилцан адилгүй байдаг бөгөөд, баруун бүсийн Баян-Өлгий, Ховд аймагт бүргэд, зүүн бүсийн Дорнод аймагт хун шувууг харах болно. Иймэрхүү амьдрах орчны онцлогт тохирсон эко туризмыг хөгжүүлэх боломжтой.

УГЗБЕТ дээрх байгалийн нөөцийн тархалтад суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгийг төлөвлөсөн байгаа хэдий ч төлөвлөгөөний нутгууд тархуу байрлалтай, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлттэй нэгдсэн уялдаагүй байна (Зураг 4.3.6). Монгол улсын нийт нутагт байгалийн нөөц баялагт түшиглэсэн аялал жуулчлалын нөөц бололцоо ихээр агуулагдаж байгаа хэдий ч нутаг нутгийн байгалийн үзэмж өөр тул бүс нутаг болон байгалийн онцлогийг тусгасан, мөн байгаль орчны хамгаалалтын бодлоготой уялдсан аялал жуулчлалын нэгдсэн бодлого төлөвлөлт байх шаардлагатай.



Эх сурвалж : УГЗБЕТ


Зураг 4.3.6 Байгалийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын бүсийн төлөвлөгөө

4) Уул уурхайн баялагийн тархалт

Өмнөх 2.4-р бүлэгт дурдсанчлан, ашигт малтмалын нөөц баялагт тулгуурласан уул уурхайн салбар Монгол улсын эдийн засгийн гол багана бөгөөд томоохон уул уурхайн байршлыг зураг 4.3.7-д харууллаа. Өмнөд хэсгийн Таван толгойн уурхай, Улаанбаатар хотын бүсийн Багануур, Шивээ Овоо уурхайгаас нүүрс олборлох боломжтой.

Зэсийг өмнөд бүсийн Оюутолгой, Цагаан суварга болон хойд бүсийн Эрдэнэтийн уурхайгаас олборлодогдоос гадна, Цагаан суварга, Эрдэнэт уурхайгаас молибден олборлох боломжтой. Алтыг Бороогийн уурхай (Сэлэнгэ аймаг), төмрийг Төмөртэйн уурхай (Сэлэнгэ аймаг), фосфор Бүрэнхаан уурхай (Хөвсгөл аймаг), цайр Төмөртийн Овоо уурхайгаас (Сэлэнгэ аймаг) тус тус олборлох боломжтой. Мөн ураны уурхай зүүн хойд хэсгийн Чойбалсан хотын ойролцоо байдаг.

Эдгээр уурхайтай холбогдох авто замын бүтээн байгуулалт явагдаж байгаа бөгөөд, 2020 онд томоохон маршрутын дагуу автозамын ажил бүрэн дуусах төлөвлөгөөтэй байна. Төв автозамын (улсын чанартай) бүтээн байгуулалт төлөвлөгөөний дагуу явагдахаас гадна илүү үр өгөөжтэй тээвэрлэлтийн хэрэгсэл болох төмөр замын бүтээн байгуулалт нэлээн их хүлээлттэй байна (дараагийн 5.7-д тодорхой дурдсан).



Эх сурвалж : ГХГЗЗГ-ын мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 4.3.7 Монгол орны томоохон уурхайн тархалт

4.4 Бүсчилсэн цогц хөгжлийн бодлогоор орон нутгийн хотыг хөгжүүлэх

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд тухайн хот болон орон нутгийн онцлогоос хамааран 2 төрлийн хөгжлийн арга зам шаардлагатай байна. Нэг нь, хэт их төвлөрсөн Улаанбаатар хотын бүсийн “Нийслэлийн бүсийн нэгдсэн хөгжлийн арга зам”, нөгөө нь Улаанбаатар хотоос бусад орон нутгийн ”бүсчилсэн цогц хөгжлийн арга зам” юм.

Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн тухайд, ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн техникийн хамтын ажиллагааны судалгаанд тулгуурласан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх өрөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” боловсруулагдан УИХ-аар хуульчлан батлагдсан төлөвлөгөө бий. Нөгөөтэйгүүр, хөдөө орон нутгийн хотыг хамрах бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа боловсруулах арга хэмжээ төлөвлөлтийн элдэв бэрхшээлээс хамаарч төдийлөн амжилттай хэрэгжихгүй байна. Хөдөө орон нутгийн хөгжлийн хувьд, хөдөө аж ахуйн бүс нугийн газар ашиглалт, эдийн засгийн ялгаа, хүн амын шилжилт, хөдөлгөөний асуудал, орон нутгийн эдийн засгийн хямрал, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээ, цаашилбал Улаанбаатар хот болон бусда тулгуур төв хотууд, орон нутгуудыг харилцан уялдуулсан тээврийн сүлжээ зэрэг цогц нэгдсэн төлөвлөлтийн асуудалд шилжин арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Энэхүү хэсэгт, хөдөө орон нутгийн хөгжлийн орон зайн хүрээг авч хэлэлцэнэ.

(1) Орон нутгийн хотын үйл ажиллагааны давхарга, зангилаа бүтэц

Орон нутгийн засаг захиргааны нэгжийн тухайд, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар (2006) нийт нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана¹¹⁹. Тус тус засаг даргатай, аймаг сум нь тамгийн газартай. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар (1993 онд батлагдсан, 1995, 2003 онд өөрчлөлт орсон) хот нь 15,000аас дээш оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар, тосгон нь 500-15,000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар гэж заасан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан ”Хот тосгоны төлөвлөлт, барилгын стандарт, норм, дүрэмд (2004 он)” хүснэгт 4.4.1 үзүүлсэнчлэн хүн амын хэмжээнд тохируулсан хот, тосгоны төрөл, ангиллын стандарт заагдан байгаа хэдий

¹¹⁹ Нийслэл Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж нь дүүрэг, хороонд хуваагдана. Нийслэл Улаанбаатар хот төв 6 дүүрэг (Сонгинохайрхай, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй) алслагдсан 3 дүүрэгтэй (Налайх, Багануур, Багахангай). Дагуул Налайх, Багануур дүүргийг 2015 оны 4 сарын Нийслэлийн ИТХ-аар дагуул хот болгон, бие даасан засаг захиргааны нэгж болгосон.

ч, тос, тосгоны ангилал тус бүрийн хотын үйл ажиллагаа талаар тодорхой дурдаагүй, хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад энэхүү стандартыг ашигладаггүй байна¹²⁰. Түүнээс гадна, 500 мянгаас дээш хүн амтай мега хот зөвхөн Улаанбаатар хот байгаа бөгөөд, Эрдэнэт, Дархан хот том хотууд бус дундаж хотын ангилалд орж байгаа юм. Бусад аймгийн төвийн ихэнхи нь жижиг хотод орох бөгөөд, түүн дотор 20,000-аас доош оршин суугчтай аймгийн төвүүд ч байна (21 аймгаас 7 аймаг).

Гэхдээ, энэхүү стандарт, дүрэмд (Мега хот, том хотын нийтийн үйлчилгээний байгууламжийн тоо болон хүчин чадлыг тооцоходоо, 2 цагийн дотор эдгээр байгууламжид ирэх боломжтой оршин суугч, түр оршин суугч, аялагч, бусад хүмүүсийн оруулан төлөвлөнө. Харин жижиг, дунд хэмжээний хотын хувьд, нийтийн үйлчилгээний байгууламжаар үйлчлүүлэгчид 1 цагийн дотор ирэх боломжтой байхаар тооцоолно) зэрэг хотын үйлчилгээний хамрах бүсийг тодорхойлсон гарын авлага болохын хамт орон зайн төлөвлөлтийн чухал ойлголт ухагдахуун гэж үзэж байна.

Хүснэгт 4.4.1 Хот, суурин газрын ангилал

Хот суурийн газрын ангилал	Хүн ам (мян/хүн)	Хот
Хот: Мега хот Том хот Дундаж хот Жижиг хот	500 дээш 100-500 50-100 20-50 хүртэл	- Улаанбаатар - - - Эрдэнэт, Дархан - Чойбалсан, Өлгий, Арвайхээр, Баянхонгор, Улаангом, - Ховд, Сүхбаатар - Сайншанд, Даланзадгад, Цэцэрлэг, Өндөрхаан
Тосгон:	0.5-20.0	Уурхай, тээвэр, амралт, жуулчны бааз
Сум	0.5 - 10.0 хүртэл	Сум, багийн төв

Эх сурвалж : Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, барилгын стандарт, дүрэм (2004 он) ашиглан

ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Нөгөөтэйгүүр, өмнөх 4.1 хэсэгт дурдсан Мянганы хөгжлийн зорилгод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлогод (2008 он) мөн адил энэхүү төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийн талаар заасан бөгөөд, 2013 оны 1 сарын 2-ний өдрийн УИХ-ын шийдвэрээр дараах 8 хотыг “бүсийн тулгуур төв хот” болгохоор тогтоол

¹²⁰ Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) ажилтанаас тодруулахад, “ОХУ-ын стандартыг ашигладаг” гэж тайлбарласан.

гаргасан байна. Эдгээр хотууд нь Чойбалсан (41,812 хүн), Хархорин (12,569 хүн), Дархан (76,428 хүн), Эрдэнэт (87,837хүн), Улиастай (15,553 хүн), Ховд (26,342 хүн), Зуунмод (14,397 хүн), Чингис (хуучнаар Өндөрхаан) (19,230 хүн)¹²¹ юм.

Энэхүү судалгаагаар хүн амын тоо, хотын үйл ажиллагааны (функц) чанар, төвлөрлийн хэмжээ, тулгуур чанар, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг бодолцон, 2, 3 дахь хот болох Эрдэнэт, Дархан, түүнчлэн зүүн бүсийн Чойбалсан, Чингис, өмнөд бүсийн Чойр, Сайншанд хотыг ялангуяа бүсийн тулгуур төв болгон, бүс нутгийн хөгжлийн төв болгон хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Эдгээр хотуудыг хөгжүүлэхэд, бүс нутгийн нөөц баялагийг ашигласан аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, хүн амын цар хүрээнд тохирсон шаталсан амьдрах орчны үйлчилгээгээр хангах, өөрөөр хэлбэл хүн амд тохирсон аж үйлдвэрийн хөгжил, нийтийн аж хуйн үйлчилгээг бэхжүүлэх хэрэгтэй. Үүний тулд, тулгуур хотуудын хот бүрдүүлэгч дэд бүтэц болох дараах 4 үйл ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай, эдгээр үйлчилгээг ойролцоох аймаг, сумын төвийн иргэд, нүүдэлчин малчид авах боломжтой болгохын тулд аймаг, сумын төв болон тулгуур хотуудыг холбосон зангилаа бүтцийг бий болгохын хамт Улаанбаатар хотыг холбохын тулд эдийн засгийн корридор байгуулах хэрэгтэй.

- Аж үйлдвэрийн дэд бүтцийн хангамж, хяналт
- Худалдаа, гадаад худалдаа, зах зээл, банк санхүүгийн үйлчилгээ
- Мэдээлэл, технологи болон нийтийн аж ахуйн үйлчилгээ
- Дээд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ

(2) Голлох авто замын бүтээн байгуулалтаар нөлөөллийн бүсийг томсгох нь


Монгол улс 21 аймагтай хэдий ч өргөн уудам нутаг дэвсгэртэй тул аймгийн төв хот болох аймгийн төвийн хүн амын хэмжээ ерөнхийдөө 20-50 мянга, Улаанбаатар хоттой харьцуулахад хамаагүй цөөн, нийслэл хот болон аймгийн төв хоорондын нийтийн үйлчилгээний ялгаа их байна.

Нүүдэлчин малчдын эзлэх хувь өндөр хөдөө орон нутагт улирлаас шалтгаалан оршин суугаа газраасаа нүүдэллэдэг тул, нийтийн үйлчилгээг төвлөрүүлэхэд хүндрэлтэй, малчдын амьдралын таталцал нөлөөллийн бүс болохын хувьд сумын гүйцэтгэх үүрэг их. Иймд, голлох авто замын бүтээн байгуулалт эрчимжиж байгаа үед аймгийн төвөөс үйлчилгээний нөлөөллийн хүрээ хир зэрэг өргөсөх боломжтойг тооцоолж үзлээ.

Улаанбаатар хотоос 21 аймгийг холбосон улсын чанартай гол авто замуудын бүтээн байгуулалт эрчимтэй явагдаж байгаа билээ. Эдгээр улсын чанартай замын бүтээн


¹²¹ Үндэсний Статистикийн Хороо, 2013 оны сумын хүн амын мэдээлэлд тулгуурлана.

байгуулалтыг 2016 онд бүрэн хэрэгжүүлж дуусгах төлөвлөгөөтэй бөгөөд, сүүлийн хэдэн жилийн туршид зам барилгын ажил явагдаж, 2014 оны байдлаар хучилттай зам 41.6% эзэлж байна (зураг 4.4.1). Тээврийн дөцөөс шалтгаалах хэдий ч авто замын хатуу хучилт хийгдсэнээр автомашины хурд эрс ихэсч, цагт 60 км хурдтай давхих боломжтой болоод байна. 1 өдөрт туулах боломжтой тээврийн бүсийг талдаа ихдээ 3 цагаар тооцон, аймаг хоорондын холбоог харахад, одоогийн тээврийн бүс (зураг 4.4.2) тэй харьцуулахад хатуу хучилт хийгдсэнээр аймаг хоорондын зай бараг алга болж, нутаг дэвсгэр нийтдээ нэг өдрийн нийтийн үйлчилгээ авах нөлөөлийн бүс хангалттай болж (зураг 4.4.3), хөдөө орон нутгаас зах болон хотын өндөр зэрэглэлийн үйлчилгээтэй холбогдох нөхцөл сайжрах болно. Энд анхаарах ёстой зүйл бол Ховд, Баян-Өлгий, Увс 3 аймаг тэргүүтэй баруун бүс нутгийн хувьд хагас бие даасан эдийн засгийн бүс нутгийг үүсгэсэн байгаа гэж болно.



Эх сурвалж : ГХГЗЗГ мэдээлэлд тулгуурлан ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав.


Зураг 4.4.1 Аймагийн төвүүдийг холбох улсын авто зам



Жич : ГХГЗЗГ-ын мэдээлэлд тулгуурлан 3 цагт хүрэх нөлөөллийн бүс тодорхойлсон.

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 4.4.2 Одоо байгаа тээврийн нөлөөллийн бүс



Жич : ГХГЗЗГ мэдээлэлд тулгуурлан 3 цагт хүрэх нөлөөллийн бүсийг тодорхойлсон.

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 4.4.3 Хатуу хучилттай авто зам барьсны дараах нөлөөллийн бүс

4.5 Стратеги хөгжлийн корридорын төлөвлөгөөнд дэвшүүлэх санал

Өргөн уудам нутагтай Монгол улсын хөгжлийг хурдасгахын тулд, хөгжлийн тэргүүлэх эрэмбэ, зэрэглэлийг тодорхой болгох асуудал чухал. Энэхүү хэсэгт, өнөөг хүртэлх дүн шинжилгээнээс, орон нутгийн нөөц баялагийг ашигласан аж үйлдвэрийн хөгжлийг нэн тэргүүнд тавьсан хөгжлийн корридорыг бий болгох санал дэвшүүлж байна.

(1) Хөгжлийн сценари боловсруулах нь

1) Хөгжлийн үндсэн зорилго

Монгол улсыг хөгжүүлэх “Монгол улсын шинэ хөгжлийн суурийг тавих” асуудлыг эрхэм дээд зорилт болгон, дараах зорилтыг санал дэвшүүлж байна.

- Уул уурхайн хөгжил, холбогдох аж үйлдвэрийн хөгжил, хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг зорилт болгосон бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлж, эдийн засгийг эрчимжүүлнэ.
- Хөгжлийн суурь бэхжүүлэхэд улсын хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй зарцуулахын тулд ”корридор маягийн хөгжил”-ийг тэнхлэг болгосон хөгжлийг хэрэгжүүлж, тэнхлэг дагуух хөгжил нь хөдөө орон нутгийн нийтийн үйлчилгээг дээшлүүлэхэд шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- Бүс нутгийн хөгжлийг дагасан байгалийн цогцолборт газар, тусгай хамгаалалтын газар зэрэг чухал байгалийн нөөц баялагийг хамгаалах асуудлыг бэхжүүлэхийн зэрэгцээ, уул уурхай зэрэг бүтээн байгуулалтаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, тогтвортой байгаль орчны хөгжлийг бий болгоно.
- Дээрх зорилтыг хэрэгжүүлснээр хөдөө орон нутгийн хоорондын эдийн засгийн ялгааг арилган, жигд хөгжлийн бүтцийг бий болгоно.

2) Хөгжлийн корридор дахь бүсчилсэн хөгжлийн санал

i) Бүсчилсэн цогц хөгжлийн 3 үндсэн элемент

Өмнөх хөгжлийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд, үндсэндээ цэг, шугам, талбай гэсэн 3 элементээс бүрдэх хөгжлийн сценарийн төсөөлөл юм.

“Цэг”-т 2 хөгжлийн элементийг анхаарах хэрэгтэй. Энэ нь “Аж үйлдвэрийг хөгжүүлэх тулгуур төв байгуулах”, “Тулгуур төв хотуудыг хөгжүүлэх (оршин суух орчныг тохижуулах) “ асуудлууд юм. Өмнөх нь аж үйлдвэрийг хөгжүүлэхтэй холбогдсон тулгуур төвийг хөгжүүлэх нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, хөнгөн болон хүнд үйлдвэрийн байршлыг дэмжих аж үйлдвэрийн парк, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилго

бүхий эдийн засгийн чөлөөт бүс (SEZ), бараа эргэлт, нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах бараа нийлүүлэлтийн төв, логистикийн төв түүнчлэн нийтийн тээврийн терминаль зэрэг орно. Мөн, дараачийнх нь тулгуур төв хотуудыг хөгжүүлэхэд, бүс нутгийн аж үйлдвэрийг тэтгэх мэдлэг чадвартай хүний нөөц болон хотын үйлчилгээ (зах зээл, санхүү, гадаад худалдаа, R&D) хангамжийн төв болох функц орсон байна.

“Шугам” нь голдуу авто зам, төмөр зам зэрэг тээврийн байгууламж болон цахилгаан, холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн байгууламжийг илэрхийлнэ. Эдгээр нь зохистой сүлжээний бүтцээр дамжин өөрийн функц, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

”Талбай” нь бүс нутгийн орон зайн болон нөөц баялагийн элементийг агуулсан байгаа. Газар (тариалангийн болон бэлчээр), байгаль орчны нөөц, ашигт малтмалын нөөц, аялал жуулчлалын нөөц, усны эх үүсвэрийг тэтгэх ой модны нөөц гэх мэт зохистой газар ашиглалтыг дэмжих орон зайн элемент юм.

Бүс нутгийн хөгжлийн сценари нь, үндсэндээ дээр дурдсан 3 элементийг агуулан, нийт нь хэрхэн үр дүнтэй, ашигтайгаар бүс нутгийн эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэхээс хамаарах хэдий ч улсын хэмжээний хөгжлийн төсөөллийг авч хэлэлцэхэд шинэ төлөвлөлтийн зарчим болох “хөгжлийн корридор” аргачлал үр дүнтэй юм.

ii) **Аж үйлдвэрийн хөгжлийн үндсэн тэнхлэг болох корридорын хөгжил**

Өргөн уудам Монгол улсын нутаг дэвсгэрийн орон зайн бүтцийн хувьд, дээрх

1) Хөгжлийн үндсэн зорилтод тусгасан бүсчилсэн цогц хөгжлийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх хөгжлийн корридорыг санал дэвшүүлж байна. Хөгжлийн корридорын стратегийн утга учрыг дараах байдлаар тодорхойлж байна.

- Монгол улсын аж үйлдвэр, эдийн засгийн үндсэн тэнхлэг болон, эдийн засгийн үйл ажиллагаанд голлох үүргийг гүйцэтгэнэ.
- Нийслэл Улаанбаатар хоттой холбогдох зам тээврийн сүлжээ хөгжсөн босоо болон хөндлөн чиглэлд хөгжлийн тэнхлэгийг төсөөлөн, түүний дагуу аж үйлдвэрлэлийг хөгжүүлнэ (аж үйлдвэрийн нэмүү өтргийн гинжин хэлхээ бий болгох).
- Улаанбаатар хотын дараагийн 2 дахь хот болох Эрдэнэт болох 3 дахь Дархан, түүнчлэн босоо болон хөндлөн тэнхлэг дагуух тулгуур хотуудыг (голлох аймгийн төвүүд) уялдуулан холбох замаар шинэ тулгуур төвийг өсөлтийн сүлжээг бий болгоно.
- ОХУ, БНХАУ-ын дунд оршдгийн хувьд хөрш 2 оронтой хамтын ажиллагааг бэхжүүлж, ялангуяа гуравдагч олон улсын зах зээлтэй


холбогдохын тулд бараа эргэлт, логистикийн сүлжээг бэхжүүлэх шаардлага их байна. Төв Азийн бүс нутаг болон БНХАУ-ын зүүн хойд нутаг, алс дорнодын Азийн улсуудтай холбогдох зүүн өмнөд зүг рүү чиглэсэн шинэ зах зээлтэй холбогдох зорилго бүхий стратегийн корридор бий болгоно.

- Монгол улсын арвин их баялагийг хамгийн үр өгөөжтэй, тогтвортой ашиглан, цаашилбал эдийн засгийн өсөлт болон нийгмийн хөгжилтэй уялдуулсан хөгжил хэрэгцээтэй юм. Үүний тулд, тухайн нэг цэг эсвэл шугаман чиглэлийн, талбайн хөгжлийн элементыг харилцан уялдуулах тавцан (platform) болох “хөгжлийн корридор”-ыг бодолцон, тэрхүү хөгжлийн корридорт стратеги бодлогын дагуу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг оруулна. Ялангуяа, тээврийн систем, цахилгаан, эрчим хүчний систем, мэдээлэл зэрэг шугаман хөгжлийн эдийн засгийн дэд бүтцийг бэхжүүлэх зэргийг хөгжлийн корридор дагуу төвлөрүүлэн хэрэгжүүлснээр аж үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

(2) Монгол улсын аж үйлдвэрийн үндсэн тэнхлэг болох “Аж үйлдвэрийн хөгжлийн корридор”

Аж үйлдвэрийн хөгжлийн үндсэн тэнхлэгийн хувьд, Монгол улсын эдийн засгийн хөгжлийн түлхүүрийг атгаж буй 2 аж үйлдвэрийн корридор төсөөлөгдөж байна. 1 дэхь “**босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридор**” нь ОХУ болон БНХАУ-ыг холбосон одоо байгаа голлох тээврийн корридор, 2 дахь “**хөндлөн тэнхлэгийн ногоон корридор**” нь харьцангуй усны нөөцөөр баялаг Монгол орны хойд хэсэгт байрлан, өсөлтийн аж үйлдвэр болох хөдөө аж ахуйн хөгжүүлэх, нутгийн онцлогт тохирсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, нэмүү өртөг шингээсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, хөдөө аж ахуйн нэмүү өртгийн гинжин хэлхээ (value chain) бий болгох зэрэг асуудлыг стратегитайгаар хөгжүүлэх корридор юм. Мөн энэхүү 2 корридорын уулзварт нийслэл Улаанбаатар хотын бүсийн өндөр зэрэглэлийн хотын дэд бүтэц (зах зээл, хөрөнгө санхүү, технологи, хяналт, хүний нөөц, боловсрол, эрүүл мэнд, анагаах зэрэг) байрласан бүтэц юм.

Босоо болон хөндлөн тэнхлэгийн эдийн засгийн корридор нь, түүнийг тэлэх БНХАУ, ОХУ-тай гадаад худалдааны корридорын үүрэг гүйцэтгэнэ. Ялангуяа, хөндлөн тэнхлэгийн хувьд, ирээдүйд баруун луу чиглэсэн Төв Азийн орнуудын зах зээл, шинээр зүүн луу чиглэсэн БНХАУ-ын зүүн хойд нутаг, цаашлаад алс дорнодын Азийн улсуудын (Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Япон) зах зээлтэй холбогдох шинэ гадаад худалдааны корридор болох нөөц бололцоотой (Зураг 4.5.1).




Эх сурвалж : ЖАЙКА –ийн судалгааны баг

Зураг 4.5.1 Гадаад худалдааны корридор (санал)

(3) Хөгжлийн корридор болон бүс нутгийн хөгжил

Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын шилжилт, хэт их төвлөрлийг сааруулан, тэнцвэртэй аж үйлдвэрлэлийн төвлөрлийг дэмжихийн тулд, орон нутгийн томоохон хотуудын өсөлтийг эрчимжүүлэх шаардлагатай. Ялангуяа, босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридор дагуу байрласан 5 хот (Дархан, Эрдэнэт, Чойр, Сайншанд, Замын Үүд), хөндлөн ногоон корридор дагуу байрлах 2 хотыг (Чингис, Чойбалсан) Улаанбаатар хотын дараа орох 2 дахь шатлалын хот (Secondary City) болгон, бүх төрлийн худалдаа, үйлчилгээ, зах зээл, мөнгө санхүү, даатгалын үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, засаг захиргаа, мэдээлэл зэрэг олон төрлийн хотын функцийг сайжруулж, түүнтэй уялдуулан ажлын байр нэмэгдүүлэх хэрэгтэй. Ингэснээр орон нутгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжин, орон нутаг дахь нийтийн үйлчилгээний чанар сайжирч, Улаанбаатар хот руу явалтгүй тохилог, хангалуун амьдрах боломжтой хотын дэд бүтцийг бэхжүүлэхээс гадна, энэ нь урт хугацаанд газар ашиглалтын тэнцвэрийг хадгалан, хүн амын нэгдсэн суурьшлын орчинг бий болгох болно (зураг 4.5.2).




Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 4.5.2 Тулгуур төв хотыг тойрсон бүс нутгийн суурьшлын төсөөлөл

(4) Эдийн засгийн стратеги хөгжлийн корридорын төсөөлөл

Дээрхийг үндэслэн, Монгол улсын эдийн засгийн стратеги хөгжлийн корридорын төсөөллийг зураг 4.5.3-т харууллаа.



4-39

Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 4.5.3 Эдийн засгийн стратеги хөгжлийн корридорын төсөөлөл

(5) Эдийн засгийн стратеги хөгжлийн корридорын орон зайн онцлог болон корридор дагуух хөгжлийн нөөц бололцоо

Эдийн засгийн стратеги хөгжлийн корридорын төсөөлөлд дэвшүүлсэн 2 корридорын тухайд тус тусын онцлогт тохирсон хөгжлийн нөөц бололцооны талаарх таамаглалыг цэгцэлж байна.

1) Босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридор

ОХУ-аас Улаанбаатар хотыг дайрч БНХАУ-ын Бээжин хот хүрэх Улаанбаатар төмөр зам болон түүнтэй зэргэлдээ улсын чанартай гол авто зам (Эрдэнэт Дархан Улаанбаатар Сайншанд Замын-Үүд) дагуух босоо тэнхлэг нь, өнөөгийн байдлаар Монгол улсын цорын ганц хөгжлийн тэнхлэг гэж хэлж болно. Энэхүү "Босоо тэнхлэгийн аж үйлдвэрийн корридор" нь улсын нутаг дэвсгэрийг баруун, зүүн хэсэгт хуваах голлох маршрут дагуу хүний хөдөлгөөн болон бараа эргэлт жижиг гол, горхи том мөрөн луу ус цутгах адил цугларах бүтэц юм. Энэхүү урсгалын төвд Улаанбаатар хот байрлаж байгаа. Улаанбаатар хотод хүн ам болон нөөц баялаг төвлөрсөн байгаа нь эдийн засгийн байрлалын хувьд оновчтой үзэгдэл гэж болох авч, нэг цэгт хэт төвлөрсөн эдийн засгийн гажуудлыг арилгаж, эдийн засгийн хөгжлийн эрчмийг энэхүү хөгжлийн тэнхлэг дагуу тэлснээр цаашдын ирээдүйн тогтвортой, тасралтгүй хөгжлийн бүтцийг бий болгох боломжтой болно.

Уул уурхай болон дагалдах аж үйлдвэрийн хөгжлийн үйл ажиллагааны тухайд, хяналтын үүрэгтэй Улаанбаатар хот болон өмнө бүсийн уул уурхай, хил орчмын бүс нутгийн аж үйлдвэрийн төвлөрөл хооронд үүрэг, хариуцлагыг тогтоон, корридор дагуух нутгийн онцлогт тохируулсан аж үйлдвэрийн хамтын ажиллагааг бий болгоно. Түүнчлэн, хөдөө аж ахуйн хөгжлийн хувьд, том хотуудын хүнс ханган нийлүүлдэг бүс нутаг болон төмс, хүнсний ногоо, мах, сүү зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүнсний боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой.

Корридор дагуух бүс нутгийн хөгжлийн цэс

Улаанбаатар хотод байрлах ноос, ноолуур, арьс шир зэрэг уламжлалт аж үйлдвэр дээр шинээр хөгжиж буй орчин үеийн үйлдвэр, үйлчилгээг ашиглах, босоо чиглэлийн корридор дагуух байрлах уул уурхайд түшиглэн нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэр хөгжүүлэх, нүүрсийг тухайн орон нутагт бүрэн ашиглах нүүрсний нэмүү өртгийн гинжин хэлхээг бий болгох зэрэг олон төрлийн холимог багц цэс байж болно.

[Уламжлалт аж үйлдвэр, шинэ үйлчилгээтэй нэмүү өртөг нэмэгдүүлэх цэс]

- Уламжлалт аж үйлдвэрлэлд (ноос, ноолуур, арьс шир) нэмүү өртөг шингээх

- Улаанбаатар хотын бүсэд орчин үеийн аж үйлдвэр¹²²болон үйлчилгээг дэлгэрүүлэх
- Бараа эргэлт, логистикийн үйлчилгээний байгууламж, үйл ажиллагааг бэхжүүлэх
- Эрүүл мэнд, боловсрол зэрэг өндөр түвшний нийгмийн үйлчилгээг хөгжүүлэх

【Уул уурхай, ХАА салбарын нэмүү өртгийг нэмэгдүүлэх цэс】

- Нүүрс угаах үйлдвэрлэлээр нэмүү өртөг шингээх
- Нүүрс угаахад хаягддаг энгийн нүүрсийг ашиглах
- Энгийн нүүрс ашиглан орон нутгийн эрчим хүчний системийг хөгжүүлэх
- Бага оврын нүүрсний уурхай, олборлосны дараах уурхайг эрчим хүчний үүсвэр болгон ашиглах (UGS)
- Хүнсний нэгдсэн боловсруулах төв (сүү, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах)
- Хүнсний ногоо тариалах үйлдвэр

【Амьдрах орчин сайжруулах цэс】

- Малчдад зориулсан үйлчилгээний байгууламж (Мичино-эки зам дагуух байгууламж гэх мэт)
- Корридорын мэдээллийн дэд бүтцийг ашигласан, мэдээ, мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, эмчилгээний систем
- Хуучирсан барилга байгууламжийн засвар болон мэдээллийн технологи ашигласан хөтөлбөр
- Өндөр настан, асаргааны дэмжлэг¹²³хөтөлбөр

2) Хөндлөн тэнхлэгийн ногоон хөгжлийн корридор

Монгол улсын хойд хэсгээр Сэлэнгэ, Хэрлэн хэмээх 2 том мөрөн гол урсдаг тул өвс ургамал сайтай бэлчээрийг бий болгодог бөгөөд, хөдөө аж ахуйн баялаг нөөц нутгийн хойд хэсгээр өргөн тархсан байдаг.

Монгол улсын төрөөс ч энэхүү баруунаас зүүн тийш байрлах хөндлөн тэнхлэгийн хөгжилд ач холбогдол өгч, Улаанбаатар хотоос зүүн чиглэлд ЖАЙКА-ийн буцалтгүй тусламжийн төслөөр Чингис хот (хуучин Өндөрхаан) хүртэлх 300км хатуу хучилттай авто замыг 2007 онд барьж ашиглалтанд оруулсан. Энэ авто

¹²² Социалист нийгмийн үед баригдсан үйлдвэрийн байшин барилга, техник, технологи хуучирч, үйлдвэрлэлийн үр ашиг муудсан тохиолдол олон бий. Эдгээр үйлдвэрүүдэд орчин үеийн технологи нэвтрүүлэх шаардлагатай.

¹²³ Асаргааны дэмжлэг хөтөлбөрийн хувьд, жирэмсэн эхчүүд, нярай хүүхдүүдийн асаргаа (эх хүүхдийн эрүүл мэндийн тэмдэглэл гм), эмэгтэйчүүд, хүүхдийн эмнэлэг, цэцэрлэг зэргийн орчинг тохижуулах асуудлууд орно.

замын бүтээн байгуулалт үргэлжлэн хийгдэж Чойбалсан хот хүрэхэд 50 км орчим хийгдээд бүрэн ашиглалтанд орох шатанд ирээд байна. Нөгөөтэйгүүр, баруун бүсийн чиглэлд Улаанбаатар хотоос Дархан хүрэх хөндлөн корридорын хойно байрлах Эрдэнэт Булган Мөрөн хүртэлх авто зам хатуу хучилттай болсон. Цаашилбал, Улаанбаатар хотоос Цэцэрлэг хүртэлх замын нэг хэсэг мөн ашиглалтанд ороод байна. Энэхүү улсын чанартай зам Ховд аймгийн чиглэл хүртэл үргэлжлэх төлөвлөгөөтэй.

Иймэрхүү байдлаар, эрчимтэй явагдаж буй авто замын бүтээн байгуулалтын дэмэнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэх харилцаа, холбоо сайжирч байна. Зүүн чиглэлд Чойбалсан, Улаанбаатар хотын дунд байрлах Чингис хот нь Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн төв болон хөгжсөөр байна. Баруун чиглэлд Эрдэнэт хот, түүнээс цааш 200 км т байрлах ХутагӨндөр сум Булган, Архангай аймгийн хөдөө аж ахуйн төв болон хөгжиж байна.

Ойрын ирээдүйд, Улаанбаатар хотоос зүүн чиглэлд Чойбалсан хотоор дамжин БНХАУ-ын зүүн хойд бүстэй холбогдон, баруун чиглэлд Улаанбаатар хотоос Ховд, Баян Өлгий, Казакстан хүртэлх эх газрын тээвэрлэлт холбогдоно. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон боловсруулсан бүтээгдэхүүний логистикийг сайжруулан, корридор байгуулснаар зах зээлээ өргөтгөх зэргээр төрөл бүрийн бараа эргэлт нэмэгдэж, түүнтэй хамт бүс нутгийн онцлогийг тусгасан нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжиж, хөдөө орон нутгийн орлого нэмэгдэх найдлагатай.

Корридор доторх хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалтыг нэг дор төвлөрүүлэх төслийг хуучин Аж үйлдвэрийн яам, одоогийн Үндэсний хөгжлийн газар ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк төлөвлөж байна. Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд бэлтгэн нийлүүлэлтийн төвлөрсөн функцыг сайжруулах хэрэгтэй бөгөөд голлох авто замын бүтээн байгуулалтаас гадна хөдөө орон нутгийн зам харилцааг сайжруулж, хаб (hub) үүргийг дээшлүүлэх хэрэгтэй. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний логистикийн үр ашгийг сайжруулах, бараа эргэлтийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг анхны алхам болгон, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг томруулан, зах зээл болон холбогдох аж үйлдвэрийг бага багаар тэлэх зорилготой. Энэхүү судалгаагаар, хөдөө аж ахуйн холимог хөгжлийг эрчимжүүлэх ”Хөндлөн тэнхлэгийн ногоон хөгжлийн корридор” төсөөллийг Монгол улсын ирээдүйн хөгжилд чиглэсэн тогтвортой, тасралтгүй эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал стратеги болгон санал дэвшүүлж байна (зураг 4.5.5).



Эх сурвалж : ЖАЙКА-ийн судалгааны баг

Зураг 4.5.4 Хөндлөн тэнхлэгийн ногоон хөгжлийн корридорын төсөөлөл

Корридор дагуух бүс нутгийн хөгжлийн цэс

Хөндлөн корридор гол нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой. Иймэрхүү хөгжлийн төсөөлөлд ХАА-н үйлдвэрлэл, технологийн паркийн төсөл нь цаг үеэ олсон тааламжтай боломж тул бүс нутгийн аж үйлдвэрлэлийн уялдаа холбоог бэхжүүлэн, дотроосоо хөгжих үйлдвэрлэлийн эргэлтийн бүтцийг бий болгох хэрэгтэй. Хөндлөн корридорын хөгжлийн цэсийн тухайд, хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингээх, хөдөө орон нутгийн амьдрах орчинг сайжруулах болно.

【Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртөг шингээх цэс】

- Хүнсний боловсруулах үйлдвэр (ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн)
- Логистикийн үйл ажиллагааг сайжруулах (Хамтарсан бэлтгэн нийлүүлэлт, хөдөө аж ахуйн бирж гэх мэт)
- Судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг сайжруулах (ХАА-н судалгааны хүрээлэн байгуулах)
- Орон нутгийн онцлогт бүтээгдэхүүн үйлдвэрлэх (нутгийн нэрийн бүтээгдэхүүн гаргах)
- ХАА-н гаралтай бүтээгдэхүүний төрөл, стандартыг сайжруулах (Зах зээл дэхь хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгаа)

【Амьдрах орчин сайжруулах цэс】

- Оршин суугчдад зориулсан үйлчилгээний байгууламж (Мичино-эки зам дагуух байгууламж гэх мэт)
- Корридорын мэдээллийн дэд бүтцийг ашигласан, мэдээ, мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, эмчилгээний систем
- Хуучирсан барилга байгууламжийн засвар болон мэдээллийн технологи ашигласан хөтөлбөр
- Өндөр настан, асаргааны дэмжлэг хөтөлбөр

【Орон нутгийг хөгжүүлэх цэс】

- Байгаль орчин, соёл урлагтай уялдуулсан хөгжил, аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулах (нутгийн онцлогт бүтээгдэхүүн, жуулчдыг татах, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нутгийн хоол, урлаг соёлын хөгжил)
- Хоол хүнс, хөдөө аж ахуйг эрүүл мэнд, халамжийн бизнестэй холбох
- ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс шууд худалдан авалтыг хөгжүүлэх
- Бүс нутгийн тулгуур төвийг бэхжүүлэх
- Нутгийн жижиглэн худалдааны цэг, нийтийн хоолны үйлчилгээг сайжруулах замаар орон нутгийг хөгжүүлэх
- Нутгийн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр орон нутгийг хөгжүүлэх
- Судалгаа, үйлдвэрлэл, төрийн хамтын ажиллагаагаар ХАА-н шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Орон нутгийн эрчим хүчийг ашигласан нутгийн үйлдвэрлэл, худалдааг дэмжих